




ХҮҮХЭД БАГАЧУУДАД ЗОРИУЛСАН
100 ЦУВРАЛ

Д. Гармаа



**ААВ ЦЭЦЭРЛЭГТ
ОРСОН НЬ**

Аав цэцэрлэгт орсон нь
Зохиолч: Д.Гармаа

ISBN: 978-99929-8-185-7

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Оршлын оронд

Зохиолч Д.Гартаа 1955 оноос уран бүтээлийн ажлаа эхэлж энэ завсар "Хөгжөөнтэй туужууд", "Уулын нууц", "Мөнгөн шуудэр", "Хусэл мөрөөдлийн тууж" зэрэг арав гаруй ном хуухдэд зориулан бичжээ. Тууний "Хөгжөөнтэй туужууд" манайд, мөн ЗХУ-д хоёр дахь удаагаа хэвлэгдсэн юм. Зохиолчийн хуухдийн туужуудыг унtigч олны хусэлтээр нэгэн ном болгон хэвлэж байна. Энэ номонд "Аав цэцэрлэгт орсон нь", "Мөнгөн гиуудэр" зэрэг хуухэд та нарын унших дуртай зургаан тууж орлоо.

Ном болгон оршилтой байдаг. Уг нь бид зохиолчийн хуухдэд зориулсан уран бүтээлийн талаар өмнөх уг хэвлэе гэсэн боловч зохиолч, И.Мотяшовын бичсэн "Монгол оронтой нуур учран танилцахад" өгууллээс хэсэглэн авч нийтлэхийг хуссэн юм. Иймд бид оршлын оронд зөвлөлтийн хуухдийн зохиолын нэрт шуумжлэгч, ЗСБНХУ-ын хуухдийн уран бүтээлийн холбооны дэд ерөнхийлөгч, дэлхийн хуухдийн шилдэг бүтээлд олгодог Андерсений нэрэмжит шагналын хорооны дэд ерөнхийлөгч Игорь Мотяшовын өгууллээс хэсэглэн авч хэвлэв.

Монгол оронтой нүүр учран танилцахад

...Доржийн Гармаа бол миний хамгийн түрүүн танилцсан монгол зохиолч байв. 1966 онд намайг "Хүүхдийн утга зохиол" сэтгүүлийн ерөнхий эрхлэгчийн орлогч байхад уул сэтгүүлийн тавдугаар сарын дугаарт Д.Гармаагийн "Гар чийдэн" гэдэг өгүүллэг нийтлэгдсэн билээ. Түүнийг Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургуулийн үргэлжилсэн үгийн зохиолын семинарыг удирддаг шүүмжлэгч Михаил Лобанов редакцид авчирсан юм.

Утга зохиолын дээд сургуулийн оюутан Д.Гармаа түүний семинарт амжилттай хичээллэдэг нь хэвлэлийн өмнөх өгүүллийг бичсэн М.Лобановын үгнээс мэдэгдэж байв. Надад тэр өгүүллэг аятайхан санагдсан сан. Түүнд хоёр жаалын амьд дүр болох өгүүлэгч гол баатар, түүний дүү Болд нар байв. Монголын тал нутаг, малчдын ахуй амьдралыг урнаар дүрсэлж ертөнцийн сайхныг ажиглаж хошноор сэтгэн зурагласан нь ах дүү хоёрын өөр хоорондоо ойлголцсон яриа байдлаас ил байв. Өөрөөр хэлбэл энэ авьяаслаг зохиолчийн хожим бүтээсэн тууж, өгүүллэг, кино зохиолуудад илэрч гарсан дүр дүрслэлийн сайхан бүхэн дээрх зохиолд шингэсэн байлаа.

Би Д.Гармаагийн романтай танилцаагүй, гэвч түүний хүүхдийн туужууд товч тодорхой байдгийг ажигласан. Үйл явдлын тэмүүлэл нь агуулгыг бүрнээ нээн харуулахтай хосолж чаддаг юм. Туужийг уншаад эргэн бодоход товчхон гэж ер санагдахгүй, харин ч олон дүгнэлт өгч юм бодогдуулахуйц болсон байдаг.

Орос хэл дээр "Хөгжөөнтэй туужууд", "Гавьяат үйлсийн мөрөөдөл", "Нэгэн зуны намтар", "Ерөөлтийн бага хүү" гэдэг туужууд болон "Хөөрхөн Байдий", "Үнэнч нөхөд" гэдэг эмхтгэлүүд тогтмол хэвлэлүүдэд олон өгүүллэгүүд нь нийтлэгдсэн билээ. Энэ зохиолуудаа хэдийд бичсэнийг би мэдэхгүй. Гэхдээ малчин Ерөөлтийн хүү Идэрийн тухай тууж г бол сэтгэл зүйн гүнзгий боловсруулалт, хурц, зангилаа асуудлыг гаргаж үзүүлсэн байна билээ.

Д.Гармаагийн зураглан буй багачуудын дүр төрх өөр хоорондоо адил байдаггүй. "Гавьяат үйлсийн мөрөөдөл" туужийн Цэдэнг аваад үзье. Тэрбээр хуурамчаар өвчтөн болж сурагчдыг айлгах, хожим гавьяат сайн үйлс хийхийн тулд болжморыг чулуугаар шидэх зэрэг олон хөгжөөнтэй хөгжилтэй арга сүвэгчлэн олж түүнийгээ ганцаараа биш, өөрийн итгэлт нөхөр Баатарын хамт хийж байгааг өгүүлж байна.

Туужийн үйл явдал юуны өмнө амжилттай өрнөж байгаа нь санаанаасаа зохиосон бус нь мэдэгдэнэ. Хүүхдүүд хожмын хор холбогдлыг ойлгоогүй боловч сайн сайхан, гавьяат үйлс бүтээх эрмэлзлээ сэтгэл оюундаа багтааж байна.

Цэдэн өөрийгөө болон найз нөхрөө инээдэмтэй хөгтэй үйл ажилд оруулахын зэрэгцээ жинхэнэ ажилч хичээнгүй, сэтгэгч, зөгнөгч байдлаар дүрслэгдэж байна. Тэрбээр бүтээлч зүтгэлтний хүслийг гүйцэтгэж байна. Эхний үед бүтэмжгүй явдал дараа дараагаар учравч түүндээ гутарсангүй, орчинтойгоо зөв харьцаж сайн үйлсийн төлөө цуцалтгүй тэмүүлж байна.

Туужид гарч буй ухаалаг эмэгтэй багш нь Цэдэнг тэсвэртэй зөв ойлгож алдааг нь засч

залруулж, үнэнч зөвлөлгөө өгч, хэзээ ч түүнийг ад үзэж шоолохгүй, хүн чанарыг нь үгүйсгэхгүй байна. Юуны өмнө хүчээр дарахаас зайлсхийн, хүмүүсийн дунд түүнийг тайван байлгаж, өөрийнхөө эгзэгтэй огцом хүсэл бодлоо биелүүлэхэд нь тэтгэн дэмжиж байна.

Туужийн ёс суртахууны дүгнэлт нь багш эмэгтэйн хэлснээр "Сайн үйлсэд жижигхэн зүйл гэж байдаггүй" гэсэн үг юм. Чухам энэ нь туужийн өгүүлэгдэхүүн бүрд илэрхийлэгдэхийн хамт

Цэдэн Баатар нартай учирч буй үйл явдал, тэдний бодолд А тусгалаа олж байна. /

"Нэгэн зуны намтар" хэмээх туужид бол нийтэд Банзай гэж алдаршсан Банзрагч нэн сонирхолтой дүр юм. Банзай бол үе тэнгийнхний хэлцдэгээр явган хэрүүлч, дүрсгүй, тэгэхдээ уурхайн конторт ажилладаг эхийнхээ өмгөөлөлд оодорч, ямар ч шийтгэл зэмлэлгүй үлддэгтээ бүрнээ итгэсэн хүү юм.

Зохиолч туужийнхаа баатар Банзайгийн төлөө сэтгэл түгшин бичиж байна. Олон нийтийн шүүхээс хүүгээ авч явахдаа ээж хүүгийнхээ хүмүүжилд хэрхэн нөлөөлөх рольтойг ойлгож байна. Хэт эрхэлж ажил хөдөлмөрөөс зайлсхийж, гоёж гангалах ахуйгаар өссөн хүү юм.

Гэвч энэ хүүгийн төрх төлөвт эхийнхээ муу нөлөөнөөс гарч чадах найдвар байна гэдгийг зохиолч харжээ. Банзай янз бүрийн муу дутагдал гаргадаг ч гэлээ түүндээ санаа зовомтгой хүү юм. Луувангийн хулгай нь ямар ч бодлогогүйгээр хийсэн зэвүүцмээр хэрэг. Дараа нь түүндээ ичиж зовж байна. Хүүд ухаалаг, шаардлагатай зөвлөгч нөхрөөс гадна сахилга журамд өөрөө суралцах, өөртөө тавих шаардлага дутагдаж байгаа нь аяндаа мэдэгдэж байна. Тийм нөхөд нь Банзайн хувьд түүний ээж ч биш, уурхайчин эцэг нь ч биш юм. Харин Банзайтай нас чацуу, Улаанбаатар ах дээрээ амралтаараа ирж буй Чойсүрэн байв.

Чойсүрэнгийн зан чанар Тимурчүүдийн төрх төлөв сайтар харагдаж байна.

Гэвч зохиолч, Банзайгаа анхааран халамжлахдаа Чойсүрэнгийн амьдралын дүрийг тодруулах үнэмшилтэй нарийн дүрслэл олсонгүй мэт байна.

Тэр нь монголын өнөөгийн багачуудын дүр төрхөөр биш, утга зохиолын талаас гаргасан бололтой. Монголын хүүхдүүдийн амьдралд Д.Гармаагийн бодлоор үнэхээр ухаалаг, сайн үйлийн төлөө тэмүүлэгч, ирээдүйн зорилготой зан чанар элбэг бий гэдэгт би эргэлзэхгүй ээ.

Энэ жаалууд нь оюун санааны гүнзгий амьдралтай, хүсэлд шунан дурлагч амьд дүртэй бөгөөд зохиолч тэднийг "дууриах г жишээ" болгож, зөв алхмыг заан сургасан аясаар бичээгүй нь мэдээж юм. Сайн хүүхдийг дүрслэх нь зүггүй сэргэлэн хүүхдийн дүрийг гаргахаас хэцүү нь эргэлзээгүй. "Ерөөлтийн бага хүү" тууж бол дээрх бэрхшээлийг давах бүрэн чадал Д.Гармаад байгааг баталж байна.

Зохиолч "адал явдлын" хурц үйл явдлаас /үл цэрвэн/ авч дүрслэхдээ зөвхөн сэтгэлд бүрэн бүтнээрээ дурсагдан хоцрох Идэр хэмээх гол баатрынхаа томруун дүрийг гаргаж амжсанаар барахгүй, түүний эргэн тойронд амьдарч байгаа хүмүүс тухайлбал, үе чацуутан Зээхүү, сурагч Бөмбөө, хэсгийн төлөөлөгч ахмад Довууч гуай, номын дэлгүүрийн худалдагч Осор гуай зэргийн реалист дүрүүдийг гаргаж чадсан байна. Туужид муу нөхрийн балаг нь бяцхан

зүрхийг шархлуулж, олон түмнийг эндүүрэлд оруулж, худал хуурмаг сэжиглэлтээс үүсэн гарч байгаа, гомдол гасланг зохиогч амжилттай дүрсэлсэн юм.

Идэр нь ухаалаг, зоригтой, ажигч гярхай, тууштай зан төлөвтэй хүүхэд юм. Хамгийн гол нь шударга, бусдын зовлонг ойлгон тусалж чаддаг, эр зоригтой юм. Эргэн тойронд нь байгаа хүмүүсийн буруу ойлголт, утгагүй зэмлэлийн эсрэг ганцаараа тэмцэх, тэдэнд үнэн байдлаа харуулах зориг тэвчээр, сэтгэлийн хүч тэнхэл түүнд хүрэлцээтэй байна. Чухам энэ нь л уншигч олны хүндэтгэл хүлээж байгаа юм.

Орос хэл дээр хэвлэгдсэн зохиолуудаар нь дүгнэн үзвэл, Идэрийн тухай Д.Гармаагийн тууж бол монголын утга зохиолд шинэ зүйл, түүний өсөлт, буурь суурийг харуулах гэрч мөн.

И.Мотяшов

1. Үүрээр

Хүйтэн салхи үлээсэн жихүүн хүйтэн үүрийн ид харанхуй дундуур буу тасхийж хавийн амьтныг цочоов. Энэ нь цагааныхан орж ирсэн хэрэг юмсанжээ. Тэргэл сар тэрүүхэн уулын чанадад далд ороод, марал мичид цэнхэр тэнгэрийн баруун этгээд тийш гудайжээ.



Харанхуйн дунд огтхон ч чимээгүй байсан гэрт нэг хүн зул асаав. Энэ гэрэл ид нойрондоо зүүдэлж байсан жаал хүүг гийгүүлжээ.

Хүүгийн ээж зулын дэргэдээс холгүй зайлан зогсож, дээлээ мөрөн дээгүүрээ нөмөрснөө хүүгийнхээ дэргэд очиж:

-Бос бос, миний хүү! гэж зөөлнөөр дуудав.

Хүү үлгэрийн ертөнцөд аль хэдийн нисэн одоод сайхан цэцгүүдийн дунд хайрт партизан ааваа даган инээд хөөртэй гүйж явна гэж зүүдлэн байв. Гэнэт буун дуунаас хүү цочин давхийж сэржээ. Энэ сацуу тэдний хаалгыг нэгэн үл таних хүнд амьсгаатай хүн балбаж эхэллээ.

Ээж нь "Чимээгүй" гэж амаа дарснаа:

-Хэн ч байж болох юм шүү. Миний хүү өндийж хувцасла! гээд А өөрөө үүдний зүг ойртов. Хүү орноосоо годхийтэл сугаран / гараад хувцсаа өмсөж, "Дайсан байж мэднэ!" гэж бодон түүнтэй тулахын тулд юуны өмнө урьд бэлтгэсэн зэвсгээ гаргав. Энэ нь хурцаас хурц том хадаас, хоёр цагаан чулуу, бас нэг чавх байлаа.

Ээж хаалгаа онгойлгохоор зэхэж хүү чавхандаа чулуугаа сайтар онилж авлаа. Хаалганы түгжээ мултран хүн орж ирсэн нь нүд хальтирмаар байв. Хүү тэр хүнийг удаан ажиглан харснаа сая л ааваа мөн болохыг мэдэж:

-Аав аа! гэж ухасхийв.

* * *

Партизанууд цагааныхантай ширүүн тулалдаан хийжээ. Даанч хүч бага, зэвсэг хомс байсан тул мэгдэн ухарч зогсолтгүй шуурган гал нээлцэн дайтсаар эрэлхэг зоригийн гайхамшгийг үзүүлээд эргэн иржээ. Эргэж ирэх нь ч бас тэдний мэргэн аргуудын нэг байсан бөгөөд ар тийшээ хэл мэдээ хүргэн тэнхэрч аваад, их хүчээр эргэж дайсныг үнсэн товрог болгоно гэж

ярилцжээ. Толгойгоо цагаан юмаар боосон аав нь сэтгэл зовмоор тайван сууж эд бүгдийг ярихад нь дайсан ойртсоны дохио мэт буун дуу үе үе нүргэлэв.

-Ээж нь өрөвдсөнөөс уйлчихаад, нулимстай нүдээр аавынх нь зүг энхрийлэн хайрлаж хараад:

-За Зоригт минь, одоо яадаг билээ дээ. Өнөө дайснууд чинь одоохон ирээд чамайг минь аваад явчих юм биш байгаа даа! гэж санаа алдан хэлэв. Аав халуун цай хэд оочсоноо хэлсэн нь:

-Сэтгэл зоволтгүй. Бид нэгэнт бүслэгдсэн. Одоо ямар боловч ар тийш нь хүн явуулж бичиг хүргүүлэх хэрэгтэй. Тэгээд эндээ хамгаалалт хийж дайсантай нэг хоёр хоног боловч нэгийгээ үзэлцээд авах хэрэгтэй.

-Аав та юунд толгойгоо даавуугаар боосон юм бэ? гэж Баатар й хүү асуув. /

-Хөх уулын тэнд манайхан дайсан цэрэгтэй тулалдсан юм. Хүч тэнцүүгүй мөртлөө... гэж ярих гэтэл аавынх нь таних хүн орж ирэв. Тэр хүн үүдний тэнд уухилан зогсоно.

-Зоригт оо! Яаравчлах хэрэгтэй боллоо. Бид Галтын өвөлжөөнд цуглахаар шийдсэн. Хүн явуулах тухай тун яаравчлан ярилцахгүй бол болохоо байлаа. Чи хүүгээ авч очих хэрэгтэй шүү гэж түүний амьсгаадан хэлэхэд нутгийн ард Дамдин гуай болохыг сая л Баатар танив. Аав нь энэ үгийг сонсоод яарч гарлаа.

-Чи нэг аягахан шөл уучихаад явах юм биш үү гэж ээж нь гуйх мэт дуугарав.

-За тэгье. Тэгээд бүгдээрээ явцгаая! гэж аав нь ээж уруу нь харан хэлээд Дамдин гуай уруу:

-Та нар явцгааж бай! Хэдэн мөчийн дараа бид тэнд бэлэн! гээд суув. Удаан хугацаа өнгөрсөнгүй ээжийн хийсэн шөл бэлэн болоход тэд хооллоод мордов.

Номин цэнхэр огторгуйд өглөөний нар мишээв. Нүдний хараа хүрэх алсын алсад тал нутаг цэлийн ухаан довын халзан зулай дээгүүр дайсны цэргийн морьтой харуул явах нь болжморын үүрэн дээгүүр хомхойгоор эргэх махчин элээ мэт ажээ.

Галтын өвөлжөө хад цохиотой өндөр уулын өвөр дээрээ оршдог. Нүдэнд танил, сэтгэлд дулаан санагдах партизан ах нар өвөлжөөний нууц буланд гал түлцгээн зарим нь хоол унд чанаж, нөгөө нэг хэсэг нь буугаа арчин нийтээрээ чимээгүй бөгөөд намуун хоолойгоор хувьсгалын дууг аялцгаах нь хэний боловч сэтгэлийг хөдөлгөнө.

Партизан отрядын дарга бут мэт сахалтай өвгөн ах Баатарын ээжтэй мэндлэв. Дараа нь Баатарыг тэвэрч сүрхий гэгч нь ширтсэнээ:

-Тэр жил биднийг хошууны ноёнттой нэгийгээ үзнэ гэж анх отрядад явахад байсан жаахан хүү ийм том эр болсон гэж үү гэснээ үнсэж:

-Баатар чи удахгүй партизан болно. Чи их үйл бүтээнэ. Одоо п хэдтэй вэ? /

-Арван нэгтэй гэж Баатар хариулав.

-Ёстой сайн хүү, чамд бид итгэж болох юм байна гэв.

Сүүлийнх нь үгийг Баатар ойлгосонгүй гайхан хоцров. Партизан ах нар цугларан дотогш орцгооход Баатар ч бас аавынхаа гараас барин тэднийг даган орлоо. Өвөлжөөний хойд талаар дамжин агуй уруу ордог аль хэдийний заншсан замтай юм. Энэ өвөлжөөг том элгэн хаданд тулган барьсан тул дээрээс нь харсан ч мэдэгдэхгүйгээр юмсанжээ. Агуйн мухар буланд гал түлж, тэнд хоёр гурван хүн суух нь мөн л партизанууд байна. Шинээр орж очигсод дүрэлзсэн галыг тойрон суухад аав нь тэр хоёрыг түлхэж:

-Та хоёр эндээ хүлээж бай! гэж Баатарыг ээжтэй нь орхиод өөрөө партизанууд тийш очлоо.

Тэд бөхийж нам дуугаар ямар нэгэн юмыг шивнэцгээнэ. Тэдгээр нууц үгсийн дундаас:

"Партизан эцгийн хүү партизан байх нь зүйтэй биш үү ! Энэ даалгаврыг тэр хүү заавал биелүүлнэ" гэсэн үг чангаар сонсогдоно.



2. Миний хүү зоригтой хүү

Хэсэг болсны дараа тэд Баатарыг дуудав. Баатар аавынхаа (дэргэд очоод дуугүй инээмсэглэн зогсоход нь партизанууд бүгдээрээ түүн тийш харав.

-Баатар аа, бид чамд чухал үүрэг өгөх гэж байна. Чи ямар хэрэг болоод байгааг мэдэж ойлгох ёстой гэснээ партизаны дарга өвгөн ах саяхан болсон тулалдааны тухай, тэнд жирийн малчин, олон партизан ах нар хэрхэн амь алдсан тухай, одоо дайсанд гарахгүй болтлоо бүслэгдээд байгаа тухай нэгд нэгэнгүй ярьж:

-Чиний аавыг чинь ч хүртэл ийм болтол нь шархдуулсан тэр аймшигт дайсныг л дарахад ар тийш ангидаа хэл мэдээ өгөх хэрэгтэй. Тэр хэл мэдээг хүргэхэд чи оролцох ёстой боллоо шүү дээ. Чамайг жаахан учраас дайсан тоохгүй. Чи зоригтой учраас дайсны дундуур зүсэн гарч ар тийш нь манай бичгийг хүргэж гавьяа байгуул! гэв.

Баатар энэ хариуцлагатай том явдлаас айсан ч юм шиг, эсвэл хийхсэн гэж тэсэж ядсан ч юм шиг дув дуугүй хэсэг зогсов.

-Тэгье, би явья! гэж хэлээд дайсан намайг алчихвал яана гэж бодоход хацрыг нь даган нулимс өөрийн эрхгүй бөмбөрөв. Ээж нь Баатарын дэргэд ирж, түүний толгойг цээжиндээ наагаад:

-Битгий уйл. Партизан хүний хүү зоригтой байх ёстой. Миний хүү зоригтой хүү. Аав шигээ зоригтой хүү! гэж ээж нь түүний хацар дээр нь үнсэв.

Баатар аавынхаа дэргэд очив. Аав нь миний хүү эцгийнхээ нэрийг хугалах нь уу, өргөх нь үү? гэсэн шиг тэгтлээ удаан ажиглан хараад уртаар санаа алдсанаа хэлэх үгээ нухацтай зөөлнөөр эхэлж:

-За чи тэгээд яах гэж бодож байна? гэж асуув. Баатар "явна" гэж бодсон ч үгүй хариулснаа:

-Аав аа? Би өөрийнхөө оодон хээр мориор явах уу? гэж шийдтэй байртай асуув.

-Тэг тэг. Бас өөрийгөө хамгаалах зэвсэг юутай билээ дээ? гэж аав нь хэлэв.

-Чавхаа аваад явья гэж Баатарын яаран хэлсэнд партизанууд бүгд нирхийтэл инээлдэв.

-Миний хүү ёстой тийм л байх хэрэгтэй! гэснээ аав нь босож:

-Бид чамд явах газрыг чинь сайн зааж өгье. Харин энэ бичиг бол хамгийн чухал бичиг шүү! Чи үүнийг хамгийнхаа найдвартай газар хадгалах хэрэгтэй. Хэрэв дайсанд мэдэгдэхэд хүрвэл энэ бичгийг ямар ч байсан үгүй хийх хэрэгтэй! гэж бичгийг өгөхөд хүү түүнийг тосож аваад цамцныхаа цаана сугандаа лав шургуулж бүсээ ороон хоёр үзүүрийг өмнөө зангидав.

Тэр даруй ээж нь тэрхүү бичгийг Баатарын цамцанд даавууны завсар хийж оёж өглөө. Одоо яагаад ч гэсэн тэр өврөөс сугарч хаягдахгүй болжээ.

Баатар агуйгаас гарч гэртээ давхиж хүрээд эр хүн алс газар явахад юу хэрэгтэй байдаг вэ, тэр бүгдийг бэлтгэв. Түүний дотор юуны өмнө өөрийгөө хамгаална гэж бодож олсон резин татгуургатай хус модон чавх, бас сүрхий гэгч ирлэсэн хадаас зэрэг зүйл багтжээ. Замдаа хүнс болохоор хэдэн ааруул боож аавынхаа авчирч өгсөн эрхэм нандин нэгэн улаан таван хошуу тэмдгийг өвөртлөв. Энэ тэмдэг бол аавынх нь найз нэг орос цэргийн малгайны таван хошуу бөгөөд аавд нь бэлэглэсэн юмсанжээ. Баатар чавхаа байн байн татаж сунгаж үзнэ. Бас ч мэргэн хараатай буюу алдах онохыг шалгахаар яг буу шиг шагайн үзсэний эцэст одоо дайсан ирэхэд ямар ч болсон айлтгүй гэж дотроо итгэв.

-Хүүгээ явуулах гэдэг маш бэрх ажил. Гэвч ингэхгүйгээр бид энэ удаа болохгүй боллоо гэж Зоригт гуай ээжийг нь аргадан зоригжуулж байлаа. Энэ үед цовоо дуу хангинасан нь:

-Отрядын даргад! Явахад бэлэн боллоо гэлээ.

Цөм эргэн харвал Баатар зогсож байна. Тэр хүү бүсэндээ чавхаа нум сум шиг агсан хутганы ширэн гэрний дотор өнөөх хадаасаа хийж хуйны нь үзүүрийг бүснээс горхидон татсан нь яах аргагүй "баатар" болох гэсэн мэт харагдсан тул бүгд тэсэж А чадалгүй инээлдэв. Отрядын дарга: /

-Номхон! гэж Баатарт команд өгөв. Аав нь Баатарын хацрыг зөөлнөөр үнсэж:

-Миний хүү хэргээ бүтээгээд яваад ирээрэй! гэж гар барин бүсэн дэх өнөөх мундаг зэр зэвсэгнээс хүн хар санаа авуузай гэж чавхыг даруй авч өвөрт нь хийж өгөв. Хүү ээждээ үнсүүлээд гадагш гүйж гаран мориндоо мордоод хуй салхи мэт хурдлан одсонд аав, ээж хоёр нь золбоотой хүүгээ далд орон ортол нь харж нөхдийнхөө хамт үдэв.

3.Оодон хээр

Тэндээс Баатар морины хурдаар өнөөх хадтай уулыг тойрон давхив. Намар цагийн алтархаг шар өнгөтэй гандуу тал дундуур ийнхүү довтолгон явах нь сэтгэлд таатай зориг сэргэнэ.



Хот айлуудын ноход хоёр гурваараа харван ирж боргоох боловч хүүгийн унасан оодон хээр морь шандас сайтай тул чихээ хулмайлган урагшаа довтолж, түүний цомбон туурайны ирээр чулуу үсрэн тоос дэгдээнэ. Хүнд морь гэгч салшгүй хань билээ. Түүний дотроос Баатарын хар багаас бүр ижил дасал болсон унахад номхон, оодон сүүлтэй энэ хээр морь бол гайхалтай хүлэг юмсанжээ.

Түүний хүрэн даалимбан дээлийнх нь хормой салхинд хийсэж, дөрөөн дээрээ босоо явахад сэтгэлд нь бахтай. Баатар морины амыг татан "морио хайрлаж яв" гэж аавынхаа хэлснийг дотроо бодож:

-Аав морио мэдэж яв гэсэн, бас ч явах зам хол, очих морь ганц! гэж бодов. Олон адуу туусан дайсны цэрэг явах нь нүдэнд хорсолтой санагдах тул:

-Манай нутгийн ард олны хамаг юмыг булаасан чамайг даа! гэж өөрийн эрхгүй шивнээд гараа зангидана.

Нэг харвал, адуу туусан хэдээс цагааны хоёр цэрэг тасран давхиж явав. Одоо тэдэнтэй Баатар уулзах буюу эсвэл зугтаан одох яахыг ч сайн мэдэхгүй тээнэгэлзэв. Баатарын нүдэнд адууны цаахна хэдэн тэмээ харагдах нь санаа авахуулсан тул тэр зүг морио залан давхиваас удсан ч үгүй хажууд дөрөө хангинаж цэргийн хоёр хүн давхин иржээ.

-И мальчик... күлээх хэрэгтэй... мэднээ! гэж орос монгол үг холин хэлээд нэг нь морийг цулбуурдан авав.

Нөгөө нь монгол хэлтэйг бодвол буриад буюу нэгэн монгол үндэсний хүн байсан бөгөөд нялганасан сайхан зан гаргаж:

-Миний дүү хаачих нь бэ? гэж асуусанд Баатар түгдрэлгүй урьд бодож олсон аргаа санаж:

-Би тэмээгээ аваачна гэж хариулав.

-Чи хэний хүүхэд вэ?

-Аавын хүүхэд.

-Уухай аав чинь хэн бэ?

-Донров? гэж Баатар худлаа хэлээд хэлээ хазав.

-Чи өвөртөө юу хийсэн юм бэ?

-Чавх.

-Чавхаар чи юу хийдэг юм бэ?

-Үүгээр зурам юмуу оготнын алиныг ч харваж алж болно.

-Уухай чи олныг алсан уу?

-Хулгана дөрвийг алсан. /

Баатарыг тэр хоёр буулган юм бүхнийг нэгжиж эхлэв. Орос

цэрэг нь өврийг нь ухаж ухаж хэдэн ааруулыг нь гаргаад: -Оо! гэж дуу алдсанд Баатар гараас нь ааруулыг нь авснаа

гурван хэсэг болгон тэгш хувааж өгөөд өөрөө бусдыг өвөртлөв.

Энэ нь тэр хоёрын санаанд тохирсон бололтой. Тэр даруй

бүсийг эргүүлэн өгч:

-Тэмээгээ аваад бушуу харь. Ийшээгээ ганц ч алхам газар

явуулахгүй шүү ! гэжээ.

Баатар мордон исгэрсээр тэдгээр сүрэг тэмээний зүг явж

өглөө. Харин нөгөө хоёр өлөн цэрэг Баатарын өврөөс авсан

ааруулаа амтархан идэхээр сууж үлдэв.

* * *

Баатар тэмээнүүдийг тусаар нэгэн хөтөл давмагц дайсны цэргийн хоёр харуулын дунд орчихов. Одоо зөвхөн эргэж буцахаас л өөр замгүй бөгөөд хэрэв буцвал гэртээ харихаас өөр аргагүй байжээ.

Морь унаж хөтлийн наана цаана хоёр явж буй эдгээр дайснуудыг хуурч тэр хоёрын хоорондуур гарвал ажил хэрэг бүтэхийг бодож Баатар дотроо "Үүгээр нэгэнт гарч чадвал цааш аавын хэлснээр уудам хөндийг уруудаж нэгэн модтой уулын давна. Тэгвэл чөлөөтэй болно" гэж бодов.

Тэр хоёрын дундуур шууд давхин гарвал болох боловч бас ч бууны суманд өртөгдөж мэдэх байсан тул ямар боловч шөнийг хүлээхээр шийдлээ.

Баатар тэмээнүүдийг хөөж цэргүүдийн дэргэдүүр элдсээр гарав. Ингэхдээ шөнө гарч болох аятайхан замыг шилэн олохын тул сайтар харж тагнаж авлаа.

"Шөнө болгож байгаад тэмээнүүдийг энэ жалга өгсүүлэн тууж тэр хөтөл өөд гаргана. Дайснууд тэмээг анхаарах бий. Тэр үеэр нь би өөрөө нөгөө талаар тэр жалгыг өгсөн гарч энэ хөтлөөр даваад зугтъя" гэж бодсон ажээ. /

Тэмээгээ хөөсөөр хөтлийг даван одоход нар баруун тийш гудайж хөтөл дээрээс харахад өөрийн нь гэрийн ойролцоох том уул нэлээдгүй хол сүндэрлэн цэнхэрлэн харагдана. Баатар тэмээнүүдийг тууж нэгэн гүнзгий жалган оруулаад өөрөө өвсний сондуул түшин хэвтэж морио хэд хазуулах гэж өвсөнд тавив.

Удсан ч үгүй нар шингэж түүний эцсийн шар туяа зүүн уулын оройд тусаад арилсанд бүрэнхий харанхуй залгав. Баатар босож, мориндоо мордоод тэмээнүүдийг шавхчин хөөсөөр өдрийн ирсэн замаар буцав. Өнөөх жалгыг өгсөн хөтлийн хажуу өөд гартал буун дуу тасхийн толгой дээгүүр сум шунгинав.

-Одоо болно!... гэж Баатар өөртөө хэлээд мориндоо ташуур өгч жалга уруу ороод түүгээр өгсөж давхисаар нэгэн хөтлийг давж цааш мориныхоо хурдаар давхилаа.

Нэлээд явснаа сая "Одоо хэрэг бүтлээ" гэж бодож мориныхоо амыг таттал гэнэт тэртээгээс хоёр юм сүүдэгнэн ойртох шиг болсонд Баатар айсандаа морио шавхуурдан "өөрөө мэдэг" гэж зугтаав. Тэр нь дайсны өнөө нэг эргүүл байсан байгаад бодвол бууны чимээгээр хөтөлд явдал болж байгааг сонсож мэдээд тэдэнд туслахаар явж байсан тэр биз.

Баатар мориндоо ташуур өгөв. Оодон хээр улам улам хурдлан давхиж нэг мэдэхнээ тэр хоёрыг ор сураггүй хол орхижээ. Одоо зогсож чимээг чагнавал юу ч дуулдсангүй. Харин тэртээ алсад буун дууны бүдэгхэн чимээ сонсогдоно. Баатар баярлаж мориныхоо хүзүүг илж:

-Ай даа оодон хээр минь, би чиний хүчээр аврагдлаа шүү ! гэж сэтгэл хөдлөнгүйгээр шивнэв.

4.Бүтэлгүй жаал

Харанхуйд тал дундуур давхихад хүйтэн салхи исгэрэн жихүүцүүлнэ. Тэр шөнийн турш яваад харанхуйд хаана яваагаа ч мэдэхгүй болов. Зам нь нэг өгсөж, уруудаж модонд тулж, голд орж явлаа. Энэ нь зүгээ мэдэхгүй толгой хандсан зүг явж байгаадаа л ийм байжээ. Үүр цайсан хойно ийш тийш харвал ер таньж мэдэх газар огт биш. Модтой том уул дайралдана гэсэн нь одоо үзвэл юун модтой уултай мантай толгод ч байхгүй шахам нүцгэн тал газар хүрч ирсэн явж байв. Ийш тийшээ сайн харвал нар чанх хойноос гарч байх бөгөөд талын зам алсын цэнхэр уулсыг чиглэжээ. "Төөрчээ" гэдэг аюулт бодол Баатарын толгойд хоромхон зуур орж ирэхэд хоёр хацрыг нь даган нулимс өөрийн эрхгүй урсав.

"Одоо өнгөрчээ, хувьсгалт цэргийн ангид захиагаа хүргэж өгч чадахгүй бол яана!" Би ингэж яваад энэ эзгүй газар үхвэл яана!" гэж бодно. Гэвч,

-Миний хүү зоригтой хүү шүү ! гэж аавын нь хэлсэн үг гэнэт санагдав. Баатар хэдийгээр ядарч сульдаад царай нь улам цонхийж морин дээрээ гуйвж байвч шүдээ зуун тэсвэрлэв.

Тэгээд Баатар цааш гэлдрүүлэв. Нэрийг үл мэдэх олон хөтөл давааг хойноо үлдээн хатируулав. Өлсөж ундаасах нь бэрх болов.

Өвөр түрийгээ тэмтчин өнөөх ааруулын хог байж юу магад гэж горьдон эрсэн боловч юу байх билээ дээ. Морь ч гэсэн цог золбоо нь буурч толгойгоо унжуулжээ. Одоо түүнд ер сайн юм юу ч үгүй, сайн нь гэвэл дайсныг ганц мундаг, ёстой партизан шиг хуурч давхин гарчээ.

Нэгэн хөтлийг даван цааш уруудтал сайхан тунгалаг устай булаг дайралджээ. Тэнд бууж морио усан өөрөө ч залгилахад духанд нь хүйтэн хөлс дааварлав.

Өлсөхийн эрхэнд янз бүрийн өвс таслан амандаа хийж том томоор зажлан идэж үзвэл тэд бүгд гашуун амттай хоолой хорсгох тул "түй" гэж нулимав.

"За ямар ч атугай урагшаа яваад л байя" гэж Баатар бодоод мориндоо мордон сажлуулсаар нэгэн хошуу тойров. Намхан г дов толгодтой энэ талархаг газрын гүвээнүүд алсын алс хүртэл үргэлжилжээ.

Тэндээс Баатар хоёр хөтөл давсны хойно хэсэг морьтой хүний бараа харлаа. Тэд Баатарыг харж нааш давхихыг нь үзвээс яах аргагүй дайсны цэрэг мөн. Морио эргүүлэн зугтъя гэвч хожимджээ. Хэдэн орос хүн бүслэн ирж хоромхон зуур хүүг мориноос буулган аманд нь алчуур чихэв. Баатарыг морин дээр шуудайтай мах шиг тэгнээд оодон хээрийг нэг нь унаж даруй давхин оджээ. Тэд нэг жижиг хөндий өгсөөд тунгалаг устай өргөн голын эрэг дээр ирэв.

Энд мориноос буун нүүр гарыг угааж хэсэг амарсны дараа цааш явлаа. Үдэш болохын үед тал дахь нэг том дугана уруу чиглэн очлоо. Энэ дугана тал нутаг дунд ганцаар харагдах бөгөөд эргэн тойронд нь цэргийн майхнуудыг барьж цагаантнууд нааш цаш сүлжилдэнэ. Дуганы орой, түүний алтан ганжир нь оройн наранд өнгөтэйгээ гялбалзана.

Энд хүрмэгц даруй бууцгааж их олз олсноо даргадаа илтгэхээр нэг нь гүйн одов. Удсангүй мөрөн дээрээ алтан саатай бүдүүн буурал орос дээр Баатарыг аваачив. Буурал орос сүртэй догшин цэнхэр нүдээр хүүг өрөмдөх мэт хараад хажуудахдаа нэг юм хэлэв. Өнөөх цэрэг Баатарыг тууж сүмийн харанхуй буланд хорив. Үдэш өнөөх цэрэг даргынхаа тасалгаанд туун оруулжээ.

Энд намхан нуруутай ихэмсэг гэгч монгол ноён сууж байна. Тэрбээр инээд алдан:

-Үгүй ер! Эднүүдийн авчирсан нөгөөх сүрхий тагнуул гээд байсан нь энэ үү дээ! гэснээ царайгаа хувилган:

-Чи хаана очих гэж яваа хүн бэ хө? гэж асуусанд Баатар ноёны өмнө сөхрөн унаж:

-Ах аа, би төөрсөн... Би... би... намайг явуулаач дээ. Би Баянхайрхан хүрэх гэсэн юм гэж уйлагнав.

-Юуны чинь Баянхайрхан бэ?

-Үгүй ээ аав тэгж хэлсэн... намайг явуулаач дээ гээд Баатар / мөлхсөөр ноёны бараг дэргэд нь очиж уйлан гуйсанд:

-Наадахаа нэгжсэн биз? Ийм турсаганууд их учиртай шүү. Холдуул! гэж ноёнтон уурлав.

Хоёр цэрэг ухасхийн Баатарыг нэгжив. Баатар сугаа тас хавчин чичирсээр зогсов. Тэдний нэг нь азаар сэжигч хүн байсан тул ярвайж зөвхөн хурууны үзүүрээр ингэс тэгэсхийж нэгжсэн дүр үзүүлээд:

-Эзэн ноёнтоон, үүнээс бөөс ч үл олдоно гэж ухрав. Баатарыг нэгэн цэрэг тууж өнөө гяндан тийш явлаа. Бичгийг нь дайсан мэдсэнгүйд Баатар дотроо их л баярлажээ.

Тэднийг гарсан хойно ноёны түшмэл:

-Эзэн ноёнтоон! Саяын хүүхэд Баянхайрхан уулыг асуусан нь учиртай байж магадгүй шүү.

-За, юуны учир байх билээ?

-Жа! Баянхайрхан ууланд өнөөх урвасан хулгай ардын цэргийнхэн бий гэж Гаврил ноёнтон өчигдөр айлтгасан билээ. гэж түшмэл доош тонгойн ёсолжээ.

-Уухай! гэж ноён хоолой засан:

-Түүнийг нааш нь даруй дууд! гэж үүдэнд зогссон цэрэг тийш хашгирав.

5. Чи жэлнэ үү, үгүй юу!

Баатар ноёны өмнө очиж зогсов. Ноён түүнээс үг дуулах гэж: -За хоёул тохитой тухтай ярья гэж их л сайн зан гаргаж алга

ташсанд зарц түүний өмнө идэх юм өгөв.

Түүний дотор Баатарын хамгийн их дуртай хайлмаг, бас айраг байжээ. Өлөн хоосон яваа жаал хүү эдгээр амттан зуушийг хармагц өөрийн эрхгүй хорхой нь хүрч тэсэж чадахаа больжээ.

Ноён хашрын хувиар учрыг мэдэж:

-Хүү чи чухам ямар хэргээр Баянхайрхан хүрэхээр яваа билээ? Үнэнээ нуулгүй хэл хүү минь. Хэрэв үнэнээ хэлбэл чамд г идэх уух юмыг харамгүй өгч, бас чиний оодон сүүлт морин дээр бас нэг морь нэмж Баянхайрханд хүргэж өгнө гэсэнд энэ сайн үг Баатарын толгой дотор нар мандах адил гэрэлтэж эелдэг зантай энэ буурал өвгөнд хамаг учраа хэлээд идэх юм дураараа идье гэж шийдсэн боловч яг ам нээн дуугарахын даваан дээр аав нь: "Чи энэ учрыг өөр хэнд ч болов задруулан ярьж болохгүй шүү. Хэрэв тэгвэл чи аав ээжээ, ах нараа муу дайсанд барьж өгнө шүү" гэж хэлсэн санаанд нь орж хэлээ тас хазан зогсов.

Ноён, хүүгийн ийнхүү тэсэж ядан буйг мэдэн дотроо бодсон нь:

"Энэ лав урвасан хулгай нарын явуулсан амьд захиа биз. Бас ч үүнээс нэгжиж юм олсонгүй нь миний бодсонтой яв цав нийлэв. Энэ олон хоног явж их өлссөн мэт бөгөөд даруй хоол өгөхөөр шахвал үгээ хэлж юуны магад".

-За чи хэлэх үү, үгүй юу? гэж зандраад ноён халбага авч хайлмагнаас том томоор үмхлэн тамшаалж гарсанд хүүгийн ходоод тэсэж болшгүй болж түүний тархин дотор "Хэлчих!", "Байг" гэсэн хоёр үг зөрөлдөн байв. Эцэстээ их тэсвэр зоригийг гарган сүүлчийн үгийг амандаа шивэгнэсэн бөгөөд идэх юм уруу харахыг больж өөр зүг харж шүдээ зуув.

-Чи хэний хүүхэд вэ?

-Аавын хүүхэд.

-Аав чинь хэн бэ?

-Донров гэдэг...

-Тэр одоо хаана бий вэ?

-Модтой уулын цаана.

-Чи Баянхайрхан хүрч яана?

-Эгчдээ золгоно.

-Худал бүү хэл! Задарсан турсага! гэж ноён хашгирав.

Тэр даруй ташуур шүүрэн авч Баатарын нүүр уруу ороолгосонд ташуурын сурны аяар хорсож улаан мөр үлдэв. Баатар хингэнэтэл уйлах бөгөөд үүний дотор худлаа уйлах авиа ч их бий. Хамгийн сайн нь түүнийг дахин нэгжсэнгүй тул өнөөх А бичиг суганд нь хавчаатай байв. /



Баатарыг ноён хөдөлж чадахгүй болтол нь зодов. Эхэндээ ухаантай байсан боловч эцэстээ ташуурын сурны дуу "хэлнэ үү, үгүй юу" гэж ноёны хашгирах үг хоёр л ээлжлэн сонсогдсоор бүдгэрэн ухаан алдан чимээ тасрав. Хээрээс идэш олсон чоно мэт ноён уухилан зогсох бөгөөд тэр даруй нэг нь Баатарыг чирэн гаргаад сүмийн хашаан дотор хаяжээ.

.. Шөнө хүйтэн салхи үлээж хүүг сэрээв. Баатар унтаж унтаж сэрсэн мэт санагдана. Ямар боловч түүний дээр үй түймэн одод жирвэгнэн тэдгээр оддын гялалзах гэрэл Баатарыг элэглэх мэт харагдана.

Бүх бие нь хөндүүрлэн хөдлөхөд ч хэцүү. Түүний ойр хавьцаа морьд үүрсэх нь дайсны цэргийн агтны хашааны нэгэн булан бололтой. Хүү өндийж ойрхон харагдах хашаа уруу тэмтчин хүрээд түүнийг түшин, уяатай морьдын дэргэд очоод харвал хашаанаас хэдэн морь уясан байв.

Тэдгээрийн захад алаг зүстэй, том биетэй морь хамраа дуугарган зогсоно. Баатар түүн уруу ойртон үзвэл тэр улам үргэн газар цавчилснаа хүний үнэр авч зөөлөн чимээгүй үүрсэв. Баатар цулбуурыг тайлан зайдан морин дээр үсрэн мордов.

Тэр морь ам нь дийлдэхгүй авч шуугижээ. Хашааны сургааганд тулан буцаад хашаан дотуур хий баахан давхихад морьд г хамраа дуугарган хөдөлцгөөв. Гэтэл Баатарын унасан сургуультай морь хашаан дээгүүр харайн гараад тал уруу нисэх мэт давхин одов.

Ард буун дуу тасхийж олон хүн шуугилдаж гарлаа. Чимээ холдоход Баатар мориныхоо дэлээс зууран түүний өтгөн үстэй дэлэнд нүүрээ наахад морь салхи шиг довтлон оджээ. Тэндээс Баатар шөнөжин давхисаар үүр цайлгаж нэг өндөр толгой дээр гарч харлаа. Доошоо уруудан одсон нэг том хөндийд хээр хоносон адуу бэлчиж байхаас гадна жижиг хадны цаана өөвийсөн бор гэр харагдав.

"Тэнд очье. Идэх юм шууд гуйгаад үзье, яадаг юм бэ" гэж Баатар бодоод ухаагаас сажлуулан

бууж бор гэрийн гадаа хүрвэл хоточ нохой нь хуцсаар давхиж ирэв. Гэрээс таяг тулсан бөгтөр эмгэн гарч нохойг хорин, хүүг гэрт оруулав. Эдний баруун хойморт сууж гэр доторхийг ажиглавал ганц авдар, банзан ор төдийхөнтэй ядуу айл юм. Авдрын дээр бурхан тавиастай, өмнө зулын бүдэг гэрэл сүүмэлзэнэ. Эмгэн гэрт орж ирмэгц зайдан морьтой довтолгон ирсэн энэ хүү хэний хүү вэ гэсэн мэт ажиглан харснаа:

-Сайн уу, хүү минь! Нутаг хаана вэ? Аав чинь хэн бэ? гэж асуув.

-Нутаг Тахилтад, Аав Зоригт гэж Баатар хариулж -Эмээ надад идэх юм байвал өгнө үү? Би Баянхайрхан хүрэх гээд төөрөөд... гэж чин үнэнээ хэлэв.

6. Жижигхэн тагнуул

Дайсны агтны хашаан дотуур өглөө эртлэн боссон нэгэн цэрэг исгэрсээр алхалж явав. Тэр юм бүгдийг ажиглаж будаа тоншихоор гүйж яваа тахиа шиг бөхөлзөн явах бөгөөд исгэрч байгааг бодвол их л жаргалтай, гагцхүү гэдэс нь өлөн биш сэн бол ямар ч маргаангүй жаргалтай хүн гэж болох юмсанжээ. Тэр гэнэтхэн доош бөхийн газраас юм шүүрэн аваад нүднийхээ ойр А аваачин сайн ажиглан харснаа: /

-Цэрэг хүн ноён даргынхаа сайшаалыг хүлээн авах ямагт дуртай тул үүнийг даргадаа өгье. Энэ улаан цэргийн таван хошуу тэмдэг лав учиртай байна гэж бодоод гүйн одов. Ноён яг тэр үед морь алдсан цэргийг байцааж байв. Тэр цэрэг ноёны өмнө нулимс цувруулан уйлагнаж:

-Тэр үхсэн зулбадсыг сэхээд, тэгээд бас морь унаж зугтаана гэж хэн мэдлээ гэж гонгиноно.

-Энэ тэмдгийг агтны хашаан дотроос оллоо гэж өнөө цэргийг илтгэхэд ноён тэмдгийг шүүрэн авав.

Түүний алган дээр гал улаан таван хошуу тэмдэг гялалзан харагдана. Ноён тэмдгийг үзэж галзуурсан мэт уурлан цэргийг нударгаар цохин унагааж:

-Чи дайсанд унаа залгуулна гэнээ! Урвасан хулгайч! гэж сөөнгөтөн хашгирав.

Цэргийн байраар нэг шуугиан дэгдэж гарлаа. Дээд ноёд нь бага дарга нарыгаа, дарга нар нь цэргүүдээ загнан сүйд болцгоов. Дуганын гол танхимд Далайн ноён ямбатайгаар морилоход алтан саагаар эмжээрлэсэн погонтой цагааны цэргийн орос ноёд түүнийг хүндэтгэж угтаж яаралтай зөвлөж эхлэв.

-Тэгэхээр тэр этгээд яах аргагүй жижигхэн тагнуул байсан нь лавтай. Ухаан алдан унасан нь ч худал байж гэж нэг офицер ярвайн байж хэлэв. Нөгөө нь хундагатай архиа хүд хийтэл залгилж:

-Манай Далай ноён нэг гэнэдчих шиг боллоо гэж инээхэд ноён ёожлуулсандаа уурсан хацар нь үе үе татавсхийж:

-Ардын намынхны зулбадас нэн их аюултай. Мэдсэн бол тэр зулбадсыг эрлэгийн газар явуулдаг л байж. Хоёр гурав алгадахаар үхсэн мэт ухаан алдахад нь гадаа хаяулсан билээ гэнэ.

-Ноёд оо! Цаг нэн үнэтэй! Ямар ч атугай хойноос нь хүн явуулья.

Тэгэхгүй бол бас тэр тагнуул бидний байдлыг мэдэгдээд аюул болуужин гэж нэг нь санал гаргав.

Энэ үед Гаврил хэмээх нэгэн шөрөвгөр шар сахалтай бага дарга халамцуугаар бараг хашгирах шахам хэлсэн нь:

-Тэр зулбадсыг би зөвхөн чигчийгээрээ өрлөж ална. Олохдоо ч морь эцээхгүй олно.

Иймийн тулд би нэг цэрэг авч мордсугай! гэсэнд:

-Зүйтэй, Гаврил чи ухаан сайтай, зориг ихтэй тул явтугай. Бид түүнийг авчирсан хойно тойрч суугаад ил галд шарж үгийг нь хэлүүлнэ. Манай цагааныхан хүнийг яаж шууд байцаадгийг эрхэм Далай ноён мэдэг! гэсэнд бүгд инээлдэн ширээ сандлаа балбацгаав.

Хэдхэн мөчийн хойно өнөөх Гаврил, Баатарын оодон хээрийг унаж нэг цэргийн хамт давхин одлоо.

* * *

Баатар эмгэнийд тавтай хооллож бас ч бага зэрэг унтаж амрав. Эмгэн хүүгийн зүүдлэн буй царайг харж дотроо бодсон нь:

"Энэ хүү түүрүүхэн идэх юм гуйж бараг уйлах гэж байсан билээ. Ихэд өлссөнийг нь бодвол хэдэн өдөр хоолгүй явсных биз. Хөөрхий минь нүүр нүд нь хавдаж, хувцас хунар нь урагдаж шүү. Замдаа ноёныд баригдаж зодуур нүдүүр амсаж дээ. Тэр ноён ямар хүн шиг амьтан биш дээ. Нялх хүүхдийг боловч тарчлааж алаад инээж байх хүн. Эд ноёдууд цөм тийм улс. Унтаг даа хөөрхий. Баянхайрхан хүрэх гэж явааг бодвол лав ардын намынхантай уулзахаар эх эцэг нь явуулсан биз."

Удалгүй хүү сэргэж өндийв. Эмгэн цай чанаж өгөв. Үд өнгөрсний хойно хүү эмээгээр Баянхайрханыг сайтар заалгахад харин ч уул газар нь тун ойр болсон ажээ.

-Хөндийг уруудан тэр том уулын зүүн сугаар ороогоод нэлээд яваад бургастай гол өгсөнө гэж Баатар дотроо тэмдэглэж авав. Явахын үед бүсээ тайлан өвөртөө байгаа эд юмсыг бүртгэн үзвэл гагцхүү улаан таван хошуу тэмдэг нь байдаггүй. Хамаг л хувцас хунараа гүвж үзсэн боловч эс гарчээ. Түүнийг нэг л газар хаясан бололтой. /

-Хайран тэмдэг. Аав минь над өгсөн юмсан даа гэж Баатар харамсав. Тэгээд бичиг маань л байгаагаас хойш яахав гэж бодоод мориндоо мордон давхин одлоо. Нэгэн удаа эргэн харвал аюултай юм айсуй. Хойноос нь хоёр морьтой хүн хөөж явав. Баатар мориндоо ташуур өгөн урагшаа давхив. Оросууд нэг юм хэлж толгой дээгүүр нь харайсаар өнгөрнө. Нэгэн хошууг тойроод нөгөө нэг жалгыг өгсөөд давхиж одоход дайсан хойно нь бас нэлээдгүй ойртон ирж явна.

7.Ажиад уулзав

Баатар морь эцэж, явах хүч нь улам буурав. Дайсан саахалтын хэр явна. Урдах замаа харвал нэг их асгатай толгой байна. Тэр толгойг орвол хаана очдогийг хэн мэдэх билээ.

Гэтэл Баатар тэр толгойг ороогоод давхин өнгөрөхийн хэрд гэнэт морьтойгоо годройтон унав. Нүүрээрээ харуулдаж унаад хамаг л хацар амаа шалбалсан боловч чухам дайсны сум оносон эсэхийг ч үл мэднэ.

Биеэ тэмтрэн үзвэл оносон газаргүй мэт. Босож морио харвал морь нь хэдийн үхэж байв. Хөөрхий түүнийг дайсны сум оножээ. Эргэж харвал өнөөдүүл саахалтын хэрийн газраас хар хурдаараа айсуй.

Яах вэ? гэж нэг хэсэг тээнэгэлзсэний эцэст хажуудаа байгаа хадтай толгой өөд хөл мэдэн гүйв. Явах тутам амьсгаа давхцан гүйж үл болно. Гэтэл асганы эгц нь дэндүү. Хаданд авирч мацаж явахдаа хад чулуунд өвдөг тохойгоо шалбалжээ. Ухаангүй шахам өөдөө зүтгэсээр хураасан мэт хадан дундуур мацсаар нэг эргэж харав. Өнөө хоёр үхсэн морины дэргэд ирж буугаад нааш явган гүйлдэж байна.

Тэдний яваа газар тэр дор байсан тул хадан хананы бараг оройд нь гарсан Баатарын нүд эрээлжлэн толгой эргэнэ. Дайсан ганц ч буудахгүй байгаа нь заавал түүнийг амьдаар баривчилна гэж санасных биз. Баатар цаашаа улам авирав. Явах тутам бүр г өндөрсөж өнөөх хад авирахад бэрх, гишгэхэд зовлонтой болов.

Гэтэл удахгүй буудаж гарлаа. Баатар дийлэх чулуугаа өнхрүүлж эхлэв. Тэдгээр нь асга уруу өнхрөн орохдоо өөр бусад чулуунуудыг хамж, бөөн тоос шороо доош унахаар оросууд хадны ард хориглохоос өөр аргагүй болов. Гэвч хориглохдоо буудсаар байна. Баатар нэгэн том хадны ард нуугдан ийнхүү баахан чулуу өнхрүүлснээ нэгэн мэргэн арга олов. Тэр дайсныг малгайгаараа хуурах болов? Баатар малгайгаа жижиг хадан дээр дөнгөж цухуйлгасан сум улам ширүүсэж эхлэв. Баатар өөр хадан дээр малгайгаа орхиод өөрөө жижигхэн тул нуугдан мөлхсөөр холдов. Дайсан сэжиг авсангүй өнөөх малгай уруу буудсаар л байна. Баатар цааш мөлхсөөр толгойн ар уруу орж гүйсээр хошуу ороов. Дайсан Баатарыг чулуу өнхрүүлэхгүй байгаад зоригжсон бололтой буудсаар огтхон ч сэжиг авалгүй өнөөх малгай уруу давшиж эхлэв. Баатар баярлан сэмээрхэн гүйж морьд дээр ирээд оодон бор дээрээ үсрэн мордож, нөгөөг хөтлөөд давхин одов. Тэгэхэд сая дайсан мэдэж хойноос нь галзуурсан мэт буудаж гарлаа. Гэвч Баатар холдсоор бараа тасрав.

Баатар оодон хээр мориныхоо хүзүүг илбэн түүний дэлэнд нүүрээ наагаад:

-Ээ дээ, оодон хээр минь! Чи бид хоёр дахиад уулзлаа гэж баярлан хэлээд эргэж харан харсаар явлаа.

8.Хэнийжэн бэ?

Тэндээс Баатар эмгэний зааснаар хөндийг уруудаад аль хэдийн алсаас харагдсан цаст Баянхайрхан ууланд тулж ирэхэд нэгэнт айл амьтан ч үзэгдэх болов. Гүехэн устай голыг өгсөн бургасан шугуйн дундуур довтлон одов. Нэлээд явсны эцэст гэнэт хажуунаас "Зогс!" гэсээр хоёр гурван морьтой орос цэрэг нэг монгол хүний хамт гарч ирэн морины хоёр талаар ороон зогсов.

-Чамд ийшээ явах ямар хэрэг байна? гэж монгол гуталтай, А ширвээ сахалтай намхан хар хүн асуухад Баатар сэжиглэсэн / байртай эд ер нь ямар улс вэ гэсэн мэт тэднийг ажиж сайн харснаа:

-Энэ хэнийхэн бэ? гэж асуув. Тэгж асуусан ч бас хашир догийг илтгэх аж.

-Ардын намын отряд! гэж монгол хүн хариулав. Энэ үгийг сонссон Баатарын сэтгэлд нар мандаж өөрийн эрхгүй баярлан инээмсэглэхэд өнөөх хэдэн хүн мэл гайхан, юу боловч цэргийн ёс дэглэмийг бодож отрядын даргад хүргэв.

Угалз хээгээр чимэглэсэн гандсан өнгөтэй цэнхэр майхны дотор гар буу зүүсэн булиа эр сууна. Хамаг хувцас нь ноорч, нүүр нь шалбарсан жаал хүү тийш тэр их сонирхсон байдалтай харж инээмсэглэнэ.

-Чи хаанаас яваа вэ? гэж асуухад

-Би Тахилтын тэндээс анх гарсан гэж Баатар хариулав.

-Уухай тэгвэл чи хаана очих гээ вэ?

-Би отрядын хамгийн том даргатай уулзах ёстой.

-За тэгвэл хэргээ хэл! Би тэр хүн чинь байна.

-Худлаа. Аав хэлэхдээ намхан нуруутай сайхан зантай хүн бий гэсэн.

-Үгүй ер нь би намхан нуруугүй, сайхан зангүй байна уу? гэсэнд Баатар инээж:

-Сайхан зантай нь ч, сайхан зантай л юм байна л даа гээд:

-Ах аа би маш чухал ажилтай яваа хүн. Намайг тийш нь оруулж өгөөч дээ гэж гуйв. Тэр хүн хэсэг бодсоноо бичиг таталган бичиж гадаанаас Бат гэдэг цэргийг дуудаад:

-“Үүнийг отрядын даргад хүргэж өг!” гэж тушаав. Залуухан тэр цэрэг олон майхнуудын дундуур Баатарыг дагуулан явав. Майхан бүхэнд хөгжөөнтэй бас л майхнуудын тэртээ урд хэдэн хүн сургууль хийж жагсаж явна.

Эд бүгд сэтгэл хөдөлгөнө. Аавынхаа хэлснийг биелүүлж, өөрийн отряд дунд алхаж яваагаа

бодоход энэ ертөнцийн хамаг л сайн сайхныг үзэж яваа мэт санагдана. Гэтэл бас "Даргатай нь уулзахдаа хэрхэн уулзах билээ" гэхээс зүрх нь түг түг цохилж шалбарсан духны нь дээр хөлс чийхарна. Нэг жижиг майханд орвол хэдэн хүн бөхийн сууцгааж юм ярьж байх нь ертаних г хүн үл үзэгдэнэ.

Бат нэг хүний өмнө ёслон:

-Энэ хүү тантай уулзана! гэсэнд намхан нуруутай тэр хүн босож Баатарыг хүүхэд гэлгүйгээр гар барин:

-За чи хэнтэй уулзах гэж хаанаас ирсэн хүү вэ? Энэ хүүд цай унд өгсөн үү? гэж цэрэгт хэлэв.

-Байлдааны нууц бичиг хүргэ! гэж намайг явуулсан юм гэж Баатар цовоо дуугаар хариулав.

-Үгүй ер, цовоо эр юмаа! гэж тэр хүн хэлээд:

-За суу суу гэв.

-Отрядын дарга нь та мөн биз? Бум гуай мөн биз? гэж Баатарыг асуусанд бүгд инээлдэж:

-Мөн мөн. За хэлэх үгээ хэл! Чиний аав хэн гэгч вэ?

-Зоригт гэгч хүн бий.

-Зоригт ий? гэж их дарга хэлснээ:

-За аль вэ, тэр бичгээ. Тэд яасан бэ? Юу болсон бэ? гэж асуулаа. Баатар дээлээ тайлан цамцнаас өнөө оёсон даавууг шүдээрээ хазан, ханз татан бичгийг даргын өмнө тавив. Дарга бичгийг хоромхон зуур уншаад босож -За Бат чи энэ хүүхдийг цэргийн гал тогооны газар аваачиж хоол идүүлнэ. Орой энд ирж надтай ярилцаарай, яв даа гээд эргэж:

-За нөхөд өө! Тахилт уруу яравчлан явах хэрэгтэй боллоо. Тэнд манай шилдэг отрядын нэг хэсэг дайсны ширүүн хүчтэй тулгарчээ гэв.

9. Сайн жүн

Орой нь Баатар даргын майханд очив. Тэрээр отрядын дарга нарт хэрхэн ирсэн, дайсанд хэрхэн баригдсан ба хэрхэн зугтан одсоноо нэгд нэгэнгүй ярьсанд бүгд инээлдэн сайшааж, Бум дарга:

-Зоригтой хүү, ёстой зоригтой хүү. Манай олон партизан Ат цэргүүд бас ийм зоригтой бөгөөд чи ч гэсэн энэ өдрөөс эхлэн / бас партизан боллоо гэлээ.

-Чи сургуульд орох дуртай юу? Одоо ардын засаг сургууль байгуулж байна. Түүнд олон мянган чам шиг сайн хүүхдийг суулгаж байгаа гэсэнд "сургууль" гэхийг Баатар сайн ойлгохгүй гүнээ их бодлогошров.

-Сургууль гэдэг чинь сүм дугана уу? Эсвэл монгол ном заадаг өөр юм уу? Ер нь ямар юм байдаг юм бэ? гэж Баатар ихэд сонирхож лавлавал:

-Ном үзнэ. Тэнд ном үзэж түмэн ард эрдмийн шимийг хүртэнэ гэж Бум гуай хариулав.

-Сургууль гэдэг чинь "бурхны" ном үздэг юм биш биз? гэсэнд бүгдээр инээлдэж Бум гуай:

-Яалаа гэж дээ. Тэнд ардын намын ач тус хийгээд бас манай Монголыг цаашид хэрхэн хөгжүүлэх зэрэг янз бүрийн эрдмийг сурна.

-Тийм бол би орноо гэж Баатар хариулав.

Гадаа бүрэн дуу тасхийж партизан цэргүүд жагсаалд гарав. Бум даргын хажууд Баатар бас дарга мэт ихэмсэг явав.

Олон партизан цэрэг өнөөх асруудын өмнүүр жагсан өнгөрч давхив.

Баатар газарчлан дайсны тал дахь сүм, бас Тахилт хүрэх замыг заав. Жагсаалын түрүүнд туг намилзан: "Шивээ хиагтыг авахад Шилэн дэнлүү хэрэггүй Шийдээд ирсэн гаминг

Ширмэн бөмбөгөөр сөнөөнө" гэж нэг нь хүчирхэг бүдүүн хоолойгоор аялж бүх отряд үүнийг түрэн дуулж явлаа. Баатараас дарга элдвийг асууна.

-Танай нутгийн олон малчин ардын хүүхдийн ямар амьдралтай вэ? гэж сонирхно.

-Хэрэв тэнд дайсангүй байсан бол хүүхдүүд цөм сайхан байхсан. Тэр ч битгий хэл, хайрт ээж аавтайгаа хамт нэгэн дор г амьдрах ёстойсон гэж Бум гуай Баатарт ярьж өглөө.

Тэд тал дахь сүмд дайран ороод дайснуудыг хиар цохиж устгав.

Баатарыг байцааж байсан ноёныг амьдаар олзлон барилаа. Тэр ноён Баатарын өмнө сөгдөн:

-Амь өршөө! гэж гуйсанд Баатар ташаа тулан ихэмсгээр алхлан Бум дарга тийш явж одлоо.

Бум дарга дайсны үүр болсон энэ газрыг зааж бас гавьяа байгуулсныг сайшаан Баатарт гар буу бэлэглээд:

-Чи бол манай партизан цэргийн хамгийн залуу нь. Их үйл хэрэгт идэвхтэй оролцсон тул шагная. Зоригтой байлдаж ахиад гавьяа байгуулаарай! Харин бид чамайг хамгаалалдаа авч явна. Чи бол үнэхээр бага балчир хүү шүү дээ гээд

-Ер нь чи ямар зэвсэгтэй хүн бэ? гэж сонирхсонд Баатар өврөө ухаж ухаж өнөөх чавхаа гаргаж харуулаад буцааж өвөртлөв.

-Би үүгээр оготно алсан боловч харин дайсантай учрахад бага нэмэр болов гэсэнд бүгдээрээ инээлдэж, түүнийг өхөөрдөн баяр хүргэцгээв. "Энэ дарга бол ёстой сайн хүн" гэж Баатар дотроо батаар бодлоо.

10. Баярын нулимс

Энэ үед Тахилтын хоёр салаа амны тэнд их үйл явдал болж байлаа.

Баатар хүүг ар тийш нь явуулсны оройноос эхлэн дайсан өнөөх өвөлжөөтэй том уулыг битүү бүсэллээ. Партизанууд шөнийн харанхуйг ашиглан уул өөд зугтан гараад оройдоо барзгар хадтай том уулын оройд нуугдан дайсныг угтан байлдахаар бэлтгэж эхлэв.

Хавь ойроос дайсанд орон гэрээ шатаалгасан хүн олон ирж, мөнхүү отрядтай нийлж өмссөн хувцас, унасан морьтойгоо гэрээс гарч хоосон ирсэн тэдгээр хүмүүсийг дарга зохих п байруудад хуваарилав. Шөнө дайсны буун дуу зогсож хавирга I мэт махир тэргэл сар үүлгүй цэнхэр огторгуйд хөөрөв.

Партизаны дарга хэдэн хүнийг харуулд гаргаад эргэн ирж буйг яг тэр үед Баатарын ээж Зоригт руу очиж явлаа. Зоригт хадны нөмөрт суугаад буугаа их л хичээнгүйлэн арчина.

Аль хэдийний шархадсан толгой нь янгинан өвдөж орой болгон халуурдгаараа халууран бөмбөлзтөл чичирнэ. Гэтэл ээжийн нүдэнд хүү нь харагдах мэт болж "Тэр минь амьд мэнд байгаа даа" гэж бодохоос зүрх нь шархтай мэт өвдөнө.

-Зоригт оо!

-Аа.

-Хүү маань одоо очоо болов уу?

-Миний хүү очсон байх аа.

-Тийм бол юунд чимээгүй алга болов?

-Би чамд эс хэлсэн билүү. Миний хүүг энэ муухай дайснууд аль хэдийн бариад алсан биз дээ... гэхэд ээж эхэр татан уйлав.

Зоригт яах ч учраа олохгүй шаналан хий л:

-За битгий уйл даа. Хүү маань эргээд ирнэ. Ирэхдээ бүр даргатай хамт давхин ирж яваа гэж сэтгэлээ хууран хэлж тайтгаруулна.

Үүр дөнгөж хаяармагц дайсан уул уруу довтолж эхлэв. Тэдний зүг харвал уулын бэлийг битүү бүрхээд шоргоолж шиг хар юм наашаа ирж явав. Буун дуу чимээгүй.

Хааяа чулуу өнхрөн тэдгээрийн зүг дүүлэн очих боловч дайсан тэнэг биш тул аль хэдийн зайлж амжаад гараа занган "чамайг даа?" гэсэн мэт заналхийлнэ.

Сайхан ойртоод ирмэгц хажуунаас нь их бага буунууд нүргэлэн дайсан энд тэндгүй годройтон унав. Манайхан мэргэн онож, гранат шидэж байсан тул дайсан үлэмжхэн хохирч

буцахаар эргэсэн боловч тэр даруй нэмэгдэл хүчээ ирэхэд дахиад л дайрч эхлэв.

-Зоригт, пулемётын дэргэд! гэж дарга команд өгсөнд Зоригт ухасхийн пулемётын дэргэд давхин хүрэв. /

Түүний дэргэд Даш тархиа зад буудуулсан хэвтэнэ. Зоригт малгайгаа аван салах ёс гүйцэтгээд анд нөхөртөө харамссандаа сэтгэл нь хямран улмаар шар нь хөдлөөд даруй хэвтэн дайсны зүг пулемётгоо чиглүүлэн шүршиж гарав.

Харамсалтай нь тэр, дайсны суманд ахиад оногдож хажуу тийш унав. Ээж дуу алдан гүйж хүрээд Зоригтыг хадны араар чирэв. Партизаны дарга пулемётын дэргэд бас нэг хүнийг дуудаж тэр хүн хэдхэн тачигнуулаад "түй" гэж нулимж босов. Үзвэл сум нь дуусчээ.

Дайсан энэ үеэр ашгүй эргэж одлоо. Дараачийн хоёр шөнө хэсэг дайснаа чимээгүй болоод дөрөв дэх өдөр гэнэт довтлон уулын оройг эзлэн авах бүрэн найдлагатай болмогц улайран дайрав.

Партизанууд нэгэн дор цуглараад салах ёс гүйцэтгэж амь дүйж эцсээ хүртэл тулалдахаар эрс шийдэцгээв.

Ийнхүү байр байрандаа очсоны хойно шарх сорвио ч мартаж, хэдэн өдөр өл хоолгүй байсныгаа ч мартан эрэлхэг зоригтой тулалдаж чулуу өнхрүүлэн галт сумыг дайсны толгойд тушаав.

Баатарын ээж хамгийн сүүлд:

-Алтан дэлхий, эх нутаг, гэрэлт нараа сүүлийн удаа харья! гээд эргэснээ гэнэт дуу алдан унав.

Үзвэл өнөө дайснуудын ар талаар улаан туг мандан ура хашгирсан ардын намын их цэрэг дайран орж айсуй. Дор бүрнээ салах ёс хийж байсан партизан нар ура хашгиран баярласандаа уйлцгаана. Ардын их цэрэг, тэр бүхний дотор гар буу бариад дайсныг буудсаар яваа жаал хүүгээ ээж нь харж Зоригт гуайг өргөөд:

-Хүүгээ хараач... Тэр ирж явна! ! гэж өөрийн эрхгүй хашгирав. Баатар оодон хээр морио унасаар хайрт аав ээждээ дөхөн явна. Хэдэн мөч өнгөрсний хойно нэгэнт ялалт манайх боллоо.

Дайсны хүүр, хаясан тэрэг тоног, уулын бэлийг нэлдээ бүрхэн А хар цоохор юм болжээ. Баатар бүхний түрүүнд уулын оройд / давхиж гараад ура хашгирч байсан партизанууд дээр давхин хүрэв. Партизаны даргын өмнө бууж:

-Тушаалыг биелүүлэв! хэмээн хангинатал илтгэн ёслоход дарга хүүг тэврэн үнсэж:

-Ээ дээ, хүү минь, бид чамайг итгэж байсан билээ гээд шархтай хэвтээ аав уруу нь хөтлөн аваачив.

Ээж нь хүүгээ цээжиндээ тэврэн олонтаа үнсэж Зоригт хоёр хөл дээрээ чүү чамай босоод,

-Хүү минь! гэж цээжний гүнээс уяран хэлээд тэврэн авлаа.

1959 он

Нэгдүгээр бүлэг

-Бос хөөе, бос гэм золиг оо!... гэж намайг хүн дуудах шиг болов. Би толгой дээгүүр дээлээ нөмрөөд шурган унтсаар л байв.

-Босно уу? үгүй юу чи! гэж өнөөх дуу ахиад гарснаа, гэнэт хучлагыг минь хуу татаад явчихав. Би өөрийн эрхгүй өндийж, нүдээ нухан байтал,

-Бушуул! Яагаад суугаад байна! Чамд хүн үг хэлж байна уу, үгүй юу? гэснээ Догоо эмээ, өрөөсөн гутлаараа намайг шидэв. Хэрэв би амжиж бөхийгээгүйсэн бол юу болох байсныг бүү мэд.

Би ч бушуухан босчээ.

-Ай муу гөлөг чамайг! Голоос ус авчир! Галаа түлээд яв! гэж зүүн орноос Догоо гуай уухилав. Би Догоо гуайг ахин гутлаараа шидэх вий гэсэн мэт түүн уруу айж хялалзсаар зууханд аргал зэрэглэж, цаасны өөдөс цуглуулан банзан шүдэнз хавирч гал ноцоох гэж оролдном. Аргал мөд асахгүй. Адууны хомоол үйрүүлэн байж арай гэж асаахад хүхээг нь эвдэрхий муу зуухнаас утаа савсаж гэрээр дүүрэн утаа болно.

-Аа заяа нь харламар. хормойгоо чирсэн новш. Тэр гал түлчихэж байгааг нь хараарай! Чонын бэлтрэгийг ... зориуд тэгж нүдийг минь хорсгох гэж утаа тавьж байгаа юм! гэж Догоо гуай уурсан, уухилан өндийхөд би түүний гуталдаа хүрдгийн даваан дээр дээлээ шүүрэн авч зугтааж гарав.

Авгайн дуу хангинасаар. Энэ авгай хэцүүхэн хүн байв. Намайг өглөө болгон ингэж босгоно. Хичээлээс ирмэгц би аргал түүж их ядрах тул шөнө ухаангүй унтах бөгөөд анхандаа өглөө дуудахад нь сэрдэггүй байв. Тэгэхийн хамт Догоо гуай нэгэн мэргэн арга олжээ. Намайг дээлээр минь хучин унтуулж, ханцуйнаас урт оосроор оосорлон түүнийгээ орноосоо уяж хононо. Өглөө өнөөх оосроосоо ганцхан угзрахад би нүцгэрч дээл минь Догоо гуайн орны өмнө оччихсон байна. Догоо гуай их зальтай. Ер нь харваас тийм гээч. Нүд нь онигор, эгээ л нэг гахайных шиг. Аманд нь цорын ганц шүд буй. Тэр нь үүдэн шүдний үлдэгдэл бөгөөд араанууд нь цөм уначихсан атал яагаад тэгж зөвхөн үүдэн ганц / шүд үлдсэнийг бүү мэд. Нүүр нь олон үрчлээстэй. Юм идэхдээ зөвхөн эрүү хамар хоёр нь нийлж байгаа шиг санагдах бөгөөд инээхэд нь өнөөх ганц шүд нь ёрдойн харагдана.

Гадаа хяруу унаж, гол уруу хөл нүцгэн гүйхэд хайрна. Миний мөр цэвцийсэн цагаан хяруун дээр харлан үлдэхэд би жигтэйхэн даарсан хөлөө дулаацуулахын тулд үхрийн баасанд дүрнэ. Намар орой болж байв. Өглөөний наранд хяруу буусан тал мөнгө шиг гялалзана. Хэрлэнгээс өглөө эрт уур манан савсаж, тунгалаг цэнхэр гол дөлгөөн эгшиг гаргаж урсана. Би хувингаараа ус хутгаж, эргэж гүйнэ. Миний хувинтай усаар наран наадаж ийшээ найгахад хувин энтээ тал уруу цалгиж, тийшээ найгахад тэртээ тал уруу цалгина. Хувинтай ус маань нарны гэрлээр сүлэгдсэн шиг санагдахад би нарыг л тийнхүү хувиндаа хийгээд барьж яваа шиг санагдана.

Гэртээ ирэхэд гал хэдийн асаж гэрт дулаан болжээ. Би тогоо тавьж, ус хийв. Догоо авгай галд дулаацаад ухаангүй хурхирч байв. Амьсгаа нь гарахгүй бүтчих гэж байгаа юм шиг ффүү... фф...фф... гэнэ.

Цай болтол би хичээлээ үзэв. Гэрийнхээ даалгаврыг арай гэж амжиж хэл бичгийнхээ дасгалын дуусгатал, цай ч буцлав. Би зэс шанагаар сүү авчирч сүлээд босоо том домбонд уудлав. Тэгээд өчигдөр орой Догоо гуайн аяганд хийж өгсөн дөрвөн ширхэг боорцгийг идэж, цай уугаад, номоо даавуу цүнхэндээ хийгээд гэрээс гарлаа.

Гадаа салхи тогтуухан, наран таалж, хүүхдүүд шуугилдаж байв.

2.

Манайх дөрөвдүгээр анги. Бид арван долуулаа. Зарим нь хоёроор зарим нь ганцаар ангийн шар партнуудад сууцгаана. Энхээ бид хоёр нэг ширээнд. Тэр бол манай зэргэлдээ айлын охин шүү дээ. Энхээ их хөөрхөн ааштай. Тормолзсон тас хар нүдтэй. Нарийхан туранхай охин байв. Хичээлдээ бол их сайхан. г

Намайг ангидаа очиход хүүхдүүд цуглаад ид шуугилдаж байна. Даваа, нэгэн ногоон шугамтай дэвтэр таван хошуутай даавуу цүнхнээсээ гаргаж,

-Хар л даа, та нар! Ах авчирч өгсөн юм л даа гэж гайхуулав. Энэ бол ёстой дэвтэр байв. Талбай гаргаж шугамдсан хагуувтар ногоон хавгастай, гялгар цаастай, арван хуудастай дэвтэр юм.

Энхээ тийм дэвтэр байхгүйдээ харамссан юм шиг түүний гар уруу шүүрс алдан харав.

-Зарна шүү авах уу? гэж Даваа эгээ л нэг морины наймаач шиг хэлэв.

-Чи юугаар өгөх юм бэ?

-Домбон саахраас өгнө.

Энхээ бодол болно. Чихэр ховордож домбон саахар ч олдохоо байжээ. Бас дэвтэр нүдний гэм байв. Багш бидэнд нэгэн зузаан бор цаас тарааж өгнө. Энэ бол модны хээ нь хүртэл харагдах черниль уудаг муу цаас байв. Аль аль нь ховор тул нарийхантай Цэрэндолгор багш маань ороод ирэв. Бид гар гараа урдаа тавьж суув.

-За хүүхдүүд ээ, хичээлээ эхэлье. Өнөөдөр 1944 оны 10 дугаар сарын 3 гэж багш эхэлнэ. Бид цөм будаа түүх гэж байгаа шувуу шиг нэг зэрэг тонголзон самбар уруу нэг харж, дэвтэр рүүгээ нэг бөхийнө.

Хичээл тармагц бид тал тал тийшээ номоо үүрэн гүйж одов. Өнөөдөр бямба гариг. Хичээл эрт тарсан. Манайд зочин ирсэн байв. Үл таних хар сахалтай хүн хоймор сууж, өмнө нь Догоо эмээ халаасан гүцтэй архи аяганд хийж байв. Би цүнхээ орон дээрээ тавив.

-Аяга аваад цай уу! гэж Догоо эмээ хичээлээс эрт тарсан нь миний буруу юм шиг хялалзан

ХЭЛЭВ.

-Энэ чинь юун хүүхэд билээ гэж хар сахалт асуув.

-Энэ өнөөх Дамчаагийн том банди. Эцэг нь түр цэрэгт татагдаад гэр нь Улаанхайрхан уруу оторт гараад, үүнийг манайд орхисон юм.

-Аа. й

Би аяга цай авч хийж суув. Догоо гуай хуруугаа хүүдийний / ам уруу хийж дөрвөн ширхэг боорцог сурмагаар хавчин гаргаж ирээд алган дээр минь тавив.

-Бушуу идэж уу! Тэгээд аргалд явна шүү. Цас хэзээ язаагүй дарах нь... Түлш алга гэнэ. Би Догоо гуай уруу хялалзан байж цайгаа уугаад, боорцгийг өвөртөлж босов.

-Морь минь усгүй хэцүүдэж байгаа юмсан. Чи хө морь унаж чаддаг уу?

Чи энэ ахынхаа морийг услаад ир! Холхон явж, бүрднээс усална шүү !

-За... гээд би гарав.

Хээр үрээ манай гадаа хантайраастай байв. Би моринд мордож, бүрдний зүг давхин одов.

Ингэж давхих нь сайхан байлаа. Амьтны элдэв шуугианаас холдсондоо баярласан зүрх минь түг түг цохилоо. Гандаж шарлангуй өнгөтэй болсон уудам талын дээгүүр тогоруун цуваа гангар гунгар дуугаран ниснэ. Зэллэн одох тогоруунууд өмнө зүгийн тэнгэрт бараа тасартал би хараад "Аав минь тэнд бий" гэж алс өмнө зүг уруу ширтэн бодол болов.

Аавыгаа бодохлоор сэтгэл хачин болно. Гэр минь санагдаж, ээжийгээ үгүйлнэ. Гэвч би чинь эр хүн шүү дээ гэж бодлоо.

"Ахайм!" гэж би томоор ханиаж, бүрдийн шар зүлгэн дээр бууж, морио булгаас услав. Наран шингэх дөхөж, бадман улаан туяа нь бутны сүүдрийг уртасган байв.

Гэдэс минь хоржигнон, уусан цай тулманд хийсэн ус шиг чимээ гаргана. Анх энд ирсэн өдрөөс хойш би Догоо авгайнд ганц удаа ч цадсангүй. Догоо авгай зун манайд очиж, хоёр хоносон. Тэгэхдээ энээ тэрээ болж, намайг энхрийлэн таалж байж,

-Ээ гэгээн минь, хүүгий чинь би л энэ жил гэртээ байлгаж үзье. Тэр дотуур байр гэдэг чинь горьгүй газар шүү. Ядаж хоол унд муутай. Ер нь олон амьтанд хийсэн хоол яаж ч олигтой амттай байх вэ? гэж улигласаар ээж аав хоёрыг зөвшөөрүүлж, тэгээд, өвлийн эхэн сард хоолонд минь тал үхрийн мах, хэдэн г хонины махтай авахаар тохирчээ. Намар ээж бид хоёрыг ирэхэд ч Догоо гуай мөн л тийм байдалтай угтав.

Гэвч ээжийг минь явсны маргаашнаас өмнөх сайхан зан нь ор мөргүй болоод, одоогийнх шиг өглөө болгон босгож, цай уухад дөрвөн боорцог л өгдөг болжээ. Тэр битгий хэл, авчирсан цагаан даавуун хөнжлийг минь ч нөмрүүлсэнгүй. Нэгэн гудас орон дээр хаяад, дээлээр минь

хучуулдаг болжээ. Ингээд бодохлоор уйлмаар байв.

Хээр үрээ ус залгилна. Тэр амьтан их цангажээ. Хамраар нь ус годхийн гарахыг ч тэр эс тооно. Би хээр үрээг усанд ханахаар хөтөлж явав. Тэгж явахдаа ихэд сонин нэгэн зүйлийг харлаа. Юу гэвэл, өрөөсөн хөл нь хугархай нэгэн тогоруу миний хөлөөс зайлах гэж далавч юугаа дэвэн дэвэн байв. Миний зүггүй хөдөлж хөлгүй тогоруу бид хоёрын хэн нь хурдан болохыг үзэхээр шийдэв.

Би түүний хойноос элдэв. Хээр үрээ үргэж байвч цулбуураас нь татахаар арга буюу явжээ. Би тогорууны хойноос хашгиран элдэв. Тогоруу дэвэн дэвэн явгалж зугтсаар байв. Гэвч хөлгүй тэр амьтан хаа холдох билээ. Хөлөө дороо хийн навсайн унав. Би чулуу эрж нэгэн бутны дундаас нударган хэртэй чулуу олоод шувууны дэргэд очиж, яг толгой уруу нь буулгахаар гараа өргөтөл, наран сөрөг нэгэн юм гялсхийв. Гартаа өргөн харахад нарны гэрэл тусч, тэрхүү сувднаас нь өнгө өнгийн гэрэл гарна. Утсан оосор нь хуучирч өгөршчээ. Би бодол болов.

-Энэ тогоруу надад үүнийг өглөө гэж би бодов.

-Амиа гуйсан ч байж магадгүй гэж би гэнэт бодов.

Тогоруун дээр ирвэл, тэр айж бүлтийсэн улаан нүдээр намайг заналтай ширтэнэ.

-Уучил намайг гэж би тогоруунд хэлнэм. Тогоруу юу ч эс дуугарав. Улаан нүд нь хорсолтой гялалзаж,

-Чи муу тэнэг жаал. Намайг алах гэж явахаар, наадахаа аваад зайл! гэх шиг болов. Би сувдан даруулгыг өвөртөө хийж / мориндоо мордов.

Хоёрдугаар бүлэг

Нэгэн удаа би дотуур байрны тэрүүгээр явж байв. Хүүхдүүд хоолондоо орж, гал тогооны өрөөнөөс аяга таваг хангинах сонсдоно. Би цонхонд хамраа налчийтал шахаж байж харав. Хүүхдүүд урт сандлууд дээр сууцгаана. Өмнө нь таваг шөл, бин харагдана. Хэдийгээр бин нь хар гурилынх байсан боловч түүн шиг сайхан зүйлийг би ер нь энэ насандаа үзсэн болов уу даа! Бас тавагтай шөлнөөс нь уур савсаж таанын үнэр ханхалж байв.

Би тэсэж чадсангүй шүлсээ залгив. Ай, энэ дотуур байрныхан ямар гоё юм бэ! Нэг харвал, манай ангийн Даваа бингээ идэлгүй өвөртөлж байв. Гал зуухны үүдэн дээр очиж түүнийг хүлээхэд Даваа ч хөлс нь бурзайчихсан гарч ирснээ намайг хараад гайхсан юм шиг.

-Чи юу хийж байгаа юм бэ? гэж асуув.

-Надад бингээ өг л дөө! гэж би гуйлаа.

-Яах юм... гэснээ Даваа, гэнэт нэг юм санах мэт болж,

-Тэгвэл чи юу өгөх вэ?



-Би юу би... гэж бодол болов. Надад даавуу цүнхнээс өөр юм олдсонгүй тул,

-Даавуу цүнхээ өгнө! гэв.

-Яасан сайн юм. Тэгвэл май! гээд Даваа алгыг минь дулаацуулсан бүлээн бин гар дээр тавив.

Миний баярласан гэдэг тоймгүй. Би бинг бушуухан хазаж амтлан залгив.

Ийм сайхан амттай бинг би ер нь хэзээ ч үзээгүй билээ. Идэж дуусдагийн даваан дээр гэнэт «Хожим ахиад өлсөнө шүү дээ. Догоо авгай юу ч өгөхгүй дээ» гэж саналаа.

Гэвч би тэвчиж чадалгүй бинг тойруулан хазсаар байгаад, тавтын мөнгө шиг жаахан дугарагийг үлдээжээ.

Бид ангидаа цуглацгаав. Тэр өдөр сургуулийн захирал багш, ариун цэвэр шалгахаар гэнэт орж ирэв. Би захныхаа даавууг угаасан учир хээв нэг л зогслоо. (Догоо гуай ус алга гээд, зөвхөн дээлийн захны дотуур нэгэн цагаан даавуу хадаж өгдөг байв). Хүүхдүүдийг үзсээр миний

өмнө ирээд захирал багш,

- Цэдэв дээлээ тайл! гэлээ.

Энэ бол ширвээ сахалтай, өндөр хүн байв. Харц нь их ширүүн хүн юм. Би дальдчин байж бүсээ тайлтал өнөөх нэгэн гайт бин өврөөс өнхрөн ойчив.

-Энэ юу вэ? гэж захирал багш бинг дээр өргөхөд, манай ангийнхан нирхийтэл инээлдэн, би ичсэндээ улайлаа.

Захирал багш миний ойрдоо ус хүргээгүй цамцыг харж, дур нь гутсан бололтой, хөмсгөө зангидав. Тэгээд, өнөөх гайт бинг толгой дээр тавьж, самбарын өмнө эгээ л нэг үзмэр шиг зогсоов.

-За хүүхдүүд ээ харцгаа! Энэ Цэдэвийн ариун цэвэр ямар байна! Бас тэгээд хувцсаа ийм муухай байлгаад зогсохгүй, бин өвөртөлж ангидаа ирсэн байна. Түүний толгой дээр байгаа бинг үзэж байна уу? гэв.

Миний нүүр уруу халуун нурам цацах шиг, хүүхдүүдийн шоолон инээлдэх нь хацрыг хорсон байв. Ингээд бас зогссон бол яамай. Хэсэг зогссоноо захирал багш,

-За хүүхээ намайг дагаад гар! гэж тушаав.

Би хойноос нь гарав. Тэр өдөржингөө шахуу анги хэсч, доод / ангийн жаалуудын өмнө нүүрээ улайлгав. Би нулимсаа тогтоож чадалгүй уйлж байв. Бодоод үз л дээ, ямар гутамшигтай юм болсон гэж санана!

Хэзээ хэзээгүй тэсрэхэд бэлэн бөмбөг шиг ичиж улаан болсон би жижиг жаалуудын өмнө толгой дээрээ бин тавиад зогсоход өнөө жаалууд хи хи хи гэж инээлдэцгээнэ.

Ингэсээр арай гэж нэг захирал багш намайг явуулахдаа, Догоо эмээг заавал авчир гэв. Би айж хулгасаар Догоо эмээд очоод,

Таныг захирал багш дуудаж байна гэвэл, эмээ амандаа юм захлах мэт эрүү хамар хоёроо хөдөлгөснөө, -Яах гэж дуудаав? гэлээ.

-Мэ.. мэ... дэ... х... гүй...: гэж би арай хийж хэлэв.

-Тийм гээ! Чи л болоод мэдэхгүй байгаа вий, хэл! гэж Догоо гуай над руу аймшигтай харж ойртов.

-Би яагаа ч үгүй... би... би... гэж намайг ээрэхэд Догоо гуай хананаас гөрмөл суран ташуур авч,

-Чи үнэнээ хэлнэ үү, үгүй юу! Хормойгоо чирсэн муу турсага хуухай!

Би ээрэн, нус нулимсандаа хахаж цацан байж үнэнээ хэлэв. Догоо гуайн царай тэгэхэд ямар

болсон гэж санана. Эгээ л нэг дүнсийтэл бүрхсэн тэнгэр шиг бараалав. Гэвч ташуураа хананаас өлгөөд, уухилсаар галынхаа өмнө суув. Тэгснээ гэнэт жигтэйхэн сайхан зантай болж инээд алдав.

-Үгүй ер, яалаа гэнээ? Бин толгой дээрээ тавьж гэнээ. Ха ха ха! Энэ инээд ер бусын сайхан инээд байв. Ер саяхан намайг зодох гэж ташуур далайж байгаагүй юм шиг Догоо гуай тэгж удтал хөхрөхөд, унжсан том зовхи нь чичирч байв. Дараа нь нулимсаа арчаад газар тулан босож, үхэр рүүгээ явав. Өлссөн ямааны нүд шиг миний нүд горьдон гарыг нь дагаж харсаар байлаа. Энэ удаа Догоо гуай дөрвөн боорцог биш, долоон боорцог гаргаж дээр нь бас жаахан өрмийн хэлтэрхий тавиад, г

-Май, ид дүү минь... Юу гэсэн үг вэ. Насаа нэм! Ингэж өлсөж байна гэдэг чинь... Аав, ээж чинь дуулбал юу гэхэв гэлээ.

Тэгээд харц нь ихэд уярангуй зөөлөн болж ирснээ, бараг шивнэх шахам дуугаар,

-Хүү минь, одоохон хувцсаа сольчих! Бас хөнжлөө гаргаад орон дээрээ тавь! Тэр захирал багш чинь манайд ирж ч үзэж магадгүй хүн шүү. За юу?

-За гэлээ би.

Эмээ хоймроо байх хээ нь хөө тортогт дарагдаад мэдэгдэхээ байсан авдраас баадантай юм гарган задалж, шинэхэн шувуу даавуугаар хийсэн миний хөнжлийг, бас ээжий минь намар авчирсан цамцыг гаргаж ирэв. Би бүсээ тайлж эхлэв.

Гэвч захирал багш ирсэнгүй. Эмээ ганцаар ихэд ууртай ирэв.

-Тэр цамц тайл! гэж тушаав.

Би гайхан харвал эмээ гөрмөл суран ташуураа хананаасаа авч, -Тайл наадах цамцаа! Хормойгоо чирсэн муу новш! Тэр

хиртэй цамц, захны даавуу угаа! гээд заавал шийтгэхийн

тулд нуруу руу нэгэн удаа гуядаж,

-Ахиад намайг ингэж тэр захирал дуудвал уу? Сайхан

мэдээрэй гэв

Би ус халаан Догоо гуайгаас айн дальдчин байж цамцаа угааж гарав.

Хоолны дараа намайг тосон дэнгийн бүдэг гэгээнд хичээлээ давтахаар суухад Догоо гуай хажууд минь ирж бөгтийн зогсоод миний бичиж байгаа руу удтал харав. Ер нь Догоо гуайн бичиг мэддэг эсэхийг, би мэдэхгүй байв.

-Алив чи юу хийж байна? Хичээл чинь мөн үү?

-Мөн.

-Тэгвэл унш!

-Үгүй тоогоо бодсон юм.

-Тэгвэл бод!

-Дөрвөн дөрвийн арван зургаа, зургааг тавь, нэгийг сана! гэж би амандаа үглэв. /

-Битгий дэмийр! Нэгийг чи санаж яах нь вэ? Шууд арван зургаа гээд л тавивал болоо биз!

-Үгүй, эмээ тэгж боддоггүй юм.

-Би мэдэж байна хэмээн эмээ зандраад

-Тоогоо бичив үү? За сайн. Тэгвэл тэр... тэр бичгээ унш!

-Ямар бичиг...

-Яагаав, бичдэг бичиг... унш бушуу!

Би эмээгийн өмнөөс харснаа айж, хэл бичгээ гарган уншив. Эмээ ихэд сонирхож байх бололтой.

-Чи нээрээ ингэж уншиж байна уу?

-Уншсан л даг...

-Хаа байна тэр бичиг чинь?

-Энэ байна гэж би хуруугаараа уншсан мөрүүдээ заав. Эмээ түүн уруу бөхийн байж харав. Гэвч нүд нь гөлийж, эгээ л нэг сохор хүн шиг байв.

-За сайн байна. Одоо унт! Дэн дуусах нь гээд эмээ ор луугаа явав.

Гуравдугаар бүлэг

Цэрэндолгор багш нэгэн удаа манайд ирэв. Багшийг үзээд, эмээ дуу алдан, урьд хэзээ ч байгаагүй сайхан зантай болоод

-Алив хүү минь, багшдаа гудас дэвсэж өг! Эмээ нь одоохон аяга цай пурхийлгээд орхиё гэлээ.

Тэгээд авдарнаасаа миний ер үзээгүй мөсөн чихэр, улаан чангаанз гарган том тавганд хийгээд, бас цагаан тос аяганд хийн, эх нь охиноо ингэж хайрлах болбуу гэлтэй эелдэг сайхнаар харж багшид өгөөд

-Цэдэв бид хоёр ч гэсэн цайгаа ууя гэнгүүтээ өнөөх цагаан тосноос хэлтэлж надад өглөө.

-Манай Цэдэв их сайн. Томоотой ч гэж ярихгүй, гагцхүү би гэдэг хүн нас өдий болж энэ маань балчирдаж хувцас хунараа г сайн цэвэрлэж чаддаггүй хүүхэд юмаа гээд эмээ

Цэдэв чи голоос жаахан мөс дөхүүлж ирэхгүй юу? Эмээгийн нь өвдгөөр хатгаад горьгүй нь... гэв.

Би ч шуудай авч гарав.. Эмээ багшид юу ярьсныг би мэдсэнгүй .

Би гэрээ их санаж байв. Манайхаас хүн ирэхгүй л байлаа. Дам сураг дуулбал манайхны хот тэр чигээрээ оторт явцгаажээ. Цас их унав.

Өвөл эхлэхэд жавар тачигнаж, хичээлд хөвөнтэй дээлтэй явж болохгүй боллоо Догоо эмээ үстэй дээлийг минь гаргаж өгсөнгүй. Би хөвөнтэй дээлийнхээ дотуур юм давхарлаж өмсөөд хичээлдээ явдаг байв.

Багшийг ирсний маргааш эмээ сайхан зан гаргаж сумын урд байх довцог дээрээс чаргаар гулган тоглож буй хүүхдүүд дээр очиж тогловол тогло гэв. Би ч хар хурдаараа гүйлээ.

-Өө, Цэдэв!

-Нааш ир!

-Миний чарганд суу! гэж хүүхдүүд дуудав. Энхээ шууд босож ирээд миний гараас хөтлөн чарган дээрээ суулгаад

-За хөдөллөө шүү. Би чиний хойно сундална! гэв.

Нээрээ өөрөө сундалдан модон чарга хөдлөхөд товцгийн уруу чарга маань салхи шиг хурдлан одов. Нүүр уруу цас пургиж, салхи сэнгэнэх шиг болов. Гэнэт гайтай юм боллоо. Чих гэнэт часхийгээд явчихав. Би дуу алдаж чихээ барилаа. Гэвч чих минь мэдээ алджээ. Надад үстэй малгай байсан боловч шинээр нь өмсөөд урчихна гээд эмээ өгсөнгүй. Би зуны малгайтай явсан юм байхгүй юу. За ингээд чаргаа зогсооход Энхээ босч ирээд миний нүүр уруу харж

-Чи яав? Яагаад ёолов? гэж асуулаа.

-Яагаа ч үгүй! гэж би нэрэлхэв.

-Нээрээ юу?

-Нээрээ!

-За тэгвэл хоёулаа одоо өндөр газраас гулгана. Ёстой сайхан болно гэж Энхээ хэлээд чарганыхаа оосроос татав. /

Би чаргыг чирч бид хоёр хөтлөлцөөд товцог өөд авирав. Энхээ, өөрт нь яг таарсан үстэй дээл, бор эсгий гутал, цагаан хурган малгайтай, даарах учир байхгүй тул хамрын нь хөлс бурзайсан байв.

Бид хоёр ахиж товцгоос бууснаас хойш миний чих бүр мэдээ алджээ. Би бодохдоо дулаацаад даарахаа байж дээ гэж бодож байв.

Тэр өдөр ямар хөгжилтэй байсан гэж санана! Би баярлаагүйгээ баярлаж байв. Би инээд алдаж, хүүхдүүдтэй шуугилдан гүйлдэнэ. Заримдаа газрын уруу хурдалсан чаргатайгаа онхолдоод Энхээ бид хоёр элгээ хөштөл инээлдэж байв.

Нэгэн удаа Энхээ бид хоёр ингэж унаад цасан дээр хөрвөн, бостол гэнэт Энхээ,

-Хүүе Цэдэв! Чиний наад чих чинь яачихаа вэ? гэлээ.

-Яаж байна! Зүгээр л байна даг гээд би чихээ барин үзвэл, цас мөс шавчихсан, бас ихэд хүнд болсон байв.

-Чи чихээ хөлдөөжээ! Ээ бас тоогүй! гэнгүүтээ Энхээ цагаан хурган малгайгаа авч надад өмсгөөд

-Одоо харьцгаая. Хүүхдүүд уруу очоод яах вэ? гэв. Бид хоёр чаргаа чирэн одов.

-Хүүш, та хоёр хаачих нь вэ?

-Жаахан тогло л доо! гэж хүүхдүүд хойноос хашгиралдана. Би одоо яана! Хүүхдүүдийн царайг, багш нарынхаа царайг яаж харна! Бас энэ чих гэсэж зүгээр болохгүй, хөлдүү чигээрээ хугараад унавал яана? гэж би бодоод гашуунаар уйлав.

-Битгий уйл. Би эгчид хэлнэ. Эгч эмнэлгийн сувилагч болохоор лав эмнэж чадна гэж Энхээ намайг тайтгаруулна.

Гэр лүүгээ дөхөж яваад манай гадаа нэгэн майхан боссон байхыг би харж ухаангүй баярлажээ.

-Энхээ хараач! Манайхаас хүн ирсэн байна. Аав ээж ирсэн дээ. Хоёул очъё. Ээж ирсэн бол

ааруул лав авчирсан... гэж г Энхээгийн гараас хөтлөн гүйв.

Манай гэрийн баруун талд майхан барьжээ. Хоёр хүн, сөглөж хэвтүүлсэн тэмээнүүдээс шуудайтай ачааг нь буулгаж байв.

Тэд танихгүй улсууд байжээ. Энхээ бид хоёр гайхсаар явж гэрт оров.

-Хаашаа алга болчихов. Бүтэн өдөржин дэмий тэнээд... Бушуу наад нүүр гар угаа! Гурил зуур! гэж эмээ, бид хоёрыг үүдээр толгой цухуйлгамагц зандрав. «Яасан ууртай эмээ вэ!» гэж Энхээ шивнээд ормогц,

-Эмээ! Цэдэв маань чихээ хөлдөөчихсөн одоо яана? гэвэл

-Хохь нь! Хэн түүнийг хээр явж цасанд умба гэсэн юм бэ. Бушуу наад гар нүүр угаа! Чи яв! гэж Энхээг хөөв. Энхээ надаас малгайгаа аваад гүйн одов.

Би ч урам муутайхан шиг гараа угаан гурил зуурахаар түмпэн авав. Чих минь хорсож эхлэв.

Дөрөвдүгээр бүлэг

Жингийн хүмүүс холоос давс ачиж ирсэн улс байв. Хоол хиймэгц Догоо гуай тэднийг дуудаж,

-Хоол ид хүүхээд, халуун дээр нь ид! гэлээ.



Намайг бол хоолоо халуунд нь ид гэж ер хэлдэггүй. Тийм учраас маш чухал улс ирснийг би тэгэхэд л ойлгожээ. Хүмүүс ч / орж ирэв.

Хууз сахалтай, нэхий дээлтэй өндөр хүн, хорчгор туранхай бор өвгөн хоёр байлаа.

Догоо гуай тэдэнд их сайн байх бололтой. Хоол хийж өмнө нь тавиад, орныхоо хөндийд ямагт хадгалдаг цагаан савгай архианаасаа таслан халаав. Тэгээд над уруу эргэж,

-Чи юугаа хараад байна? Унт! гэв.

Миний чих ихэд өвдөж байв. Би Догоо гуайн өгсөн аяга хоолыг идээд унтахаар орондоо оров. Тооноор оддын гэгээ сүү-мэлзэж байв. Миний нойр хүрсэнгүй. Дээлээ толгой дээгүүрээ нөмрөн хэвтэв. Ингэхгүй бол болохгүй, би хөлдсөн чихээ хүйтэн гараараа илэн байж, унтсан юм шиг хэвтэж байв. Энэ завсар өнөөх аяны улсууд ч ярьж эхлэв.

-За тэгэхээр Догоо гуай минь бид танд арван шуудай давс орхилоо шүү. Одоо чинь дайн тулааны цаг болж, юм ховордсон үе. Хэрэв аятайхан борлуулаад юм болгоод өгвөл танд бид харамж шангийг нь гомдоохгүй өгнө гэж мэдээрэй! гэж ширвээ сахалт хэлэв.

-Ээ хүүхэд минь болохгүй яах вэ. Эмээ нь яаж ийгээд цааш нь харуулж л орхино гэж эмээг хариулахад,

-Амьтан хүнд мэдэгдвэл эвгүй юм болох вий дээ. Одоо цаг гэдэг тун зовлонтой, ялих ялихгүй юмнаас хэрэгт ороход амархан. Танай энэ хүүхэд зүгээр л хүүхэд байгаа даа. Сургуулийн хүүхдүүд ч хэцүү шүү. Толгой дээр цахиур хагалж мэднэ гэж тожгор өвгөн хэлэв.

-Энэ уг нь айлын хүүхэд. Эцэг нь түр цэрэгт татагдаад зүүн хязгаарт байна. Гайгүй томоотой, томоогүй байлаа ч гэсэн яах вэ, гарын дор юм. Үнэнийг хэлэхэд өвлийн идшинд нь болоод л суулгачихсан юм л даа.

-За хөөрхий тийм байж.

-Унтаж амар хүүхэд минь!

Догоо гуай хойроор гудас дэвсэж ор засав. Би дотроо г бодсоор байлаа. Өглөө босоод би аянчны майханд оров. Тэнд шуудайтай давснуудыг давхарлан тавьжээ. Пүүгээ дэвсгэрээ нэг талд нь хураасан байв. Яах гэж орсноо ч мэддэггүй юм. Нэгэн уутан дотор цайны нь хийц байв. Дээрээ зураасан хээтэй том том боорцогнууд, кило хүрэхгүй үгүйтэй хатаасан гогцоо боов байв. Би юу ч авсангүй.

Энэ өдөр би туйлаас их өлсжээ. Эмээ надад цайны хийц дууссан гээд боорцог ч өгсөнгүй Хичээлдээ очсон боловч би хоолны тухай л бодсоор байв.

Хичээлийн дараа би өлссөндөө өөрийн эрхгүй аянчны майхан уруу оржээ. Би хатаасан гогцоо боов дөрвийг авч усанд явахдаа идэхийн тулд хоёрыг өвөртлөөд, үлдсэнийг гэрийн ар дээр тавьж хадгалав. Би усанд явлаа. Өнөөх боовноосажилсаар явав. Түүн шиг сайхан боов насаараа ч идэж үзээгүй шиг санагдана. Ааруул шиг хатсан боов аман дотор минь тачигнаж, арай гэж дийлэн хазахад минь арааны шүлс асгаруулам сайхан амттай байв. Би өлссөн нохой үхрийн том булуу мэрэхийн адил, гогцоо боовыг шүлсээ гоожуулан байж идэв.

Анхны цас ороод удаагүй байлаа. Хоёр эргээр нь цас хөвсийсөн их гол уур манан татуулан урсаж байв. Би гогцоо боовоо идэж дуустал будант алсын хязгаар уруу харж зогсов. Тэгээд усаа утгаад явлаа.

...Намайг ирэхэд Догоо гуай үүдэн дээрээ ташаагаа тулан зогсоод хилэн бадарсан нүдээр намайг харж байв.

-Аа, муу турсага, Боовны хулгайч! гэж тэрээр саахалтын хэрийн газраас хашгирав.

Би өчүүхэн хулгана адил бүлтгэнэсээр очлоо.

-Аа муу заяа нь орхимор! Хормойгоо чирсэн шидэл! Хүний хоол мөрөөрөө цуслахгүй, бас ирсэн хүнийг зүгээр байлгахгүй, хуруу хумсаа шургуулна гэнээ! гэж тэрээр бүр чанга хашгирч намайг дэргэдээ очмогц барин авч дээлийн захан дээрээс шүүрэхэд би эгээ л нэг шилэн дээрээсээ базуулсан нохойн гөлөг шиг хийд өргөгдөв. Энэ сацуу хэрэв жинчид ирээгүй бол юу / болох байсныг бүү мэд. Жинчид эмээг тайтгаруулан, аргадаж байж намайг тавиулав.

-За гайгүй, муу турсага чамайг... Хашраах цаг ирнэ! гэж Догоо авгай хэлж, уухилсаар суув.

Маргааш орой нь намайг хичээлээс ирэхэд Догоо гуай ихэд хөгжилтэй болсон байв. Надад хоёр ширхэг боорцог аяганд хийж өгөөд:

-Цайгаа бушуу уу? Одоо чиний бичгийг хамт үзэцгээнэ! гэв. Би гайхан байж цайгаа ууж дуусав.

-Номоо авчир! Бушуул! гэж Догоо авгай тушаахад би хэдэн дэвтрээ гаргаж ирэв.

-Үзгээ гарга! Бич! гэж Догоо гуай тушаагаад намайг дэвтрээ гаргахлаар

-Бич ингэж бич! гэж хэллээ. Би салганан чичирсээр бичиж эхлэв. Цэдэв би аянчны майханд ороод... гэж Догоо гуай дуудаж гарлаа. Надад энэ үг хэдийгээр аймшигтай байсан боловч би бичихээс өөр яах билээ.

-Бичив үү? Юугаа муухай харсан юм. Цааш нь бич!... боов хулгайлсан нь үнэн «Идэж байхад сайхан байлаа...» Бич бич! Бич ээ, моншоо «Идэж байхад сайхан байлаа. Баригдаж байхад муухай байлаа» Бичив үү? Алив харъя гээд Догоо гуай миний бичиг уруу бөхийн харснаа,

-За унш! гэж тушаав. Миний нүүр улайж, тийм гэхийн аргагүй улаан юм болжээ. Гэвч би уншихаас өөр аргагүй болов.

-Цэдэв би... аянчны майханд ороод боов хулгайлсан нь үнэн...

-Унш! унш!

-Идэж байхад сайхан байлаа гэнгүүт би эхэр татан уйлж гарав.

-Унш! гэм! үхсэндээ уйлсан турсага вэ. -Баригдаж байхад муухай байлаа...

Миний нүүр царай, дуугарч байгаа дууг сонсоод Догоо авгай ихэд сэтгэл ханасан бололтой хөхөрч гарлаа.

Үүнээс хойш, би Догоо авгайн зугааг гаргах амьтан болов. Догоо гуай уйтгарласан үедээ, өнөөхийг чанга дуугаар уншихыг надад тушаана. Би ч уншиж эхэлнэ. Тэр битгий хэл нэгэн удаа, гаднаас хэдэн авгай дагуулж ирээд,

-За та минь, манайх гэдэг айл нэг айхтар хулгайчтай болоод байна. Аянчны майхан ухаж боов хулгайлдаг хүн чинь энэ шүү дээ гэж намайг заав. Би ичиж улайн доош ширтэхэд авгайчуул над уруу гайхсан мэт харцгаав.

-Хулгайлсан юм нь энэ байна. Шинэхэн хулгайч болоод гэрийн ар дээр тавьчихсан байхлаар нь олсон юм гэж өнөөх гайт хоёр боовыг дээр өргөн харуулснаа Догоо гуай,

-Алив, тэр ном унш! Миний бичүүлснийг унш! Бушуу гэж тушаав. Би дэвтрээ гаргаж өнөөх гайт үгнээс ичин, хоолойгоо зангируулан байж уншихад авгайчуул бахаа ханатал инээлдэцгээв. Ялангуяа тэдний янцгаах мэт инээдэм дундаас, Догоо гуайн инээд бүр ч онцгойрч


-Байг даа, нялх амьтныг!

-Инээдтэй хүүхэд юм.

-Догоо чи арай дэндүү ширүүдэж байна гэлцэнэ.

Ингэж би Догоо гуайн таних танихгүй хүн болгоны өмнө ичиж зовон өнөө зүйлийг уншдаг

албатай болов. Би өшин уурлаж эхлэв. Хэдийгээр нас минь бага, цус минь шингэн ч гэсэн, ингэж амьтан хүний доог болох юу билээ? гэж бяцхан гарын хумсаа шигдтэл зангидаж хөмхийгөө зуув.



Тавдугаар бүлэг

Догоо гуай, аянчны авчирсан давсыг зарж эхлэв. Үдэш орой хүмүүс манайхаар орж, Догоо гуайтай уулзахад тэд шивнэсэн дуугаар ярилцан, мөнгө төгрөгөө өгөлцөж авалцах боловч олонх хүн:

-Дэндүү үнэтэй байна. Дайн тулааны цаг болчихоод хоршоо худалдаанд давс ирэхгүй болохоор л авахаас биш... өөр цагт сан бол гэлцэнэ.

-Энэ чинь миний юм биш. Хэрэв минийх байсан бол би хамаагүй хямд өгч байхгүй яах вэ... гэж Догоо гуай аргалаад мөнгийг дээлийнхээ халаас уруу шургуулж, давсыг хүүдийлж өгнө.

Үдэш тосон дэнгийн гэрэлд мөнгөө тоолон амандаа юм шивнэнэ. Нэгэн удаа би хөнжлийн завсраар эмээгийн мөнгө тоолохыг харав.

-Үүнийг тэдэнд, үүнийг өөртөө... гэж Догоо эмээ мөнгийг хоёр тусгай ялгаж байв. Би сая л ойлгожээ. Жинчид давсаа дөрвөөр өгөөрэй гэснийг Догоо гуай, зургаа хүргэж зарж байв. Дундаас нь шанага давс бүрт хоёр цаас хожиж байжээ.

Би өнөөх сувдан даруулгыг номынхоо цүнхэнд цаасанд ороон хийсэн байв. Ээж минь ийм даруулгатай болохсон гэж хэзээнээс хүсч байсан юм. Би өвлийн амралтаар харихдаа үүнийг аваачиж өгнө гэж, амь шигээ хадгалж байлаа. «Ээж минь, юутай их баярлах бол! Баярлаад зогсохгүй намайгаа үнсэж, миний хүү ухаантай хүү шүү» гэж айлын ээж нарт ярина вий гэж бодож байв.

Шинэ жил дөхөж байлаа. Манай сургуулийнхан шинэ жилээр сүлд мод чимнэ гэж хөл хөөрцөг болж байв.

Би хүүхдүүдийн концертонд орох болов. Энхээ бид хоёр хамтран дуулах болжээ.

«Ногоон зүлэг байнаа гээд

Наадмын ёстой бөх шиг

Хамаагүй чанга унагаавал

Харин би чинь уурлана шүү» гэж Энхээ эхлэхэд /

«Чи өөрөө барилдана гэчихээд

Чанга унагаавал уурлана гээд

Яагаа ч үгүй байхад хулчийдаг

Янзын жаал чи шүү дээ» гэж би дуулна.

Бид сургуулийн улаан буланд концертод бэлтгэж байв. Цэрэндолгор багш маань бидэнд дуу зааж, концертыг найруулж байлаа. Ийнхүү нэгэн удаа концерт давтаад харьтал эмээ их л ууртай суух бөгөөд намайг ормогц авдраас цаасанд боодолтой нэгэн зүйл гаргаж,

-Чи үүнийг хаанаас хулгайлсан бэ? Аа! гэж зандрав. Харвал, миний өнөөх хээрээс олсон сувдан даруулга мөн. Би үнэнээ хэлэв.

-Аа, тийм үү? Тийм юм бол чи эрт надад өгөхгүй яасан юм бэ?

-Би ээждээ хадгалсан юм л даа.

-Чи яагаад эзнийг нь олж өгөхгүй заавал ээждээ гэж хадгалдаг билээ? Сургуулийн хүүхэд чинь юм олбол эзнийг нь заавал олж өгдөг биш билүү? гэж Догоо гуай ширүүн гэгч асууснаа,

-Би үүний эзнийг нь олж өгнө! гээд далд хийв. Үнэндээ бол Догоо гуай эзнийг нь олж өгөөгүй гэдгийг би мэдэж байсан л

даа.

-Нэгэн удаа Баян улаанаас жин ирэв. Тэр жингээр ээж миний хоолыг явуулжээ. Надад гэж цаасанд боодолтой боов, цагаан тос, чихэр ааруул явуулсан байв. Догоо гуай цагаан тосноос хэлтэрхийг миний аяганд хийгээд:

-За ховрын юмыг үзмэгц битгий идчих гээд бай! Хааяа амталж байхад сайхан байхгүй юу? гээд авдрандаа хийв. Бас хэдэн кило ноос явуулж, хоршоонд тушаагаад дугуй булантай цай, тамхи авч явуулаач гэсэн байв.

-Чи энэ ноосыг хоршоонд аваачиж тушаа! Тэгээд дугуй булантай цай тамхи хоёр үнэнд нь аваад ир! гээд Догоо гуай намайг явуулав.



Би ч хоршоо уруу ноосыг үүрсээр очлоо. Тэнд хүн амьтан байсангүй, Түүхий эдийн эрхлэгч Данзан гуай намайг таньж, миний үгийг сонсоод ноосыг авч, нэг дугуй булантай цай, улаан дүнсний хамт өгөөд, дэвтэр дээр хорын харандаагаар юм тэмдэглэв. Гэвч энэ тамхи, цайг эмээ манайх уруу явуулаагүй болохыг би бүр сүүлд мэдсэн билээ. Учир нь тэр үед цай, тамхи их үнэ хүрдэг байв.

Зургадугаар бүлэг

Мичин жилийн цагаан сар болов. Шиний нэгний өдөр би сумын төвийн хэдэн айлаар хэсэж, хар гурилын боов хэдэн ширхгийг оллоо. Энэ боовнуудыг эмээ инээд алдан хүлээн авсныхаа дараа,

-Хүү минь, чамд шигшсэн гурилын ганц цагаан боов олдсонгүй юу? гэлээ.

-Үгүй... гэхэд минь

-Чамд энүүхэн хөдөөгүүр таньдаг айл бий билүү?

-Бий. Жавзан эгчийнх. Ухаагийн өвөр уруу бий. Бас А Самдан гуайнх... /

-Иш хүү минь, тэгвэл мордож үз. Эмээ нь морь олоод өгье гээд Догоо гуай гарч одсоноо удсан ч үгүй нэгэн морь хөтлөн ирэх нь сонсогдлоо.

Намайг байдгаар нь хувцаслуулав. Би ойрдоо өмсөөгүй шинэ даалимбан гадартай үстэй дээл, цагаан хурган малгайгаа өмсөж ёстой нэг цагаан сараар л хүн ингэж явдаг болов уу гэмээр ихэмсгээр ханиасаар морь унан сумын төвөөс шогшуулан гарав.

Энэ өдөр хөдөө нутагт хэдий зудтай боловч нартай байв. Цасны ширхгүүд нарны гэрэлд солонгорон харагдана. Уул хөндийн алсад адуу бэлчин бараан дүрс нь тэнгэрийн цэнхэр хязгаартай нийлэх мэт үзэгдэнэ.

Тал нутгаар морьтой золгоочид, хэсүүлчид нааш цааш давхилдах бөгөөд хурц, тод өнгийн хувцас нь ялгаран харагдана.

Яах гэж ийнхүү намайг хөдөө айлууд уруу явуулсныг би ойлгохгүй л байв. Юу ч гэсэн Догоо эмээд цагаан гурилын боов л хэрэгтэй л юм байж...

Би тэр өдөр нээрээ ч ганц цагаан боовтой болов. Түүнийг Жавзан эгч нэгэн дугуй цагааны хамт өгчээ. Бас хар гурилын дөрвөн боовтой болж, ганц төгрөг хуртэл олов.

Орой намайг ирэхэд Догоо гуай сайхан зантай угтав.

-Ээ хүү минь, даарсан байлгүй яах вэ. Суу, суу! Цай уу! Хоол ид! Дулаац! хэмээн Догоо гуай эгээ л нэг том хүн угтах мэт хэлээд

-За эмээдээ бэлгээ өгчих гэв. Би өврөө ухааж, айлаас олсон хар цагаан гурилын боовоо цөмий нь өгөв. Тэгэхдээ нэг цаасаа л өгсөнгүй.

-Аа бас сайн хүү шүү гээд эмээ боовнуудыг далд хийж, дугуй цагаанаас эмтлэн амсаж үзсэнээ,

-Май, үүнийгээ чи ид! Юм олсон хүн идэлгүй яах вэ гэж тун чухал зүйл буцаан өгөх мэт хоёр

гараа сарвайв.

Энэ өдрөөс хойш боовнуудыг би дахин үзсэнгүй.

Эмээ, надад боовнуудаас зөвхөн өгөөгүйгээр ч барахгүй улам Л ч харгис догшин болж, зарахгүй ажилгүй боллоо.

Үүр цаймагц намайг хэдэнтээ дуудсанаа сэрэхгүй болохоор өнөөх оосроосоо угз татан дээлийг минь хамж авна. Намайг өөрийн эрхгүй өндийхөд,

-Хормойгоо чирсэн новш! Настай хүнийг өрөвдөх хайрлахаа мэдэхгүй. Одоо бушуу гал түлээд, мөсөнд яв! гэж тушаана.

Би гал түлж, шуудай авч гол уруу явах бөгөөд хүйтэн хайруу өглөө мөс хагалах шиг хэцүү юмыг би үзсэнгүй. Жижиг сүхээр мөсийг дохино. Зузаан шил шиг тунгалаг мөс дороо хөндийгүйгээр чулуутайгаа барьцалдан хөлдсөн учир, надад юун амар дийлдэх билээ.

Арай гэж эмтлэн, шуудайны дундуур мөс үүрэхэд жавар хацар гарыг хайрч, гар минь улайн, даарснаас мэдээ алдана. Бээлий надад байсангүй...

Хичээлдээ би ямагт хожигдох бөгөөд үргэлж өлсгөлөн явна. Байрны хүүхдүүд хоолноосоо хааяа илүүчилж, хар гурилын тал мантуу ч юм уу, нэг үмх мах ч юмуу цаасанд боон авчирч өгнө. Энхтуяа их сайн жаал.

Тэр надад гэрээсээ идэх юм авчирч өгөх бөгөөд тэр нь хэдийгээр адууны мах боловч түүн шиг амттай зүйлийг би ер идэж үзсэн болов уу даа. Хичээл тармагц би гэртээ ирнэ.

Догоо авгай дөрвөн ширхэг боорцог өгөөд хар цай аяганд хийж,

-Бушуу идэж уу! Барилгын түүгээр явж зомгол түүж ир! гэж тушаав. Би барилгын түүгээр очиход тэндхийн ах нар цөм манай аавын танилууд байв.

-Аа Цэдэв хүү ирэв үү?

-Ааваас нь сураг байна уу?

-Алга аа. Зовох юмгүй хүү минь, цэрэгт сайн яваа гэнэ билээ. Тамсагбулагт байгаа гэсэн. Нутгийн улсууд сая очоод ирсэн

дээ,

-Энэ хүү Догоогийнд гэл үү? Айхтар чавганц даа. За хүү минь А май, наад жаахан зомголоо шуудайлж ав!... /

Би зомголыг яаран шуудайлна. Энэ завсар өнөөх ах нар ярьсаар л байна.

-Ай хөөрхий дайн ч болох юм билүү? Цаг хэцүү байна...

-Ах нар муусайн германуудыг баруун тийш нь хөөсөөр гэдэг

шүү.

-Тэд дийлнэ. Сайн санаатай хүмүүс юунд ч дийлддэггүй юм.

-Дайн болбол хэцүүдлээ. 39 он шиг юм болох вий гэж зовох юм.

-Дайн хаана ч дайн л юм. Идэх уух, өмсөж зүүх хүртэл ховордоод, энэ зуд хүртэл хажуунаас...

Би зомголоо үүрч буцаж алхана. Тэр дайн гэгч юу вэ гэж бодном. Бод бодсоор эцэст нь дайн гэгч манай Догоо эмээ шиг ийм л нэг ууртай чавганц байдаг болов уу гэж сананам. Ийм чавганц айл бүрээр ороод, идэх уухыг нь хамж, байдгийг нь цөлмөөд, хүмүүс эгээ л нэг над шиг хоосон нойтон явахыг дайн гэдэг болов уу гэж бодном. Тийм ч байж магадгүй.

Би алхсаар л байв. Бяцхан зүрх минь баясалтай цохилно. Аав минь сайн яваа. Тамсагбулагт байгаа. Аавынхаа тухай дуулсан болохоор сэтгэлд таатай. «Аав минь мөд ирнэ.

Манайх ойртон нүүж ирэхэд би гэртээ харина. Энхтуяа бид хоёр хурганд явж, Хэрлэнгийн эрэг дээгүүр ус харан хөл нүцгэн гүйлдэнэ. Тэгэхэд ийм их цас байхгүй.

Уул хөндий нөв ногоон байх биз. Ай яасан гоё вэ! гэж би хөөрөн бодном.

Намайг зомгол үүрээд ирэхэд Догоо гуай ер баярласан шинжийг үл үзүүлэх бөгөөд,

-Тэр хатавчинд тавь! Тэгээд цай уувал, уугаад, мөсөнд яв! гэж тушаана. Мөсийг би өдөрт хэдэн удаа үүрэх боловч Догоо гуай цай их уух учир дорхноо дуусаж орхидог байв.

Нэгэн удаа намайг мөснөөс ирэхэд Догоо гуай сайхан зантай угтав. Тэрээр тоотой хэдэн боорцгон дээр домбон саахрын хэлтэрхий тавиад

-Цай уу! Дараа нь хоёул гэртээ захиа бичнэ гэв. Намайг цайгаа ууж дуусмагц эмээ миний толгойг ихэд энхрийлэн нэгэн удаа илээд, Л

-За цаас ав. Бич! гэж тушаав. Би ч харандаа цаас бэлтгэлээ. «Сайн уу ээж ээ!» гэж Догоо гуай зүгээр л нэг хүнтэй мэндэлж байгаа юм шиг эхлэв.

-Би их сайн байна. Эмээ надад их сайн байдаг. Би өлсөөгүй, дандаа цатгалан байна. Та нарыг санаагүй. Наашаа ирээд хэрэггүй. Сургуулиа тарахлаар нэгмөсөн очно...

Ингэж бичүүлээд захиаг авч

-За одоо зомголд яв! Би энэ захиаг явуулна гэв.

Над хичээлээ унших зав олддоггүй байлаа. Нэгэн өглөө ийм явдал боллоо. Тэр өдөр маш дулаахан бөгөөд хаврын амьсгал орсон юм шиг байв. Ангийн цонхоор сайхан тунгалаг нар мэлтийтэл тусна. Тооны хичээл орж байв. Цэрэндолгор багш хүүхдүүдийн даалгаврыг

шалгав. Би муу дүн авлаа.

-Яаж байнаа, Цэдэв ээ! Яагаад муу авч орхив? Чи чинь гурван жил дараалан сайн сурсан шүү дээ! гэж Цэрэндолгор багш зэмлэнгүй байдлаар надад хэлэв.

Би толгойгоо маажин зогсов.

-Дүү минь, багшдаа үнэнээ хэлчих. Чи ер нь энэ жил сурлагаар их муу болжээ. Яагаад байна?

Миний нүүр улайн, чих хүртэл халуу оргиод явчихлаа. -Багш аа надад болох уу? гэж Энхээ тэндээс гараа өргөв.

-За!

-Багш аа, энэ Цэдэвийн байгаа айл байна шүү дээ. Догоо эмээ чинь их ууртай юм билээ. Цэдэвт идэх юм өгдөггүй. Бас дандаа хялалзаж цэхэлзэж, үргэлж л түлээ түү, мөс ч авчир гэдэг юм билээ. Тэгээд хөөрхий амьтан, Цэдэвт хичээл давтах зав олддоггүй байх аа...

-Тийм үү? гэж Цэрэндолгор багш дуу алдаад

-Нээрээ юү? гэж надаас асуув.

-Нээрээ шүү дээ? Тиймээ, Цэдэв ээ? гэж Энхээ асуув. Би юу ч гэж хэлж чадахгүй зогссоор л байв.

«Одоо яана? Багш эмээ дээр очно. Эмээ надад муухай зан А гаргаж зодно» гэж би айн бодном. /

«Үгүй, тэгснээс явсан дээр...Ээж дээрээ очсон дээр... оргоё» гэж. Би гэнэт шийдэв. Ийнхүү би хичээл тартал тэсэж ядан хүлээв. Хичээлийн дараа намайг гуанз уруу явахад Энхээ,

-Чи хаачих нь вэ? Харихгүй юм уу? гэлээ.

-Үгүй, чи явж бай!

-Чи надад гомдсон биш биз?

-Үгүй, үгүй...

-За тэгвэл баяртай!

Энхээг гүйн ормогц би шууд гуанз руу очив. Манай сум дорно зүг явсан машины зам дээр байдаг тул өдөр бүр машин ирнэ. Тэр машинууд гуанзны хажууд зогсож, даарч бээрсэн аяны хүмүүс гуанзанд хооллон дулаацаад явдаг байв.

Би гуанзанд бушуухан орж, нэг төгрөгөөрөө мантуу авав. Хар гурилын мантуу хоёр ширхэг өгдөг байлаа. Би халуу оргисон тэр мантууны нэгийг идэж, нөгөөг сүүлд идэхийн тулд

өвөртөө хийв. Гадаа гарвал гурван машин зогсож байх бөгөөд хүмүүс нь гуанзанд бужигналдана.

Би машин дээр сэмээрхэн гарч, тэвшний өмнө талд байх босгож тавьсан хэдэн шуудайтай ачааны дэргэд бөхийн суугаад дээрээсээ эсгийгээр даруулав.

Долдугаар бүлэг

Удаж удаж хүмүүс машин дээр сууцгаав. Азаар над дээр хүмүүс суусангүй байтал машин хөдөлсөн боловч нэгэн настай авгайн дуу гарч

-Даржаа чи шуудайтай юмаа, гурил түшүүлээд тавьчихсан юм уу? Урд тал уруу зай муудчихсан байх чинь! гэлээ.

-Үгүй шүү. Миний шуудайтай юм энд байгаа...

-Тэгээд цаадах чинь хэний юм тэнд оччихов... Та нар намайг шахаад болохоо байлаа...

Миний ухаан гарах шахав. Би дүүрлээ гэж бодоод бөхийн суусаар л байв. Гэвч өнөөх шуудайны эзэн залхуу хүн бололтой. Л

-За яршиг, машин нэгэнт хөдөлсөн. Донсолгоонд зай гарах биз? гээд хажуу тийш налж суухдаа яг миний толгой дээр тохойлдов. Надад хэцүү байлаа. Тэр их хүнд хүн бололтой. Хэсэгхэн зуур яваад миний толгой өвдөж эхэллээ. Хүзүү минь хөшиж, нүд эрээлжлэв. Би арай л ёо ёо! гэж орилсонгүй шүдээ зууж байв. Гэтэл ашгүй машин донсолж өнөөх хүн нөгөө тийш налав. Гэвч өндийхөөс өөр аргагүй боллоо. Хүзүү хөшөөд сүйд болж байв. Машин нэлээд явснаа зогсов. Жолооч нь машиндаа бензин хийх бололтой.

-Хүүе Даржаа, наад торхныхоо бөглөөг аваад энэ шолоонкийг шургуулаад орхи! гэж жолооч хашгирав.

-За, за! гээд Даржаа нь миний хажуу талын торх уруу өвдгөөрөө мөлхөхдөө хүзүүн дээр минь дөрөөлөв.

-Ёо ёо ёо! гэж би хашгирлаа.

-Хүүе та минь юу болох нь энэ вэ?

-Хүн орилоод байна!

Би тэсэж, нулимсаа хүчээр бариад шүдээ зуув. -Яалаа гэнээ?!

-Хүн "Ёо, ёо" гэж орилсон... Хаанаасыг хэн мэдэх вэ? Их л холоос орилох шиг болсон дог.

-Дулмаа чиний чих буруу дуулсан байлгүй яахав гээд Даржаа,

-За соров уу? Болсон уу? гээд хойшоо болов.

Хэдийгээр мөрөн дээрээс Даржаа гуай холдсон боловч дараагийн аюул намайг зовоож эхлэв. Энэ бол бүтэж үхэх аюул байв. Машин зогсож байхад үүгээр түүгээр сийгэх салхи алга тул бор эсгийн дор бүгчимдэж эхэллээ.

Би бүтэж үхэхгүйн тулд эсгийнд нүх гаргах гэж хумсаараа эсгийг сэмлэн урав. Яг машин хөдлөхөд эсгий цооров. Хүмүүс ч жавраас эмээн бөхийцгөөв. Эсгийг хуруу хэртэй цоолж, түүгээр хүмүүсийг ажиглан, өөрөө чөлөөтэй амьсгалж явав.

Миний хажууд дах нөмөрсөн бүдүүн хүн байна. Өнөөх Даржаа А гэгч тэр бололтой. Нөгөө талд настай авгай хөвөнтэй дээл / толгой дээгүүрээ нөмрөөд суужээ. Цаашаа харахад бас нэг хэдэн хүн сууж байв.

Гэнэт үүргэлж байснаа сэрсэн юм шиг өнөөх авгай над уруу харж аймшигтай чангаар

-Ай! гэж хашгирлаа.

-Юу болов оо Дулмаа? гэж Даржаа толгойгоо өндийлгөн асуув.

-Чи түүнийг хар! Эсгийн цоорхойгоор хүний амьсгаа харагдаж байна! гэж Дулмаа шивнэн хэлэв. Би амьсгаагаа дотогш татав. Даржаа нааш харснаа инээд алдав.

-Чи мөн хөгийн хүн ээ дээ Дулмаа! Зүгээр нэг цоорхой л байх чив! гээд Даржаа доош бөхийн тамхиа татав.

Би амьсгаагаа гаргаж уртаар амьсгаа авав. Дулмаа гуай над руу нүд салгалгүй ширтэнэ.

-Айя! гэж тэр ахиад дуу алдав.

-Та нар чинь юу болоод байна? гэж хойноос нэг хүн асуув. Дулмаа гуай энэ удаа юм хэлсэнгүй. Нүдээ анив. Тэгээд харахад нь би өнөөх нүхээр хэлээ булталзуулж байв.

-Ээ бурхан тэнгэр! гэж Дулмаа ахиад дуу алдан, тэгэхэд машины бүх хүмүүс инээлдэв. Цаашаа харж суусан хүүхэн над руу эргэж,

-Та чинь юу л болоод байна даа? гэхэд Дулмаа гуай над уруу дохив.

Энэ үед миний амьсгаа харагдсан байлгүй яах вэ. Өнөөх хүүхэн айж царай нь жигтэйхэн болоод явчихлаа. Тэгээд цааш эргэж бусад улсдаа шивнэв.

-Нээрээ тийм байна...

-Цантчихаж...

-Амьд амьтан л байгаа хэрэг.

-Оргодол хулгайч ороод суучихав уу? гэж жиг жуг гэлцэв. Гэнэт Даржаа гуай миний дээгүүрх эсгийг хүчит гараар угз татан авав. Би айж хулгасан амьтан хүзүүнийхээ чилээг гаргах гэж өндийлөө. Л

-Ээ, базарваань! Хэлээгүй юу! гэж Дулмаа дуу алдав.

Аяны хүмүүсийн ширүүн нүд над уруу ширтэнэ. Энэ сацуу ч нэг нь машины бүхээг цохиж, машин ч зогслоо. Юу болов? гэсээр жолооч буув.

-Наашаа өнгий! үүнийг хар! гэж Дулмаа гуай бүхнээс түрүүн хашгирлаа.

Жолооч тэвш уруу авиран харснаа намайг сая л үзэж, -Хүүе энэ чинь юу вэ? гэхэд -Сайн эр! - Оргодол!

-Намайг хичнээн айлгав аа! гэлцэнэ.

Би доош бөхийн хэсэг зогссоноо үг дуугүй машинаас буув.

-Хүүе чи хаачих нь вэ? гэж жолооч миний мөрнөөс татна.

-Гэртээ харина...

-Гэр чинь хаана вэ?

-Баян-Улаанд...

-Ээ дүү минь чи буруу машинд суусан байна. Баян-Улаан чинь бүр сумнаас нөгөө тийш явдаг замтай байхгүй юу? гэж жолооч бодол болон хэлээд

-Гэртээ харих гээд сургуулиасаа оргочихсон эр байж, үгүй ээ мөн сайн эр ээ!

-За байз, үүнийг чинь яадаг хэрэг вэ?

-Буцах машинаар явуулж орхиё. Жаахан хүлээвэл машин ирэх байлгүй.

-Хээр зогсоод осгох нь. Дараагийн сум хүрээд, хүнд захъя. -Нээрэн тэгье гээд жолооч намайг машиндаа суулган цааш хөдлөв. Хүмүүс надаар тоглоом хийж шуугилдаж байв. -Энэ золиг нэг л учиртай оргосон доо! гэж Дулмаа гуай хэлээд -Хүү чи яагаад гэртээ харих болов? Гэрээ санаа юу? Эсвэл өөр шалтгаан...

-Гэрээ санаад... гэхэд минь,

-Үгүй чи үнэнээ хэл. Май энэ чихэр ид! Тэгээд үнэнээ хэл. А Энэ их хүйтэнд ер хэдий гэрээ саналаа ч гэсэн аль нэг машинд / хамаагүй суух ёсгүй дээ, нэг учир байна гэв.

Би Догоо эмээгийн тухай ярьж гарлаа. Хүмүүс энэ түүхийг нулимс урстал уйлж байж, бас нулимс урстлаа инээж байж сонсов.

-Тэгнээ тэгнэ. Үүний нүд тэгж хэлээд байсан юм! гэж Дулмаа гуай хэлж,

-Дүү минь одоо буцаж очоод тэр Догоогийнд битгий оч! Цэрэндолгор багш дээрээ л оч! Тэгээд байранд суусан нь дээр. Юу гэсэн үг вэ. Тэр чинь их муу хүн байна.

-Нээрээ тэг, дүү минь! Бас нутгийн амьтныг дамаар шулж байдгийг нь дуугүй өнгөрч болохгүй! гэж Даржаа гуай хэлэв.

Дараагийн суман дээр тэд намайг орхиж явахдаа, нэг нэг цаас (төгрөг) өгөөд, захисныг заавал биелүүлээрэй, зоригтой байгаарай, гэж захицгаав. Дулмаа гуай бүр намайг өрөвдсөндөө уйлж явав.

Өртөөний гэрт би хоёр хонов. Машиныуд дандаа л баруун талаас ирээд дорно зүг явав. Энэ машинууд брезинтээр бүтээсэн сум ачиж, заримы нь хойноос их буу зүүсэн байв. Хоёр хоносны дараа өртөөний сайхан зантай өвгөн гуай нэгэн цэргийн машинд намайг гуйж суулгаж өгөв.

Наймдугаар бүлэг

Намайг суулгасан машин сургуулийн өмнө зогсоход, мэдсэн юм шиг Цэрэндолгор багш маань гараад ирэв.

Жолооч өртөөний өвгөний захиснаар миний тухай ярьж, намайг хүлээлгэн өглөө. Цэрэндолгор багш ч намайг дуу алдан тэвэрч авав.

Тэгээд,

-За дүү минь, ангидаа очъё доо! гээд гараас хөтөлсөөр ангидаа оров. Манай ангийнхны баярласан гэдэг жигтэйхэн. Намайг эрж тэд энд тэндгүй явжээ. Тэгээд муу юм бодож ихэд гунигтай болсон байв. Гэтэл би зүв зүгээр хүрээд очдог. Тэгэхлээр баярлалгүй яах вэ! Ялангуяа Энхээ бүр ч их баярлаж байв.

-За хүүхдүүд минь сууцгаа! гээд багш, намайг ширээнд минь суулгаж,

-Цэдэв маань эргээд ирсэн нь юутай их баяр вэ! Тийм ээ, хүүхдүүд ээ! Харин харамсалтай нь оргож зугтсаны оронд багшдаа, нөхдөдөө үнэнээ хэлэх ёстой байв. Энэ бол Цэдэвийн буруу. Бид нар бас Цэдэвийнхээ гэр орны амьд-ралтай ойртоогүй нь бас буруу. За ингээд одоо Цэдэвийг бид байранд суулгана. Аль нэг муухай санаатай хүнд Цэдэвийгээ загнуулах ч үгүй, зарцлуулах ч үгүй. Тийм биз хүүхдүүд ээ.

-Тийм ээ! гэж бүгдээр нирхийлгэв. Яг энэ үед хаалга сэвхийн нээгдэж, Догоо гуай уйлсаар орж ирэв.

Тэрээр намайг тэврэн авч, нүүр нүдгүй үнсээд, үглэн дуулж гарав.

-Ээ, бурхан минь, миний энэ хэдэр зан хүүхдийг алах шахав шүү дээ. Ингэж яваад чоно нохойд идүүлсэн бол яана! Осгосон бол яана! Ээ бурхан.

-Догоо гуай та гарзнаж байна уу? Бид ангийн хурал хийж байна гэж Цэрэндолгор багш зөөлхөн хэллээ.

-Ангийн хурал аа?! За за... Би одоохон... гээд над руу эргэж,

-Тармагц хүү минь харьж үз. Эмээ нь сайхан хоол унд хийгээд хүлээж байя гээд гарлаа.

-За тэгээд Цэдэв өөрөө юу гэж бодож байна даа? гэж надаас багш тайван асуув.

-Би сургуульдаа хайртай. Би байранд сууна. Би... Догоо гуайнд очихгүй. Догоо гуай намайг зоддог... гээд л би уйлж орхилоо.

-Зүйтэй. За тэгвэл хүүхдүүд ээ одоо Цэдэвийгээ байранд нь оруулж өгье.

Хүүхдүүд шуугилдан гарахад би тэдэнтэй хөтлөлцөн гүйж байв. Намайг тэд саруулхан том

дотуур байрны тасагт оруулаад нэгэн модон орыг

-Энэ чиний ор! гэж заав. Бас Энхээ энэ тэр нярваас ор дэр п авчирч орыг минь засаж өгөв.

Хоёр хүүхэд Догоо гуайнхаас миний хувцас хунарыг авчрахаар гүйн одлоо.

Багш намайг халуун усны байшинд авчирч, тэнд байсан нэг эгчийг дуудав.

-Манай Цэдэвийг нэг сайхан угаагаад орхиорой. Шинэ цуу ямбуу цамц, өмд өмсгөөрэй. Өнөөдрөөс эхлээд манай сургуулийн дотуур байрны хүүхэд болж байгаа юм шүү! гэж захилаа.

Би усанд оров. Ай ямар сайхан гэж санана. Энэ бол миний анх удаа орж үзсэн халуун ус байв. Би хирээ сайтар угаав. Ингэж би анх удаа 1944 оны мичин жилийн зудны өвөл дайны амьсгаагаар зан нь эвдэрсэн Догоо гуайн хар хараал, хатуу гараас ангижирч, сургуульдаа бүрмөсөн очсон юм даа.

Оршил

Хүүхдүүд та нар цөмөөрөө аавтай. Аав бүхэн янз бүр. Зарим нь бүдүүн. Зарим нь нарийхан, эсвэл өндөр, эсвэл нам, нэг нь сахалтай, нөгөө нь сахалгүй... Харин миний ярих гэж байгаа Цэцгээ, Санаа хоёрын аав бол маш бүдүүн, тэгсэн мөртөө сахалтай хүн. Харин ээж нь гэвэл эгээ л нэг таримал улиас шиг эгц нуруутай, бас тэгээд жигтэйхэн нарийхан хүн. Хэрэв нэг өдөр аав чинь гэнэт цэцэрлэгийн хүүхэд болчихвол та нар яана гэж бодож байна?

Харахад яг л аав мөн атлаа, харин ердөө л таван настай Санаа шиг жаахан хүүхдийн зангаар аашилж, тэгээд зогсохгүй зүггүйтэж байвал ямар инээдтэй болох вэ?

Ер нь бүдүүн том сүрлэг атлаа сахалтай хүүхэд байж болох уу? Энэ тухай урьд нь Санаа, Цэцгээ хоёр бодсон юм биш. Тэр хоёр тоглохдоо, нэг нь сургуулийн хүүхэд, нөгөө нь автобусны кондуктор болж тоглодог юм байж.

Нэг орой аав ажлаасаа ирээд хоол идэж суутал Санаа дэргэд нь очиж, хэрхэн хоол халбагадаж байгааг нь харах гэсэн юм шиг тонгойн нүүр өөд хараад:

-Аав аа... аав! Та том болоод хэн болох вэ? гэж асуужээ. Тэгэхэд аав нь толгойгоо өндийлгөж хараад

-Чи өөрөө хэн болох вэ? гэж асуув.

-Би юу? Би том болоод сургуулийн хүүхэд болно... хэмээн Санаа хүссэнээ яг үнэнээр нь хэлэв.

-Эгч том болоод автобусны кондуктор болно гэдэг... Аав та нээрээ хэн болох юм бэ? гэхэд аав нь таваг шөлнөөс нэгэн том халбагыг балгаж орхисноо,

-Би юү? Би том болоод цэцэрлэгийн хүүхэд болно... гэлээ. Санаа хи, хи хэмээн хөгжилтэйгээр инээв.

-Ийм том сахалтай хүүхэд байдаг гэнээ?... гэж инээсний хариуд аав нь:

-Би тэгээд цэцэрлэгийн хүүхэд болж, хүүхэд байх ямар А жаргалтай хийгээд, та нарыг өсгөж өндийлгөх гээд аав ээж нар / хэрхэн зовдгийг та нарт үзүүлнэ гэлээ.

Бүх явдал үүнээс л эхэлсэн юм.

1.Цэцэрлэгт

Нэг мэдэхэд Санаа том болсон байв. Тэр бүх байшингийнхан байтугай ойр хавийн хороолол, тэр ч бүү хэл, сургууль дээрээ хамгийн өндөр нь гэж гайхагджээ. Тэгээд бүр сурлагын дэвтэр нь онцоос өөр дүнгүйг яана. Санаа хичээлээсээ тараад, замын гарцаар гүйн гарч, гэртээ ирлээ. Тэр маш их баяртай байсныг зүйрлэн хэлэх юм алга.

Ер нь нэг л мэдэхэд сурагч, тэр ч байтугай бүр бага ангиар дамжина гэлгүй, шууд л ахлах ангийн хүүхэд болчихсон байвал хэн чинь ч баярлах шүү дээ. Тийм болохоор Санаа ихэд баясгалантайгаар дуу аялж гадаа хаалганы тэнд хэвтэж байсан нэгэн бөөрөнхий чулуут багынхаа зангаар шүүрэн авч, тэртээд байсан төмөр хайрцгийг дангинатал шидээд гэртээ очив. Хаалганыхаа товчийг дарлаа. Тэгтэл ээжийн оронд нэгэн өндөр гэгч нуруутай сайхан эгч хаалга онгойлгож өглөө. Санаа, гайхсан гэдэг жигтэй. Тэр эгч, ээж шиг нь өндөр тэгсэн мөртөө их мариатайг үзвэл, хэрэв жаахан хүүхэд байсан бол Цэцэгээ эгч яах аргагүй мөн гэхээр аж. Бас тэр эгчийн царайнаас нэг харахад аав, бас нэг харахад ээж хоёулаа зэрэг харагдах шиг болно.

-Ор, ор миний дүү! Цайгаа уу! гээд эгч нь дүүгээ хөтөлсөөр гал тогооны өрөөнд орлоо. Одоо үзвэл, хааяа чихэр булаацалдах юм уу, хэн нэгнийхээ болохгүй явдлыг ээж, аавд бушуухан «Алтан хошуу» хүргэснээс болж зодуулдаг Цэцэгээ эгч, ийм том болсон бололтой.

-Цайгаа уу, миний дүү!

Би одоо том болоод автобусны кондуктор болсон болохоор чамайг хуруугаа хөхдөг, унтаахай, халтар нүүрт энээ тэрээ гэж ердөө ч шоолохгүй. Яалаа гэж том эгч чинь тэгэх билээ дээ. Одоо хоёулаа ёстой эвтэй байна. Аав, ээжийгээ ёстой л хүүхэд Л шиг асарна. Тэд маань бид хоёрыг том болгох гэж зөндөө зовоо шүү дээ гээд эгч өмнө нь талх, тос, ёотон өрж, аяганд цай хийлээ. Тэгээд гал тогооны өрөөг янзлахдаа хэлэх нь:

-Би одоо зорчигчдын үйлчлэгч. «Хүмүүс ээ, билетээ аваарай! Битгий шахалдаарай. Урд зай байна шүү. Өвгөн настай, хүүхэдтэй хүнд суудал тавьж өгөөрэй!» гээд л хүмүүст үйлчилнэ. Естой гоё. За эгч нь ажилдаа явлаа. Чи цэцэрлэгээс аавыг авахаа мартуузай...

Тэгээд эгч сав суулгаа арчиж дуусгаад, гарч одлоо. Тэгэхдээ ээжийн барьж явдаг урт оосортой цүнхийг санжигнуулсаар холдлоо. Санаа, гайхан цонхоор харна. «Ямар сонин хэрэг вэ! Аав цэцэрлэгт байна гэнээ!» гэж бодтол саяхан нэг орой ярьж байсан нь санаанд орлоо. Тэр яриаг бодоод Санаа инээд алдлаа. «Үнэхээр аав нь цэцэрлэгийн хүүхэд болсон гэж үү!? Тийм том, бүдүүн байж, цэцэрлэгийн жаалууд дунд будаатай сүү ууж суух гэж үү! Бас тэгээд, том мөртлөө жаахан жаалуудтай зэрэгцэн зогсоод

«Маамуу нааш ир

Манайд хоёулаа тоглоё

Аав ээж хоёрын

Авчирсан тоглоом бий шүү гэж дуулах гэж үү?».

Санаа, эгчийнхээ үгэнд орж бушуухан хувцсаа өмсөөд цэцэрлэг уруу явав.

Цэцэрлэг тарж, аав, ээж нар хүүхдүүдээ дагуулаад харьж байна. Зарим нь Санааг харж, «Энэ хүүхэд хэнийг авах гэсэн юм болоо» гэж гайхна. Тэгтэл сонин юм боллоо. Цэцэрлэгийн багш, өчигдөрхөн Санааг хүлээж авч байсан мөртлөө, таньсангүй.

-Чи хэнийг авах нь вэ? гэж асууж байна.

Санаа үүдээр шагайн харлаа. Аав хэдэн жаалуудын дунд инээд алдан тоглож байна. Тэгж тоглоход сахал нь шөрвөлзөн, гүйхэд шал доргих шиг болно.

-Хүүе Зандраа! Томоотой бай! гэж багш аавыг зандраад А Санааг юм хэлсэн юм шиг /

-Алиныг гэнээ? гэж давтан асуув.

-Тэр сахалтай... жаалыг... гэж баахан ичисхийн долоовор хуруугаараа заалаа.

-Зандраа, яваарай! Гэрээс чинь хүн ирсэн... Май чихрээ! гэж баавгайт чихэр нэгийг өгөв.

Тэгэхэд аавын баярласан гэж жигтэйхэн. Тийм том хүнээс гарамгүй зан гарган гурван удаа цовхроод, эгээ л Санаа цэцэрлэгт байхдаа тэгдэг шиг багшийн гараас чихрийг булаах шахам авсны дараа нөгөө булан тийш гүйн очиж зүгээр тоглож байсан Соёлмааг гижигдэн унагаад, Болдоогийн тоглоомыг нураасны дараа «үгүй ер яасан зүггүй монш вэ? Зүгээр байсан хүүхдийг уйлуулаад!» хэмээн загнуулж байж сая гарч ирэв.

-Энэ хүүхдийн дотуур хувцсыг солимоор болжээ. Нусны алчуурыг өөрөөр нь угаалгаж сурга! Бас хормогчийг нь индүүдээрэй. Арав хүртэл тоолуулж сурга! гэхчлэн багш нь яг л Санааг ээжид нь захидаг шигээ захиж явууллаа.

Дөнгөж нэг юм тэсэж байж багшийн үгийг дуулангуутаа л тэр хувцасны өрөөнд шуугилдаж байгаа жаалууд руу туулай шиг л дэгдэн орлоо. Тэгээд Алимаагийн сандлыг унагаж, Баярын өмсөж байсан гутлыг авч зугтаах зэргээр хэсэг үймүүлсний хойно сая өөрийнхөө шүүгээг онгойлгов. Хэрэв тэнд байгаа юмсыг олон хүн харсан бол лав айсандаа болоод гэдрэг ухрах байсан. Өмд гутлаа нэгэн дор хумхин тавьсан нь ердөө л резинэн бөмбөг шиг хаалгаар өнхрөн орж ирлээ. Бас пальто нь дээрээс нь унаж, нэг гутлын инээд нь тун их хүрсэн байртай улаан хэлээ унжуулан инээх маяг үзүүлжээ.

Энэ бүхнийг хараад Санаа ичиж байсан боловч нэгэнт өөр хүнийх биш, өөрийн л аав болохоор хувцаслахаас биш яах вэ. Гэвч, аав нь Санаагийн багынхыг яг дууриасан хүүхэд болсон болохоор хэлсээр байтал гутлаа буруу харуулж өмсөөд, хорьсоор байтал эрхий хуруугаа амандаа хийн амтархан хөхөж гарлаа.

-За битгий тэг... хуруу нь муухай болчихно... за битгий... гэхчлэн Санаа хичнээн гуйгаад ч нэмэр алга. Харин болихын Л оронд хээв нэг, «Тэгвэл би яавлаг иднэ!» гэж зүтгэж байна.

-За, за... тэгнэ, явья... гэхээс өөр үг Санаад олдсонгүй. Тэгээд маш их ичсэнээс нүүр хийх газраа олж ядаад, бушуухан л гарахын түүс болж аавын гараас бараг чирэх шахам хөтлөн холдлоо.

2. Автобусанд

Цэцгээ ажил дээрээ ирж, төв замд хуваарилагдсан автобусандаа суугаад, зорчигчдод үйлчилж эхэллээ. Гэрэл туссан цэлгэр том автобусанд суугаад, хүмүүст толгой дохин мэндэлж, үйлчилнэ гэдэг ёстой гоё. Чухам том болоод ингэж л явах юмсан гэж Цэцгээ хэдийнээс мөрөөдсөн билээ. Тэгтэл нэг л өдөр санасан хэрэг бүтнэ гэдэг сайхнаа даа.



Цэцгээ инээмсэглэн, цүнхнээсээ билет авч хүмүүст тараан, мөнгийг маш шаламгай хураагаад

-Урагшаа ахиарай, Уухай! Урд зай байна шүү. Тэр хүн наад өвөөдөө суудал тавьж өг! Дараагийн буудал... гэхчлэн цангинатал зарлана. Тэгтэл Цэцгээгийн сургуулийн дэргэд А автобус зогслоо. Баахан охид орж ирсний дотор, ээж нь байна. / Тэр, Цэцгээгийн сургуульд явахдаа өмсдөг хүрэн даашинзыг, хар паарчигтай нь өмсөөд, бас үсээ ихэд гоёх гэсэн байртай хоёр салаа болгон, угт нь тууз зүүжээ. Цүнхээ хайш яйш барьсан гарынх нь хоёр хуруу дан черниль болсноор барахгүй хацарт нь мөнөөх чернилээр том гээчийн толбо үлдээжээ. Охидууд автобусны хойд талд бөөгнөрөн шивнэлдсэнээ, зарим нь билет авахаар мөнгөө цуглуулсан боловч ээж, тэднийг өөр рүүгээ дуудаад нэг юм хэллээ. Тэрнийг нь Цэцгээ сайн сонсов.

-Яах юм!... Намайг дагаад урагшаа зүтгээд бай! Би ёстой гоё аргална. Тэгээд, билетгүй явчихна гэхэд нь охидууд яах юм бэ гэсэн шиг бие бие рүүгээ харснаа шуугилдан, урагшаа гүйв.

-Хүүе билетээ авцгаа! гэж Цэцгээ ээжээсээ ялихгүй жаахан зовж сулхан шиг дуугарсан боловч нэмэр алга. Үнэндээ ээж нь, ердөө л хоёрдугаар ангийн Цэцгээ шиг л харагдаж байв. Тийм өндөр, гоё туранхай авгай жаахан охин шиг зан гаргана гэдэг үнэхээр инээдэмтэй мөртлөө, гайхмаар байсныг яана. Гэтэл хэзээ ч билээ, Цэцгээ өөрөө мөн, охидыг дагуулан ингэж автобусанд үймүүлсэн түүх нэг бус удаа тохиолдсон болохоор ээжийн нь зан ааш, өөрийн нь багынхыг давтаж байгаад бүр ч байх суух газаргүй болно. Нэг харсан чинь дороос нь өргөс хатгасан юм шиг ээж үсрэн босоод жолоочийн бүхээг уруу очиж тэнд өндөр настанд зориулсан нэг суудал дээр лагхийтэл суув. Дараагийн буудал дээр өвөөгөөс нь ах байрын таягтан өвгөн орж ирээд ийш тийш суудал харснаа «энэ охин л суудал тавьж өгөх байх» гэж бодсон бололтой.

Цэцгээгийн ээжийн хажууд очиж зогсов. Гэвч, ээж тун босохтой манатай, харин ч яг Цэцгээгийн багынх шиг, зориуд инээд алдаад чанга гэгчээр дуу эхлэв.

-Дуул дуул, охин минь... Хөөрхөн дуулдаг охин байна... гэж өвөө зогссон хэвээр хэллээ. Цэцгээ үнэндээ тэссэнгүй. Шууд ээжийн дэргэд очоод, гараас нь татан босгож

-Та энд суу! гэж өвөөг суулгав.

-Аа, ямар сонин юм бэ! Энэ чинь Цэцгээ шүү дээ, Автобусны Л кондуктор болно гэдэг юм л даа. Аа ёстой гоё. Өнөөдөр, бүтэн өдөржингөө машинаар нь зугаална даа! гэж ээж яг л нэг жаахан охин шиг хэллээ.

-Нээрээ юү?

-Нээрэн.

-Аа ямар гоё вэ! Одоо хичээл тарсан болохоор хэдүүлээ зугаалаад байя. Би л лав Нойпоо эгчийг кондуктор байхад тэгж зугаалдаг байсан гэж охидын нэг нь нэмж байна.

Ингэснээр бүгд зоригжин, олон хүүхэд нь ээжийнхээ тал талаас шавах адил, нөгөө хэдэн охид Цэцгээ тийш (яг л Цэцгээ хааяа үерхдэг охидтойгоо явж байгаад ээжийг тааралдахаар шавдаг шиг) дайрлаа. Ингэхэд Цэцгээ, бушуухан зугтаж, кондукторынхоо байранд орохоос өөр замгүй боллоо. Хүмүүс инээлдэнэ. Автобус цааш хөдөллөө.

Өөрийн ээж юм болохоор Цэцгээ өмнөөс нь тэр ч байтугай мөнөөх хэдэн охины мөнгийг хамт төлөхөөс өөр аргагүй болов. Тэглээ ч гэсэн ээж нь үерхдэг охидтойгоо, эгээ л нэг бүр нялх, цэцэрлэгийн хүүхдээс долоон дор зан гарган шуугилдсаар байв. Тэд, сандал дээр бөөгнөрөн хэсэг дуулснаа, нэг нь чанга исгэрч, дараа нь хаанаас ч олсон юм бүү мэд, шохой гаргацгаан, автобусны суудлын ард, өнөөдөр өгсөн гэрийнхээ даалгаврыг бодож эхэллээ.

-Та нар болиоч! гэж хичнээн хэлэвч нэмэр алга. Эцэст Цэцгээ шохойг нь булаан аваад, шууд л ээжийгээ гэрт нь хүргэхээр гар дээрээс нь чирэх шахам буулгалаа.



3. Тоглоом

Энэхэн мөчөөс эхлээд л Цэцгээ, Санаа хоёр аав ээжийн \ оронд хэрхэн хүүхэд маллах хэцүү хийгээд, хэрэв томоотой байж гэм, хүүхэд байх шиг жаргалтай юм үгүй гэдгийг амсаж ойлгож эхэлсэн юм даа. Ямар нэг үл бүтэх амьтан аав ээжийг нь, том чигээр нь сургуулийн 2 дугаар ангийн сурагч, цэцэрлэгийн жаал болгож орхижээ. Тэгээд тэд, яг л өөрсөд шиг нь зантай хүүхдүүд болжээ. Аав нь бол, эрэгтэй болохоос биш Санаатай яг адилхан, ээж туранхай болохоос биш Цэцгээтэй адилхан зантай хүүхэд болж дээ.

Ням гаригт Цэцгээ, Санаа хоёр их ажилтай өнжлөө. Аав, ээж хоёр нэгэнт гадаа тоглоомын талбайд бяцхан хүүхдүүдтэй тоглохоор явсан болохоор тэдний цэцэрлэгийн хувцас, сургуулийн нь бэлтгэлийг хийх гэж тэр хоёр ихэд ядрал.

Эхлээд Цэцгээ, шавар шавхай болсон гутлыг нь янзалж тосолж тавиад, ээжийн черний болгосон даашинзыг угааж дэлгэснээ аавын урт шалбуур өмдийг индүүдэхээр авгал дотроос нь өдий төдий чулуу, шалан дээр унав. Тэгсэн чинь, аав яг л Санаа шиг, элдэв чулуугаар халаасаа дүүргэж явдаг хүүхэд болсон юм байжээ.

Нэгэнт аав, ээжийн оронд Цэцгээ, Санаа хоёр болсон юм болохоор тэр бүхнийг цэвэрлэхгүй бол яаж болох вэ. Гэр орон янзалж, хог шороо арилгаад, бас шалаа угаан, тоосоо арчих зэргээр ганц бүтэн сайнд ядартлаа ажил хийгээд тэр хоёр бас гадаа тоглоод өлссөн болов уу гэж аав, ээж хоёрыгоо хооллохоор дуудлаа.

Тэгтэл ямар, амьтад ирсэн гэж бодож байна. Мөнөөхөн өмссөн гоё улаан цуваа ээж нь яг голоор нь цуу татаад урчихсан, хоёр гартаа уралдааны туг дэрвүүлэх адил барьсаар ирдэг байна. Харин аав, усан хоолойны нүхэн дотор бусадтай хамт ноцолдсоноос толгой үс нь шороо болоод, өрөөсөн өмдний нь өвдөг бас цуурчээ.

Гэтэл энэ бүхэн яая гэхэв, хамгийн гол нь ээж, охидоосоо ихэд айх бололтой, ардаа нэг юм хичээнгүйлэн нуужээ. /

-Наадах чинь юу юм бэ? Алив үзье! гэж Санаа ээж рүүгээ дөхлөө.

-Миний юм! хэмээн ээж гэдэргээ хоёр алхам ухарсан боловч шалан дээр нэг юм тар няр хийн чимээтэй унав. Үзвэл Санаа, Цэцгээ хоёрын тун саяхан, хэдхэн хоногийн өмнө жаахан хүүхэд байхдаа ихэд аргилж гамнаж тоглож байсан хөөрхөн хүүхэддэй нь хөл гараараа салаад хэвтэж байна. Түүнийг хараад Санаа өөрийн эрхгүй уйлав.

-Миний хөөрхөн хүүхэддэй «Йй, ий» гэж ирээд л том болсон гэхэд гайхмаар дуу гаргаж байгаад уйлав. Тэгэхэд ээж, гэмшсэн янзтай зогсон, харин аав, яг л Санаагийн багынх шиг хуруугаа хөхсөөр харж байна.

-Хайран тоглоом!... Одоо яая гэх вэ дээ гэж Цэцгээ хэмхэрсэн хүүхэддэйг авч зайлуулаад шалаа цэвэрлэж гарав.

-Би дугуй авна гэж гэнэт аав хуруугаа хөхөхөө болиод хэлэв.

-Ямар дугуй?

-Унадаг дугуй... Хүүхдүүд гурван дугуйтай хөөрхөн дугуйгаар тоглосон. Би бас тэгнэ! гэж эгээ л Санаагийн багынх шиг аав зүтгэж байна.

-Өнөөдөр яршиг. Сүүлд авья гэж Санааг хэлэхээр аав шалан дээр өөдөө харан унаад сахлаа шөрвөлзүүлэн, хоёр хөлөөрөө шалыг бөмбөрдөж гарлаа.

Тэгээд бас том, том нулимс дуслуулан хана цуурайтгал орилохыг яана. Хэрэв тэгж бархираад удсан бол лав гадаа айлын хүн орж ирж бөөн шившиг болох байсан тул Цэцгээ эгч бушуухан аргадав.

-За битгий тэг! Бид хоёр одоохон дугуй авч өгье гэхчлэн аргадан бас хоолны шүүгээнээс нэгэн том алим өгч байж аавыг дуугүй болгов.

Тэгээд дорхноо гүйж дэлгүүрээс хөөрхөн дугуй авчирлаа.

-Оо ёстой гоё! үүгээр чинь тоглоод байдаг хэрэг гээд аав сэтгэлийнхээ хөдөлгөөнийг дийлэхгүй гурван удаа дэвхрэн шал доргиогоод, нэгэнтээ бас «ура» хашгирч дугуй уруу дайрлаа. Тэгтэл юу болсон гэж санаж байна.

Нэг харсан чинь ээжийн уруул газар хүртлээ «сунасан» байв. Ихэд уурласан байртай улайгаад, мөнөөхөн жигтэй урт сунасан урт уруул, одоохон уйлах гэж байгаа хүнийх шиг хачин болжээ.

-Хүүе ээж, яаж байгаа нь энэ вэ? гэж Санаа дуу алдана.

-Та нар аавд болохоор дугуй авч өгөөд надад болохоор... гэснээ ээж «Ий» гэж чангаар уйлав. Хоёр охин энэ удаа цөхөрсөн янзтай бие бие рүүгээ харлаа.

-Би тэгвэл, дөрвөн дугуйтай гутал авна! гэлээ.

-Юуны чинь дөрвөн дугуйтай гутал! гэж Цэцгээ дуу алдав.

-Яагаав, зун, өвөл, хэдийд ч гэсэн хөлдөө углаад гулган тоглож болдог дугуйтай... гэхэд нь

-Тэр чинь их үнэтэй. Нэгмөсөн бүгдийг нь авч болохгүй шүү дээ сүүлд авья гэж Санаа аргадав.

Тэгэвч ээж, бараа хураадаг хонгил уруу уурлан ороод, хоол ч идэхгүй цай ч уулгүй Цэцгээ, Санаа хоёрыг үнэхээр зовоосон болохоор авч өгөхөөс өөр аргагүй болов.

Яг энэ үед мөнөөх дугуйн дээрээ суугаад аав, баахан хүүхдүүдээр түрүүлэн их л хөгжилтэй тоглож байв. Энэхүү шинэ дугуйг унаж үзэх гэсэн хүний тоо дорхноо даруй арав гараад явчихлаа. Эхлээд, нэг давхрын хүүхдүүд ухаж үзсэнээ, дараа нь таван давхрынх, эцэст бүх

айлын жаалууд жижиг хөөрхөн гурван дугуй унасан гайхмаар том хүн дээр цуглаж, өөрийг нь хэдэн удаа цааш түрж гүйснээ булаацалдан авч зайлав. Харин аав хойноос нь хөөцөлдсөөр одлоо. Тэгээд тэдэнтэйгээ нийлэн өнөөх дугуйгаараа өдөржин тоглосны эцэст юу болсон гэж са-нана. Тэр дугуй эзэнтэйгээ хамт, өглөөхөн аавын тоглож хувцсаа шороодсон усан хоолойн нүхэнд хэдэн удаа унаж аав мөрөн дээрээ нэгийг суулган байшин тойрч давхих зэргээр үзүүлж байгаа юм шиг урагш жийсэн өвдгөн дээрээ хоёр жийсний эцэст, хойд засмалын уруу чаргаар гулсах адил бөөнөөрөө дугуйн дээрээ шавааралдан нэгэнтээ бууж үзье гэсэнд энэ санал бүгдэд таалагдсан учир дугуйгаа хөтлөн тоглоомын талбай руу гүйлдэв. /

-Ёстой гоё, одоо бүгдээрээ хэнээр ч түлхүүлэхгүй энэ гулгуур руу бууна. Алив миний хойноос!... гэж аав ихэд баяртайгаар хэлээд бусдыг дагуулан гулгуурын төмөр шат өөд пижигнэтэл гүйн гарав. Аавын хэлсэн үг бүгдэд таалагдсан учир тэр хавийн олон хүүхэд бүдүүн нарийнаараа шулганалдан авирцгаав.

-За хөдөллөө шүү! Бүгдээрээ суусан уу? гэх аавын дуу дээр дээрээсээ шавааралдан суусан олон хүүхдийн дороос арай ядан дуулдлаа.

-Хөдлөөрэй, хөдлөөрэй! Нэг, хоёр, гурав аа!... гэтэл хүүхдийн овооролдоон дундаас дугуйны хяхатнах эвгүй дуу уйлах мэт дуулдсанаа урагш хөдөлж хар хурдаараа газар буухдаа дээрээ байсан жаалуудыг тараан шидэв.

-Аа ёстой мундаг.. гэж аав шороогоо гөвөн босоод хартал юу харагдсан гэж санана. Саяхан дэлгүүрт шинээр байсан өнөөх дугуй, аль гаригаас ирсэн юм бол гэмээр нэгэн том бөөн төмөр болон хэвтэж байв.

4. Бээлийгээ идсэн нь

Уншигч минь! Хэрэв хэн нэг хүнийг өмсөж явсан гутлаа хээв нэг амтархаад идчихэж гэвэл үнэмших үү? Яагаад ч үнэмшихгүй шүү дээ. Харин, ээж бол өмсөж яваа бээлийгээ, зажилдаг бохины оронд ихэд тааламжтайяа идчихдэг хүүхэд болсон юм байж. Яг үнэндээ Цэцгээ жаахан хүүхэд байхдаа бас бээлий, пальтоныхоо болон даашинзныхаа ханцуйг сэмлэн иддэг идэмхий байрын хүүхэд байсныг мартаж болохгүй.

Өвлийн хүйтэн эхлэхэд Цэцгээ ээждээ сайхнаас сайхан хээтэй, гоёоос гоё нэхээстэй ноосон бээлий авч өглөө. Тэр бээлийг хэрэв хямгатайхан хүүхэд сэн бол бүтэн өвөлжингөө, тэр ч байтугай хойтон өвөл нь хэрэглэж болохоор тийм бөх сайхан эд юмсанж. Гэтэл, бээлий аваад бүтэн хоног болоогүй байхад ээж сургуулиас ирэхдээ, гар нь их халууцсан байртай тэр бээлийний нэг хурууг цоолон сэнгэнэсэн агаар чөлөөтэй г орохоор болгосон байв.

-Яаж байгаа нь энэ вэ, цоо шинэ юмыг... гэж Санаа дуу алдлаа. Гэвч, ээж бээлийгээ авч хоёр тийш нь чулуудаад, юм хэлсэнгүй.

Маргааш нь аав, ээж, Санаа, Цэцгээ дөрвүүлээ холын ууланд цасан дээр зугаалахаар явлаа. Халуун саванд цайтай, торон уутанд идэх юмтай явсан болохоор хэн нь ч гэсэн ууланд очоод өлсөхийн аргагүй байлаа. Аав Санаагийн багынх шиг зүтгэдгээрээ зүтгэн чарга авч, ээжтэй хоёул гулгаж гарлаа. Харин Санаа цана авч Цэцгээтэй уралдан тоглолоо.

Гэвч аав удаан тоглосонгүй, чаргаар тоглох нь түүнд сонирхолгүй болсон байртай, хоёр гутлаа хооронд нь хэсэг зодолдуулснаа нуруугаа үүрэн, цанаар гулгаж байгаа хүмүүсийг харахаар очив. Харин ээж аавын хойноос харж нэгэн хэсэг зогссоноо чаргандаа суун уулын уруу буухдаа ингэж тоглох нь үнэхээр тааламжтай байгааг илтгэх гэсэн адил, цоорхой бээлийнийхээ нэгэн хурууг тасдаад идчихэв.

Ингээд аавыг цанаар гулгагчдын дунд үймүүлж, хүнд дайруулчих гээд болохгүй болохоор Санаа, Цэцгээ нар хөтлөн ээж дээр ирэхэд ээж өмсөж явсан бээлийнийхээ өрөөсний сүүлчийн хурууг идэж дуусаад байв, Тэгээд цадсан юм уу яасан юм, муухай ярвайн, тэрхүү нэхмэл эдийг цас уруу буцааж нулимав.

Энэ хэрэг үүгээр дууссан бол ч яах вэ. Олон хүний дунд загнаж зэмлэлтэй биш. Хөөрхий Санаа, Цэцгээ хоёр бээлийг нь харамсан нэгэнтээ шогшроод, гар нь даарна гэсэндээ, зузаанаас зузаан хөвөнтэй бээлийгээ тайлан Цэцгээ, ээждээ өгөхөөс өөр аргагүй боллоо. Тэгээд үдийн хоол идэцгээв.

Тэр нь гэвэл дээр нь бээлий нэмж идэх нь байтугай, дөрвүүлээ идээд ч бармааргүй амттай боов, чихэр, хиам болон чанасан мах байлаа. Гэтэл, хоол идээд цаг ч болоогүй байтал ээж, Цэцгээгийн өгсөн бээлийг чухам нэг цаасан зарлал иддэг ямаа шиг амтархан зажилж, бас түүндээ цадаагүйгээ харуулах / гэсэн шиг сангийн чарганы суран оосрыг шалчийтал зажилсан байлаа. Ийм идэмхий амьтан хэрэв олон болсон бол, лав бээлий болон малгай, тэр ч байтугай гутал үйлдвэрлэх гэж ихэд зовохсон биз.

5. Зочин

Аав, тавгийн идээг байлгадаггүй зантай хүүхэд болсон юм байж. Тийм ч учраас охидууд ааваасаа чихрээ нуух гэж ихэд зүдэрнэ. Гэтэл аав, хаанаас ч хамаагүй мөнөөх чихрийг олоод идчих тул нэгэнтээ Цэцгээ

-Хэрэв ахиад тавгийн чихэр хуурайлах юм бол хашраана шүү гэжээ.

Тэгтэл сонин юм боллоо. Маргааш нь хажуу айлын хүн орж ирээд түр саатан суутал Цэцгээ түүний өмнө тавагтай чихэр, аягатай цай тавив. Тэр хүн цайг оочлон суух завсраа тавагтай чихэр рүү гараа явуулсанд аав:

-Битгий таваг хуурайл! Хэрэв таваг хуурайлбал Цэцгээ хашраана шүү! гэлээ. Тэгэхэд ирсэн зочны сандарсан гэж яана. Царай нь чавга шиг улайн, цайгаа ч дуустал уулгүй, малгайгаа өмсөж гарахаар явлаа. Санаа, Цэцгээ хоёрын ичсэн гэж яана. Санаа, Цэцгээ хоёр зочныг гарсан хойно тавагтай чихрээ хураан, харин аав, ээжид юу ч хэлсэнгүй.

Зурагт радиогоор «Чамайг даа» гэдэг кино гарч байсан тул аав, ээж "хоёр түүнийг үзэхээр суулаа. Ээж энэ дэлхий дээр түүнийг үзэхээс сайхан юм байхгүй гэсэн шиг, дэлгэц уруу хамаг анхаарлаа хандуулсан байхад харин аав эрхий хуруугаа амандаа хийн, яг Санаагийн багынх шиг амтархан хөхсөөр харж байна. Дэлгэц дээр чоно туулай хоёр хөөцөлдөж, чоно нь осол болж, том хөндий төмөрт ороод, цаашаа ч үгүй, наашаа ч үгүй болж байна. Тэгтэл нэг хэдгэнэ ирж, хөлний нь улан дээр суухад ихэд гижиг нь хүрсэн чоно байж ядан байна.

Ээж, аав хоёр түүнийг харж маш их инээлдэв. Үнэндээ ч чонын хөгтэй явдал Цэцгээ, Санаа хоёрт ч инээдтэй байсан л даа.

Кино дөнгөж дуусангуут хаалганы хонх дуугарлаа. Цэцгээг очиж онгойлгоход хорооны дарга нэгэн том хавгастай юм барьсаар орж ирэв.

-За Цэцгээ, сайхан амарч байна уу? Яг өнөөдөр амжих ёстой нэг чухал зүйл бүртгэхээр ирлээ гэж дарга шат өөд явахдаа ядарсан байртай амьсгаадан хэлэв.

-Та суу л даа. Санаа! Миний дүү даргад цай, идээ барь! гэж Цэцгээ хэлээд ширээ арчиж, сандал авч өглөө.

Дарга сууж, малгайгаа сандал дээр тавив.

-Би яарч явна. Алив хоёул энэ хүснэгтүүдийг бүртгэе гэж дарга хавгастай юмаа нээлээ. Тэр нь бол хороо хорины бүртгэл юм байж.

За, энэ чинь юу ороод ирэх нь энэ вэ? гэсэн шиг аав, Санаагийн багыг яг дууриасан зангаараа, сормуусаа хөдөлгөн, хуруугаа хөхсөөр тэр хүний дэлгэж тавьсан зүйл рүү өнгийн харлаа.

-Хойшоо бай! гэж Цэцгээ аавд хэлэв. Тэгэвч аав юун энэ үгийг тоохтой мантай, харин ч улам

дөхөж, хороон даргыг чихэр рүү гараа явуулмагц «Битгий таваг хуурайл» гэж хашгирлаа.

Гэвч хороон дарга айлуудаар орж бүртгэл хийхдээ зүггүй хүүхдийг бишгүйдээ үзсэн болохоор огт тоолгүй нэгийг авч ам руугаа хийгээд.

-Пээ! Ийм том хүүхэд хуруугаа хөхнө гэнэ ий?! Мөн шившиг ээ! гэлээ.

Тэгэхэд аав яльгүй жаахан зовсон байртай гэдэргээ болж байна. Одоо л томоотой болох нь гэж ойлгосон бололтой хороон дарга буурал сахлаа нэгэнтээ илээд

-За тэгэхлээр охин минь! гэж яриандаа оров.

Тэр хоёрын яриа үнэндээ хүүхдэд хамаагүй юм байсан болохоор аав, ээж рүү гүйж

-Чоно больё! Туулай больё! гэлээ.

-За тэгье. Нээрээ тэгж тоглоё, ёстой гоё! хэмээн ээж хэлж А\

-Би туулай болно. Харин чи чоно бол! гэв. /

-Үгүй би туулай болно гэж аав зүтгэж байна.

-Үгүй, чи чоно бол! гэж ээж зөрлөө.

-Та хоёр чимээгүй байгаач! гэж Цэцгээ тэндээс дуугарав.

-Би чоно болж чадахгүй, мэдэв үү! Тэр чинь муухай гэж аав хэлээд туулайн баг авахаар ухасхийтэл ээж хойноос нь элдэн өрөө тасалгааны дотор бөөн шуугиан боллоо.

-Аа яа, яа яа! Ямар зүггүй хүүхэд вэ! гэж хороон дарга толгой сэгсрэв.

-Чимээгүй бай л даа, хүн зүгээр суулга! гэж Санаа тэссэнгүй хашгирав. Гэвч үүнийг сонсох сөгөө тэр хоёрт байсангүй. Хоёул туулайн багнаас болж дээр дороо орон, идэх юм булаацалдсан торойнууд шиг чарлалдлаа. Ээж нь эцэст нь мөнөөхөн багийг мулт татан аваад шидтэл, номын тавиурын хураалттай байсан номнууд дээр унаж, эргэж ойхдоо ширээн дээр юм бичиж байсан хороон даргын дух уруу дэлсэж унав.

Нэгэнт болохгүй хэрэг хийснээ мэдсэн аав, бушуухан гарч зугтахаар үүд уруу ухасхийхдээ өөрийнхөө малгайны оронд хороон даргын малгайг шүүрч аваад гарав.

-Хүүе чи малгай өгөөд орхи! хэмээн хороон дарга дуу алдлаа. Тэгэвч аав тэр үгийг сонсоогүйгээр барахгүй, ихэд хурдан гүйж юманд бүдэрч ойчихдоо шороонд нэг сайн хутгаж аваад цааш одлоо. Одоо яах билээ? Даргын малгайг авч өгөхгүй бол болохгүй. Тийм учраас Санаа аавын хойноос, яг л зуун метрийн явган уралдаанд оролцож байгаа тамирчин шиг гүйлээ. Харин тэгэхэд аав, үнэхээр уралдаад үзье! гэсэн адил хоёр гараа цээжин тушаагаа аваад циркийн байшин тийш байдаг хурдаараа жирийлээ. Хүмүүс урт сахалтай бүдүүн хүн, сургуулийн нарийн туранхай охин хоёрын уралдааныг гайхан харцгаана.

Замын дунд Санаа, аавыг гүйцэн алдсан боловч, аав хүчээ нэг дахин нэмж, засмал зам дээгүүр жирийн гарч, таримал моддын хоорондуур шургаад, бартаат замын уралдаанд яаж явах тухай биеийн тамирын багш үзүүлэх сургууль хийж байгаа г юм шиг л усан оргилуурын дугуй тавцан дээгүүр харайн зугтав. Гэвч Санаа дорхон нь гүйцэж малгайд гар хүрдгийн даваан дээр, хойд замаар ирсэн машин дугуйгаа шатгал тоормослох нь дуулдлаа.

Аав ч зогсож, Санаа ч сандран эргэн харвал, уурандаа дэлбэрэх шахсан жолооч гараа зангидан занаж байна. Ингээд аавыг хөтлөн, хүнд загнуулсандаа ихэд уруу дорой байдалтайгаар Санаа буцав.

6. Бэлэг

Шинэ жил боллоо. Аав, ээж хоёр нь жаахан хүүхэд болсон болохоор охидууд гэрийнхээ төв дунд сүлд мод зоож өнгийн гэрлээр чимлээ. Бас элдэв тоглоом дүүжилж, хөвөнгөөр цас хийж гоёлоо. Тийм сайхан сүлд модыг хэрэв гаднын жаалууд харсан бол гэр бүртээ л ингэж чимэх юмсан гэж санахсан биз. Харин аав сэтгэлийн хөдөлгөөн ихтэй хүүхэд болсон болохоор үүдний тус газар хоёр, сүлд модны дэргэд гурван удаа дэвхрэн. баярласнаа илэрхийлээд гэрэл чимгүүдийн хэр зэрэг гоё болохыг үзэхийн тул хуруугаараа тус бүрийг нэг удаа хатган автал, нэгэн улаан бөмбөлөг модонд муу бэхлэгдсэн байснаас аавын гарын аяыг даахгүй санжигнахдаа мултран унаж, шалан дээр будаа болов.

-Яаж байна аа? Хайран, хамгийн том, гоё юмыг... гэж ээж шогшров. Аавын царай ялиггүйхэн улайсхийгээд доошоо бөхийн шилнүүдийг түүж эхэллээ.

Шинэ жилийн орой бүх хүн наргиан хөгжөөнтэй байдаг болохоор Санаа, Цэцгээ хоёр уурласангүй. Харин ч бугарсан шилнүүдийг хаман цэвэрлэж, сайхан хоолоор аав, ээж хоёрыг дайллаа. Өглөө нь бол, том хүүдий дүүрэн бэлгийг тэр хоёрт гардуулаад:

-За ингээд гэртээ байгаарай. Сайхан тоглоорой! Сүүлд бид цөмөөрөө цирк үзнэ. Ах дүүгийн дээ очно. Тэгэхдээ өнөө биш, / маргааш гэв. Хэрэв тийм бэлгийг өөр хүүхэд авсан бол, айлаар орно гэж бодох нь байтугай, барж идмээргүй их зүйл байсныг тоочоод яах вэ? Наад зах нь алим, мандарин, модтой чихрээс өгсүүлээд нанжин чавга, нар хамба хүртэл байсныг яах вэ. Гэтэл бэлэг аваад цаг ч болоогүй байтал мань хоёрт айл хэсмээр санагдаж эхэллээ.

-Бид хоёр гадаа тоглоод ирье? гэж ээж охидоосоо гуйв.

-Тэг, тэг! Харин битгий хол яваарай! гэж Цэцгээ санаандгүй зөвшөөрөв. Тэр хоёр ч малгай пальтогоо өмсөөд гарч одлоо.

-Одоо хоёулаа яахав? гэж аав асууж байна.

-Хоёулаа айлд орьё... үгүй, хоёулаа ч гэж дээ чи эхлээд Шарав гуайнд ор... би чиний хойноос хайсан хүн болоод орьё гэхчлэн ээж, Цэцгээ л яг багадаа заль гаргаж байгаа юм шиг хэлэв.

-Гоё оо, гоё оо, гоё оо! хэмээн аав, хонгилын хананаас шавар унатал цовхроод, хүнд түлхүүлсэн юм аятай, гэнэт ухасхийхдээ Шараа гуайн үүдээр сум шиг л шунгинаад орлоо.

-Аяар, аяар! Наад хаалга үүдээ зөөлхөн хаа! За чи чинь ингэхэд хэний хүүхэд билээ? гэж Шарав гуайн эмээ нүднийхээ шилийг духан дээрээ авч тавиад асуув.

-Би... би... гэж аавыг хэлж дуусаагүй байтал, хаалга онгойж ээж орж ирлээ.

-Сайн байна уу, эмээ? Тавтай амарч байна уу? гэхчлэн ээж яг л сургуулийн хүүхэд шиг цангинуулан мэндлэв.

Түүний энэ эелдэг мэндчилгээ эмээгийн сэтгэлд ихэд таалагдсан бололтой инээмсэглээд, нүднийхээ шилэн дээгүүр харж, шүүгээ рүү очлоо. Тэгээд «Эд нар ер нь их өлссөн амьтад байх» гэж бодсон бололтой хоёр хоёр бууз авчирч, аав, ээжийн тоссон алган дээр тавиад

-Хм... Манайх цагаан сараар л бэлэг өгдөг юм шүү дээ, хүүхдүүд минь. Тэгэхэд л ирээрэй гэв.

Аав ээж хоёр гарлаа. Сайхан хоол идчихсэн болохоор буузыг идэх гэдэг мөн хэцүү, бас хаяж болохгүй, эмээ гомдоно. г Халаасандаа хийе гэтэл тостой. Нэг харсан чинь аав, өнөөх буузыг нусныхаа алчууранд боож байна.

-Чи яах нь вэ?

-Уурын хоолойн доогуур нууж орхиё гэнэ. -Тэгээд яах гэж? -Яахав, суулд авахгүй юу!

Ээж тэгээд бодов «Нэгэнт л айл хэсэх юм болохоор тэгсэн нь дээр шүү дээ» гэж бодоод хоёул боосон юмаа уурын хоолойн ард эвгэйхэн тавиад гүйлдэн гарлаа.

Энэ удаад бол аав түрүүлсэн ч үгүй, шууд л хоёулаа явж, эхлээд Дамба гуайн байдаг зэргэлдээ хаалганы зургаан айлыг гүйцээгээд дахиад явахдаа зүүн хаалганы Зэвгээ гуайнхаас авахуулаад, хоёр дугаар хаалганы Хоролбадам, таван давхрын Тамжид эгчийнхээр хүртэл оров.

Тэгээд гэртээ ирэхдээ ямар амьтад ирсэн гэж бодно! Эгээ л нүүр ам тос хөлс хоёрт халтардаж, их идсэнээс уурын тэрэг шиг амьсгаадсан амьтад болсон байлаа. Хүмүүсийн өгсөн ёотон чихэр, алим талх, дугуй боовыг халаасандаа багтааж ядаад, болохгүй болохоор нь гадуур өмднийхөө халаасанд түнтийтэл хийснээс, хэрэв зургийг нь зурж гэм, ёстой л нэг гахайрхуу маягийн дүрс гарах байсан даа.

За энэ ч яах вэ, бас бага хэрэг. Маргааш нь Халтар ахынд очоод тэдний хашааны айл болгоныг гүйпээж, Түмэн ахын ганц бие хөгшнөөс бэлэг авна гэж аав яг л Санаагийн багынх шиг уруулаа унжуулан зогссон зэрэг ч бас яахав. Нөгөөдөр нь аав, ээж хоёр бэлэгнээсээ болж ямар шуугиан дэгдээсэн гэж бодно. Уг нь их үймээн болгон ялихгүй юмнаас эхэлдэг шүү дээ. Хоёулаа яг л нэг гэрийн хоёр шиг, цуглуулсан бэлгээ ширээн дээр дэлгэн хувааж байсан юм байж. Тэгтэл харсаар байтал ээж, нэг модтой чихрийг өөрийнхөө хувийнх руу хийчихэв гэнэ.

Тэр нь тэгээд яг ч үгүй, аавын өөрийн нь тэмдэглэсэн модтой чихэр байсан тул аав тэссэнгүй. /

-Өгөөд орхи! Тэр чинь минийх! гэж шууд л ээжийн бэлэг рүү дайрав.

-Болиоч! Би чамд хоёр алим илүү хийсэн шүү дээ гэсний хариуд аав юу ч хэлсэнгүй, харин өнөөх чихрийг шууд булааж аваад ам руугаа хийж орхив.

-Аа ямар онгиороо вэ! Хүн оронд нь алим өгөөд байхад гэнгүүтээ ээж, хацар дээр нь зөөлхөн алгасанд чихэр нь амнаас нь мултарч шалан дээр уналаа. Тэгэхэд аав чихрээ унагасандаа харамсан, ээжийг барин авч, бөөн шуугиан дэгдээлээ. Хэрэв энэ үед Санаа, Цэцгээ хоёр орж

ирээгүйсэн бол юу болох байсныг бүү мэд.

Хэдэн хоног өнгөрчээ. Бэлэг ч дуусав. Аав цэцэрлэгтээ, ээж сургуульдаа явлаа. Нэг өдөр аав нүд нь орой дээрээ гарчихсан гүйсээр ээжид очив.

-Чи яав аа?

-Бууз!... Дөрвөн буузаа мартчихжээ гэж аав дуу алдлаа. Тэгэхэд ээж гал тогооны өрөөнд сав суулга угааж байсан юм байж.

-Нээрээ тэгж! Одоохон очиж үзье гэж хэлээд хоёул гүйлдэн гарав. Тэгээд хар хурдаараа очсон чинь юу харагдсан гэж бодож байна.

Уурын хоолойны дэргэд нэгэн гөлөг ихэд цадсан байртай зогсоод, хэл амаа долоож байна.

-Хм! Энэ гөлөг нусны алчуур бас идчихдэг юмаа? гэж аав, уурын хоолойны араар гараа оруулж үзээд, тэнд алчуур ч үгүй, бууз ч үгүй болсон байв.

-Ямар хачин юм бэ! гэж ээж гайхна.

-Энэ тэгээд хэний нохой юм бол оо?

-Бодвол эзэнгүй гөлөг биз.

-Тэгвэл хоёулаа авч тэжээх үү?

-Болохгүй. Нохойд янз бүрийн өвчин байдаг гэж багш хэлдэг. Энэ нохой өвчтэй байвал яана. Харин тэжээхийн оронд хааяа нэг идэх юм өгвөл болох юм. Эзэнгүй болохоор лав их өлсөж байгаа. За явъя гэж ээж хэллээ.

Тэдний ярьсныг ойлгоод идэх юм өгөх улс байна гэж бодсон байртай гөлөг хойноос нь сүүлээ унжуулан дагалаа.

7. Осолтой тоглоом

Хэрэв эрхэм уншигч та ямар нэг хүнийг нохойтой ана мана ноцолдож, дээр дороо орон уралцаж, хүний хашгирах дуу, нохойн гаслах бараг саахалтын хэрээс сонсогдож байвал тоглож байна гэж бодох уу? Аав нохойтой тоглохдоо чухам нэг ингэж хашгирч тоглодог хүүхэд болсон юм байж.

Өвлийн нэг нартай өдөр аав цэцэрлэгтээ явсангүй. Тэр гэрийнхэндээ хэлэхдээ «Би өөрөө яваад цэцэрлэгтээ очно. Хэнээр ч хүргүүлэхгүй» гэх зөрсөн мөртлөө, яг замын дундаас буцав. Тэгээд өөрийн байшингийн довжоон доогуур яг л нэг золбин гөлөг шиг шургаж тэнд байсан мөнөөх бяцхан нохойг олж авснаа:

-Гарья. Танай энд чинь эвгүй юм гэж нохой найздаа хэлэв. «Зөв шүү!. Гарах нь мөн...» гэсэн шиг золбин сүүлээ хөдөлгөн зөвшөөрч байна.

Ингээд хоёул гарлаа. Саяхан танилцаж, салшгүй найз болсноо үзүүлэх гэсэн мэт тэр хоёр байшингийн өвөр нөмөр уруу хамт явлаа. Үүнээс хойш аав, нохойг «Золбин» гэж нэрлэх болов. Үнэндээ ч энэ нэр нохойн хүүд таарсан бололтой. Яагаад гэвэл нэрээ сонсоод Золбин, тэнгэр өөд хошуугаа өргөж байгаад гурван удаа «хав, хав, хав» гэж хуцлаа. Тэр нь чухам юу гэсэн үг болохыг хэн мэдэх вэ. Ямар ч л байсан энэ нь аавд тааламжтай санагдсан болохоор тэр нохойтойгоо тоглож гарав.

Эхлээд тэд хөөцөлдөв. Аав зугтаж, Золбин түүний хойноос хөөж зуух маяг үзүүлж, хэрэв уур хүрвэл ингэдэг юм гэж үзүүлэх гэсэн шиг, өвлийн нь пальтоноос нэгэн хэсгийг өм татан хаяв. Гэвч аав үүнийг анзаарсангүй. Нохойн хүүтэй тоглож байгаа шуугиант мөчдөө сэтгэл нь хөдлөөд эргэн ухасхийхдээ Золбинг арван алхам газарт гасалтал шидэв. Гэвч Золбин дорхноо босож / энэ удаад чадагдсаныхаа хариуг авахаар ухасхийхдээ, аавын газар унасан хүзүүний ороолтыг гүзээ идэж байгаа юм шиг хэдэн хэсэг таслан хаячихаад, дахин ухасхийхдээ гоёлд өмсдөг цэнхэр өмдийг нь дотуурхи ягаантай нь давхар цоолохдоо аавын гуяыг сүрхий гэмтээв. Гэвч их онгирсон үедээ Санаа багадаа тэр зэргийн юмыг тоодгүй өнгөрөөдгийн адил аав анзааралгүй, нохойн хүү рүү дайран хоёр чихийг нь сунатал атгаад, усан хоолойны хана мөргүүлэв.

Яг энэ үед хүмүүсийн инээлдэх дууг аав сонслоо. Өөдөө харвал усан хоолой тавьж буй ажилчид ирээд, нохойн хүүтэй нэгийгээ үзэж байгаа аавыг харан инээлдэж байна. Тэгэхдээ тэд аавыг нохойтой тоглож байна гэж бодсонгүй. Харин «золбин нохойтой үнэнээсээ үзэлцэж байгаа юм байна, мөн ч эрэлхэг хүүхэд ээ» гэж бодсон байж.



Олон хүн хараад аав баахан сүрдэн Золбинг тавьтал тэр харин чихнийхээ өвдсөнд уурлаж, энэ удаад аавын тавхайд хоёр соёныхоо үзүүрийг шигдтэл хазав.

-Ёо, ёо, ёо! гэж аав дуу алдан уналаа. Энэ сацуу хүмүүс шуудуу руу үсрэн орж, Золбин ч амь наана, там цаана зугтлаа. Хүмүүс аавыг гэрт нь хүргэж өгөв. Нохойн хүүтэй ноцолдсоноос нүүр ам нь шороо тоос болж, хувцас хунар нь нооройн хүн харахын аргагүй г болсон аавыг Санаа, Цэцгээ хоёр дуу алдан угтлаа.

Үнэндээ, Золбин нь гөлөг байсандаа онож, хэрэв том нохой байсан бол пальтоноос нь алга дарам газар урах нь байтугай, бүр ар нуруу нь тэр чигээрээ сүйдэж аав тавхайгаа шалбалах төдий болоод зогсохгүй, өрөөсөн хөлгүй ч болох байсан юм уу, хэн мэдэх вэ. Нохойтой тогловол хормойгүй гэдэг ч яг үнэн шүү.

8. Эцэг эжийн журал

Нэгэнт аав нь цэцэрлэг ээж нь сургуульд юм болохоор, эцэг эхийн хуралд охин нь л сууж таарнаа даа. Яг тийм.

Нэг өдөр сургууль дээр эцэг эхийн хурал болов. Тэр хуралд Цэцгээ очлоо. Ангийн багш хүүхдүүдийн эцэг эхийг бүртгэж, Баттөр гэдэг хүүхдийн аавыг Баясгалан гэдэг охины ээжтэй хурлын тэргүүлэгчээр сонголоо. Дараа нь багш хүүхдүүдийн тухай ярьж гарлаа.

-Манай хүүхдүүд ер нь нийтээрээ сайн л даа. Гэхдээ, тэдний маань дотор ганц нэгийн зэрэг сахилга батаар дорой хүмүүжил муутай хүүхэд байгаа юм. Хэрэв тэр хүүхдүүдийн дутагдлыг засчих юм бол манай анги үргэлж зуун хувийн сурлагын амжилт үзүүлсэн ч чадахгүй гэхийн газаргүй. За жишээлбэл, Одмаа (тэр нь Цэцгээгийн ээж шүү дээ) байна. Одмаа бол сурлагаар тийм ч муу биш. Гэтэл энэ хүүхэд даанч сахилгагүй. Ухаан нь ангидаа ирчихээд, хичээлээ томоотой давтахын оронд, ханан дээр цэцэг зурдаг. Бас завсарлахаар аятайхан амрахын оронд энэ ч хүүхдийг түлхэж, тэр ч охинтой ноцолдож, самбарын алчуураар шиддэг гэв. Цэцгээ улам доошоо навтайсаар байв. Ээжийн тухай эвгүй юм ярих тутам, нүүр хийх газар олдохгүй болно. Тэгтэл, Цэцгээг жаахан байхад, ээж бас ингэж ширээний цаана байж ядан суудаг байсныг Цэцгээ саналаа. Хүүхдийнхээ төлөө ингэж зовж сууна гэдэг хэнд ч гэсэн аймшигтай хэрэг шүү. Хэрэг үүгээр дууссан бол бас яамай. Багшийн дөнгөж үг хэлж дуусангуул /

-Аа Одмаагийн гэрээс хүн ирсэн юм бий. Тэгвэл хэлэх юм бий.

-Одмаагийн ээж нь үү? Сайн ярь хө!... гэхчлэн эцэг эхүүд шуугилдлаа.

-Танай тэр Одмаа чинь, манай охины дэвтэр дээр элдэв юм зурсан байсан. Бас багшийн оронд дүн ч тавьсан байх шиг...

-Чиний тэр Одмаа чинь манай хүүгийн нусны алчуурыг урсан.

-Одмаа манайд очоод хамаа бусаар дотор өрөөнд орж үймүүлж, аяга хагалсан...

-Тэр Одмаа чинь хүүхэд дагуулж бүтэн өдөржингөө автобусаар тэнэсэн байна даа.

Хүмүүсийн энэ элдэв шуугиан Цэцгээг ёстой нэг ядрааж гүйцлээ. Хурлын дараагаар ангийн багш, Цэцгээг үлдээж байгаад хэлсэн нь:

-Та битгий зов. Энэ бүх дутагдлыг амархан засаж болох шүү дээ.

-За тэгээд, та завтай бол охиныхоо хичээл дээр ирж суусан ч болно... Маргааш өглөө бид маш сонирхолтой хичээл хийнэ. Тэр хичээл дээр суувал зүгээр юмсан гэнэ.

Маргааш нь Цэцгээ тэр хичээлд суулаа. Ээжийнхээ хажууд сууж чухам юу хийж байгааг нь харлаа. Багш самбар дээр тоо бичиж байхад ээж тэр тоог хуулж эхэлснээ, нэг харсан чинь дэвтрийнхээ голоос цаас авч нэгэн өндөр байшин зурж эхлэв. Тэр байшингийнхаа тагтан

дээр хүүхэд ч гэхэд хэцүү, багш ч гэхэд хэцүү нэгэн хачин маягийн юм зурж, шүүгээгээ тас нясхийтэл онгойлгоод будгаар будаж янзлав.

-Болиоч! Тоогоо бодооч! гэж Цэцгээ шивнэсэн боловч юун түүнийг анхаарахтай мантай, харин ч энэ зураг өөрт нь ихэд сайхан санагдсан бололтой, дуу алдан дороо дэвхэцлээ.

-Хэн хөлөө хөдөлгөөд байна? Чимээгээ аядаач! гэж багшийг хэлж байхад өөр нэгэн цаасыг уран авч, яг л бин идэж байгаа юм шиг амандаа хумхин хийв. Тэгтэл удсангүй өнөөх цааснуудаа харахаас дотор муухайрмаар шалчгар юм болгон гаргаж ирээд урагш нь шидлээ. Тэр цаас хаана очиж тогтсон гэж санаж байна. Яг самбарын өмнө зогсоо багшийн баруун чихийг оноод, бут г үсрэхдээ самбар дээр цагаан толбо болон наалдав. Тэгэхэд багш ихэд зовж чихээ бушуухан арчаад эргэж харлаа.

Ичиж зовон, өмнөөс нь нүүр улайсандаа байх суух газраа олж ядсан Цэцгээ, ээжийг зүгээр байлгахын тулд сэм чимхсэнээс болж ээж ангийн хүүхдүүдийг цочтол уйлж гарлаа.

-Юу болов оо? гэж багшийг ойртон ирэхэд ээж түрүүчийнхээсээ улам чанга дуугаар орилон

-Энэ Цэцгээ чинь хүн чимхээд!... гэхчлэн мэдүүлэв.

Ээжийн хичээлд суусан энэ ганц цагийн дотор Цэцгээ ёстой л нэг үйл тамаа цайж гүйцлээ.

9. Ялихгүй явдал

Ер нь хүний амьдралд ялихгүй мөртлөө хожим болтол сэтгэлд бодогдохоор инээдтэй явдал зөндөө байдаг шүү дээ.

Амралтын өдөр Санаа, Цэцгээ хоёр аав, ээжийг дагуулан дэлгүүр хоршоогоор явав. Цагаан сар дөхөөд, эмээдээ бэлэглэх юм бэлдэх гэж явсан юм байж. Тэгтэл аав дэлгүүрт дөнгөж ормогц л «Алим иднэ» гэж Санаа, Цэцгээ хоёрыг сандрааж гарлаа.

-Үгүй байз... эхлээд эмээдээ бэлгийн юм авна. Тэгээд дараа нь...-гэж Цэцгээ хичнээн аргадсан боловч аав үгэнд орсонгүй, харин ч хүн гишгэж, шорсс тоос, элдэв цаас хөглөрсөн шалан дээр гэдэргээ харан унаад, худалч хүнд бараг байшин доргиосон бүдүүн дуугаар уйлж, чулуун шалыг хоёр хөлөөрөө тожигнотол бөмбөрдөн тонгочив. Олон хүний дунд ийнхүү гэнэт согтуу юм шиг унаад, байдаг хоолойгоороо орилсон аавыг охид нь авах хэцүү, байх хэцүү. Үнэхээр ичиж зовмоор байсныг зүйрлэн хэлэх үг алга.

-За за! Боль л доо! Бид алим авч өгье гэхчлэн гуйж байж нэг юм болиуллаа. Тэгээд Санаа түүний уйлж буй аманд томоос том алим нэгийг хийж дуугүй болгов.

Цаашаа явцгаалаа. Эмээдээ бэлэглэх юмаа ч бүрэн авч чадсангүй. Их дэлгүүрийн хоёрдугаар давхарт гармагцаа аав / тоглоомын тасаг руу очиж, гал гаран бууддаг автомат буу заавал авна гэж зүтгэлээ.

-Эмээдээ юм авья л даа. Бид гэрээсээ цөөхөн мөнгөтэй гарсан шүү дээ гэж ээж хэлж байна.

-Үгүй! Би заавал буутай болно! гэж аав зүтгэв.

-Дараа больё... Цэцгээ эгчийн цалин буухлаар авья...гэж Санаа учирлав.

Гэтэл аав юу ч хэлээгүй мөртлөө бас л гэнэт сүхээр цохиулсан юм шиг пидхийн уналаа. Идэж байсан алим нь тээр тэнд шалан дээгүүр өнхрөн одов.

-Буу авна! Буу... уу... уу?! гэсэн аавын сүрлэг дуу дэлгүүрт яваа бүх хүн, тэр ч байтугай тоглоом, гоёл чимэглэлийн чихмэл амьтдыг хүртэл цочоов. Хүмүүс цөм аав уруу харлаа. Гэвч аав шалан дээр, өөдөө харан унасан хэвээр орилж

-Буу авна... буу... уу! гэх дуу нь чихэнд чийртэй хангинана.

-Одоо яанаа?! гэж Цэцгээг сандрах хооронд хүмүүс тэднийг шаваад авлаа.

-Энэ яасан хүүхэд вэ?

-Тоглоом авах гэнэ

-Тэгээд, аваад өгөхгүй яасан юм бэ?

-Эцэг эх нь хаана байна? гэхчлэн шуугилдана.

-Эмээдээ дээл авахаа болихоос доо гэж Цэцгээ, Санаад хэлэв.

-Тэгье! гэж Санаа урам муутайхан зөвшөөрлөө. Тэгээд тэд бууг нь бушуухан авч аавын гарт бариулаад гар дээрээс нь өргөн босгоод гүйлдэх шахам гарлаа.

Ингээд эмээдээ дээл авч чадсангүй. Их дэлгүүр таван давхар. Хоёрхон давхарт нь гараад л энэ шүү дээ. Хэрэв дөрвөн давхрыг гүйцээсэн бол Санаа, Цэцгээ хоёр улаан ч мөнгөгүй болох байсан. Яагаад гэвэл аав охидынхоо багынхыг дуурайсан мөнгө үрэмтгий хүүхэд болсон юм байжээ.

Гэртээ дөнгөж ирэнгүүт аав өнөөх ихэд шуугиан дэгдээсэн буугаа авч тоглохоор гүйн гарлаа. Тэгээд цонхоор харсаар г байтал Балжид эмээг уулга алдтал галлаж, хажуу хаалганы Цэдэн өвөөг халтирч унатал цочоон буудаад цааш гүйн одлоо. Гэвч аав цагийн дараа гэхэд буу нь ихэд сонирхолгүй болсон болохоор өөрийнхөө Цэцэрлэгийн Ламжав гэдэг жаалтай шүглээр сольсон байв.

Аав гадагшаа гарч, нэгэн үе гэрт, овоо чимээ шуугиангүй болоод байтал өрөөнд гэнэт цагдаагийн шүгэл тасхийх нь тэр.

Тэр шүглийн дуу хэтэрхий чанга, цуурайтай байсан болохоор ном уншиж суусан Санаа номоо алдаж, Цэцгээ чихээ таглахаас өөр аргагүй болов.

-Хүүе үүнийг хараач! Буугаа алга болгож орхиж... хэмээн Санаа дуу алдав.

-Буугаа яасан бэ? гэж Цэцгээ асуув.

-Үүгээр сольчихсон юм байхгүй юу? гэж аав хээвнэг хэлээд гарлаа.

Тэгээд эргэж ирэхдээ юутай ирсэн гэж бодож байна? Шүглээ чавхаар сольж, цагийн дараа чавхаа юуных ч гэмээр юм, нэгэн хачин хайрцгаар солих зэргээр бүх л өдөржингөө наймаа хийв.

10. Өвдсөн нь

-Хүн өвдөнө гэдэг аюултай. Зөвхөн өөрөө өвдөөд зогсохгүй, өвчтэй хүний төлөө хүн болгон л зовно. Тийн учраас өвдөх гэж хүсэх ч юм биш. Харин гэтэл ээж, аавд нэг өдөр хэлсэн нь:

-Санаа, Цэцгээ хоёр бидэнд хайртай юм уу, үгүй юм уу гэдгийг дахиад нэг үзэх үү?

-Тэгье! гэж юу ч бодолгүйгээр яг л Санаагийн багынх шиг аав хашгирч байна.

-За тэгвэл хоёулаа өвчтэй больё. Туж л ёолоод, элэг ч өвдлөө, зүрх ч хатгалаа гээд л байгаарай. За юу. Хэрэв тэгээд тэр хоёр ихэд сандрах юм бол хайртай нь тэр, хэрэв тоохгүй бол хайргүй нь тэр. Ойлгов уу? гэж ээж хэлэв.

-Ойлголоо. Ямар догь вэ. Ингээд л тэр хоёрын бидэнд хайртай эсэхийг бас нэг мэдчихье гэхчлэн аав хэлж, тэр даруй / урьдын саа өвчин гэдэгт дайрагдсан амьтан шиг нүүр амаа мурийлгаад унав.

-Энэ үед гадуур явсан Санаа, Цэцгээ хоёр орж ирдэг байна. Гэрт нь хүүхэд орхиогүй юм шиг таг чиг болохоор нь тэр хоёр ихэд гайхаад өрөөгөө онгойлговол, аав шалан дээр уначихаад өрөөсөн нүдээрээ харж байна. Харин ээж орон дээрээ унаж, яасан нь мэдэгдэхгүй цээжээ базална. Тэр хоёр ухаан алдтал айв. Үнэндээ ээж, аав хоёрын хэнээс нь ч гэсэн өвчтэй хүний царай харагдахгүй, тэр ч байтугай хацар нь улайж эрүүлээс эрүүл улаан уруул нь тодоос тод харагдаж байсан боловч тэр хоёр айсандаа юу ч мэдсэнгүй, дуу алдацгаан ухасхийлээ.

-Яасан бэ? Бие нь муу байна уу? гэж Цэцгээ ээжийг шалгаан духан дээр нь гараа тавьж үзнэ.

-Ёо, ёо, ёо! гэж сүртэй чангаар уйллаа.

-Үгүй одоо энэ чинь юу болох нь энэ вэ?! Түрүүхэн зүгээр байгаагүй билүү гэж Цэцгээ гайхна.

Тэгээд аав руу ухасхийв. Аав нүдээ аньж, дотуураа их шаналж байгаа юм шиг уруул нь өмөлзөнө. Ер нь хэн ч харваас өвчин туссан гэдэг нь яриангүй. Тийм болохоор хоёр охин ийш тийш гүйлдсэнээ эмч дуудмаар ч болов.

-Санаа чи үзээч. Нээрээ энэ хоёрын дух нь халуун ч юм шиг гэж Цэцгээ хэлээд ээжийн толгойг дарж үзсэнд Санаа.

-Нээрээ толгой нь жигтэйхэн халуун байна гэснээр, үнэхээр өвдөж гэж тэр хоёр итгээд зогссонгүй, ээж өөрөө хүртэл тэр хоёрын ярианд итгэж «Нээрээ би өвдчихсөн юм биш байгаа!» гэж бодлоо.

Ингээд Санаа, тэрүүхэн доод давхарт байдаг Жаргал гэдэг эмч эгчийнд очихоор явав. Удсан ч үгүй, тэр эгч нь ирж, эхлээд «тун муу» байгаа ээжийг дараа нь аавыг үзэхээр суув. Ээж бушуухан хувцсаа тайлж үзүүлэв. Тоглоом нь шоглоом болж, ийм явдалд хүргэсэн болохоор эмчид үзүүлэхгүй яах вэ?

-Амьсгал! Уухайс!... Цаашаа эргэ, сайн амьсгал! гэхчлэн Жаргал эмч гялалзсан цагаан чагнуур, ар өвөрт нь тавин г чагнаад:

-За энэ нь ч уг нь гайгүй л байх шиг байна. Мэдэгдэх л юм алга. Маргааш гэрэлд харуулахаас биш! гээд аавыг үзсэнээ мөн гайхсан нүдээр охидыг хараад.

-Ингэхэд чи яасан гэлээ? Хаана нь өвдөөд байна? гэж асуулаа.

Аав бодсон ч үгүй шууд:

-Толгой! гэж заагаад эмчийг толгой барихаар

-Гэдэс! хэмээн ходоодоо зааж будлиулсны дараа

-Хөл! гэж хэлж нэг үзсэнээ бүр сүүлд нь даанч нэг хэлэх юм олдохгүй болохор нь

-Гутал! гэж ам алдлаа.

Очиж очиж, гутал өвддөгийг анх удаа сонссон эмч гэдрэг ухрав. Энэхүү гэнэн бөгөөд инээдтэй ярианд тэсвэр алдсан ээж өвчтэй гэснийгээ ч мартаад хи, хи, хи хэмээн хөхөрлөө.

Өөрөөр нь доог тохуу хийсэн хүүхдүүдэд уур нь хүрсэн эмч босон харайв. Санаа, Цэцгээ хоёр ч уучлалт гуйсан бүх үгийг хамж шимэн үглэсээр үүд хүртэл үдэж өгөв.

Төгсгөл

Санаа, Цэцгээ хоёр голын эрэг дээр сууна. Хэн хэн нь ихэд гунигтай байв. Үнэхээр, энэ хэд хоногт хүүхэд маллах гэдэг ямар зовлонтой болохыг нүдээрээ үзэж, биеэрээ туулсан болохоор цаашид яах нь мөн бэ? гэдгийг бодож шийдэхийн тулд энд иржээ. Зун бол аавын цэцэрлэг тараад, ээж бас хичээлээ дуусчээ. Тэр хоёр нэг нь хөдөө, нөгөө нь пионерийн лагерьт явна гэж зүтгэж байв. Тэнд ямар их адал явдал, нүүр улайм хэрэг тохиолдохыг хэн байг гэх вэ.



Үнэндээ Санаа, Цэцгээ хоёр хэдий чинээ аав, ээжийн зүггүй зангаас хашрах тутмаа, өөрсдийнхөө бага насыг эргэн санаж, чухам зориуд тэднийг хашраах гэж л аав, ээжийг хүүхэд болгоод, зүггүй занг нь хэвээр үлдээж, ийм хачин байдалд оруулсан юм шиг санагдана.

Тэгэвч одоо яая гэх вэ дээ.

Аав, ээж нь тэднийг «маллах» гэж багад нь хичнээн их зовж байсан ч, үр хүүхдээсээ уйдаж, салахын мөн болдог эцэг эх гэж ер байдаггүй болохоор улам л хайрлан энхрийлж байсан шүү дээ. Түүний ижил Санаа, Цэцгээ хоёр бас аав, ээждээ ихэд хайртай болохоор хөдөө гадаа, пионерийн лагерьт ч гэсэн хамт л явахаас өөр аргагүй. Энэ явдал хэзээ дуусахыг бүү мэд. Бас аав, ээжийг яг тэр чигээр нь хүүхэд болгосон тэр үл мэдэгдэх хүч чухам илбэ ухааны үзэгдэл үү, ид шид үү? гэдгийг тайлж олох цаг нь ч одоо хэр болоогүй байна гэснээр зохиогч би «Аав цэцэрлэгт орсон нь» гэдэг туужаа дуусгая. Дараа уулзатлаа баяртай.

1974-1-28

Оршлын оронд хүүхдийн жотын тухай

Газар дэлхий дээр янз янзын хот байх юм.

Миний ярих гэж байгаа хот бол энэ ертөнцийн хамгийн сайхан, бас хамгийн өвөрмөц нь юм. Яагаад вэ гэвэл, тэнд дандаа хүүхдүүд байх, тул хотыг «хүүхдийн хот» гэж нэрлэнэ.

Хүүхдийн хотод нэг ч том хүн байхгүй. Тийм болохоор хот цэвэрлэгчээс эхлээд, хотын дарга, хүүхэлдэйн театрын найруулагч, циркийн баавгай тоглуулагч хүртэл, тэр ч байтугай бүр морин тойруулгын дасгалжуулагч, үлгэрийн нь танхимын үлгэрчин хүртэл хүүхэд юм.

Хүүхдийн хот бол ямар нэг муу муухай явдал, балиар заваан байдал, эсвэл муу сурах мэтийн хачин зүйлийг зөвхөн үлгэрээс л мэддэг бөгөөд хараал хэлэх, тэр ч байтугай цонх хагалах, хоорондоо зодолдон хэрэлдэх юм уу, дэвтэр дээрээ үзгээрээ баалгаж бэхийн толбо болгох, эсвэл даашинзын зах бохирдох мэтийн бусад олон хотын хүүхдийн үзэж туулсан зүйлийг огт мэдэхгүй тул, хэрэв тийм юм тохиолдож гэмээнэ ихэд хирдхийн цочиж «лав өөр гаригаас ирсэн байх» гэж бодно.

Нээрээ шүү. Та нар битгий жуумалз. Яг үнэн. За жишээлбэл ийм, нэг явдал тохиолдсон юм. Хүүхдийн хотын захын хорооллын нэгтээ, ногооны хашааны дэргэд, өвөл зунгүй үстэй малгайтай, нэлээн гандсан хуучин хүрэм бүхий нэгэн мануухай хэзээ ч юм байсан гэлцэнэ. Ням гаригийн орой Амраа гэдэг жаал түүгээр явж байснаа гэнэт мануухайн малгай дээр хоёрын зэрэг хар толбо, бас хүрэмний ханцуйд нэг ширхэг буурцаг салхиар хийсэн ирж унасан байсан тул ийм хөгийн зүйлийг үзээгүй Амраа гайхахдаа исгэрснээр ч барахгүй, тэр даруй найзууддаа хэлэхээр гүйн одов.

-Аюул, аюул!... гэж түүний зүрх цохилж байлаа.

Энэ тухай тэр дороо л хот даяар мэдэв. Хотын дарга, зургадугаар ангийн Бадраа яаралтай арга хэмжээ авч, мөнхүү хэргийн газар дээр наймдугаар ангийн сурагч Сайнжаргал А тэргүүтэй эмнэлгийн хэсгийг явуулав. /

-Хүүхдүүд ээ, сандрах хэрэггүй. Мануухай лав өвдсөн биз. Өвчний учрыг олохоор явсан хүмүүс Мануухайн малгай дээрх аймшигт толбо үл танигдах буурцаг сэлтийг цэвэрлэх болно... гэж радиогоор намуухан дуутай нэвтрүүлэгч охин ярьж байлаа.

Үнэндээ ч цагийн дараа гэхэд Мануухайг эдгээн сувилах бүлгийнхэн малгайг нь химийн бодисоор цэвэрлэж, хаанаас унасныг үл мэдэх буурцгийг шингэн бүхий шилэнд хийн музейд хүргүүлэв. Хэрэв өөр хотод бол энэ явдлыг огт тоохгүйсэн. Хорвоогийн салхинд туугдсан аль хог буртаг, үр буурцаг дээлэн дээр унахыг хэлж барах вэ. Гэтэл хүүхдийн хотод бол тийм биш. Учир нь бүх иргэд ариун цэвэр болоод ёс горим, сахилга батыг чанд хатуу сахидаг болохоор энэ мэт өчүүхэн зүйл хүртэл аюулт өвчин тахлын хэртэй дуулдана.

Хүн болгонд байдаг биеийн тамирын цэнгэлдэх юм уу, морин тойруулга энэ хотод бий. Бас амьд амьтдын үзэсгэлэн бий. Сонин музей нэг бийг өгүүлье.

Улаан туйпуугаар барьсан музей юм. Түүний доторх өрөө тасалгаа бүрд сараалж тор татаж, аль гариг болоод ямар зууны амьтан болохыг тодорхой тайлбарласан нэгэн хэсэг үзмэр бий. Тэр үзмэр бараг өдөр болгон шахуу баяжиж байдаг.

За жишээ нь, саяхан музейн захирал есдүгээр ангийн Олдох радиогоор ярихдаа хэлсэн нь:

-Манай музейд нэгэн шинэ үзмэр нэмэгдлээ. Энэ бол дундад зууны үеийн бодит баримт. Нэг зураг олдсон юм. Тэр зураг дээр хуруугаа хөхөж байгаа жаахан охины зураг гарчээ. Хуруугаа хөхөж болох уу даа ер та минь ээ? Ном бичдэг, эсвэл шагай нясалдаг тэр хуруугаа шүү дээ. Энэ бол яах аргагүй өнгөрсөн зууны явдал бололтой... Бас бид дээр үеийн хүмүүсийн хэрэглэж байсан эд юмсыг нэмж олсон. Түүний нэг нь бол чавх юм. Номонд бичсэн том хүмүүсийн дурдатгалаас үзвэл, урдны зарим тэнэг жаал тийм юм хэрэглэн цонх хагалах, бор шувууг юм уу, хэн нэгнийхээ толгой уруу бундуу гартал харваж байсан бололтой гэв. Тэр музейд нэгэн төмөр хүн бий. Төмөр хүн музейг л тайлбарлаж, өөрийнхөө гайхмаар түүхийг ярина. Энэ мэт тун сонин зүйл олныг хүүхдийн хотоос олж үзэж болно.

Тэр бүгдийг тоочихоо больё. Хүүхдүүд өдөрт ээлжээр хичээлдээ яваад, хотын үйлчилгээ, үйлдвэр, ногооны талбайд ажиллана. Үдэш түмэн сайхан дэнлүү асаж, бүжиг наадам, бас кино, ер нь хүүхдийн дуртай бүхэн гарна. Хүүхдүүд маш эвтэй. Ах захыг мэднэ гэдэг нь жигтэйхэн. Ухаандаа автобусанд явж байхад өөрөөс нь яльгүй өндөр л харагдвал ах зах хүн гээд л суудал тавьж өгнө. Бас их тусархуу. Ийм сайхан хот байдаг юмсанжээ. Огтын хиргүй тунгалаг, жаргалтай тэр хотод болсон нэгэн явдлын тухай үлгэр өгүүлнэ.

Тэгэхдээ юунаас эхлэх вэ? Аа тийм, мануухайгаас.



Нэгдүгээр бүлэг

Сайхан сэтгэлт эмч, тануухай хоёр

Нэгэн өдөр сайхан сэтгэлт эмч Жаргал ногооны газрын түүгээр явж байгаад мануухайг харав.

Мануухай бороонд угаагдаж, наранд хорчийтлоо хатсан үстэй малгайгаа нарийхан модон толгойдоо углаж, хуучин хүрэн хүрмээ хэлтийлгэн тун ч гунигтай байдлаар ногооны талбай уруу харан зогсож байлаа.

-Хөөрхий зайлуул!...

Эмч, ямагт хүнийг өрөвдөж явдаг хүн болохоороо мөнөөхөн мануухайг хайрласандаа ингэж хэлэв.

-«Хөөрхий амьтан!... Ёав их уйтгартай байгаа даа. Хичнээн ч хоног ногооны хашаа манаж ингэж зогсох билээ. Тэгтэл, үүний эзэн нь энэ хорвоод хулгайч хэмээх хачин амьтан байдгийг дуулаад түүнээс ногооны хашааг хамгаалаг гэж энэ мануухайг босгосон хэрэг биз. Гэтэл одоо тийм амьтан байх нь бүү хэл, ном сударт л сураг нь гараад өнгөрсөн хэрэг шүү дээ гэж Жаргал бодлоо.

«За тийм ээ... Би нэг ч хулгайч харсангүй» гэх адил Мануухай тэлж хадсан модон гараа хөдөлгөв.

«Тийм болохоор энэ хөөрхий мануухайг гэртээ аваачъя. Хүн дүрстэй юм болохоор лав хүүхэдтэй тоглохсон гэж бодож байгаа. Хэрэв эрдэм сурдаг юм бол манай хүүхдүүдийн тоглох дуртай хүүхэлдэй ч болж юу магад... »

Жаргал гуай ингэж бодсондоо өөрөө ч баярлаж, хашааны толгой дээрээс мануухайг зөөлхөн буулгав.

-Ээ ямар гялайсан юм бэ! гэж мануухай баярлан унав.

Тэгээд эмч гуай мануухайг гэртээ авчирч, сайтар угаан цэвэрлэж, нар салхинд онгож гандсан нүүрэнд нь тос түрхээд, хөмсгий нь будаж, нүдийг нь тодруулав. Хөөрхөн төмөр зүрх бас хийж амь орууллаа.

-Ай... Ямар сайхан бэ! гэж овоо нэг хүн дүрстэй болсон хойноо А мануухай хашгирлаа. /

Жаргал үнэн сэтгэлээсээ түүнд тус больё гэсэн юм болохоор зүрхийг нь чагнаж, баадууг нь чангалаад, гарыг нь чилээхгүйсэн гэхдээ нугас хийж өгөх зэргээр хөдөлгөөнтэй болгож, анх төрөхөөсөө аваад өрөөсөн байсан хөлий нь хоёр болгож, хуучин хоёр индүү олж гутал болгон өмсгөв. Ингээд цагийн дараа гэхэд мануухай маань овоо нэг хүн дүрстэй амьтан болсон байлаа. Жаргал, мануухайг ширээнд суулгаж, өмнө нь сайн чанарын тосоор хайрсан боов, нэг таваг хайлмаг тавив.

-Ид дүү минь, сайн ид! Олон хоног гадаа зогссон чамд сайн хоол л тус болно. Тэгээд дараа нь хоёул ном үзэх болно гэж хэлэв.

Мануухай одоо баадуутай ч гэсэн зүрхтэй, будмал ч гэсэн нүдтэй амьтан болсон тул ганц ухасхийн хайрсан боовыг идэж орхиод, бас дээрээс нь үзэмтэй хайлмагийг тавагтай нь үмхчихээд, нэгэн данх жимсний шүүсийг хээв нэг залгилав. Дараа нь өөрийн эрхгүй үүрэглэж, эхлээд модон эрүүгээрээ ширээний буланг тогхийтэл цохиж байснаа, шалан дээр пад хийтэл унав. Аргагүй шүү дээ, хөөрхий манаа манах гэж өчнөөн төчнөөн өдөр гадаа зогссон амьтан чинь. Эмч эмнэлгийн нэгэн өрөөнд мануухайг өргөн аваачиж, цагаан даавуутай орон дээр хэвгүүлээд өөрөө хажууд нь суун:

-«Бүүвэй, бүүвэй, бүүвэй

Бүлтгэр хүү минь унтаарай

Бүрэнхий харанхуй болжээ

Бөжин туулай унтжээ

Бүлтгэр хүү минь унтаарай

Бүүвэй, бүүвэй, бүүвэй...» гэж бүүвэйлэв.

Үнэхээр энхрий дотно жаал хүү адил Мануухай, эмч гуайн дуунд тэр дороо л хурхирч гарлаа.

* * *

Мануухайн тухай тэр дороо л хүүхдийн хотынхон мэджээ. Жаалууд унтаж байгаа мануухайг харах гэж эмнэлэг рүү цувж, Л зарим нь цонхонд хамраа шалчийтал наажээ.

-Хүүхдүүд ээ, битгий шуугиарай! Мануухай маань сайн унтаж аваг. Түүнд нойр их хэрэгтэй. Дараа нь би эрдэм заана. Зав чөлөөнд нь харин та нар хамт тоглоорой гэж эмч аяархан хэлэв.

-Эхлээд бид аваачна шүү. Манайхан түүнийг дүүжин даажин дээр суулгаж зугаалуулна гэж хойд хорооллын жаалууд санал гаргав.

-Тэгвэл түүний дараа манайхан аваачна. Бид цирк үзүүлж, морь унуулж сургана... гэхчлэн голын тэртээх хүүхдүүд захив.

-Эдний дараа бид аваачиж музей үзүүлье... гэхчлэн бараг нэг жил явсан ч бармааргүй их урилгыг эмч сонсоод

-За, за яахав. Аваачна л биз, үзүүлнэ л биз. Гагцхүү унтахад нь битгий саад бол! Дараа нь, эрдэм ном сураг, одоо явцгаа! гэлээ. Үнэхээр ч маргаашнаас нь эмч гуай мануухайг эрдэмд сургах гэж эмнэлгийнхээ нэгэн өрөөнд оруулан суулгав. Гэвч мануухай бол хэзээ ч мануухай л байдаг болохоор, эмч гуайн энэ сайхан сэтгэлийг ойлгохгүй, дэвтэр дээр «А» үсгийн эхний зураас гаргахын оронд харин цонхоор ширтэж салхинд хийсэн унасан хамхуулыг харан инээд

алдав.

-Дүү минь, эрдэм ном сурна гэдэг ямар их гайхамшигтай болохыг чи удахгүй үзнэ. Эхлээд хоёулаа «А» үсгийг бичиж суръя. «А» бол бүх номны эхлэл нь! гэж Жаргал эмч хэлээд самбар дээр шохойгоор бичив.

Мануухай, дэвтэр дээр үсэг бичих гэж тонгойсноо, тэрхүү дэвтрээс шинэхэн цаасны үнэр ханхалж байхлаар юм идмээр хорхой нь хүрч эхний хуудсыг хамж аваад зажлав. Дараа нь түүнийгээ нулимж орхиод, зурмал хоёр нүдний аль нь харж байгааг шалгах гэсэн мэт нэг нэгээр нь дарж буу шагайх мэт шагайв.

-За бичив үү? гэсээр эмч ойртож ирлээ. Мануухай энэ үед дөнгөж баруун нүдээ таглаж байсан болохоор тэрхүү хөгжөөнтэй тоглоомоосоо болж инээд алдлаа.

Хэл бичгийн хичээл дуусав. Дараагийн хичээл тоо байлаа. А Эмч гуай Мануухайд тоо тоолохыг зааж гарлаа. Тэгэвч Мануухай / модон толгойтой юм болохоор нэг ч тоо сурсангүй. Харин тоо сурахын оронд сууж байгаа ширээгээ мод уу, аль төмөр үү гэдгийг шалгах гэсэн мэт хяхатнуулж байлаа.

Зүгээр байгаач! Битгий тэг! За тоогоо тоол гэхчлэн хичнээн хэлээд нэмэр алга. Тэгээд эмч цөхөрч эцэст Мануухайг

-Түр гарч зугаалаад ир! гээд явуулав.

Мануухай гүйн одлоо. Түүнд гудамжаар сэлгүүцэх шиг сайхан юм хаана ч үгүй мэт санагдана. Гудамж талбайд хүүхдийн дуу хадаж байлаа. Хүүхэд жолоодсон машинууд давхилдан, хүүхэд цагдаа шүгэлдэн зохицуулна. Бас жаалуудын суусан галт тэрэг хурдалж жижигхэн машинист нь толгойгоо цухуйлган өнгөрөхөд бяцхан охин дарцгаа өргөсөөр өнгөрөөнө. Тэнгэрт пионеруудын барьсан онгоцууд сургууль хийж, голоор бяцхан усан онгоц дуран зүүсэн бээлийн чинээ ахмадынхаа удирдлагаар аажуухан явна.

«Мануухай! Мануухай Манай хашаанд зочлоорой! Мөхөөлдөс зайрмаг идээрэй

Мөсөн гулгуурт гулгаарай!» гэж гурван охин тагтан дээрээсээ дуулан урив.

Мануухай тэднийд очсонгүй. Гурван байшин өнгөртөл гүйж, явж байсан автобуснаас нэгэнтээ зүүгдэн таван гудамж уруудаад сая бууж, тоглоомын талбай уруу орлоо. Тэнд хүүхдүүд тоглож байв. Зарим нь зассан талбай дээгүүр дугуйгаар уралдаж, зарим нь хиймэл нууранд завиар зугаалж, бүр нэг өөдсөн чинээ өвгөн гэмээр нэг жаал үлгэрийн гэрт шийний хувцас өмсөөд, морин хуур хүнгэнүүлэн үлгэр ярьж байна. Үлгэр сонсогчид нь дандаа хүүхдүүд юм. Мануухай тэдний дунд шахалдан суулаа. Ер нь үлгэр гэдгийг анх удаа сонсож байгаа болохоор Мануухайд сонин ч, гайхалтай ч байлаа. Гэвч нэг мөч өнгөрсний хойно Мануухай уйдаж эхлэв.

Тэр гүнзгий санаа алдаж, өөрийгөө баярлуулан инээхийн тулд, өмнөө суугаа охины моодойсон гэзэгнээс чангаалаа.

-Зүгээр бай л даа! гэж тэр охин найрсгаар гуйв. Гэвч Мануухай нөгөө гэзэгнээс нь бас чангааж, туузанд нь цаас хавчуулав.

-Ямар хачин амьтан бэ? гэж охин ундууцаад гэзгээ татан авлаа.

-Өөрөө чи хачин амьтан гээд Мануухай, арынхаа хүүхдүүдийн «битгий халхлаад байгаач!» гэж шуугихыг эс тоон гарав.

-Хачин амьтан...

-Гэзгий нь чангаасан.

-Цаас зүүсэн... гэх мэтээр ийм балмад явдлыг үзээгүй хүүхдийн хотынхон шуугиж гарлаа. Мануухай, тэндээсээ элсэн дээр очиж, тоглож байсан жаахан хүүхдүүдийн хүрзийг бас элсний машины нь аваад ганцаараа тоглож гарлаа.

Хүүхдүүд уйлалдаж, хэзээ ч ийм дээрэнгүй явдлыг үзээгүй зохицуулагч жаал уйлаан орилооноор шүглээ тас хийлгэсээр гүйн ирэв. Мануухай ч зугатан одлоо.

Хоёрдугаар бүлэг

Мануухай олзлогдов.

Мануухай зугтан одлоо. Үнэхээр аймшигт хэрэг хийсэн мэт түүнд санагдан, шүгэлтэй жаалаас амь зулбан зугтав. Түүний чихэнд шүглийн догшин дуу удтал сонсогдсоор л байлаа. Тэр, хотын орон сууцны дундуур баахан гүйж, дараа нь явж байсан цахилгаан тэрэгний араас зүүгдэн, хотын захад гараад ой уруу оров.

Модны гүнд, тайван чөлөөтэй бөгөөд Мануухай хожуул дээр сууж амрав. Ийнхүү эзгүй хээр гарсан нь Мануухайд таатай байлаа. Ер нь Мануухай хээрийн зэрлэг амьдралд их дассан бололтой. Тийм ч учраас элдэв шуугианаас хол, эрдэм ном гэж шахан шаардах хүнгүй газар Мануухай сайн амарч авья гэсэн шиг ногоон дээр тэрийн хэвглээ. Тэгээд унасан чигээрээ унтаж орхив. Хичнээн цаг унтсаныг бүү мэд. Нэг л мэдэхэд аймшигт / нэгэн амьтан түүний сүвээ уруу өвдтөл ёврон сэрээв. Нойр нь тун их хүрч байсан боловч Мануухай арай гэж хүчлэн өрөөсөн нүдээ нээв. Тэгтэл юу харагдсан гэж бодно. Түүний өмнө, төмрөөр хуягласан, гозгор төмөр малгайтай нэгэн аймшигт амьтан зогсож байв. Тэр амьтан яагаад ч юм, өрөөсөн нүдээ том гэгчийн хар даавуугаар даран боож, бүсэндээ том илд, хэд хэдэн хутга санжигнуулаад, уурга шиг урт жадаараа Мануухайг хатган үзэж байна. Мануухай тэр дороо л үсрэн бослоо. Малгай нь хөсөр унаж, даахирч ширэлдсэн сүрэл мэт шар үс нь их айс-наас болж арзайлаа.

-Ална, хядна! гэж төмөр мэт хүйтэн хахир дуугаар хараагаад тэр амьтан жадаа гозолзуулан ойн гүн уруу явахыг тушаав.

Ингэж Мануухай, Түн түн-пин пан хэмээх аймшигт дээрэмчинд баригдлаа.



Ойн гүнд, дээрэмчдийн суудаг овоохой байв. Тэр овоохойн гадуур хог новш хөглөрнө. Ойн дээрэмчид дөрвүүлээ ажээ. Тэдний толгойлогч нь Тортогбуртаг хэмээх нэртэй бөгөөд бие жаахан боловч догшин ширүүн харцтай юм. Тортогбуртаг ямар ч амьтан болж хувирч чадах ид шидтэй. Тийм болохоор дээрэмчид түүнээс ихэд айх тул үг дуугүй хэлснийг нь биелүүлнэ. Л

Үлгэрт гардаг гуталт муурын дүртэй тун ч адилдуу нүүр царайтай дээрэмчнийг Халхайбалхай гэнэ. Тэр бол маш их аймхай бөгөөд овоохойноосоо таван алхам ч холдож эс чадна.

Харин Хойрог-нойрог хэмээх дээрэмчин бол идээд л унтаад байх дуртай юм. Хэрэв унтсан л бол заавал иднэ. Аа хэрэв идсэн л бол заавал унтана.

Тэр бол ойн гүнд хэвтшиндээ байгаа баавгай шиг нойрмог бөгөөд туйлын залхуу нүдтэй. Харин Мануухайг тууж аваачсан Түн түн-пин пан бол зэрлэг бөгөөд ямагт эвдэх нураах эсвэл түймэрдэх түйвээхийг хүснэ. Ярихдаа хүртэл хэн нэгийг байлдаанд дуудсан юм уу зодоон цохионд уриалсан үгтэй байдаг. Мануухайг аваачмагц өрөөсөн гараа өргөн эзэндээ ёслоод:

-Түн түн-пин пан ирлээ! гэж нэрээ нэгэнтээ зарласнаа -Мануухайг олзоллоо! гэж мэдэгдэв. - Адгийн муу боол Арчаагүй муу сүг Эзэн ноёнд сөгд!

Элгээ эвхэж сөхөр! гэж тэрбээр дүрэмдэн хашгираад -Урна, гасална! хэмхэлнэ! гэв.

Гэвч Тортог-буртаг ноёнтон ухаантай бөгөөд хортой дайсан болохынхоо хувьд төрсөн дүүгээ үзсэн мэт туйлын таатай инээмсэглээд Түн-түн-пин панг гэдрэг түлхэн холдуулж,

-Хонгор хөөрхөн Мануухай минь, яаж яваад энэ зэрлэгт баригдав аа? гэлээ.

-Би, би... гэж Мануухай түгдрэн

-Хүүхдийн хотоос зугтааж... бас эрдэм номноос... хэмээн уйлах шахам үнэнээ өчив.

-Хи, хи, хи! гэж дөнгөж сая сэрсэн мөртлөө, өрөөсөн нүдээ ч бүрэн нээж чадахгүй нойрмоглосон хэвээр Хойрог-нойрог Мануухайн арчаагүйг шоолон инээд алдаж хуруугаараа заагаад

-Хи,хи, хи! Зугтаж гэнэ шүү! Хи ,хи, хи! гэв. Халхай-балхай А инээх үү яахав?! гэсэн мэт дээрэмчдийн ахлагч уруу харна. / Тэгээд эзнээ инээмсэглэж байхыг үзэж, шал худлаа мөртлөө Ха, ха, ха! гэж хөхрөв.

-Больцгоо! гэж зандраад Тортог-буртаг үрэл шиг жаахан нүдээрээ Мануухайг харж хэлсэн нь:

-Зөв. Оргох нь зүйтэй. Зөвхөн оргоод орхивол бас буруу, тэмцэх хэрэгтэй. Эрдэм ном сурах гэдэг бол тэнэг хэрэг. Харин дээрэмдэх түйвээх гэдэг бол тун ч зугаатай.

Тэгээд чамайг өчнөөн хоногоор манаанд зогсоогоод сүүлд нь эрдэм ном мэт балай юмыг заах гэсэн тэр хүүхдүүдтэй нэгийгээ үзэх хэрэгтэй. Бид чамд тусална! гэлээ.

Тортог-буртаг том тэвшин дээр өөрийнхөө хамгийн дуртай хоолыг тавьж Мануухайг дайлав. Тэр нь бол, ойн бор хулганын дөрвөн хөл мах, янзаганы өрөөсөн чих, нялцгай биетний аймагт багтмаар юм уу даа гэмээр нэгэн хачин дунгийн хөл болон бас бус зүйл байв.

-Идье! унтъя! гэж Хойрог-нойрог хоол уруу дайрав. Гэвч эзэн нь шидэт долоовор хурууныхаа урт хумсаар нэгэнтээ занган дохиж түүнийг нам унтууллаа. Хоолон дээрээ Тортог-буртаг хэрхэн харь орноос ирснээ ярилаа.

-Би бол язгуурын тэнүүлчин хүн байлаа. Тэгээд би «аз жаргал гэгчийг дээрэмдэн тонож олох

ёстой» гэдэгт хагуу итгэсэн юм байхгүй юу даа.

Миний жинхэнэ төрсөн нутаг хаана ч байдаг юм бэ, бүү мэд. Ухаан орохдоо л би аав ээж дээрэмчдийнхээ хамт ойд тэнэж явсан юмдаг. Дараа нь бид дээрэм хийгээд, баригдан алдаж тэнэсээр байгаад энэ хүрсэн юм. Миний үнэнч туслагч Түн-түн-пин пан миний замд тааралдсан юм.

Энэ бол хэзээ нэгэн цагт хуучны дайнч баатрын өмсөж байсан хувцас шүү дээ. Би өөртөө сайн нөхөртэй болохын тулд ид ши-дийнхээ хүчээр түүнийг ийм хүн болгосон юм.

Аа харин Хойрог-нойрог, Халхай-балхай хоёр бол хог дотор хаягдсан тоглоомууд. Нэг нь гуталт муур гэдэг тоглоом, нөгөө Л нь хаймран бамбарууш байсан болохоор яг л тэр төсөөрөө дээрэмчин болсон нь тэр. Эд маань хайр гамгүй эдэлж нухаж, урж эцэст нь хаясан хүүхдүүдээс өшөөгөө авна гэдэг юм.

Тийм ч учраас бид нар хүүхдийн хот уруу дайрч түүнийг эзлэн авах болно. Сайн нөхдийнхөө өшөөг авна гэдэг бол гавьяат үйлс даруй мөн. Тийм биз дээ. Түн-түн-пин пан аа!

-Яг үнэн эрхэм дээдэс ээ! Одоохон бид хүүхдийн хот уруу дайрна. Эвдэж нураана. Эзэлж тараана! Ёстой гоё гэж түн түн пин пан хашгирч, тэгж их баярлаж хөөрсөндөө гурван нялх хус модыг булга татан хаяв.

-Гэвч... хэмээн дээрэмчдийн ахлагч хуруугаа гозойлгон анхааруулж чимээ намдаагаад хэлсэн нь:

-Гэвч шууд дайрна гэдэг бол тэнэг хэрэг мөн.

Хүүхдүүд маш их эвтэй учир дийлэхэд амар биш. Харин түүний оронд тэдний хүчийг дотроос нь задлах хэрэгтэй. Өвчин тахал мэт хань нөхдөөрөө тэдний хүчийг доройтуулах хэрэгтэй. Тийм болохоор Мануухайд одоо тун ч хөгжөөнтэй эрдэм заах болно. Тэр эрдэм лав чиний сэтгэлийг сэргээх биз. Алив баатрууд аа! Сурсан сурснаа Мануухайдаа зааж өгцгөө! гэлээ. Тэгмэгц өнөөх баатрууд хэмээх дээрэмчид нь хашгирлаа. Гагцхүү Хойрог-нойрог л унтсан хэвээр байв.

Гуравдугаар бүлэг

Айтшигт эрдэт зааж байна.

Мануухай харгис догшин дээрэмчдийн дунд олон хонолоо. үнэндээ ойд амьдрах нь түүнд зугаатай байлаа. Өдөр болгон дээрэмчид түүнийг ойгоор дагуулан явж хүүхдийн хотод үзээгүй аймшигт зүйлсийг үзүүлэн тун ч хачин эрдэмд сургаж байлаа. Эрдэм ч гэж дээ, тэр нь бол үнэхээр өвчин л юм.

Эхлээд Мануухай Түн түн-пин пангийн мэдэлд очлоо. Харгис А догшин тэр дээрэмчин түүнийг дагуулан ойгоор тэнэв. /

Эхний өдөр Түн түн-пин пан зургаан ширхэг эрвээхэй, дөрвөн шоргоолж, нэгийн зэрэг хөөрхөн алаг эрээн соныг барин авч түүндээ туйлын их баярласандаа замд тааралдсан бүх модны мөчрийг сэлмээрээ тас цавчин аймшигтайгаар инээж явлаа. Тэгээд ойн цоорхойд үдлэв. Олзолсон шавьж, хорхойнуудыг хожуул дээр тавиад Түн-түн-пин хэлсэн нь:

-Эрхэм дээдсийн тушаалаар эзэн миний хүссэнээр, өчүүхэн муу мануухай чи, эдгээр амьтдыг тарчлаан зовоож, тамлан хөнөө!

Мануухай тийм муухай хэргийг өөрөө хийх болсондоо, айн, гэдрэг хоёр алхам ухрав. «Үнэхээр тэгж сүйтгэж болох уу даа? Хүүхдийн хотод бол эрвээхэйг үнэхээр гоо сайхны нь хувьд ихэд хүндэтгэн сул чөлөөтэй явуулдгаар барахгүй, шоргоолж, соно мэтийг бол ой цэвэрлэгч ашигтай амьтад гэж үзэх тул алж устгах нь байтугай харин ч арчилж өсгөдөг билээ» гэж бодно.

-Тушаал биелүүл! Хэрэв тушаал эс биелүүлэх юм бол турсгыг чинь хуулж, туулайн бөөр модноос дүүжилнэ, шатаана! гэж Түн түн-пин-пан хашгирлаа.

Тэгээд уурандаа ч тэгсэн үү, эсвэл сургах ч гэсэн үү, нэгэн эрвээхэйн өрөөсөн нүдийг сохолж, хоёр шоргоолжны хөлийг хугалан доголлон болгоод, эрээн сононы баруун далавчийг хуга татав.

Мануухай, айсандаа болоод шоргоолжнуудыг, эрвээхэйтэй хамт индүүн хөлөөрөө няц даран сөнөөж, соныг хол авч шидэв.

-Зөв, чи сайн сурч байна! гэсэн эзнийхээ үгэнд зоригжин Мануухай аль тааралдсанаа дэвсэлж, цэцэг ургамлыг тасалж, мод бутыг зэрлэгээр хугалдаг өвчтэй болов.

Дараагийн өдөр Мануухай Халхай-балхайг дагалаа. Хэдийгээр Хал-хай-балхай гурван том сэлэм, нэг бороохой, хоёр жадаар зэвсэглэсэн боловч ямагт айн хулчийж, шумуул шунгинахын тоолонгоор модны доогуур орон зугтаж, ялаа янгинахын тоолонгоор хадны ангал уруу харайн орж нуугдана. Л Түүний хэт их аймхай, хулчгарыг анхандаа сайн мэдэхгүй байсан мануухай үнэхээр аймаар юм болсон хэрэг байлгүй гэж хамт зугтаасаар байтал өөрөө ч бас аймхай болов.

Тэгээд үд хүртэл ойгоор дөнгөж нэг саахалт хэр яваад л Халхай-балхай

-Хөл минь өвдөв. Толгой минь ч эргэв. Бас өлслөө, цангалаа гэсэн тул хамт буцаж ирлээ.

Эцсийн өдөр Мануухай Хойрог-нойрогийг дагалаа. Тэгж явах нь үнэхээр залхуутай байсныг зүйрлэхийн арга даанч алга. Яагаад вэ гэвэл, арван хэд алхаад л Хойрог-нойрог идэж, хорин хэд алхаад л унтана. Нэг үгээр хэлэхэд өдөржин идэж унтаж, өнгөрөв. Овоохойгоос эзэн дээдсийн өгч явуулсан зурамны зүрх, жирхний хоёр хөл, бас хонин гүрвэлийн хоёр бүтэн махыг тэр дороо ганцаараа идчихсэн мөртлөө, дараа нь ойн мөөг, цэцгэн дээр тогтсон шүүдэр, хэн нэгний идэж орхисон яс зэргийг ховдоглон идээд өдөржингөө Хойрог-нойрог унтсаар нэгэн өдрийг өнгөрөөв. Харин тэгсэн чинь сүүлдээ, идэх юм олдохгүй болохоор мань Мануухайн өрөөсөн чихийг салгаж болох нь уу, үгүй юү гэсэн мэт үзсэнд Мануухай өөрийн эрхгүй айн зугтлаа.

Эзэн дээдэс Тортог-буртаг шиг амьтан Энэ хорвоо дээр лав байхгүй биз. Тэр бол, бөөн хог л гэсэн үг. Мануухай түүний дэргэд ямагт байсаар долоон жил хог шороон дунд хэвтээд гарч ирсэн мэт бохир болсноор ч барахгүй, хаа явсан газраа хөөн мөр гаргаж, унтсан газраа шороон ором үлдээдэг болсныгоо мөн ч сайхан гэж бахархдаг болов. Ингээд, мань Мануухай хүн үзээд гайхмаар өвчтэй амьтан боллоо. Тэр Түн-түн-пин пан шиг зэрлэг, Халхай-балхай шиг аймхай, Хойрог-нойрог шиг залхуу, Тортог-буртаг шиг бохир болов.

-Хонгор хөөрхөн Мануухай минь, одоо бид чамайг хүүхдийн хот уруу явуулна. Тэнд очоод өөрийнхөө сурсныг хүүхдүүдэд тарааж чадвал чамайг өндөр дээд шагналаар шагнах болно.

Хэрэв тэгээд хүүхдүүдэд чиний өвчин тарж, тэд үймэн сандарч А эхэлдэг юм бол дээрэмчид бидний хэрэг бүтэх нь тэр. Тэгсэн / цагт бид хотын дөрвөн талаас довтолж, хүүхдийн хотыг эзэлж аваад, эрхэм хүндэт Мануухайгаа хотын дарга болгоно. Тэр цаг удахгүй ирнэ гэдэгт итгэж байна. За аян замдаа сайн яваарай, Мануухай минь. Түн түн-пин пан, чи хүндэт Мануухайг ойгоос гартал нь сахин хамгаалж яв! гэж Тортог-буртаг, Мануухайн модон духан дээр үнсээд хэлэв.

Хүүхдийн хотыг дээрэмчдийнх болгохын тулд Мануухай эзэн дээдсийнхээ хэлсэнд зоригжин одов.

Дөрөвдүгээр бүлэг

Үл танигдах өвчин

Сайхан сэтгэлт эмч Жаргал ихэд гунигтай болжээ, Түүнээс Мануухай зугтан одсон нь ямар харамсалтай хэрэг вэ. Хир буртагнаас нь арилгаж, ундаалан хооллож, бас эрдэм зааж байсан ачийг ч эс бодон Мануухай зугтан алга болжээ.

Хайрт Мануухайгаа байхгүйд хойноос нь сэтгэл зовсон эмч «Энд тэнд явж байгаад өвдөх юм уу, бэртчихээгүй байгаа» гэж үргэлж бодно.

Хэдэн өдөржин эрэл сурал болсон боловч Мануухай олдсонгүй. Харин түүний сураг гарахын оронд хүүхдийн хотод ер урд өмнө дуулдаагүй хачин өвчин гэнэт дэлгэрэв. Тэр өвчнөөр өвчлөгчдийн тоо дороо л арав хүрлээ. Хамгийн түрүүн тийм өвчин туссан хүүхэд өчигдөр эмнэлэгт хүргэгдэж ирлээ. Тэр нь бол Цодоо гэдэг хүүхэд юм. Цодоог хүргэж ирсэн нэг хорооллын жаалууд хэлэхдээ:

-Гэв гэнэт муухай дуугаар хашгирсан.

-Бас хүний өмнөөс хэлээ гаргасан... гэжээ. «Үгүй бас гайхмаар аа! Хашгирах ч бас яахав, хүний хийдэг л явдал. Заримдаа жишээ нь хөл бөмбөг тоглож байгаад ч юм уу эсвэл хонь хариулж яваад хашгирах явдал ч байдаг л даа. Харин хүний урдаас хэлээ гаргана гэдэг бол эрүүл хүнд тун байж Л болшгүй хэрэг» гэж бодсон эмч хэвдээ байна уу, үгүй юу гэдгийг үзэхийн тулд хэлийг нь харав. Тэр нь ч яах вэ байдгаараа л байлаа. Харин зүрх нь хүчтэй цохилж байх шиг санагдахлаар нь эмч гуай чагнав. Үнэхээр л дэлбэрэм чангаар цохилох зүрхний нь дуу эмчийн чихэнд тод сонсогдлоо.

-Дүүдэй минь, Чи ямар нэгэн юмнаас айсан уу? гэж эмч гуай болгоомжтой нь аргагүй асуув.

-Үгүй!

-Тэгвэл цочсон уу?

-Үгүй!

-Тэгээд чухам яасан юм бэ дээ? -Би юу? Би... гээд Цодоо нэг хэсэг түгдэрснээ -Тоглосон. Түүнтэй би хэлээ гаргаж тоглосон гэлээ. -Хэлээ гаргаж тоглосон ий?! гээд эмч «Гайхалтай хэрэг ээ! Хэн тэгээд түүнтэй хэлээ гаргаж тоглосон байх нь вэ?» гэж

бодоод:

-Тэр чинь хэн юм? гэж асуувал -Мэдэхгүй! гэнэ.

«Маш хүнд өвчин тусчээ дээ. За байз юу ч болсон тайвшруулах эм өгдөг хэрэг үү дээ» гэж эмч бодов.

Тэгтэл удсангүй цагийн дараа бас нэг хүүхдийг хүргэж ирлээ. Тэр хүүхэд айлын цонх хагалдаг өвчин туссан юм байж. Хэрэв хоёр гарыг нь сайн барихгүй бол одоо ч эмнэлгийн цонхыг хагалахад бэлэн, үнэхээр үзэн ядсан нүдээр харж буй тэр хүү «эвдэлнэ, нураана» гэнэ.

Бас хоёр цагийн дараа гурав дахь нь ирэв. Тэр хүүхэд хэтэрхий гайхмаар хүүхэд болжээ. Юу гэвэл сүлд модны наадмаар юм уу, эсвэл хүүхдийн баяраар наргиан болгож баг өмссөн мэт, нүүр ам нь хөө, хувцас хунар нь шороо болжээ. Энэ мэт хачныг тоочивч баршгүй.

Харин хамгийн сүүлд ирсэн хүүхдэд бол энэ хотын хамгийн А шившигт явдал болох ном дэвтэр урдаг өвчин тусчээ. Тэр / тооныхоо дэвтрийг голоор нь тасалж, унших бичгээ хавтсаар нь салгаад түмэн бодисын номон дээрээ өөрийнхөө шавхайтай тавхайн мөрийг үлдээсэн байв.

«Ийм гайхалтай өвчин хаанаас гарав. Ямар муу санаат амьтан түүнийг тараав?

Хэзээнээс ариун тунгалаг хүүхдийн хотыг ямар аюул нөмрөх нь энэ вэ» гэхчлэн Жаргал эмч туйлын их сэтгэл зовж, өвчтэй хүүхдүүдийг өрөвдсөндөө уйлж байлаа.

Тэгтэл оройхон хэрд хотын аюулаас хамгаалах газрын дарга Чагнаа эмнэлэг рүү яаралтай утасдаж:

-Хотын хойд хорооллоос гурван хүүхэд алга боллоо. Танай түүгээр үзэгдээгүй биз? гэж асуулаа.

-Юу болж байна даа. Ер нь манайд янз бүрийн өвчин туссан арваад хүүхэд хэвтэж байна. Тэдний байдал тийм ч сайн биш. Гэтэл дээрээс нь хүүхэд алга болно гэдэг чинь юу гэсэн үг вэ! гэж Жаргал эмч дуу алдав.

-Эмч, та тайвшир. Бид нэгэн үл бүтэх амьтны мөрийг олоод байгаа. Тэр мөр явсан газар л хүүхэд өвчин тусах юм уу, эсвэл алга болж байна. Тэгэхлээр яах аргагүй энэ явдал түүнтэй холбоотой. Индүүний ул шиг хачин гурвалжин тэр мөр ямар нэг хорт бүдүүлэг амьтны мөр байж таарна гэж Чагнаа ууртай хэлэв.

-Индүүний ул шиг мөр ий?!

"За тийм ээ. Эгээ л нэг, бохир гал дээр халаасан индүүний ул л тийм байдаг... Юу гэж?

-Үгүй, Үгүй... ээ... дарга минь, би танайхантай хамт явж, тэр үл бүтэх амьтныг олоход тусалж болохгүй гэж үү?

-Бололгүй яахав. Дуртай зөвшөөрнө. Гагцхүү...

-Тиймээ. Би ойлгож байна. Гэвч би өвчтэй хүүхдүүдийг үзэж эмнэхийнхээ зав чөлөөгөөр л явах юм шүү дээ.

Жаргал эмч утсаа тавиад гүн бодолд автав. Индүүний мөр гэсэн үг түүнд байн байн

бодогдоно. «Хэн тийм гуталтай байх Л билээ. Эмчийн өчнөөн хайсан Мануухай л индүүн гуталтай биш үү? Тэгтэл Мануухай хүүхэд хулгай хийх гэж үү? Бас санахаас айдас хүрмээр өвчин хүүхдэд тараах гэж үү?»

Ингэж санахаас Жаргал эмч эгээтэй л ухаан алдсангүй. Тэгээд өвчтөнүүдийг бушуухан үзээд, эм тангий нь уулгаад, гарч одлоо. Тэр, морин тойруулга руу яаран хүрч, номхон бөгөөд хурдан хээр алаг морь уналаа. Тэр хээр алаг морь эмч гуайг хотын хойд зах хүргэхээр дороо л шуугитал хурдлав.

Сайхан сэтгэлт эмчийн дуу

Энэ үест Мануухай гурван жаахан хүүхдийг усан хоолойн нүхэнд оруулаад тэр нүхний ёроолд байх шалбаагт угааж байлаа. Хүүхдүүд хувцсаа тайлаад, нүцгэн байсан боловч Мануухайн зааснаар бусдаас ичиж зовохыг хэдий нь мартсан тул, тэгж шавар шавхай дотор хутгалдах нь зугаатай санагдан инээд алдацгаана.

Мануухай ер нь тун урамтай байв. Дээрэмчдийн хэрэг бүтэж хүүхдүүдэд заасан зүггүй зан юм уу, үл бүтэх дэггүй ааш нь газар авч хотод хачин өвчин дэлгэрсэнд тэр ихэд баярлана.

«Юмыг яаж мэдэх вэ. Ингэсээр байгаад хүүхдийн хотыг бүрэн эзлэх ч юм билүү. Тэгэхлээр чинь аймшигт дээрэмчид хотыг дөрвөн талаас нь дайрч өөрийн болгох юм бол, үнэхээр Мануухай л хотын дарга болно. Тэгвэл мөн гоёо!» Ингэж бодсон Мануухай хүүхдийг бохир занд сургах гэж үнэн голоосоо мэрийж байлаа.

Хүүхдүүдийг уснаас гаргаад Мануухай, харахаас нүд халтирам шавхай дундуур туучлаа. Өөрөө бас туучиж, индүүн гутал, үстэй малгай, хэлхгэр том хүрмээ хүртэл шавар болгож, нүүр амаа шавардан будав.

Бяцхан гурван жаалд урд өмнө нь огт үзээгүй энэ тоглоом А үнэхээр хачин санагдсан болохоор дуу шуу болоод л шавар / руу дайрлаа. Тэгээд, Мануухайг дууриан нүүр амаа будаж, гэдэс ходоодондоо хээ тавин, хэдхэн хормын дараа гэхэд, гахайн гурван торой шиг л амьтан болсон байв.

Мануухай тэднийг шавраас гаргаж, хот уруу орж ирээд, тун саяхан шүршигч машин лут хүчтэй усан цацрагуудаараа цэвэрлэж толийлгосон цэвэр гудамж дээгүүр шавар шавхайн мөр гарган явлаа. «Тэр гурвыг одоо хот руу явуулах хэрэгтэй. Гэр орондоо очиж, шавар шавхайд тоглохыг бусдадаа зааж өгье» гэж Мануухай шийдэв.



Гахайн гурван торой шиг тэр гурав нүцгэн хөлөөрөө гудамжийг бохирдуулан, муухай хар мөр гаргасаар гэр рүүгээ гүйлээ. Мануухай тэдний хойноос харж баярлан хэсэг зогссоноо яваад өгөв. Одоо тэр, өөр хүүхэд хайж эхэллээ. Түүнд хувцсаа урах дуртай жаал л хэрэгтэй байв. Тийм жаалыг олоход амархан л даа. Даашинзныхаа ханцуйг хадаасанд огло татсан юм уу, эсвэл, өмдөө урсан жаал л тааралдвал гүйцээ шүү дээ. Тэгтэл санасан ёсоор нэг жаал охин циркийн хажуу талын сандал дээр сууж байлаа. Тэр охин хөлөө унжуулан суугаад хүүхэлдэйнхээ дээлийг тайлж байв. Яг тэгэхэд дэргэд нь Мануухай очсон байлаа.

Мануухай охины гараас хүүхэлдэйн дээлийг авч; Л

-Хоёулаа энэний товчийг авч чулуун дээр тавиад хагалж үзэх үү? гэж найрсгаар асуув. «Хүний юмыг дур мэдэн авдаг ямар хачин амьтан бэ!» гэж тэр охин бодсон боловч, найрсгаар асуусан үгэнд нь баярлаад

-Тэгье! гэж дуртай зөвшөөрөв. Тэгээд хоёулаа хэзээ язааны найз шиг хөтлөлцөн замаас гараад чулуу олж товчнуудыг нэг нэгээр цохиж хагалж гарлаа.

-Товчин дотор чинь юу ч байдаггүй юм байна. Хоёулаа нэгэнт товчийг нь хэмхэлсэн юм чинь одоо дээлийг нь урж үзье. Ёв дотроос нь гоё юм гарах байх гэж Мануухай санал гаргав.

-За тэгье! гээд охин хүүхэлдэйнхээ дээлийг өглөө. Мануухай ч түүнийг нь авч тэр дор нь хоёр хэсэг болгов. Гэвч дээлнээс юу гарах билээ дээ.

-Одоо хоёулаа миний хүрмийг урж үзье. Түүн дотор юу ч байж мэднэ гэж Мануухай хэлэв.

Ийнхүү дээл хувцас ураг нь жаахан тусгүй ч гэсэн, сонин санагдсан болохоор тэр охин Мануухайн хүрмийг элбэн урав.

Дараа нь Мануухайн малгайг эвдэх гэж баахан ноцолдоод болохгүй болохоор нь өөрийнхөө өмсөж явсан шинээс шинэ цагаан шаахайны улыг санжигнуулж нохойн хэл мэт хөлөө цухуйлгалаа.

Ер нь урж эвдэж тоглох гэдэг их сонин зүйл бололтой. Тийм болохоор мань охин ихэд уурласан маяг үзүүлж, нохой архирах шиг хадаасан шүдээ цухуйлгасан шинэ шаахайгаараа газар алгандан, бараг чармай нүцгэн шахуу амьтан болоод гэр рүүгээ гүйн одов. Мануухай инээсээр үлдлээ.

Яг энэ үед аюулаас хамгаалах газрын дарга Чагнаа, эмч Жаргал болоод бас бус хүүхдүүд хотыг нэлд нь харж чадах том дуран авайн дэргэд суугаад үл мэдэх амьтныг харж байлаа.

-За ямар байна? Мануухай мөн үү? гэж Чагнаа эмчээс асуулаа.

-Мөн л юм шиг байх юм даа. Гагцхүү малгайгүй, хүрэм нь А уранхай, тэгээд шавар шавхай, хог буртаг болсон амьтныг / танихад хэцүү л байна гэж Жаргал хэлэв.

-Мөн ч байсан, биш ч байсан, дайрч очоод барья гэж хүүхдүүд-дийн нэг нь санал гаргалаа.

-Тэгж болно. Гэхдээ холдоогүй дээр нь барих нь мөн гэтэл эмч «Би очоод үзвэл яасан юм бэ? Би Мануухай байсныг хүүхэлдэй болгож эмнэсэн юм болохоор эрхбиш миний дууг сонсоод...» гэхэд нь Чагнаа:

-Зөв! Тэгээд ямар санаатайгаа эмчид хэлэг. Эмч ч гэсэн хэлүүлж авахыг бодох хэрэгтэй. Бид зугтаах бүх боломжийг хаана. Харин та л барьж авахыг бод, за бушуу хөдөлж үз! гэлээ.

Эмчийг хээр алаг мориндоо мордож хотын гудамжаар аль хөдөлгөөн багатай газраар

ергүүлсээр цирк хүрч очтол Мануухай цаашид юу хийхээ бодон зогссоор л байлаа. Тэгээд гэв гэнэт морин төвөргөөний чимээ сонсож ухаан алдталаа айгаад зугтав. Түүний гүйх нь даанч хурдан. Ид шидийнхээ хүчээр Тортог-буртаг түүнийг тийм хурдан болгожээ.

Мануухай арван гудамжийг ганц хормын зуур харайн өнгөрч дахиад таван байшингийн хажуугаар нисэх мэт хурдлаад, усан хоолойны нүхээр орж зугтахаар шургатал,

-Мануухай! Миний хөөрхөн Мануухай намайг хүлээгээрэй! гэх энхрий зөөлхөн дууг олж сонслоо. Жаргал эмчийн тэр дуу Мануухайн тархинд байсан муу муухай бүхнийг зайлуулсан мэт тэр дороо номхон бөгөөд хүлцэнгүй амьтан болон зогслоо.

Зургадугаар бүлэг

Хэн явах вэ?

Мануухайг эмч гэртээ авчирч хамаг хир бүртгийг арилган усанд оруулаад ширээнээ суулган түүний дуртай хайлмаг, амтат боовоор дайлан:

-Хонгор хөөрхөн Мануухай минь юунд надаас зугтан одсон бэ? Одоо бас дахиад зугтах гэж үү? Үгүй шүү дүүдэй минь, Л хэрхэвч чамайг дахин явуулахгүй. Чиний энэ хувцас хунар, нүүр ам даанч хүн харахын аргагүй болжээ. Чамд нэгэн янзын өвчин туссан бололтой. Чи тэр муухай өвчнийг нэг л газраас авсан байж таарна. Хаанаас авсныгаа эгчдээ хэлэх юм байгаа биз гэж ярина.

Тэр Мануухай бүрмөсөн эргэж орхисон ухаан санааг цэвэрлэж, бүх үнэнийгээ хэлж чадах үгээр аргадан тайтга-руулж, хоолонд нь сайн чанарын сэтгэл сэргээх эм шингээж түүний дуртай улаан усны оронд «Зүрх уяраах» гэсэн нэртэй амтат балын өнгөтэй ундаан уулгав. Тэгээд Мануухайн хувцсыг нь солиод, индүүн гутлыг нь тайлж, мөнөөхөн анх Мануухайг ирэхэд хийж өгсөн нугасаа хүртэл модон гарнаас нь салган авч зэвийг нь цэвэрлэж унтуулав.

Эмч Мануухайн хажууд суун сэтгэл зүйн илэлт хэмээх нэгэн ёсны дасгал хийж, судас шөрмөсийг нь илэн таалж гарлаа. Тийм их түйвээн гаргаж өдөржин шавар усан дотор тоглосон юм болохоор Мануухай хэвтсэн дороо л унтаж орхилоо. Тэгснээ гэв гэнэт огтын эрүүл цэвэр дуугаар нойрон дундаа өөрт тохиолдсон бүх явдлаа ярьж гарлаа. Хэрхэн эмчээс зугтаж, яаж хүүхдийн хотоор зугаалж хэрхэн жаалуудын юм булаан авч, цагдаа жаалаас зугтсан болон ойн дээрэмчин Түн түн пин панд олзлогдсон, тэр дээрэмчид ямар хачин зүйлсэд Мануухайг сургасныг яриад, хүүхдийн хотыг эзлэн авахын тулд яаж заналхийлж байгаа болоод өөрт нь ямар даалгавар өгч явуулсныг нэгд нэгэнгүй өчив.

-За харж байгаа биз дээ? Үнэндээ! Яг л үнэн. Хэрэв тийм муухай санаатай амьтдад олзлогдоогүйсэн бол миний хөөрхөн Мануухай юунд элдэв хэрэг тарих билээ. Дарга минь тэр аюулт дээрэмчидтэй нэгийгээ үзэх цаг болжээ. Би бас тэдний эсрэг тулалдах багт явмаар байна. Миний бодоход, тэр дээрэмчдийн эсрэг буу шийдэм хэрэггүй юм. Харин ухаанаар зэвсэглэх хэрэгтэй. Ер нь би тэдний эсрэг тулалдаж чадах сайн чанарууд А бүхий хүүхдийн багийг зохион байгуулбал яасан юм бэ? гэж / эмч, Мануухайн үгийг сонсоод Чагнаад утсаар хэлэв. -Мануухайгаа яах юм бэ?

-Үүнийг хааш нь ч алдахгүй. Ер нь дээрэмчдийн байр байдал, зан араншинг мэддэгийнх нь хувьд авч явсан ч болох юм. Би түүнд сэтгэл засах эмчилгээ хийж эхэллээ. Энэ л үр дүнгээ өгнө байх гэхлээр

Таныг тийм баг байгуулахад бид татгалзахгүй. Амжилт хүсье! гэлээ.

Жаргал эмч тулалдаанд бэлтгэв. Тэр хамт тулалдах хүмүүсээ олохын тулд хотоор өдөржин давхив. Дээрэмчдийн эсрэг баг байгуулах гэж буйг хэрэв ямар нэг аргаар шиншилж мэдвэл, ид шидтэй Тортог-буртаг яаж ч мэдэх учир эмч маш их болгоомжилж байлаа. Тэр ч байтугай

Энэ тухай тас нууцалж, дээрэмчдийн эсрэг багийг байгуулахын тулд өөрөө хүн болгонтой уулзаж, «нууцыг задруулахгүй!» гэсэн амыг нь авч явав.

Энэ үеэс айхгар хүнд өвчтөнгүүд эдгэрч, сэтгэл зовмоор юм алга болжээ. Хүүхдүүд сургуульдаа явж, зарим нь ажил хийж, хүүхдийн хот наргиан шуугиантай ерийнхөө амьдралд шилжив.

Жаргал эмч хүүхдийн дотроос дээрэмчдийн эсрэг тулалдаж чадах хүүхдийг тун ч амархан олов. Ер нь тэгэхгүй ч яах вэ дээ. Ертөнцийн хамгийн сайн сайхан чанар шингэсэн хот юм болохоор эмчтэй тааралдсан бараг бүх хүүхдүүд сайн чанартайгаа харуулж, хотынхоо төлөө дээрэмчидтэй нэгийгээ үзье гэж илэрхийллээ. Тэр багт хэн бэ гэвэл, нэгдүгээр ангиасаа эхлээд онц сурсаар байгаа наймдугаар ангийн Азжаргал, хотын биеийн тамирын идэрчүүдийн аварга Бэхбат, ногооны талбайгаас их ургац хураасан Арвай гэх зэрэг хамгийн мундгууд оролцлоо. Дээрэмчидтэй нэгийгээ үзэхийн тулд Жаргал эмч тэднийг цуглуулсан даруй яриа хийж Мануухайг хувцаслан дээрэмчид байх зүгийн ойн зах уруу орлоо.

Долдугаар бүлэг

Хойрог-нойрог \

Мануухай яваад удлаа. Хүлээж ядсан дээрэмчид хэдэн өдөржин хийх юмаа олохгүй дэмий л нэг холхив. Харин ингэж дэмий хүлээнэ гэдэг нь унтахыг хэлдэг юм гэсэн шиг Хойрог-нойрог л таван өдөр туж унтав.

Эцэст уур нь хүрсэн Тортог-буртаг үсрэн бослоо. Дэндүү их уурласан үедээ тэгдэг шигээ хавийн газрыг шүлс ус болгон шүдээ хавираад тэр одоо хүртэл унтсаар байгаа Хойрог-нойрогийг айсандаа ухаан алдтал нь хашгирав.

-Урваж байна! Урвалт! Мануухайг дүүжлэн, хамгийн муухайгаар тарчлаан зовоож!... гэтэл Түн түн-пин пан дууриан:

-Нурууг нь хугалж, нугасыг нь тасална! гэв. Эзэн дээдсийнхээ ийм их ууртай байхыг хэзээ ч үзээгүй Халхай-балхай сүрдсэндээ дагжин чичирч бутны доогуур толгойгоо шургуулав.

-Хойрог-нойрог! Миний үнэнч дээрэмч! гэж эзэн нь нойрмог улаан нүдтэй Хойрог-нойрогийг гэв гэнэт эелдгээр дуудлаа. Сайхь дээрэмчин ч тэр дороо л эзнийхээ өмнө очиж ёслов.

-Магадгүй, сайн санаат Мануухайд аюул тулгарав уу? Эсвэл их хэргийг нэгэнт эхлээд, биднийг хүлээж байгаа ч юм билүү. Ухаантай бөгөөд зоригтой Хойрог-нойрогийг Мануухайн хойноос явуулъя гэж би шийдэв. Чи яаралтай явж түүнтэй уулзан, хэл мэдээ авчир! гэж Тортог-буртаг хэлэв.

Хойрог-нойрог хот уруу явлаа. Түүний залхуу туйлын их хүрч байсан боловч эзэн дээдсийнхээ аймшигт царайг санах тусмаа л аргагүй урагш явж байв. Гэвч Мануухайн өдөртөө хүрсэн хүүхдийн хотод Хойрог-нойрог гурав дахь хоногтоо л арай гэж хүрлээ. Хотын захад арай гэж нэг юм хүрээд, үнэхээр ядарсан ба өлссөнөө мэдээд бүтэн туулайн мах идэж орхиод алтан харганын бутан дундуур шургаад унтаж орхилоо. Түүний хурхирах дуу нь ойр хавийн байшингаар удалгүй цуурайлж гарлаа.

-Хүүхдүүд ээ, түүний унтахад бүү саад бол. Харин сэрэхэд А нь үзүүлэх жүжгээ бэлдэж бай! гэж Жаргал эмч, Мануухай / болоод жаалуудад хэлэв.

Үнэхээр даруй хоёр цаг унтсаны дараа Хойрог-нойрог өндийж сэрэв. Эхлээд нэг нүдээ, дараа нь гайхсандаа нөгөө нүдээ нухаж байж нээснээ дуу алдан босов. Үзвэл тэрүүхэн хажууд байх шавхай дотор Мануухай гурван жаалхан хүүхдийн хамт биеэ шавардан будаж тоглож байв.

-Хэ, хэ, хэ! гэж Хойрог-нойрог инээд алдан танил Мануухайгаа тэврэн авахаар ухасхийв. Усан дотроос бамбарууштай төстэй дээрэмчин гарч ирэхлээр гурван жаал цочиж амаа ангайн гайхан зогсов.

-Мануухай!

-Хойрог-нойрог! гэлцэн нөгөө хоёр тэврэлдэн авлаа. -Чамайг яагаад алга болов гэж эзэн дээдэс ууртай байна. Тэгээд яасан тухай мэд гэж явуулав гэж Хойрог-нойрог хэлээд -Чамд идэх юм байна уу? гэлээ.

-Байлгүй яах вэ? Алив, хүүхдүүд ээ хоол авчир! гэж Мануухай тушаав.

Өнөө гурван шавар болсон жаал дорхноо гүйж, хажуу талын байшингаас Жаргал эмчийн зааснаар түмпэн дүүрэн амтаг жимс, чанаж хөргөсөн мах авчрав.

-Харж байгаа биз дээ. Би энэ хотод хэзээ язааны эзэн болжээ. Хот тэр аяараа миний гарт байна. Иймд эзэн дээдсийг одоохон ирж надтай уулз гэж хэл! Хотыг дөрвөн талаас дайраад хэрэггүй. Харин нэг нэгээрээ ирж, миний зааснаар сэмхэн бөгөөд түргэнээр зохих газруудыг дэс дараалан эзэлж авбал тун ч боломжтой юм байна. За тэгээд түргэн яв! Алив, хүүхдүүд ээ, үүнд идэх юм авчирч өг! гэж Мануухай ихэмсгээр хэлэв. Гэвч Хойрог-нойрог идвэл л заавал унтдаг тул тэр дороо нүд нь анилдан буудуулсан юм шиг л уналаа. Унтсан хойноо сүхээр цохисон ч сэрмээргүй Хойрог-нойрогийг хүүхдүүд дамжлан, идэх юм, жүржийн охь дүүрэн чихсэн богцтой нь хамт ойн гүнд (Н сэмээрхэн аваачиж тавилаа.

Наймдугаар бүлэг

Халхай-балхайн паян

Хойрог-нойрог бүрэн бүтнээр барахгүй хэт их идсэнээс амьсгаадаад үг хэлэх ч чадалгүй ирэхэд нь дээрэмчид үнэнээс гайхав.

Тэгээд түүний ярихыг сонсмогц сэтгэл ихэд хөдөлсөндөө Түн түн-пин пан зургаан царцааны хөл хугалж, гурван залуу жодоо модыг суга татан хаяв.

Халхай-балхай ч баярлаж, аймхайгаа мэдэхгүй бушуухан хүүхдийн хотод хүрч эзлэн авахаар өөрийнхөө зэвэнд идэгдсэн буу зэвсгийг агсаж, дээрээс нь Хойрог-нойрогийн хумсны хутгыг, Түн түн-пин пангийн унагаасан жодооны нэг мөчрийг авч бэлдэв. Гэвч эзэнтэн хотоос ирсэн дээрэмчийн үгийг бүрэн үнэмшихгүй:

-Нээрээ биз? Худлаа биш биз? гэж асуусаар байлаа.

Итгэж ядаад ч байх юм алга. Хойрог-нойрог бэлхнээ хүүхдийн хотын байдлыг үзэж, тэр ч байтугай амьсгаадталаа идээд, нойр нь хүрсэндээ эзнийхээ хөлний тэнд хөсөр унан унтаж байв.

Догшин ширүүн эзэн, хот уруу хэнийг явуулахаа дорхноо бодож оллоо. Хэрэв тийм амархан л юм бол Халхай балхай яваг!

Ийм аймхай хулчгар амьтан хэрэв хотын нэгэн хэсгийг эзэлж авдаг юм бол бидэнд юуны аюул байх вэ? гэж бодоод

-Халхай-балхай! Ойн эрэлхэг дээрэмч! Аян дайнд бэлтгэ! гэж тушаалаа. Бас эзэнтэн хэлсэн нь:

-Эзлэн авсан даруй том харанга нүдэж, чимээ өг! Тэгсэн цагт дараагийн дээрэмчинг явуулах болно! гэв.

Ийнхүү тэр өдрийн үдээс хойш Халхай-балхай аян дайнд мордлоо.

Үнэнийг хэлэхэд Халхай-балхай бүсэндээ тус бүр зургаан сумтай нагаан буу дөрөв, хурцаас хурц чинжаал хутга гурав, модон шийдэм болоод жодооны мөчир, хумсны хутга зэргээр А зэвсэглэсэн боловч навч хөдлөхийн тоолонгоор унан тусаж, өвс / хийсэхийн тоолонгоор үсрэн хэвтэх зэргээр их л айж явав.

Халхай-балхай хүүхдийн хотод шөнө орж ирлээ. Тэрбээр модны сүүдэр даган алхаж хэзээ л хаанаас нь бариад авах бол гэж айсаар явлаа. Гэвч Халхай-балхайг хэн ч барьсангүй. Харин хотын төв гудамжинд нэгэн муу хав нохой л түүнийг ихэд муухайгаар харж байснаа гэв гэнэт хуцаж давхив.

Халхай-балхай айн зугтаж, тэр чигээрээ нэгэн том хашаагаар ороод, өөрөө ч мэдэлгүйгээр

тэрхүү циркийн амьтдын хүрээлэнгийн хашаанд ээлжит тоглолтын дараа гаргаж дүүжилсэн том төмөр харангыг балбаж, аврал тусламж эрэв. Тэрхүү харанга нь туйлын их чимээтэй хадаасан болохоор циркийнхнийг тэр дороо хөл дээр нь босгон, ойн алс гүнд хүртэл цуурайтав.

Хэрэв яг энэ үед амжиж Мануухай ирээгүйсэн бол, Халхай-балхай лав, циркийн манаачид баригдах байсан биз.

-Зогс! хэмээн манаач Сармагчин хүний хэлээр хашгирч дээвэр дээрээс бууж ирэх тэр мөчид Мануухай, Халхай-балхайг хөтлөн хашааны хаалгаар гарч амжсан байв.

Халхай-балхай ингэж Жаргал эмч болоод хүүхдүүдийн гарт тушаагдлаа. Түүний айснаасаа болж, өгөх ёстой чимээгээ яагаа ч үгүй эрт өгчихсөний нь мэдээд хүүхдүүд хөгжилтэйгээр инээлдэв.

-За Халхай-балхай минь. Одоо чи дээрэмчин гэдэг нэрээ орхиж, хүүхэлдэй гэдэг эрхэм нэртэй болно. Эмч Жаргал гуай чамайг эмнэж, муу муухай аймхай хулчгар чамайг ажилсаг, хичээнгүй, зоригтой болгоно. Ийм учраас чи хүүхдийн хотод үлдэх ёстой. Хэрэв чи хүүхдийн хотод үлдье гэвэл бүхнийг хүүхдүүд хийх болно! гэж Мануухай хэлэв.

-Ий ий... айж байна! гэж Халхай-балхай уйллаа.

-Айх юм байхгүй. Энэ хүүхдүүд цөмөөрөө чиний нөхөд мөн гэтэл:

-Биш! Миний нөхөд биш! Намайг хүүхэлдэй байхад эд нар л хог дээр хаяж... Тэгээд би муу санаат Тортог-буртагийн гайгаар Л дээрэмчин болсон би... би... гэж Халхай-балхай мэгшив.

Тэгтэл юу болсон гэж санаж байна. Гэв гэнэт, хаанаас гараад ирснийг мэдэхгүй нэг жаахан охин, хүрч ирээд

-Эвий хөөрхөн, гуталт муур хүүхэлдэй минь! гээд л тэврэн уйллаа.

-Уучил намайг! Одоо би яасан ч чамайг хог дээр дахин хаяхгүй. Чи миний хүүхдийн хотод гуталт муур хүүхэлдэй хэвээрээ үлдэнэ гэж тэр охин бас хэлэв.

Есдүгээр бүлэг

Тун-тун пин пан хотод

Зэрлэг догшин Түн түн-пин пан уулын орой дээрээс харангын дууг олж сонсоод эзэндээ яаран гүйж ирэв. Одоо түүний ээлж болжээ. Хэзээ ч хэнийг ч өршөөж үзээгүй энэ дээрэмчин хотыг яаж сүйтгэх болдоо.

-Хамгийн дотно эрэлхэг Түн түн-пин пан чамайгаа одоо явуулья. Хотыг эзлэн авах хэрэг ийм амархан бүтэж байгаад би нэг л итгэхгүй байна. Чи бол миний хамгийн итгэлтэй хамгийн эрэлхэг дээрэмч. Хэрэв чи хотын аль нэг хэсгийг эзэлж аваад өөрийнхөө нэн дуртай зүйл болох их буугаар буудаж ёслох юм бол, би бүх ялалт манайх болжээ гэж бодох болно. За яв даа, Түн түн-пин пан минь! гэж Тортог-буртаг хэллээ.

Түн түн-пин пан хот уруу явав. Эвдэлж нураана, урж тасдана гэж бодохоос түүний хөл, гарын алга загатнаж байлаа.

Харин энэ үед Хойрог-нойрог гэнэт сэрэв. Түүний удтал унтсан царай хавдаж, зовхи нь унжаад амьтан хүн харахын аргагүй болсон байв.

Гэдэс нь өлсөж гомдол нэхэх мэт дуугарахыг яана. Тэр юу ч хамаагүй идмээр санагдав. Тэгээд овоохойг онгичиж, түмпэн сав хангинуулан хайсан боловч юу ч олдсонгүй. Дээрэмчид хоол ундгүй орхижээ. Одоо Хойрог-нойрог хоол хаанаас олж болохыг А сайтар бодлоо. /

Гэв гэнэт түүний толгойд мэргэн бодол гялсхийтэл орж ирэв. Мэдээжээр хүүхдийн хот л санаанд нь орсон хэрэг. Тийм их хоол унд өөр хаанаас ч олдохгүй. Тийм болохоор Хойрог-нойрог хоолтой газар уруу одоохон гүйж хүрмээр байлаа.

Хойрог-нойрог эзнээсээ ч зөвшөөрөл авсангүй. Шууд л ойн дундуур шурган алга болж, өлссөндөө болоод түрүүн гурав хоног явснаа ч мартан тэр дороо л гүйн одов. Гэвч мэдээжээр Хойрог-нойрогийг хэн ч угтсангүй. Хүүхдүүд нэгэн тийш яарч, тэр зүгт их чимээ гаран, галын аюул болсон мэт машинууд давхина.

Хойрог-нойрог Мануухайг хайж хотоор тэнэж гарлаа. Тэгтэл гэв гэнэт Хойрог-нойрог нэгэн их овоолсон чулуун дунд орчихов. Тэр их чулууг уг нь барилгад хэрэглэх гэж авчирсан бололтой. Гэтэл Хойрог-нойрог мөнхүү чулуудын нэгтээ байх цоо шинэ хаалгатай жижиг байшинг харав.

Лав тэнд идэх юм овоолоостой байгаа биз гэж бодоод орлоо. Үнэхээр ч урт тавиур дээр хиам шиг хэлбэртэй урт гонзгой зэрэгцүүлэн тавьсан байв.

-Ухайс! Ээ бас сайхан аа! гэж Хойрог-нойрог тэдгээр улаан цаасанд ороолттой юмнаас шүүрэн авлаа.

Энэ бол огтхон ч хиам биш, харин хээрийн чулуу дэлбэлдэг дарь байлаа. Тэрхүү гонзгой цаастай дарь бүхний дотор дэлбэлэгч зүйл нуусан байжээ. Хойрог-нойрог хэрхэн түүнийг

мэдэх билээ. Идэх юмны мөрөөсөл болсон амьтан чинь хажуу талаас нь хазаад авав. Юун даагдахтай мантай, эгээтэй л шүдээ авсангүй. Тэгтэл, нэгэн янзын шуугиан чимээ гарч, бас дотор муухай болмоор үнэр ханхлаад унав. Яг энэ үед гаднаас нэгэн хүүхэд гүйн орж ирэв. Мэдээжээр хачин амьтныг хараад зог туссан боловч гарт нь дэлбэлэгч байхыг мэдэж,

-Хүүе та үүгээр яах нь вэ? гэж сандран асуулаа.

-Идэх гэсэн юм! гэж Хойрог-нойрогийг хэлж дуусаагүй байтал зоригт хүү ганц үсрээд гартахийг нь авч хаалгаар гадагш Л шидлээ. Тэгээд Хойрог-нойрогийг унаж тустал нь түлхлээ. Тэрхүү аймшигт зүйл чулуун дунд тэсэрсэн нь яамай даа. Хэрэв тэгээгүйсэн бол Хойрог-нойрог байтугай, хөөрхөн жаал хүү ч лав үлдэхгүй байсан.. Ёут дэлбэрэлтийн чимээ их бууны дуу шиг хот даяар дуулдаж, ойг цуурайтуулан одлоо.

Яг энэ үед Түн түн-пин пан хотын захын хайс, замын тэмдгийг суга татан унагаж, цэцгийн мандал дээгүүр гишиглэн, цонхнуудыг чулуугаар хага цохиж байв. Түүний энэ аймшигт хэргийг зогсоож, хүүхдүүдэд барьж өгөхөөр Мануухай, Халхай-балхай хоёр яаран очлоо.

Аравдугаар бүлэг

Ид шидийн хучээр

Өндөр уулын орой дээрээс Тортог-буртаг их тэсрэлтийн чимээг сонслоо. Тэр нь яг л их бууны дуу шиг сонсогджээ. Түүний эргэлзсэн талаар бөгөөд Түн түн-пин пан их буугаар чимээ өгснөөс гарцаагүй. Энэ нь хотын аль нэг хэсгийг эзэлж авлаа гэсэн дохио яах аргагүй мөн тул хүүхдийн хот уруу аюулт дээрэмчин яарч орлоо.

Тэр овоохойгоо нураан хаяв. Хүүхдийн хотод өндөр сайхан байшинд суух юм болохоор овоохойгоор яах вэ. Өөрийн гэсэн юмнаасаа шидэт хайрцгийг авч өвөртөө хийв. Тэрхүү хайрцаг дотор дээрэмчид байвал зохих бүх муу санаа бүхэн байдаг юмсанжээ. Тэгээд Тортог-буртаг хожуул дээр суун хэсэг зуур юм бодлоо. Тортог-буртаг тун их баяртай байлаа.

Хүүхдийн хотын ноён болж гоё машинд сууна. Гудамжаар явахад нь өчүүхэн боол хүүхдүүд бөхийн ёсолж, их эзэнтний өмнө сөхрөх болно. Тортог-буртаг ноёнтон үгэнд ороогүй тэднийг урт суртай ташуураар ороолгож байгаа нь харагдах шиг болно. Түүний хажуунаас Түн түн-пин пан ердөө ч салахгүй.

Харин Хойрог-нойрог, Халхай-балхай хоёр зарц боолын ёсоор А дагах биз. /

Тортог-буртаг, Хойрог-нойрогийг үгүйлсэн ч үгүй хот уруу яаран хүрэхээр явлаа.

Хамгийн хэцүү бөгөөд идтэй шидтэй Тортог-буртагийг барих гэж хүүхдүүд чамгүй бэлдсэн байлаа. Ямар ч амьтан болж хувирч чадах түүнийг осол эндэлгүй барьж авахын тулд тун сая эзнээ олж хүүхдийн хотод бүрмөсөн үлдэхээр ам өгсөн Халхай-балхай, бас Хойрог-нойрог, анхнаасаа хүүхдүүдэд тусалсан Мануухай нартай хамт Жаргал эмчийн сэтгэл уяруулах эмчилгээний ачаар номхон хүлцэнгүй болсон Түн түн-пин панг хотын зах уруу явуулав. Дээрэмчдийг эсэргүүцэн барих баг нууц газар үлдэж сэргийлэхийн дарга Чагнаа тэдэнтэй нийлэв.

Үдийн хавьд Тортог-буртаг хот, уруу орж ирлээ.

-Эзэн дээдэс минь тавтай морил! гэж Мануухай дуу алдан хашгирлаа.

-Хүүхдийн хот манайх болсон. Бүх газрыг эзлэн аваад гагцхүү эзэн дээдсийнхээ зарлигийг хүлээж байна. Тийм биз дээ. Түн түн-пин пан аа? гэж Халхай-балхай асуув.

Халхай-балхайн зоригтой сэргэлэн дууг сонсоод нэгэн үе гайхах мэт зог туссанаа эзэн дээдэс нь шууд л Түн түн-пин пан уруу очлоо. Тэгтэл юу болсон гэж сананаа. Түн түн-пин пан чухам л нэг хэлхээтэй төмөр адил дуу гарган

-Аюул!... Аюул! гэж хашгирав.


Энэ сацуу Мануухай ч ухасхийж, бусад нь ч үсэрч аюулт дээрэмчний гараас барьсан боловч хожимджээ. Тортог-буртаг үзэгдэхгүй болж нэгэн муухай мөр гаргасаар хотын гүн уруу зугтан

одлоо. Түүний хойноос Чагнаа, Жаргал болон хүүхдүүд нэхэж гарлаа.

Арван нэгдүгээр бүлэг

Мөрдсөн нь

Мөрдөгчид Тортог-буртагийг хөөсөөр байгаад нэгэн сургууль уруу оруулаад алдав. Тэр сургуулийн гурвын «б» ангид Тортог-буртаг орж, чухам хэний хажууд наалдан мөрдөгчдөөс зайлъя даа гэж бодохын тулд ширээн доогуур орлоо. Тэр ид шидийнхээ хүчээр үзэгдэхгүй болсон учир хэн ч түүнийг мэдсэнгүй.



Тэгж хэдэн минут өнгөрсний дараа Тортог-буртаг ширээн дороосоо мөлхөн гарч, нуугдах газар хайн хичээллэж байгаа жаалуудын хажуугаар явлаа.

-Хүүхдүүд ээ, тоогоо сайн бодно шүү. Тооныхоо хүрдийг цээжилсэн хүүхдэд бол энэ тоо тун ч амархан. Бас цэвэр бичих хэрэгтэй. Чи яагаад байна? Битгий ийш тийшээ хараад байгаач! Тоогоо бод! гэж. багш арын ширээний жаалд хэллээ.

Яг энэ үед Тортог-буртаг тэр хүүгийн хажууд зогсож байснаа үзэгний нь үзүүрээс дусах гэж байсан бэх уруу нь орчихов. Бэх дэвтэр дээр, дусаж бөөн хар толбо боллоо.

-Яанаа! Багш аа! гээд л нөгөө жаал дуу алдлаа.

-Яав, юу болов?

-Дэвтэр дээр бэхийн толбо болчихлоо гэж жаал хүү уйлав. А Ийм явдал хэзээ ч гарч байгаагүй тул бүх хүүхэд эргэж харлаа. /

-Ай бас гай яа! Энэ их муу шүү гэж багш гасална. Энэ үед гаднаас Жаргал эмч, Чагнаа болон бусад мөрдөгчид орж ирлээ.

-Уучлаарай, та бүхнийг ангиудаар үзлэг хийж явааг мэдсэнгүй. Бидэнд хэзээ ч тохиолдоогүй золгүй явдал боллоо. Нэгний маань дэвтэр гэв гэнэт бэхийн толбо болчихлоо гэж багш тайлбарлав.

-Хи, хи, хи... Одоо ч намайг олохоосоо өнгөрөө вий. Хэд хоног энэ жаалын дэвтрийн завсар нуугдаж байгаад сэмээрхэн ой руугаа оргоно доо гэж тэдний сандарсан царайг харан Тортог-буртаг дооглон инээв. Гэтэл урдаас сүрхий бэлтгэлтэй Жаргал эмч бэхийн толбо арилгах

гайхамшигт эмийг гарган дэвтэр дээр болгоомжтой нь аргагүй дусаалаа.

-Халцгай!! гэж хорссондоо Тортог-буртаг ангийн бүх хүүхдийг цочтол хашгирлаа. Тэгээд дэвтэр дээрээс зугтан одов.

Яг энэ үед тэр нэгэн охины захны даавуунд уусан нуугдлаа. Ай бас гай байх гэж... Харсаар байтал шороон хар мөр дэвтэр дээрээс зугтаж ширээн дээгүүр дамжаад, нөгөө талд байсан охины хүзүү рүү орчихсонд зах нь ердөө л тун саяхан шороотой усанд дүрсэн мэт харлаж орхив.

-Ээж ээ! гэж захныхаа муухай болсныг хараад тэр охин уйллаа.

-Тайвшир, дүү минь тайвшир. Энэ бол аюултай амьтны мөр. Одоохон энэ эмч чинь цэвэр болгож өгнө! гэж Чагнаа хэлэв, Жаргал эмч уйгагүй зангаараа өнөөх шингэн зүйлээ хөвөнд шингээн бөхийв. Удахгүй тэндээс хүн ёолох шиг дуу гарч, нэгэн муухай мөр гарган Тортог-буртаг ангийн нөгөө тийш зугтан одлоо.

Бүх хүмүүсийг харсаар байтал тэр мөр алга болж, харш хамраа цэвэрлэх дургүй нэг хүүхэд ханиад хүрсэн мэт найтаах дуулдлаа. Хэрэг үнэхээр бишдэв. Тортог-буртаг тэр хүүгийн хамрын салст бүрхэвчийн дор нуугдсан ажээ.

Арван хоёрдугаар бүлэг

Тортог-буртаг зугтсаар байна

Тортог-буртаг, мань хүүгийн хамрын салст бүрхэвчийн дор нуугдав. Ингэнэ гэдэг үнэхээр зовлонтой ажээ. Хэзээ ч хэдийд ч цэвэрхэн явдаг хүүхдийн хотын нэгэн жаалд ийм аюул тохиолдоно гэж хэн мэдлээ.

Яаж ч чадахаа байсан Жаргал эмч болоод бусад хүүхдүүдийг элэглэн шоолох гэсэн мэт Тортог-буртаг тэр хүүгийн хамрын нүхээр гадагш бултайна. Түүний цухуйж байгааг харна гэдэг тун ч зэвүүн.

Тэр хүүг аав ээж нь Жаалхүү гэж нэрлэдэг юмсанж. Жаалхүүгийн зовлонтой явдалд сэтгэл зовсон Жаргал эмч шуухинаа гэдэг өвчнийг дарах эм өгөөд дийлээгүй учир эцэст нь бусад олон эмч нартай зөвлөж ийлдэс хэмээх нунтгийг өгөхөөр тогтов.

Гурилнаас ч нарийхан ширхэгтэй тэр эм, барагтай нян байтугай алив идтэн шидтэн албин чөтгөрийг ч болов үлдэн хөөхөөр тийм хатуу гашуун бөгөөд догшин зүйл байлаа. Тийм болохоор Тортог-буртаг эгээтэй л мажийсангүй. Бушуухан зугтаж, мөнөөхөн хэдэн өдөржингөө зовсон хүүхдийн хөл уруу шурган орлоо. Мэдээж хэрэг, Жаалхүүгийн хамар дороо зүв зүгээр болж, харин хумсны нь завсраар өргөс шаасан адил өвдөж гарлаа.

Тортог-буртаг хөлийн хумсны дотор нуугдаж чухам л одоо хэн ч олохгүй гэхдээ баяртайгаар инээд алдав. Үнэхээр Тортог-буртагийн мөр алга болжээ. Жаргал, Чагнаа хоёр айсандаа царай нь цайлаа. Мөр алдагджээ. Одоо Тортог-буртагийг хаанаас олох билээ. Тэгтэл ашгүй Жаалхүү өөрөө эрэлчдэд тус боллоо.

Сүүлийн долоо хоногт хумсаа аваагүй нь санагдсан тул эмч болоод найз нөхдөөсөө ичиж зоволгүйгээр үнэнээ хэлэхээр шийджээ, Магадгүй, зальг муу дээрэмчин Жаалхүүгийн сул талыг ашиглаж ч байж болох юм шүү. Тэгээд Жаалхүү гутлаа А тайлан эмчид хөлөө харуулав. Жаргал эмч түүний хөлийг сайтар / үзэж одоохон усанд оруулан цэвэрлэх гэж Жаалхүүг эмнэлэг рүүгээ дагуулан одлоо.

Энэ үед яг жин үд болж байлаа. Зуны халуун өдөр хүүхдүүд голын усанд шумбацгаана. Наранд шарж, элсэн дээгүүр гүйлдэн тоглоно. Тэдний хажуугаар явж байхдаа Жаргал эмч нэгэн сонин хүүхдийг олж харлаа. Үзвэл анх Мануухайг хот руу ирэхэд тааралдсан гурван жаалын нэг нь шавар дунд зогсоод голын наанги шороогоор бүх биеэ будаж байв.

-Хүүе чи яаж байгаа юм бэ? гэж Жаргал эмч дуу алдлаа. Тэгэхэд нөгөө хүүхэд огт нь тоохгүй царай гаргаснаа гэв гэнэт өнөөх шавраасаа авч Жаалхүү рүү шидэх нь тэр. Хүүгийн нүүр будагдаж бас хувцас нь муухай боллоо.

-Ай ямар муухай юм бэ? гэж хэлж дуусаагүй байтал, чухам нэг жинхэнэ нуугдах ёстой газар маань энэ жаалын толгой юм гэж бодсон бололтой Тортог-буртаг сэмээрхэн зугтан Цодоо хэмээх тэр жаалын толгой уруу хээв нэг орж явчихлаа.

Жаргал эмч түүнийг нь мэдсэнгүй. Хойноосоо яваа жаалуудад Цодоог сайн захиж орхиод юу ч гэсэн Жаалхүүг усанд оруулж тортог-буртагийг барья гэж эмнэлэг уруу одлоо.

Арван гуравдугаар бүлэг

Цодоогийн топгойд

Энэ үеэс эхлэн Цодоо сахилга журамд дургүй, ер нь өвчин зовлон тусахдаа амархан сул биетэй боллоо. Хэрэв хүүхдийн хотын бүх иргэдийн дотроос хамгийн муу сурлагатай хүүхдийг олъё гэвэл аль ч хорооллын жаалууд түүнийг л заамаар тийм хачин болжээ. Цодоо бас тэсвэр хатуужил муутай болж, үргэлж янз бүрийн өвчин тусаж хотын хүүхдийн гайхмаар явдал үйлдэж хичээл тасална.

Тортог-буртаг тийм хүүхдийн толгойд удаан нуугдаж чадна гэж бодлоо. Зөвхөн нуугдахаар ч барахгүй, өөрийнхөө ид Л шидээр сайн найзаа бүр нэг дийлдэшгүй болгож хувиргая гэж бодлоо. Ингээд Цодоо ямар ч хүүхдийн гаргахгүй ааш занг гаргах болов. Түүний ааш зан хувирч хотын бүх зан заншил, дүрэм журмын эсрэг бүхнийг Цодоо хийдэг боллоо.

Хичээл номоо таслах, хий дэмий тэнэх бол наад захын хэрэг. Тэр «Эвдэнэ нураана» гэх мэт Түн түн-пин пангийн яриаг сурч, цонх хагалахыг хамгийн дээд жаргал гэж үзэх болов. Бас их идэх юм уу, үргэлж унтах бол уг нь Хойрог-нойрогийн зан боловч Тортог-буртаг Цодоо найзынхаа толгойд шингээж өгчээ.

Цодоо хачин аймхай боллоо. Түүний айдаггүй юм гэж ер үгүй. Тэнэе гэж бодовч гэрээс тавхан алхам холдож эс чадна. Өглөөд донгодох тахиа, эсвэл усанд яваа завьчин хүүхдийн сэлүүрийн дуу цөм Цодоог дагжаан чичрээнэ.

Ийнхүү Цодоо дөрвөн дээрэмчний тус бүрийн балагтай занг сурчээ. Цодоогийн толгойд Тортог-буртаг нуугдсан нь ил боллоо. Бүх хүүхэд түүний төлөө сэтгэлээ зовоох болов. Одоо чухам яавал дээр вэ?

Удсангүй хотын гудамжнаа том зарлал гарлаа. Тэр зарлалд өгүүлсэн нь

«Хүүхдийн хотын хайртай иргэдийн нэг нь аюулд орлоо. Түүний толгойд ойн дээрэмчин, аюулт илбэчин Тортог-буртаг нуугджээ. Хайрт найз нөхрөө яаж аврах тухай удтал зөвлөлдсөний эцэст Жаргал эмчийн саналыг сайшаав. Энэ санал ёсоор хотын бүх хүүхэд өөрсдийнхөө сайн чанаруудаас эмчид авчирч өгөхийг хүснэ. Нэн даруйхан л бол сайн сан!» гэжээ.

Сайн нөхөртөө туслахгүй хэн байх вэ. Хүүхдүүд хотын эмнэлэг уруу цувж гарлаа.

-Би үргэлж онц сурдаг. Тэр бол миний мэриймжтэй зангийнх. Би түүнээсээ өгнө гэж нэг нь хэлэхэд нөгөө нь

-Би бол биеийн тамирын аварга. Би энэ алдар цолыг тун их Н тэсвэр хатуужилтайдаа авсан юм. Би түүнээсээ өгнө гэв. -Би цэвэрч нямбай зангаасаа өгнө гэж гурав дахь нь ярьж, -Би тэгвэл ажилсаг даруу зангаасаа өгнө гэж дөрөв дэх нь хэлнэ.

Нэгэн хүү чухам юугаа өгвөл дээр юм бэ? гэж бодож бодож хоёр ширхэг цаастай чихэр

авчирсан байлаа. Харин Жаалхүү элдэв чулуу цуглуулах дуртай тул, ойрмогхон уулнаас авчирсан ховор гантиг, утаат болрын хэлтэрхий барьжээ.

-Үүгээр чинь хүн яах юм бэ? Сайн чанар авчир! гэсэн болохоос биш... гэж нэг охиныг хэлэхээр нь Чагнаа:

-Чулуугаа ч өг. Чулуу цуглуулж төрөлх хотынхоо музейг гоё болгоё гэсэн сэтгэлээсээ өг! Тэр бүгд чинь Цодоод хэрэг болно гэжээ.

Жаргал эмч хүүхдүүдийн сайн сайн чанаруудыг нэгтгэн дэлхий дээр хаана ч гараагүй «Эв-1» гэдэг эм болголоо. Тэр эмээ Цодоод өгч тархи толгойноос нь Тортог-буртагийг хөөн зайлууллаа.

Тортог-буртаг хичнээн зүсээ хувилгавч түүнийг нууж чадах муу хүүхдийг хотоос олж чадсангүй. Тэгээд Жаргал эмч түүнийг барин авч шилдэг эм тан болоод сэтгэл засах эмчилгээнийхээ үрээр ид шидийг нь арилгав. Хүүхдийн хот тайван боллоо.

Төгсгөл

Газар дэлхийн хамгийн сайхан хүүхдийн хотод амар жимэр боллоо. Одоо бол энэ хотод Мануухайн оронд музей тайлбарлагч төмөр хүн л байна. Хүүхдүүд түүнийг тэгж хувилгажээ. Хойрог-нойрогийн оронд хөөрхнөөс хөөрхөн бамбарууш, Халхай-балхайн оронд гуталт муур гэдэг тоглоом байна. Хүүхдүүд түүнийг өөрийнхөө нөхөд болгожээ. Үлгэр бүхэн сайхнаар төгсдөг шүү дээ. Энэ бүх түүхийг төмөр Мануухай ярьж, Түн түн-пин пан, Тортог-буртаг нараас үлдсэн зүйл болох шидэт хайрцаг болоод Түн түн-пин пангийн төмөр хуягийг үзэгчид тайлбарлана.

Эцэст тийм гоё хот хаана байдаг юм бэ? гэж асуу л даа. Хэрэв тийм гоё хотод очъё гэвэл байна шүү... энэ үлгэрт гарсан сайн сайхан бүхнийг хийсэн цагт л тэнд очно. Тэгэхлээр манай үеийн бүх жаалууд хүүхдийн жаргалант хотод очих л гэж үлгэрийг үнэн болгож өнөө сурч, мөрөөдөж байгаа хэрэг үү дээ. Тэр хот бол ирээдүй гэсэнтэй яг адилхан үг юм.

1974 он

Өмнөх өгүүлэл

Болд гэж нэг сонин хүүхэд байдаг. Түүний дотны найз охин нь Цэцгээ юм.



Өнгөрсөн зуны амралтаар би Болд Цэцгээ хоёртой саалийн бригад дээр уулзаад олон дахин гуйж байж тэмдэглэлийг нь уншсан юм. Энэ тэмдэглэлд тэр нэгэн зуны явдлуудыг бичсэн юм билээ. Энэ түүхийн зарим хэсгээс ярья. Харин та нар Болд, Цэцгээ хоёрт талархлаа хүргээрэй. Учир нь хожим би өөрсдөөс нь зөвшөөрөл авсан юм шүү. За уншигч минь та бидний өмнө ногоон хавтастай гурван дэвтэр байна.

Эхэлье...

Цэцгээгийн тэмдэглэл

Өнөөдөр 6 дугаар сарын 3.

Гадаа суугаад тэмдэглэл хөтлөхөд мөн гоёо! Цэвэлмаа багш бидэнд хэлэхдээ, тэмдэглэл хөтлөх их сайн байдаг гэсэн, нээрээ хожим уншихад сонин байдаг байх шүү. Өнөөдөр, би өглөөнөөс аваад л дандаа баяртай байлаа. Цөмийг нь тэмдэглэе.

Өглөө

Цэвэлмаа багш биднийг ангид цуглуулаад зуны даалгавар өгөв. Тэгээд:

-Хүүхдүүд ээ! Хоёр сарын дараа бид ахиад уулзана, тэгэхэд хэн нэг нь даалгавар биелүүлээгүй байж нүүрээ улайлгав зай! Сайхан амраарай. Аав ээждээ сайн туслаарай! гээд:

-Зуныхаа даалгаврыг биелүүлээд, зун бүгдээрээ нэг нэг ажил хийчихсэн ирэхэд чинь багш нь яасан их баярлах бол оо... гэлээ.

Би амралт эхэлсэнд зөндөө баярлажээ. Багшийг захиас өгч байх хоорндуур сэмээрхэн хувьхандаа инээд алдаж, ингэж их баярласнаасаа зүггүй хөдөлж байв.

Тэгээд Болдыг шогломоор санагдаад явчихлаа.Өврөөсөө эгчийн нэхмэлийн зүүг гаргаж Чимэгээд: /

-Чимэг ээ! Би Болдыг сүүлтэй болгох уу? гэв. Тэр, миний урдаас гайхсан янзтай харснаа:

-Яаж? гэж асуув.

-Хар аа! гэж нэхмэлийнхээ зүүг үзүүлээд хэсэг цаас ширээн дотроос гаргав. Би сэмээрхэн Болдын бүсэнд хүрээд нэхмэлийнхээ зүүг хатгаж үзүүрт нь цаас сүлбэв. Энэ нь их инээдтэй зугаа байсан.

Нээрээ шүү! Болдыг хөдлөхийн тоолонгоор цаас нь шаржигнаж, Болд царай нь улайгаад гайхсан шинжтэй эргэн харна. Энэ үед би инээчих гээд амаа баривч болсонгүй, тэсэж ядаж байв. Чимэг ч бүр байхгүй л дээ, нүүр нь үрчийж, тэссэн хэр нь болохгүй хи хи хи гэнэ. Энэхэн үед аз болж багшийн яриа дуусав. Чимэгээ бид хоёр зөндөө инээлдлээ. Болдыг бас хүүхдүүд харж эрэгтэй жаалууд хүртэл ха, ха, ха инээлдээд,

-Хараач ээ Болдыг...

-Хо, хо, хо

-Сүүлтэй болчихож.

-Бөөн сүүлтэй морь шиг... гэлцэв.

Болд царай нь улаалзгана шиг туяараад, зовсноос өнөө зүүг суг татан авлаа. Тэгээд над уруу эгдүүцсэн янзтай харснаа: -Чинийх үү? гэв. -Минийх...

Тэр, хэсэг дуугүй зогссоноо зүүг эргүүлж тойруулж харйад

-Энэ зүүгээ надад өгөөч!

-Чи яах нь вэ? гэж би сонирхов.

-Хэрэг болно. Нээрээ шүү!... гээд Болд:

-Зүүгээ хаячихсан юм. Олдохгүй байна. Над өг л дөө гэж гуйв. Эгчийн өгсөн юм болохоор харамсалтай байсан боловч Болд сайн жаал болохоор би татгалзсангүй өглөө. Тэгээд ч биймар хэрэглэж байгаа биш. Болдод тэр зүү яагаад хэрэгтэй юм бол оо?

Энэ хооронд Болдын тухай тэмдэглэе. Өнгөрсөн намар тэр манай ангид шилжиж ирсэн. Томчуулын ярих нь бол, Болдын г аавын дүү нь энд, манай суманд байдаг аж. Тэгээд дүүтэйгээ нэг дор амьдрах гэж Баяндэлгэр сумнаас манай Эрдэнэ рүү ирсэн юм гэлцэнэ. Ээж нэг удаа надад тайлбарласан нь:

-Хүн настай болоод ирэхлээрээ ойрын садангаа мөрөөддөг л дөө. Тэр нь ч дээр байдаг. Ингэхлээр Шарав гуай дүүгээрээ хүндлүүлэх гэж нүүж ирж л дээ. Чи дүүгээ харах дургүй байдаг шүү. Хэрэв түүнийг хайхрамжгүй байвал хожим дүү чинь настай болоод чамайг хүндлэхгүй болчихож мэднэ шүү! гэсэн юм.

Энэ үгнээс хойш би их айдаг болсоон... Дүүгээрээ хожим өөрийгөө хүндлүүлэхийн тул өдөр болгон салхинд зугаалуулж тоглуулж эгчид тусалдаг болсон. Тэр битгий хэл, нэг удаа эгчийн байхгүйд дүүгээ би хуурайлж, тэгээд хичнээн их магтагдсан гэж санана. Эгч гэдэг маань суман дээр байдаг эгч шүү дээ.

Болдынх манайхаас одоо холгүй нутагладаг. Тэдний аав, ээжийг би нэг ч удаа хараагүй. Чимэг хэлэхдээ бол их сайхан зантай өвөө байна лээ гэсэн.

Өвдгөө хүрсэн сахалтай, дандаа инээсэн, хүүхдэд их хайртай, толгойг нь илж, үнсэж, их гоё юм ярьдаг тийм өвөө бол уу, тийм ч байх аа даа. Болд бид хоёр цуг явах боллоо. (Аав, Болдын морийг авчирсан юм).

Бид хоёр сумын баруун хажуу тойронгуут Баянголын уудам талбиун хөндийг өгслөө. Миний бор морь хэзээ хэзээгүй давхихад бэлэн, дороо тэсэж ядан дүүхэлзэнэ. Хурдны морь л доо. Болд саарал гүү унаж явав. Тэр нь далан дээрээ хөөрхөн загалтай, жороо удмынх юмсан. Гэлээ ч миний морийг уралдаанд гүйцэхгүй гэж би бодоод хорхой хүрч Болдыг өдөв.

-Болд оо!

-Аа.

-Хоёул уралдах уу?

-Тэгье гэж Болдын нүд үзтэл сэргээд ирлээ. Хоёул гийнгоолон мориндоо ташуур өгөв.

Болдын царай баяртай гялалзана. Лав түрүүлнэ гэж бодсон А байх аа. /

Хөдөө талын хөрс халцарсан замаар Болд бид хоёр урд хойноо орон уралдав. Гэвч миний морь хурдны морь болохоор Болдыг бараагүй хаяв. Зүрх толгойн орой дээгүүр намайг дахин гарч ирэхэд хойноос минь Болдын дуу хадаж:

-Цэцэг ээ, хүлээ... Цэцэг ээ!... гэх сонсогдлоо. Болдыгоо өрөвдөөд мориныхоо амыг арай ядан татаж даваан дээр хүлээв.

Тэр гүүгээ шавхачсаар гарч ирэхэд царай нь улайж халууцсан байлаа.

-Ямар хурдан эд вэ! гэж ямар нэг барааны тухай ярьж байгаа юм шиг «Эд» гэж нэрлээд Болд миний морийг магтав. -Сумын наадамд уядаг морь л доо гэж би гайхуулан: -Тав түрүүлсэн юм! гэж хоёр тоо илүү хэлэв. -Үгүй ер... гээд тэр: -Тэгвэл ч их эд юмаа! гэлээ.

Болд тийм зантай жаал л даа. Юмыг ярихаараа дандаа «Эд» гэдэг. Инээдтэй. Анх ирээд манай ангид сууж байхдаа Чимэгээд шоглуулчихаад:

(Шоглох ч гэж дээ. Чимэгээ дээлийн нь ар талд «5» гээд л шохойгоор биччихсэн юм).

-Яадаг эд вэ? гэсэн.

Үүнээс хойш ер нь юм болгонд шахам «Эд» гэдэг үг хэрэглэж явдгийг нь би мэднэ.

...Болд бид хоёр цааш явлаа. Манайх Цуурайтад, Болдынх Чулуутад юм. Өнөөдөр ямар сайхан өдөр байсан гэж санана. Тэнгэр маш сайхан цэлмэг байв. Баянголын ус энэ тэнгэр шиг л цэнхэрлээд, айлуудын дүрс усанд тусаад бүр их сонин харагдана. Хүүхдүүд эрэг дээгүүр гүйлдэнэ. Тэгэхдээ бүр жаахан хүүхдүүд байв. Тэгэхэд би чинь дөрөвдүгээр анги төгссөн томоо охин байхгүй юу. Болд надтай чацуу. Энэ жил арван хоёртой. Гэхдээ тэр чинь надаас хамаагүй өндөр өө! Лав Гаваа эгчийн нуруутай тэнцэх байх аа. Боровтор царайтай, хамар нь ч бас бор... Нүд нь харин хар, томоотой жаал л даа.

Би урьд нь үзээгүй юм шиг ингэж Болдыг сайн ажигласнаа өдрийн явдлыг асуумаар санагдав.

-Болд оо!

-Аа.

-Чи нэхмэлийн зүүгээр юу хийдэг юм бэ? -Хэрэг болох л доо... гэж Болд ихэмсэг дуугараад: -Сүүлд би чамд юу хийснээ үзүүлэмз. За юу? «Загасны дэгээ л биз гэж бодоод -За, за гэв.

Тэгээд бид хоёр салж, гэр гэр рүүгээ давхив. Болд:

-Манайхаар, очоорой. Цэцгээ! гээд давхисан юм.

...Ээж намайг хүлээгээд л гэрийнхээ гадна зогсож байлаа.

Тэгээд уян дээр намайг буунгуут, тэвэрч үнсээд бөөн баяр

болов.

Би ээжийдээ ямар их хайртай вэ! Хөөрхий, ээжий минь намайг дэргэдээ суулгаад нүд рүү минь эгц ширтэж духан дээр үнсээд:

-Миний охин ямар суралцав даа? гэв. "Дунд" гэж би сулхан дуугараад «Өө ижий ямар намайг зэмлэх юм биш» гэж бодоод

-Тэр нэг тоо нь болоогүй гэж тайлбарлав.

-Муу л байна даа. Уг нь чи их сайн сурах л ёстой хүн дээ охин минь. Муу л байна! гэлээ.

-5 дугаар ангид би заавал онц сурна гээд ээжийгээ тэвэрч

-Ээж ээ! Надад хайлмаг хийж тавьсан уу? гэж асуув.

6 дугаар сарыг 12.

Зөндөө олон хоног тэмдэглэл хөтөлсөнгүй.

Гадаа зүсрээ бороо шаагиж, хүйтэвтэр байна. Ийм бороонд нүцгэн гүйхэд соньхон байдаг. Чимэгээ бид хоёр бүр жаахан байхдаа ийм бороонд тэгж их гүйдэг байсан... Өчигдөр аав нэгдлийн төвөөс орой болсон хойно ирэв.

Аав ер нь дандаа ингэж оройттол явдаг юм л даа. Дарга болохоор их ажилтай байдаг юм байна. Өнгөрсөн жил аав дарга / байгаагүй. Зүгээр нэг данс хөтөлдөг л хүн байсан. Тэр ажил нь аавд их зохидог байсан байх аа даа. Аав өдөржин, оройжин шалны өрний дэргэд сууж нүдэндээ шил хийгээд хуучивгар (одоо хүртэл бий) сампинд тоо бодно.



Бодоод л байна. Бодоод л байна. Тэгж тэгж нэг л цагт бөөн баяр болон босож ирээд:

-Ай хө, Дулмаа, хоол халуун уу? гэдэг сэн. -Аав аа! Тооныхоо хариуг олсон уу? гэхэд минь - Олсон, олсон гээд намайг үнсэж:

-Аль вэ, миний охинд бас хоол хий! Аавтайгаа хамт сууж идэг! гэнэ.

Тэгээд л би аавтайгаа их юм ярьж хоолоо иддэг сэн. Хожим нь би тэр их сампинддаг тооны учрыг ойлгосон юм. Тэр нь тайлан гэдэг юм байж. Аав тэрүүгээр л өөрийнхөө бригадын ажил сардаа ямар байсныг гаргаж чаддаг юм байж. Үүнээс хойш би аавыгаа гайхамшигтай хүн гэж биширдэг болсон юм.

Одоо аав дарга... Нээрээ ийм Хэрсэнгийн даваа шиг өндөр нуруутай, өргөн цээжтэй, зөөлхөн мөртлөө цаанаа сургамжтай харцтай, юм ярихаараа комбинатын яндан шиг бүдүүнээр

дуугарч ярьдаг ийм хүн дарга болохоор их зохидог байх аа. Улсууд түүний үгнээс зөрж чадахгүй, над шиг битүүхэндээ г жаахан айдаг бол уу даа. Аав гадаа морио чөдөрлөж, эмээлээ барин орж ирээд ташуураа гозойлгон дээр нь эмээлээ тохож гэрийн хаяанд тавив.

-Яасан их оройтох юм, Буян минь! гээд ээж цог дээр жигнэсэн цай хоолоо өмнө нь тавив.

-Ажил гэдэг далай... гэснээ аав:

-Хөгийн юман дээрээс маргаад хурал сунжруулчихлаа. Энэ хорвоод мөн хачин юм их байх юм... гэж халбага авав. Би хэдийн орондоо орчихсон байсан тул 4 дүгээр ангийн том сурагч хүний ёсоор тавьтартайхан хэвтэж байв.

Сэмээрхэн яриаг чагналаа.

-Юу болов? гэж ээж их л сонирхсон янзтай асуусанд аав хоол амандаа үмхсэн мөртөө:

-Өнөөх... Шарав гуай... гээд зажилж:

-Хонь нэмж авья гээд... инээдтэй эр ээ.

-Эрүү өвдөгтөө тулсан байж гурван зуун хонь зуны улиралд маллана. Саалий нь саана. Сэтгэл зоволгүй, өгөөтөх, яахыгаа бид мэдэж байна гээд...

-Үгүй ер дөө, хэцүү өвгөн өө дөө гэж ээж яг л хурал дээр нь хэлж байгаа юм шиг хэлээд аавын хэдийн хоосолчихсон аяганд хоол хийв. (Ээжий дандаа ингэж аавыг хооллох үед нь дэргэд нь ирж суудаг юм. Нээрээ, түүнд их хайртай байх аа. Надаас илүү ч хайртай юмуу бүү мэд).

-Маргаж, маргаж, сүүлд нь яах вэ дээ нэмж өглөө. Улсуудын гайхсан гэж... Өвгөн хэлэх нь:

-Хүү сургуулиа тараад ирсэн, одоо болно. Хүү минь бидэнд тусална. Хамаг ажлыг минь хийдэг хүн л гэх юм.

Тэгтэл хүү ч яах вэ, хүү л байж. Тэр чинь хонь хариулаад явж чадна. Ишиг хурга хариулж чадна. Саалийн талаар ямар юманд нь тус болох вэ дээ. Эмгэн нь тавь гарсан хүн бий. Олон хонь саана гэдэг чинь тийм амар юм биш биз дээ. Гэтэл зүтгээд болдоггүй. Эцэст нь нэгдлийн дарга Доной гуай: /

-Бригадынх нь дарга юу гэх нь вэ, үгийг нь сонсьё гэв. Би яах вэ дээ, хэсэг бодлоо. Тэгээд эцэст нь:

-Шарав гуай өөрөө өөртөө итгэснээс л ингэж байгаа биз. Хонь нэмж өгье л дээ. Юу нь буруу байх вэ? Үнэхээр дийлэмгүй бол буцаагаад л авна биз... Эсвэл хүн хүчний туслалцаа үзүүлдэг ч юмуу?... гэв. Дарга инээмсэглэж толгойгоо дохиод:

-За асуудал дууслаа. Буянгийн хэлснээр болог... гэсэн. Хүмүүс тарж, хоорондоо бас л маргав. Би Шарав гуайнд очоод хонь хүлээлцэж өгөөд оройтчихлоо. Жаал хүү нь ер нь ажилд сайн

бололтой шүү. Айхгар тархи юм даа. Онц сурдаг гэнэ шүү дээ. Хэцүү эр ээ гэв.

Энэ яриа над их сонин байлаа. Болдын аав зоригтой хүн юм даа.

Ийм зоригтой хүн чинь юуг ч дийлнэ дээ. Багш нэг удаа надад хэлэхдээ,

-Зоригтой бол юуг ч дийлнэ шүү. Зориг байвал бүхнийг ялна.

Тоо бодохдоо л чи зоригтой бодож бай. Юм сурахаасаа айдаг, шантардаг хүн бол зориг муутай, муу хүн гэсэн. Үүнээс хойш би үнэхээр тоонд зоригтой болсон боловч гэм нь одоо болтол дундаас дээш дүн аваагүй л яваа юм. Болд бас зоригтой байх аа. Хэрэв зориггүй бол онц сурахгүй л дээ. Нээрээ тийм! Яаж нэг мундаг зоригтой больё доо. Тэгвэл чинь тоонд онц гараад л, хүн болгон намайг магтаад л... Орой болтол би юм бодож хэвглээ.

Бороо одоо болтол шаагисаар л... Норсон дээврийг борооны дуслууд балбаж, намайг нэгэн жигдийн авиагаараа бүүвэйлэв. Аав лаа барьж ахиад л данс мансаа дэлгэлээ.

Хөөрхий аав минь унтаж амраасай даа. Бороо, бороо... нэгэн жигдийн авиагаар намайг бүүвэйлнэ. Миний нүдний өмнүүр сонин сонин бодлууд урсаж байгаад нэг мэдэхэд би таг унтаж орхижээ.

Өнөө өглөө би ээжээсээ гуйж Болдынд очих зөвшөөрөл авлаа. Амралт эхлээд зөндөө удчихсан байхад би өдөр туж г гэртээ л байдаг байв. Ядахдаа манай хотод үерхээд тогломоор хүүхдүүд байхгүй л дээ. Ганцаараа байхаар өөрийн эрхгүй уйдах юм. Яг багшийн хэлсэн шиг. Багш минь биднийг нэг удаа цуглуулж, сонин юм ярьсан, тэр нь нөхдөөсөө тасарч ганцаардсан хүний тухай байсан. Тэр нь тэгээд хүнтэй нийлэхгүй гэж шийдээд холоо ойд очиж амьдардаг юм. Өдөр ирэх тутам хүн амьтантай уулзах юмсан гэж бодогдоод л хөөрхий амьтан их зовноо. Тэгээд сүүлдээ ганцаараа амьдарч чадахгүй болоод танил нөхдийндөө очдог. Багш энэ зохиолыг яриад:

-Хүн чинь их нийгэмч амьтан юм шүү. Хүнтэй нийлэхгүй ганцаараа явж чадахгүй гэсэн юм. Нээрээ би түүн шиг хамт тоглох нөхөд байхгүй байвал уйтгартай байна л даа. Тэгээд би Болдтой уулзахаар явлаа.

Намайг очиход яг үдийн хонь хотолж байв. Тэгээд даваан дээрээс харахад хашаатай хонь, ёстой л нэг ээжийн гэээгний сувдан даруулга шиг соньхон харагдаж байв. Намайг уян дээр морио уяхад Болд баярлачихсан гүйж ирлээ.

-Сайн уу? гээд тэр

-Еэ, яасан сайн юм бэ! Цэцгээ би чамайг ирэх байх гэж бүр эртнээс харсан юм... гэж гарыг атгав.

-Манайх энэ... гэж, Болд олон гэрүүдийн хамгийн баруун талын гэрийг заагаад:

-Ээжий хотон дотор байгаа. Би ч бас гарах ёстой юмсан. Чи намайг хүлээнэ биз дээ. Би удахгүй. Тэгээд хоёулаа зөндөө юм ярина. Хотод байдаг ах надад их сонин зурагтай ном

явуулсан. Чи үзээд хүлээж байгаарай гэнэ.

Бид хоёр гэрт орлоо. Тэднийх чинь тохилог айл юм л даа. Хоёр том жаазтай. Гоё ортой, эргүүлэг нь шинэхэн, авдар нь бас тийм хуучин биш. Намайг оронгуут Болдын аав намайг үнсэв. Сайхан зантай боровгор царайтай, намхавтар нуруутай тийм өвөө байлаа.

-Охин минь суу! гээд

-Болд оо найздаа цай өг. Авдранд чихэр бий, гарга... Эсвэл / охин минь чи тараг ууна уу?

-Зүгээр ээ өвөө! гэж нэрэлхүүдүү хэлэв.

Болд гадагш гарах гэж их л яарч байгаа бололтой. Авдарнаас чихэр гаргаж таваглаад, номынхоо савнаас нэг ном гаргаад надад сарвайж, эргүүлэгний тэндээс төмөр бүслүүртэй хөөрхөн жижиг хувин авснаа сүү болсон хормогч бүслээд гарч одов.

Яах нь юм бол? гэж би гайхаад

-Чи хаачих нь вэ гэж хойноос нь асуухад өвөө, Болдын өмнөөс:

-Саалинд гарч байгаа юм. Ээжтэйгээ элбэж энэ олон хонийг чинь саадаг юм шүү дээ гэв. Би бүр гайхаж орхилоо. Үгүй мөн сонин оо доо. Эрэгтэй хүн сааль саана гэж үү? Болд чинь өөрөө том болоод би жолооч болно гэдэг мөртлөө одоо саальчин байх гэж үү. Яаж чаддаг юм бол оо гэх зэрэг олон бодолд би ороод нэг үе гайхах, нэг үе ичих хослов.

-Гайхаж байна уу? гээд өвөө:

-Ээжийгээ дагаад энэ ажлыг сурчихсан юм. Муу нь юу вэ. Хүн чинь ажил хийж сурах хэрэгтэй биз дээ. Чи ч гэсэн сааль саадаг байлгүй гэв. Үнэндээ энэ үгийг сонсох надад ичгэвтэр байсныг нуугаад яахав. Өвөөгийн урдаас би харж ч чадахгүй, нөгөөх Болдын өгсөн номыг уншиж ч чадахгүй суув.

Нүүрэн дээр цог тавих адил өвөөгийн үг намайг сандаргав. Тэгэлгүй ч яах вэ. Болд саальчин болоод өдий олон хонь саалцаж байхад би нэг удаа ч гэсэн хувин авч хонь сааж үзэх гэж оролдсонгүй. Мөн ичгэвтэр ээ дээ. Эмэгтэй хүн байж, эрэгтэй хүнээс дор...

Би сэмээрхэн гарч хонины хот руу очив. Нүдээрээ үзэж итгэх л хэрэгтэй санж. Гэвч өвөө худлаа хэлсэнгүй. Болд тарж хэвтсэн хонины захад хундан хонь саагаад сууж байв.

Сууж байгаа нь эвлэг аятайхан гэдэг нь. Дараа нь тэр, харлаг хонь, тэгээд эвэртэй халзан хонь саав. Тэр бүгдэд маш түргэн дадмаг хөдөлнө. Өнөөх хонь нэмж авсан учир нь үүндээ байж.... Хамаг юм одоо тодорхой боллоо. Энд ингэж зогсоод байх надад г дэндүү ичгэвтэр байсан болохоор би гэр рүү гэлдрэв.

-Цэцэг ээ! гэж Болд намайг харангуут дуудаад:

-Чи саах уу? Тэгвэл май!... Энэ хувин! гэж дүүрэн сүүтэй хувин над уруу зангав.

-Үгүй, үгүй гэж сандран толгой сэгсрээд:

-Дараа... гэж нэрэлхэв.

Үнэндээ л надад энэ үгийг сонсох ч, Болдын нүүрийг харах ч эрх алга. Над шиг муу охин ч байдаггүй байх аа даа. Би ёстой л эрхлэхээс өөр юм мэддэггүй амьтан юм байж... Өдөр туж идэж, тоглож, ээжий аавдаа ямар ч тус байхгүй, ердөө хэнд ч хэрэггүй хүн юм байж... Өөрийнхөө урагшгүйг бодохоос уйлмаар санагдана. Ингэж бодохлоороо л хүн болгон намайг хараад байх шиг, энэ охин чинь одоо юу ч мэдэхгүй амьтан... эрх юм..., тэгээд сургуульдаа хүртэл олигтой сурч чаддаггүй юм шүү дээ гээд байх шиг, зарим нь хуруугаараа гэрийн цаанаас нөгөөдөө заагаад инээлдээд байх шиг надад санагдаад болдоггүй л дээ. Нүүр хийх газар үл олдоно. Тэгээд би тэсэж байж чадсангүй мориндоо мордон гэрийнхээ зүг одов оо.

Болд лав надад гомдсон байх даа. Даваан дээр гараад эргэж харахад минь Болд миний хойноос удтал хараад зогсож байснаа урам муутай нь аргагүй гэрийнхээ зүг гэлдэрч яваа харагдлаа...

Өчигдрийн тэмдэглэлийн үргэлжлэл

6 дугаар сарын 17.

Болдынхоос би морины хурдаар ирлээ. Ээж лав гайхсан байх даа. Би мориноосоо үсрэн бууж уяаад энэ бүх явдалд ээж л буруутай юм шиг гэртээ оронгуут үг дуугүй уйлав. Хөөрхий ээж минь бүр сандарчээ.. Надад их хайртай болоод ялиггүй юм л болоход ээж минь арга нь барагдаж суудаг юм л даа. Орон дээрээ түрүүлгээ харан хэвтээд намайг ухаан дүрсгүй орилоход ээж хажууд минь ирж духыг минь дарж үзээд: /

-Охин минь яав? Юу болов хэлээч дээ... За ээждээ хэл... өвдөө юү? гэж асуув.

Гэвч би дэндүү адгуу, зөрүүд зантай болохоор улам чанга уйлав. Ээж намайг аргадаж ядаад хажууд минь уйлчих шахан зогслоо. Эцэст нь би ээжийнхээ зовиуртай царайг харж өрөвдөөд хүзүүг нь тэвэрч тайвшрав. Ээж миний томоогүй охин яасан юм бол доо гэсэн мэт над уруу гайхан харсаар л сууж тайтгаруулах зөөлөн үг хэлсээр л байлаа. Эцэст нь удаан дуугүй юм бодож сууснаа:

-Ээж ээ! Та хэдийд хонь сааж сурсан юм бэ? гэж асуулаа. Ээж миний энэ хэлсэн асуултад гайхсан байлгүй дээ, юм бодож хэсэг сууснаа

-Яах нь вэ, миний охин?...

-Хэл л дээ? гэж би шалав.

-Бүүр жаахнаасаа... гээд ээж миний бүснээс доохнуур хэрийн газар гараараа зааж:

-Ийм жаахнаасаа... Ээж минь сүрхий хүн байсан юм. Ажилд их сайн, хүүхдүүдээ зүгээр суулгаж эрхлүүлэхийг боддоггүй, ямагт ямар нэг ажилд сургаж, өөрөө бүх л өдөр хөдөлчихдөгсөн. Ээжий маань надаар... одоо, наймтайгаас эхлээд хонь мал саалгаж, чиний насан дээр би дээл оёчихдог болсон байсан гэж ээж хуучилж өөрийгөө л дурсан санаж байгаа мэт намуухан дуугаар ярилаа.

-Намайг тэгвэл, яагаад ийм жаахнаас эхлээд ажилд сургаагүй юм бэ? гэж би асуув.

Ээж миний үгийг зөвшөөрч баярлан духыг минь үнсээд нулимс унаган:

-Үр минь, охин минь. Миний охин ямар ухаантай сайн хүүхэд вэ гээд тэврэв.

6 дугаар сарын 18.

Ээжий намайг ажилд сургах боллоо. Хөөрхий ээжий минь намайг ажил сурч чадах болов уу даа гэсэн мэт харж санаа алдав. Дараа нь модон хувин авч өгөөд:

-За ажлаа эхэл дээ! Харж байя. Тэр бор халзан хонийг саа гэж заасан юм. Оройн саам байлаа. Би тэр хонийг бариад г дэлэнгээс нь атгаж, өрөөсөн гараараа саав.

Ямар том хөхтэй хонь байсан гэж бодноо. Үнээнийх шиг том мөртлөө жигтэйхэн их чинэрчихсэн тийм хөхтэй юм. Ээжий хонь саах завсраа намайг эргэж харна.

Би хөхий нь дийлэхгүй хичнээн удаан суусан гэж бодно. Тэр хонь яргуй их идсэн байх аа. Энэ жил яргуй их гарсан юм. Замаар давхихад энгэр дүүрэн цэнхэрлэж салхинд найган тааламжтай гоё үнэр ханхалж байсан. Хонь, тэр уруу явсан юм болов уу? гэж би бодов.

-Дийлэхгүй байна уу? гэж гэнэт хажууд ээж дуугараад

-Олигтойхон хөдлөөч. Хоёрын хооронд илээд байхаар ямар хэрэг байх вэ гэж аашлав.

-Дийлэхгүй байхад... гэж хоолой минь зангираад үг ч хэлж чадсангүй. Арай гэж саасан болоод босож ирсэн чинь сүүгээр дүүрэн хоргол болчихсон байв.

Ээж хараад элгээ хөштөл хөхрөхөд би бор халзан хонинд уур хүрч байлаа. Дараа нь би нэг төлөг саалаа. Түрүүний хонийг ээж бариад дэлэнг үзээд тавихдаа:

-Болж, сайн байна гэж намайг магтсанд сэтгэл сэргээд ирлээ.

Би саальчин болно. Болдоос дээр, хамаагүй мундаг саальчин болно гэж бодогдон, «Эмэгтэй юм болохоор шал ондоо байна. Цэцгээг хараач дээ, мундаг саальчин шүү дээ» гэж хэн нэг нь магтана даа гэж яг л тэгж байгаа юм шиг баярлав. Төлгийг сааж байхад тэр тонгочоод саалгахгүй байснаа ганцхан урагш ухасхийхдээ хойд хөлөө хувинд дүрж сүүгий минь асгуулав. Хувинд зөндөө сүү байсан юм. Тэгээд төлөг зугтаан талийж өгөхөд би хувингаа шүүрэн авсан боловч юу ч үлдсэнгүй. Сүү бууцанд дорхноо л шингэж нойтон толбо үлдлээ. Саасан хамаг сүүгээ асгуулсандаа би гомдон уйлахад минь хонины хашааны тэртээ буланд сууж байсан ээж гүйн хүрч ирээд сүү асгасныг үзэж:



-Еэ харлаа, за яах вэ битгий уйл, сүү л хайран гээд сүүг хуруугаар дүрж духандаа түрхэв. Тэгээд:

-За өнөөдөр болно. Гар гар гэж намайг хашааны хаалга руу түлхэв. Би гэртээ орж ирээд хүйтэн юм ууж зөндөө юм бодлоо.

Би ер нь муу хүн юмаа даа. Нээрээ би бүр хүүхдүүдийн хамгийн муу урагшгүй хүүхэд юм. Аав, яагаад намайг муу гэдэггүй юм бэ? Аав муу хүнд их дургүй хүн шүү дээ. Нэг удаа нэг муу хүнийг аав, аймаар загнаж байсныг би мэднэ. Би хараад их айсан юм. Тэр хүн архи

уугаад ажлаа хийгээгүй юм байх л даа. Үүний төлөө аав зөндөө их загнаж явуулсан мөртлөө сүүлд нь хөөрхий амьтан гэж өрөвдөж байсан юм. Ер нь аав муу хүнд дургүй л дээ. Аав нээрээ намайг мэдээгүй байх аа. Тэрнээс биш аймаар чангаар загнавал яана!...

Болд яагаад ямар ч ажилд сайн байдаг юм бэ? гэх зэрэг олон бодолд би ороод,

-Ямар ч байсан би саальчин болно доо. Харж л байгаарай, үзүүлнэ. Тэр төлгийг би маргааш заавал барьж саана даа гэж бодов.

6 дугаар сарыг 26.

Өдөр ахих тутам би өөрийнхөө урагшгүйг мэдлээ. Би ерөөсөө саальчин болж чадахгүй юм байна. Саальчин болоход чинь их олон юм мэдэх, хийх хэрэгтэй юмсанж. Ээж шиг өглөөнөөс аваад л орой болтол туж хөдлөөд л байвал болох юм. Тэгтэл г тоглох зав гарахгүй бол яах юм бэ?

Хэдэн өдөр өнгөрлөө. Би саальчин болох гэж хэдэн удаа оройн саалиар ээжийтэй хамт хувин авч гарсан боловч үгүй бол сүүгээ асгачихна, үгүй бол ядраад, залхуу хүрээд гар өвдөөд больчихдог байв. Тэгээд би энэ ажлаасаа дорхноо уйдлаа. Эцэст нь би Болдтой уулзмаар бодогдов. Ээжээсээ ахиад л зөвшөөрөл авч Болдынх уруу явлаа. Намайг очиход Болд хониныхоо хотон дотор бууц цэвэрлэж байв. Тэр хотынхоо олон жаахан хүүхдүүд дунд дарга шиг л аашилж овоолсон бууцыг адсаган дээр ачин дараа нь чирч жалга уруу асгаж байв. Нэг л их шуугиан сонсдоно. Болд намайг хараад яг хуучнаараа угтаад гүйж ирлээ.

-Сайн уу, Цэцэг ээ? гээд гарыг минь атгаж:

-Эртээр чи яагаад явчихсан бэ? Над гомдоогүй биз дээ? Нэг л харсан чинь даваа давж явсан. Ямар түргэн явсан бэ? гэж олон асуулт тавив.

-Гэрт ажилтай байснаа гэнэт санаад... гэж би худлаа хэлээд,

-Тэнд юу болж байгаа нь энэ вэ? гэж гол төлөв богино өмдтэй олон жаалууд уруу заав.

-Сайн дурынхан!... гэж тэр бахадсан байртай ихэмсгээр дуугараад:

-Хотоо цэвэрлэж байна. Энэ хотыг чинь цэвэрлэхгүй бол хонь түлэгдсэн боорцог шиг хар болчихно шүү дээ гэв. -Ах аа! Болд ах аа! гэж тэд дуудна.

-Наадхаа битгий замд нь савируулаад байгаач! гэж Болд бууц ачсан адсаганы урт оосроос зүтгэж байгаа олон хүүхдэд зааварлана.

Болд бид хоёр гэрт орж сайхан зантай өвөө бас түүнээс ч сайхан зантай, жижиг биетэй, Болдын ижийд үнсүүлэв. Тэд намайг нэг л том зочин шиг дайлж гарлаа. Орсон даруй л өмнө минь цай аягалж, ширээн дээр боов чихэр өрлөө. Болд надад уншсан номоо үзүүлнэ. Тэр ирснээсээ хойш юу хийснээ ярьж:

-Чи манайхаар ирж бай. Манай энд чинь их аятайхан байдаг.

Хүүхдүүд олонтой. Суман дээр манай ангийнхан дайралдаж байна лээ. Би эртээр сум ороод ирсэн. Цэвэлмаа багштайгаа уулзсан гэж ярив. Би Улаанбаатар руу явна гэж хэлэв.

-Хэзээ? гэж Болд айсан мэт над уруу нүдээ бүлтийлгээд:

-Бүрмөсөн үү? гэж асуув.

-Яалаа гэж дээ гэж би инээд алдаад:

-Ахындаа айлчилна. Ах маань намайг ирээсэй гэж их хүсдэг юм л даа гэв. Ер нь ч би ингэж шийдсэн юм. Хонь сааж чадахгүй юм, яршиг. Би саальчин болохоо болихоор шийдэв гэв,

Болд бид хоёр тэднийд хэсэг суугаад гадагш гарч бууц зөөж байсан хүүхдүүд дээр очлоо. Гэнэт ингэж явснаа Болд нэг юм санасан мэт.

-Хүүе, Цэцгээ чи нэг сонин юм үзэх үү? Сонин ч гэж дээ! Яагаав дээ өнөө зүү... Чи надад нэхмэлийнхээ зүүг өгсөн шүү дээ.

Тэр зүүгээр чинь би юм хийсэн юм, Нээрээ үзэх үү? -Тэгье гэж би дуртай зөвшөөрөв.

Үнэндээ мань эрийг загасны дэгээ л хийсэн байх гэж бодсон юм. Гэтэл ямар догь юм байсан гэж бодноо. Би хоёр дахь удаагаа ичиж нүүрээ халаах минь энэ! Болд намайг хөтлөн гэртээ оруулаад,

-Чи битгий шоолоорой, за юу! Би зүгээр туршиж үзсэн юм гээд шүүгээгээ уудалж, нэгэн цагаан утсан тор гаргав. Энэ нь Болдын нэхсэн орны өмнүүр унжуулдаг тор байсан юм. Би түүнийг гайхан хараад авч үзсэнээ:

-Нээрээ чи өөрөө нэхсэн юм уу? гэхэд Болд толгой дохиод:

-Зүгээр би оролдож л үзсэн юм гэлээ.

Өнөө болтол би тор нэхэж үзээгүй байсан болоод тэр ажлыг Болд эхлээд хийчихсэн байсанд хачин санагдав. Тэгээд би

Болдыг ер нь эрэгтэй юм уу, эмэгтэй юм уу гэж гайхахад хүрлээ. Миний гайхсан царайг тааварласан байдалтай Болдын ээж над гуруу хараад,

-Охин минь манай Болд дэндүү их саваагүй хүн шүү. Саваагүй ч гэж бас болохгүй л дээ. Энэ чинь муу юм биш, юм болгоныг оролдож, сургах гэж явдаг сайн хүү байгаа юм... гэв.

-Над чи сүүлд өөрийнхөө хийсэн торыг үзүүлээрэй. Хоёулаа хоёр гэртээ дандаа айлчилж бие биедээ тусалж байя. Тэгэх үү? гэж Болд намайг гаргаж өгөхдөө хэлэхэд нь би түүний гарыг атгаад:

-Тэгье, тэгье! гэж хэлсэн боловч үнэндээ шал өөр юм бодож намайг олон дахин зовоосон энэ Болдын хичээмтгий, ажилч занг бахархах өөрийгөө зэмлэх голох сэтгэл төрж байв. Яаж ч

зүтгээд би Болд шиг жаал болж чадахгүй байх даа. Тэгэхлээр мэрийгээд хэрэггүй шүү дээ.

Өнөөдөр яасан сайхан өдөр вэ! Мориор давхихад салхи өмнөөс үлээж нялх ногооны үнэр ханхална. Өнөөдөр машин ирэх ёстой. Тэр машин намайг хот уруу авч явна. Болд үлдсэн. Лав намайг гайхсан байх аа. Олон ааштай юм гэж бодсон бол уу.

Надад түүн шиг сайн хүүхэд болох чадал алга л даа. Болд минь баяртай! Сайн сууж байгаарай! Хотоос ирээд чамд сонин юм ярина.

Болдын тэмдэглэл

6 дугаар сарын 29

Ямар догь вэ! Өнөөдөр манай «сайн дурынхан» бас нэг догь ажил хийлээ. Энэ ажлыг бригадын дарга Буян гуай хүртэл үзээд сайшаасныг яах вэ. Лав Цэцгээд хожим хэлнэ дээ. Энэ нь чулуун гортиг байв. Сургуульд хүртэл ийм гортиг байдаг. Сумын дарга нэг ирээд явахдаа хаалгаар нь гарч байсан удаа бий юм. Энэ ч их догь ажил даа. Манай «сайн дурынхан» ер нь сүрхий жаалууд шүү, ямар гэж бодно «Сайн дурынхан» гэдэг маань манай хотын жаахан хүүхдүүд юм. Энэ ажлыг хийчихээд, цөмий нь жагсаав. / За хэн хэн байна даа харья.

Би ер нь тэднийг дандаа ингэж жагсаадаг зантай. Цэвэлмаа багш хэлэхдээ ямар ч ажилд дэглэм журам хэрэгтэй гэдэг. Тэгээд ч эд нар чинь сургуульд ороод хүүхдийн баяраар заавал жагсана шүү дээ. Тэгэхдээ хөлөө олохгүй байвал муухай л даа. Эртнээс сурч л байг! Хамгийн эхэнд Дондог зогсоно. Цэрэн гуайн жаал л даа. Инээдтэй хөгийн эр ээ. Нүүрээ утаахдаа их дургүй. Одоо хүртэл богино цамц нь урагдаад, тэр цоорхойгоор нь халтар ходоо нь цухуйна. Сөөсгөр үстэй, нүцгэн хөлтэй. Хөлс нь гоожсон ув улаан царайтай амьтан юм. Харин магтууштай нь ажилд их сайн. Сэтгэл нь нэг хөдлөхөөрөө ердөө л оодгоносон тугал шиг болдог тул «усыг» нь жаахан халаахгүй байхыг бодох хэрэгтэй юм. Тэр нэг хөл дээрээ нөгөө хөлөө тавиад ха, ха, ха гэж хэзээ хэзээгүй инээхэд бэлэн зогсчээ. Дараа нь Даваа, их ууртай, үнэхээр нямбай жаал. Тэгээд бусад нь хамгийн бага Дарь, Бар, Бор гурав зогсоно. Сайн хүүхдүүд байгаа юм.

Биднийг шуугилдсаар бууцны ажилд ороход ямар шүү инээдтэй явдал болдог гэж бодно. Зарим нь хүрз аваад «машин» дээр (машин гэж манай хөх адсага л даа) ачиж эхлэхэд зарим нэг зүггүй нь адсага дээр гарч тонгочно. Тэгээд л бөөн хашгиралдаан болно. Гэвч цагийн дараа харахад хот цэв цэвэр.

Тэр үеэр хүүхдүүд цөм гэр гэртээ өмнөө тараг тавиад сууж байна. Заримдаа бас нийлж цуг уухыг яах вэ.

Би тэдэнд эртээр дуу заав. Энэ ч гоё юм болох байсан юм. Ажил тарахдаа би

-Дуу заана! гээд

-Та нар үдийн хонь хотолсны дараа яг энд цуглаарай! гэж хонины хашааны өмнөх зүлгийг заалаа.

-Тэгье, тэгье гэж тэд баярлан дэвхцэцгээв. Яг энэ ёсоор л цугларлаа. Би тэдэнд дуу заах гэж хоолойгоо засаад:

-За сонсож бай! гээд

«Маамуу нааш ир /

Манайд хоёулаа тоглоё

Аав ээж хоёрын

Авчирсан тоглоом бий шүү...»

Тэд олон янзын хоолойгоор өргөн авлаа. Дуулж байгааг нь харахад бүр их сонин. Зарим нь наранд нүд нь гялбаад тас аньчихсан аялна. Зарим нь хаа тэртээ хол тийш ширтэн юм харна. Гурав дахь нь хуруугаараа оролдож нөгөөгөө элэглэнэ. Хэд дахин дуулсны дараа би өөрөө тэднээр дуулуулаад чагнасанд нэг нь:

«Маамаа, маамаа» гэж байхад нөгөө нь: «Мөөмөө, мөөнөө», гэж гурав дахь нь бүр шал ондоо: «Би тоглоом тоглоно доо на, на, на!» гэнэ.

Энэ удаад над ямар ч урам байхгүй байсан тул тэднийг тарцгаа! гэсэнд тэд шуугилдан тал тал тийш гүйлдлээ. Би гэр рүүгээ урам муутай алхав. Цэцгээ надад нэг л юманд гомдоод байх шиг. Би яачихсан юм бол оо?!

Яагаад ч юм бэ, Цэцгээтэй уулзаад яриад суумаар санагдах юм. Тэр цовоо сайн охин доо. Одоо өдийд Цэцгээ Улаанбаатар хотод алхаж яваа. Тэнд наадам болох гээд л өдий төдий хүүхдүүд ийш тийшээ гүйлдээд. гимнастикийнхан голын цэнгэлдэхийн тэнд цэцэг болон сургуулилж байгаа даа. Хурдан мориныхон сэтгэл нь хөдөлсөн урамтай сайхан яваа болов уу. Нээрээ тийм байдаг,

Гадаа суугаад тэмдэглэл хөтлөхөд их аятайхан юмаа. Салхи сэвэлзээд, тэртээ энгэрт хонь майлалдах нь хөгжим шиг. Гэнэт миний сэтгэл аягүй их хөдөллөө. Ерөөсөө юм болгоныг л сурах юмсан. Нээрээ шүү, хүн л юу хийж чаддаг байна цөмийг...

Машин барьж, улайрч байгаа тэнгэрийн тэртээ холын хаяа хүрэх юмсан. Бас онгоцны жолооч болохсон. Эсвэл тун сүрхий адуучин болохсон. Ээ нээрээ, манай ангийн хүүхдүүд маргааш эмнэг сургана гэсэн шүү дээ. Очье байз. Эмнэг сургах ямар догь байдаг гэж бодно. Ёстой сайхан. /

Тэмдэглэлийнхээ дэвтрийг би хумхив. Морио авчирч аргамжаад үдийн саамнаас өмнө эмнэг сургагчид дээр очихоор шийдэв.

6 дугаар сарын 30.

Уг нь энэ явдал аятайхнаар эхэлсэн юм. Намайг цавьдар морио ташуурдсаар Тосонгийн аманд очиход адуучид адуугаа хураачихаад Балдан Дугар нар ирчихсэн байлаа.

-Сайн байцгаана уу? гээд би тэдэнтэйгээ уулзсандаа баярлаж

-Эмнэг сургах нь уу? гэж асуув.

-Харж байгаа биз дээ, яах гэж ирсэн байна? гэж Балдан хялалзаад:

-Чи харах гэж ирэв үү? гэж асуув.

-Юуны чинь харах! Би бас эмнэг булгиулна гэсэнд Балдан, Дугар уруу харж намайг заан хөхрөөд

-Хараач дээ, энэнийг... эмэгтэй жаал байж бас эмнэг сургах юм гэнэ шүү. Тэнэг... гэв.

Миний уур хүрлээ. Яагаад би эмэгтэй байдаг билээ гэж Балдан уруу давшилсанд тэр:

-Чам шиг, ямаа сааж, тор нэхэж суудаг эрэгтэй жаал байна уу даа, үгүй юу? гэсэнд Дугар;

-Боль, Балдаан гэж хориглов.

Би учиргүй их гомдлоо. Би тусгүй юм юу хийсэн юм. Миний ажил чинь тэгж хүн хийдэггүй ажил юм уу. Хачин юм даа. Улсууд намайг магтдаг байхад Балдан харин эмэгтэй хүн гэж элэглэнэ гэнээ. Тэр өөрөө тэгээд юу хийсэн юм бэ?

-Еэ муу эмэгтэй жаал!

Би чамайг яах ч үгүй л дээ. Эмэгтэй хүнд гэм хор хүргэх муухай. Эндээс харин яв яв. Битгий эмнэг уна. Чамд өгөх ч үгүй, чадах ч биш гээд Балдан хазаар барьж адуучид уруу явлаа.

Энэ бүх үгэнд би гомдсон боловч адуучдын дэргэд очив. Балдан нэг эмнэг дээр мордоод тэр нь цовхчин булгиж мань эр г инээмсэглэнэ. Үнэндээ ч надад Балдан шиг тэсэх тэсвэр бага болохоо мэдсэн юм. Гэвч тэгж булгиулахыг маш их хүсэж байв. Дугарыг нэг эмнэг дээр мордон тал тийш тонгочуулж одсоны дараагаар, би Сүрэн гуайд очоод

-Надад нэг морь өгөөч, би булгиулж үзье! гэж гуйв. Сүрэн гуай над руу гайхсан мэт тоомсоргүй ширвээд

-Үзэх ээ?!... гэж асууснаа

-Эмнэг гэдэг чинь ч чиний цавьдар морь шиг «хонь» биш дээ хө. Тэгж санааны зоргоор үзүүлээд ч байдаг юм биш гээд өгсөнгүй. Би тэнд Дугар, Балдан хоёрыг л хараад зогсоод байлаа. Үнэндээ тэд сайн булгиулж байв.

-Энэ хүүхдүүдийг нэгдлийн дарга өөрөө явуулсан юм гэж Сүрэн гуай адуучин өвгөн гуайд хэлээд

-Айхтар хүүхдүүд... гэв. Нэг л мэдэхэд үд болоод аль хэдийн хонь хотлох болчихсон байлаа. Би сандран мориндоо мордов.

Өнөөдрийн тохиолдсон бүх л явдал над гомдолтой байв. Сүрэн гуай ч, Балдан ч цөм намайг эмэгтэй жаал гэж элэглэснээс тэгсэн юм шиг, яриагүй энэ л учраас намайг эмнэг унахаас татгалзсан шиг бодогдоно. Тэгээд тэнд дооглуулсандаа бүр их гомдов. Би замаар аажуухан гэлдэрч явав.

Гэнэт замд морь булгиулж чадах эсэхээ үзэх сонирхол намайг хөгжөөв. Эргэж очъё гэвч, хонь хотолж байгаа болохоор ээж минь тэр олон хонио ганцаараа дийлэхгүй ядарна гээд, яавч

харилгүй болохгүй. Гэтэл морь булгиулж үзэх хүсэл намайг тогтож байлгах аргагүй болов.

Энэхэн үед л миний толгойд мундаг гоё бодол орлоо. Ямар догь бодол орсон гэж бодноо! Би ташуураа авч цавьдар мориныхоо сүүлийн угаар хатгав. Морь чихээ соотойлгон хэсэг холбилзон хөдөлснөө гэнэт огло үсрэн булгиж гарав. Ташуураа би алдаж орхилоо. Түүний суран үзүүр нь морины сүүлэнд хавчуулагдсан юм байжээ. Эхлээд тонгочиход нь надад баярлах сэтгэл төрж байсан боловч гижиг нь хөдөлж сандарсан морь хэд дэвхэцсэнээ яах ийхийн завдал өгөлгүй зүлгэн дээр / шидчихлээ. Тэгээд л морин төвөргөөн сонсогдов. Намайг Толгойгоо барьсаар босож ирэхэд цавьдар морь эмээлээ гэдсэн доороо авч, Баянголын тэртээ тал өөд давхиж яваа харагдав. Түүнийг харах, өөрийнхөө энэ тэнэг явдлыг бодох гэдэг надад ямар хачин байсан гэж санана. Хэрэв миний тэнэглэснийг Цэцгээ харсан бол яах байсан бол оо! Ер нь улсууд мэдсэн бол юу гэж бодох байв.

Өнөөх нэг магтагдаад байсан саальчин хүү чинь ингэдэг хун байсан юм бий гэж лав инээлдэх байсан болов уу. Би тэртээд хаягдсан ташуураа авч алхав. Нүүр ам шороо болоод хөл хөндүүрлэж байлаа. Шарваараа сөхөөд үзэхэд шилбэ минь хөхөрч хэсэг газар шалбарчээ. Унахдаа л чулуунд цохисон нь тэр биз... Би доголсхийн гэр рүүгээ алхав.

Гэр маш хол байлаа.

Явах тутам хөл минь эмзэглэж, улам өвдөнө. Яарахгүй бол болохгүй байв. Ээж өдийд хонио сааж байгаа. Настай болсон хүн, тэгээд ганцаараа тэр олон хонийг яаж сааж дийлэх вэ дээ. Ээжийгээ, би өрөвдөв.

Аав надад найдаж өдий олон хонь нэгдлээсээ авсан. Намайг л бүх итгэлээ гэж олон хүнд ярьсан. Тэгтэл би энд ямар ч юм болоогүй байхад морио зориуд үргээгээд түүнээсээ болж уначихаад ингээд явж байдаг. Одоо яанаа! Намайг саарал морьтой ах гүйцэж ирлээ. Энэ ах их сайхан зантай, инээдтэй, хөгийн юм ярьж, хүн их инээлгэдэг, надаас жаахан өндөр нуруутай (гоё цүнхтэй) бор нүдтэй, өргөн хөмсөгтэй хүн байв.

-Дүү хаачих нь вэ? гэж асууснаа:

- Яагаад доголоов? Мориноос ойчоо юу? гэж хэллээ. Тийм гэж би толгой дохив.

-Чулуутын хонины суурь дээр очих гэсэн юм. Манайх тэнд байдаг гэсэнд.

-Еэ тэгвэл дор очих юм байна гэж тэр ах хэлээд

-Алив сундал. Давхиад буучихья гэв. Би түүний ард сундалдаж ах гуай морио ташуурдав.

-Хоёул цогиулая. Тэгэхгүй бол чамд эвгүй байж магадгүй гээд тэр ах өвөг өвөг цогиулав.

-Хөөе жаал аа, чи Болд гэдэг хүүг таних уу? гэж тэр асуув. Ямар Болд? гэж намайг асуусанд,

-Хоньчин Шарав гуайн хүү Болд... саальчин гэсэнд өөрийнхөө нэрийг сонсож нүүр улайх шиг болов. Тэгээд энэ хүн яах гэсэн юм бол гэж бодоод:

-Та яах нь вэ? гэвэл,

-Би түүнтэй уулзах гэсэн юм.

Пионерийн сонинд тэр сайн хүүг бичиж, зургийг нь тавих ёстой юм. Яагаад гэвэл тэр чинь ээжтэйгээ элбэж зуныхаа амралтаар 300 хонь сааж их ажил хийж байгаа хүн юм байна шүү дээ гээд

-Чи таних уу? Ямар шүү хүүхэд вэ? Нэг хотонд байдаг уу? гэв. Надад хэлэх үг алга. Нүүр минь лав маш их улайсан байх. Би юу ч гэж хэлсэнгүй.

-Чи яав аа? гэснээ тэр гайхсан янзтай,

-Танихгүй юу? Яагаад дуугүй байна? гэлээ. Би арга олдохгүй түгдэрснээ

-Болдыг би танихгүй... гэж сулхан дуугараад мориноос буучихав.

-Хүүе жаал аа чи яасан хөгийн эр вэ? Юунд мориноос буучихав гээд

-Яах вэ дээ. Танихгүй бол танихгүй л биз. Чи өөрөө Чулуут уруу очно гэсэн шүү дээ. Би хүргээд өгье гэж тэр ах шалав.

-Үгүй би тэнд очихгүй! гэж зөрөөд дараа нь хэсэг дуугүй зогссоноо:

-Ах аа тэр, Болд чинь... Болд чинь байна шүү дээ муу хүүхэд. Тийм сонинд бичмээр сайн жаал биш гэлээ. -Яагаад сайн жаал биш гэж?

Тэр ах надаас бүр нэг сайн сонсоод авья гэсэн шиг^] мориноосоо бууж ирэв. /

-За хэл, яагаад тэр муу жаал юм бэ?

-Муу жаал, муу жаал... яагаад гэвэл... муу жаал гэхээс өөр үг надаас даанч гарсангүй. Би айж тэвдэж хөлс гоожоод нүүр улайж байв.

-Битгий надаас зов гээд тэр ах:

-Чиний нэр хэн бэ? гэж гэнэт асуув.

Энэ үг намайг цочоолоо. Юу гэж хэлэхээ би мэдэхгүй бүр тэвдээд эцэст нь миний амнаас «Болд» гэсэн үг намайг хэлье гэж бодоогүй байхад яагаад ч юм гарчихав.

-Уухай Болд гэнээ? гээд ах гуай сонирхож

-Овог... овог... гэснээ би

-111... LLL шар-ав, гэв.

-За ингэхлээр тэр хүү чи өөрөө байжээ гээд: -Надаас битгий зов. Аль вэ явья. Танайд очье. Би

түүний хойноос дагалаа.

6 дугаар сарыг 30

Уг нь бол хонь хэдийн бэлчээрт байх цагаар би гэртээ ирлээ. Хонь хотондоо хашаатай, эжий минь бүр хөлөрчихсөн сандран барин хонио сааж байв. Намайг хүнтэй сундалдаад ирснийг мэдмэгц гүйж тэврэн аваад

-Хүү минь юу болов чи чинь, мориноосоо уначихаа юу? гэж үнсэв.

-Зүгээр! Ээжээ гээд би:

-Цавьдар морь юмнаас үргээд надыг чулуудчихсан юм. Юу ч болоогүй гэж тоохгүй янзтай дуугарснаа:

-Алив би тусалъя ээжээ, гээд гараа угаах гэж гэр уруу гүйв.

-Ах аа та манайд хүлээж байгаарай гэхэд минь тэр инээмсэглэж

-Тэгэлгүй яах вэ. Чи ажлаа хий хий! гэв.

Бид хоёр замдаа их юм ярьсан л даа. Тэр ах «Пионерийн үнэн» сонины сурвалжлагч юм гэнэ. Намайг хувингаа аваад г саалийнхаа хувцсыг өмсөөд гарч ирэхэд ах олон удаа зургийг минь аваад

-За Болд оо! Би хүлээе гээд гэрт орсон юм.

Ээж минь зөндөө ядарсан байжээ. Арга ч угүй шүү дээ. Саалийн сүүлчээр хонио бэлчээгээд гэртээ орж ахад би хонь яагаад саах болсноо, мөн юм болгоныг сурахсан гэж хүсдэгээ цөмийг ярьж өгвөл:

-Манай ангийн Цэцгээ ч бас тэгж боддог. Тэр их сүрхий охин байгаа юм. Би нэг ч удаа гэрээр нь очоогүй. Лав хонь мал сааж, ээждээ их тусалдаг байх гэж ярьсан юм.

7 дугаар сарын 6.

Хэдэн өдөр өнгөрлөө. Би хуучнаараа л ажиллаад байв. Цавьдар морийг минь Гэндэн гуай авчирч өглөө. Аав яваад эвдэрч будаа болсон эмээлийн сэгийг өчигдөр Тосонгийн зүүн хяраас авчирсан. Тэр эмээлийг гэрийн хаяа уруу урам муутай нь аргагүй шидсэнээ:

-Хайран эмээл, нэгдлийн юм шүү дээ! гэсэн юм. Ингэж хэлснээс намайг нэг цохиод авсан нь илүү байв. Гишүүн нь нэгдлийнхээ юмыг хичнээн хайрладаг гэж бодно. Энэ чинь том гарз шүү...Гэтэл тэр гарзыг би хийсэн байдаг. Муухайяа. Бас сурвалжлагч ах гуайд би худлаа хэлж цавьдар морь үргээд чулуудчихсан гэж хэлсэн. Үнэндээ бол тийм биш байдаг. Нүүр минь халуу оргиж өөрийгөө зэмлэв, Тэгээд урамгүйхэн санаа алдан суугаа аавынхаа дэргэд очиж

-Аав аа! гэж зөөлхнөөр дуудав.

-Юу гэв хүү минь! гэж аав асуув.

-Миний буруу...гээд би:

-Намайг уучил, би муу хүн гэж хамаг болсон явдлыг цөмийг тоочлоо.

Аав миний үгийг сонсоод хөмсөг зангидан хэсэг сууснаа

-За яах вэ буруугаа хүлээсэн чинь сайн. Одоо харин буруу хэрэг хийснийхээ хариуд амласан үүргээ биелүүлэх хэрэгтэй гэв. /

Буруугаа нэгэнт хүлээчихлээр дотор ямар сайхан болдог гэж санана. Би баярлан хөгжиж гүйн гараад өнөөх сайн дурынхныгаа дуудаж цуглуулаад эртээрээс хойш цэвэрлээгүй хотоо зааж:

-Машин бэлтгэ! Ажилдаа ороод! гэж тушаалаа. Хүүхдүүд хонины хашаа уруу хашгиралдан гүйлдэв. Цэцгээ ирэхгүй болохоор би бүр уйдаж орхилоо. Эртээрээс хойш олон хоножээ. Болсон бүх явдлыг Цэцгээдээ яримаар байв. Цэцгээ хотын сонин, тэнд юу юу үзсэнээ лав ярина даа. Нээрээ би түүнээс энэ сонинг сонсох гэж зөндөө хүссэн юм. Гэвч өдөр хоног өнгөрөх тутам тэр алга л байлаа. Нэг өдөр Буян гуай манай хотонд ирж яриа хийв. Би ярианы дараа Буян гуайд ойртон:

-Буян гуай! гэж зөөлхөн дуудаад, Цэцгээ хотоос ирэх болоогүй юм уу? гэлээ.

-Аа, юу гэнээ? гэж Буян гуай цүнхээ ташаандаа зүүж:

-Цэцэг үү? Цэцэг ирэх болсон л юмсандаа, алга л байна даа. Хүү чи яах гэв, юм асуух гэв юу? гэв.

-Үгүй л дээ... гээд, би

-Бид хоёр нэг ангид сурдаг шүү дээ гэснээ, нэг сонин үг толгойд орж ирэхлээр нь:

-Цэцгээтэй уралдах гэсэн юм... -Юугаар уралдах? -Ажлаар...гээд би:

-Яах вэ, ухаандаа саалиар ч юм уу уралдахгүй юу. Хэн нь түрүүлэх нь вэ үзье гэв. Буян гуай уруулаа цухалдсан шинжтэй хазаж хэсэг бодсонсоо:

-Мөд ч ирэхгүй байх аа даа гэж санаа алдаад -Ирээд ч нэмэргүй л дээ, гээд мордон давхиж одлоо. Энэ үгийн учрыг би ойлгосонгүй. Буян гуай намайг Цэцгээтэй уралдана гэхлээр яагаад царай нь улайсан болох, бас юунд цухалдсан, яагаад нэмэргүй гэж хэлснийг нь би ойлгосонгүй.

Би тэмдэглэлээ түр орхиж юм бодов. Хүүхдүүд гадаа цуглаад намайг дуудацгаана. Тэд өнөөх сайн дурынхан. Би дэвтрээ г орхиод! гарлаа.

Цэцгээгийн тэмдэглэлийн үргэлжлэл

7 дугаар сарын 7

Удахгүй наадам болно! Мөн гоё! Өчигдөр орой би ах эгч хоёртой хамт Сүхбаатарын талбайгаар явлаа. Орой чийдэн гялалзаад цэцгийн үнэр ханхлаад ямар сайхан байсан гэж бодноо. Ёстой нэг зуны орой л байлаа. Өдийд юм бол манай Баянголд үхэр тугал мөөрөлдөөд, хүүхдүүд шуугилдан, эжий минь улсуудтай хамт хургаа ялгалцаад гэртээ орж байгаа даа. Хаа ч юм бэ, талбайн нэгтээ сонин зарж байснаас ах худалдаж аваад «Пионерийн үнэн» сонингийг нь намайг унш! гэж өглөө. Би дүүгээ тэргэнд суулгаад түрж явсан болохоор гар завгүй байсан боловч авч тэргэн дээр тавив.



Дүү ямар сонин мэдэх биш дээ дорхноо хумхиад барьчихлаа. Тэгэхлээр нь би авч өвөртөө хийх гээд урдаар тэнийлгэв. Гэнэт миний нүдний өмнө сонин юм харагдсанд би гайхлаа.

Энэ нь цагаан халаад өмсөөд хувин бариад хониныхоо хашааны дэргэд зогсож байгаа Болдыг хараад би баярлах / гайхах хослов. Тэр их сандарсан юм уу яасан юм инээд хүрмээр байдалтай зогсоно. Цаана нь хонины хашаан дээгүүр нэг хонь Болдтой хамт заавал зургаа авахуулна гэсэн юм шиг толгойгоо чадлаараа өлийлгөн хашаан дээгүүр цухуйж байв.

-Хараач ах аа, эгч ээ! гэж би дуу алдав.

-Юу болов? гээд эгч:

-Таньдаг хүү юм уу? гэлээ.

-Нэг ангийн хүүхэд! гээд би сэтгэл нэг л хачин болж:

-Болд гэдэг юм. Миний найз л даа гэлээ.

Болдын, сонинд гарсан нь сонин, сайхан мөртлөө нэг л ёсон биш юм шиг, уг нь түүний оронд эмэгтэй хүүхэд л байвал илүү сайхан шиг, тэгтэл тэр эмэгтэй нь би байх ёстой байсан шиг надад санагдаад болдоггүй. Тэгээд Болд ингэж тэнд ажил төрөл хийгээд амрах чөлөөгүй байхад би энд жаргал хөөгөөд гүйж явдаг, ер нь юу болж байна гэж бодлоо.

Ямар ч байсан ингэж сууж боломгүй санагдав. Тэгээд явахад бэлтгэж эгчид:

-Эгч ээ би харилаа! гэсэнд эгч ах хоёр намайг гэнэт ингэж шийдсэнд гайхсан бололтой.

-Юу гэсэн үг вэ, Цэцгээ. Наадам үзээд явахгүй юу гэцгээв.

Гэвч би тэдний үгийг дуулах ч дургүй байв. Бушуухан л харьж Болдтой адил ёстой ажилч, сайн хүүхэд болохыг л хүсэв. Наадам үзэхгүй нь надад харамсалтай байсан авч би тэсэж тогтож чадсангүй болсон бүх явдлыг цөмийг яриад маргааш нь явахаар болов.

7 дугаар сарын 13

Өнөөдөр ер бусын явдал боллоо. Болдынх Цуурайтын адаг өөд шинэ нутагт буухад манайх бас нүүж тэднийхэнтэй саахалт, айл буув. Манай хот одоо ойрхон айлтай боллоо. Болд яасан их баярласан гэж санана даа. Эртээр, хотоос ирээд юу болсныг цөмийг нь тэмдэглэх хэрэгтэй санж... Намайг наадам үзэлгүй хотоос гэнэт ирсэнд эжий их гайхав. Тэр намайг урьдынхаа г заншлаар тэврэн авч үнсээд:

-Охин минь, яагаад гэнэт хүрээд ирээв? Өнөө наадам үзнэ гэсэн чинь яалаа? Цаадуул чинь сайн уу? гэлээ.

-Сайн! гээд би Болдоос дутахгүй саальчин больё гэж хэрхэн шийдсэнээ гэртээ орох завсраа ээжийдээ ярив.

Ээж миний дуртай хайлмагийг тэрхэн дороо бэлтгэж аяганд минь хийж өглөө. Намайг хооллож байхад над уруу харж их л юм бодсон байдалтай суулаа. Чи түрүүн нь оролдоод дийлээгүй байж ахиад чадах бол уу даа гэсэн шиг л намайг харна. Маргааш нь би ахиад л өнөөх ажилдаа орлоо. Эхлээд бас л урагшгүй загнаж эжийд зэмлүүлж байсан. Харин одоо бол сүрхий болжээ. Би өөрөө саальчин болсноо ойлгоод байгаа юм. Эжий ч бас зөвшөөрч байгаа, өдөрт би бараг арав шахам ямаа саачихдаг юм чинь саальчин биш гэж хэлж болох уу?

Дараа нь би Болдынд нэг өдөр очлоо. Болд намайг очиход ямар их баярласан гэж бодноо. Тэр надтай уулзаж хоёул эрвээхэй барих гэж хөөгөөд Баянголын эрэг хүрлээ. Тэнд сууж сониноо ярилцав. Ногооны ааг үнэртэж хажууд гол мяралзан, тэнгэр цэв цэлмэг ёстой сайхан өдөр байлаа. Цэвэлмаа багш ноднин бил үү, уржнан бил үү энэ Баянголыг зураад бидэнд авчирч үзүүлсэн юм. Яг л тэр зураг шиг цэв цэлмэг тэнгэртэй, нов ногоон байгальтай их гоё өдөр байлаа. Болд намайг байхгүйд хэрхэн уйдсанаа яриад мөн эмнэг сургах гэж хэрхэн очсон, Балдан өөрийг нь эмэгтэй жаал гэж хочилсон болон сонинд гарсны нь дараа тэр хэрхэн ирж гар бариад мөрийг нь алгадах мөртлөө яагаад ч юм өөрийнхөө резинэн гоё ташуурыг бэлэглээд, сүүлд эмнэг сургахдаа заавал цуг явна гэж амласан, тэр эмнэг сургасан өдөр Болд өөрийнхөө морийг үргээж эмээлээ хөглүүлснээ цөмийг ярьж хоёул инээлдэв. Би түүнд хотод юу юу үзсэнээ бас ярилаа. Болд хэлсэн нь:

-Танайх манайх хоёр айлсан бол...уралдах юмсан. Чи лав мундаг саальчин байхаа гэлээ. Миний хацар улайсан юм уу / яасан юм өвдөх шиг болоод би ичин доош тонгойв. Тэгээд хэсэг дуугүй сууснаа,

-Болд оо!... Би чамд нэг юм хэлье гээд ер нь хүн үнэнч байх хэрэгтэй гэж Цэвэлмаа

багшийнхаа захидгийг санаж, түүнд өөртөө тохиолдсон бүх л явдлаа яриу. Энэ бүхнийг Болд гайхсан янзтай сонсоод суулд нь:

-Еэ, тийм үү? гэснээ

-Чиний зөв. Аргагүй гэж хүлээв.

-Би чамд тусална. Тэгээд хоёулаа ёстой мундаг саальчин больё. Тэр битгий хэл, би чамд тор нэхэхийг хүртэл зааж өгье гэсэнд би Болддоо хэмжээлшгүй их баярлав.

Ийнхүү хэдэн өдөр өнгөрсний дараа гэнэт Болд, бид хоёрын аз болж, нэг дор айл буув. Орой хониныхоо хашааг бариад хургаа хоёр тийш нь ялгасны дараа Болд бид хоёр уулзаж тэднийд ороод шагайгаар тоглолоо. Шагай шүүрч байснаа Болд гэнэт хэлсэн нь:

-Хүүе Цэцгээ хоёул, маргаашнаас эхлээд уралдъя. Тэгэх үү? Самбар гаргаад, түүн дээрээ Болд, Цэцгээ гэж бичье. Өдөр тутам саасан сүүнийхээ хэмжээг хониныхоо тоотой бичье тэгэх үү? гэв. Би саалинд муу болохоор тэртэй тэргүй Болдод хожигдох нь мэдээж л дээ. Гэвч би үзье гэж бодоод:

-Тэгье! гэж дуртай зөвшөөрөв. Бид хоёр том зузаан цаасан самбар бэлтгэж түүн дээрээ хоёр нэрээ бичээд маргааш гадаа хадахаар тохирлоо.

7 дугаар сарыг 14

Урьд шөнө юу болсон гэж санана аа! Намайг шөнө унтаж байтал нойрон дунд улсууд ярилцах шиг боллоо. Бас нэг нарийн дуутай хүн уйлаад ч байх шиг. Энэ дуу Болдын дуутай тун адилхан байхлаар нь би цочин сэржээ. Гэр дүүрэн улсууд шуугилдан эмчид явах тухай ярилцаад, Болд миний орны хөл дээр суучихсан уйлж байв. Түүнийг би хэмжээлшгүй өрөвдлөө. Сэмээрхэн өндийж Болдын ханцуйнаас татаад:

- Болд оо! Чи яав? гэхэд минь миний орны өмнө сууж байсан ээжий байг гэж дохио өгөөд:

-Миний охин бос! Болдын чинь ээжий нь гэнэт бие нь муудаад хариугүй...гэв. Би тэр дорхноо хувцаслалаа. Манай хотынхон энэ учраас манайд цугласан юм байж.

-Аль вэ? Гонгор оо! Чи баруун үхрийн суурь уруу явж үз. Бага эмчийг аваад ир! гэж аав өөр нэг хүнд тушаах сонсогдов.

-Битгий хий сандраад байцгаа! Ерөөс сандрах явдал алга. Тайван үзэх хэрэгтэй. Алив та нар харьцгаа. Хэрэг болбол цөмийг чинь дуудна гээд аав манай хотын эмнэлгийн сувилагч нэг эгчийг:

-Чи тариа хийсэн гэл үү? гээд,

-Сум уруу хүн явуулчихсан. Удалгүй түргэн тусламж ирнэ гэв. Болдыг би аргадаж,

-Битгий уйл! гээд хацрыг нь арчаад өрөвдсөндөө дагаж уйлчих шахаад л байв. Оройхон юу ч

болоогүй тайван байсан хэр нь энэ өвчин ирэхээрээ ямар түргэн ирдэг юм! бэ дээ. Болд тайтгарсныхаа дараа:

-Ээжий хуучинтай юм л даа. Тэгээд тэр нь байнга ингэж зовоодог юм гээд харихаар гарахад нь би бас дагалдаж гарав.

Ээж нь орон дээрээ царай нь цонхийн тун муу байгаа байдалтай хэвтэж байлаа. Өмнө нь лаа бариатай, өвөө хажууд нь суух нь царай нь харлаж миний нэгтээ үзсэн гуулин хөшөө шиг... нэг л анир чимээгүй байдалтай нь айдас хүрмээр ээ! Эмээ бүгчим, аяархан амьсгална. Бид хоёр өлмийгөөрөө гишиглэн өвөөгийн дэргэд очлоо. Өвөө бид хоёр уруу их л өрөвдсөн байртай харснаа:

-Та хоёр унт... Би хөгшнийг сахъя. Сэтгэл зоволтгүй гэж шивнэв. Гэвч бид хоёр унтсангүй. Өвөөг өөрий нь унтуулах гэсэнд тэр дургүйцэж байв. Удалгүй эмч ирлээ.

7 дугаар сарыш 15

Хөөрхий Болдыгоо би өрөвдөөд барахгүй нь. Эмнэлгийн шар / тэрэг ирээд эмээг аваад явахад өвөө цуг явав. Тэр өглөө Болд, хурдлан одсоор баруун даваа давсан тэрэгний хойноос харсаар үлдсэн билээ. Тэгэхэд дэргэд нь би яаж юу ч хийж чадалгүй Болдтой адилхан уйлсаар зогслоо.

Тэр даруй л манай хотынхон цугларч Болдын хонийг яах тухай ярилцав. Зарим нь нэгдэлд буцааж өгье. Тэнд аргыг нь хайна биз гэнэ. Зарим нь цөмөөрөө ээлжилж саая гэлээ. Тэгэхлээр нөгөө хэсэг нь уурлаж, юуны чинь ээлжилж саах, өөрийнхөө хувийнхыг дийлэхгүй ядаж байхад... гэнэ. Болд тэр цуглаанд сууж байснаа гэнэт босоод, ааваас зөвшөөрөл авах гэж гараа өргөв.

-Буян ах аа...

-Юу гэв? За хэл! гэж аав зөвшөөрөв. Тэр босож зогсоод уртаар санаа алдан малгайгаа оролдсон хэвээр:

-Хонийг хэнд ч битгий өг! Би өөрөө саая. Надад... Надад... гээд миний нүд уруу юм хэлээч дээ гэсэн юм шиг аргадан хараад:

-Надад Цэцгээ тусална! гэв. Энэ үгэнд би хичнээн баярласан гэж бодноо! Тэр дорхноо би үсрэн босож: -Аав аа, Тусалъя би! гэж хашгирав.

Хүмүүс биднийг гайхан харцгаав. Тэгээд өөрсдөө мэдэж байгаа биз гэсэн шиг дув дуугүй болцгоов. Аав ч бас хэлсэнгүй. Тэр над уруу ууртай юм шиг эвгүйхэн хараад уруулаа хазаж юм бодно.

Болд бид хоёр ажилдаа оров. Үдийн хонь ирсний дараагаар Болд бид хоёр хувин аваад хашаан дотор орлоо. Энэ удаа ямар ч их будилсан гэж бодно. Хамгийн эхлээд л нэг зусгийг сааж байсан чинь гэв гэнэт тэр тонгочин эгэм уруу минь тийрээд явчихад нь хувинтай сүүгээ

алдав. Бас нэг бор нүдэн хонь эврээрээ нүд уруу цохичихов. Тэгэвч би ажилласаар л байлаа.

Болд над уруу баяртайгаар толгой дохино. Гэвч түүний нүдэнд нэг л сэтгэл зовсон шинж байгааг би ойлгоод л байв.

Би гарынхаа хурууг мэдээ алдтал саасан боловч Болд бид хоёр үдийн сааман дээр хонио цагт нь сааж дууссангүй, айлын авгайчуул ирж туслалцав. Би Болдын сэтгэлийг хөгжөөх гэж их л ядна. Хоёул хашааны гадуур хөөцөлдсөн авч түүний гүйж байгаа нь их л хүнд байсан л даа. Аргагүй л дээ. Ээжидээ сэтгэл нь зовж байгаа, хөөрхий ээжий нь яаж байгаа бол доо. Хоёр хоног өнгөрөхөд бас л сураг алга л байв. Тэр уйтгартай болж, ажилдаа ч гэсэн хайнга боллоо. Яаж Болддоо би тусална. Яана, хөөрхий Болд минь!

Болдын тэмдэглэл

7 дугаар сарыг 17

Ээж яваад хоёр хонолоо. Сумын эмнэлэгт байснаа онгоц ирээд бүр Улаанбаатар хот уруу явсан л даа. Би цуг явах гэсэн боловч аав гэртээ үлд гэж хэлсэнд юм ойлгодог сайн хүү болохоороо би үлдсэн юм. Гэлээ ч ээжийнхээ хойноос сэтгэл зовоод болдоггүй. Цэцгээ ёстой сайн охин. Тэр анх надад тусалж саалин дээр ажиллаж байхдаа ямар их хөглөж ядарч байсан бэ. Одоо тэгэхэд цөмийг нь сураад бас надтай хамт л ээжийн минь төлөө зовоод заримдаа уйлдаг юм. Бид хоёр өглөө үдэшгүй хамт байв. Аав хүнээр захиа өгч явуулсан байлаа. Түүнд бичсэн нь:

-«Хүү минь, ээж нь сайн болж байна. Битгий сэтгэл зовоорой. Хамгийн гол нь сайн ажиллаж хониныхоо саалийг битгий таслаарай. Удахгүй очно. Аав чинь» гэжээ. Цэцгээ захиаг уншаад зөндөө их баярлаж:

-Мөн гоёо! Сайн болж байна гэж байна шүү дээ.. Болд оо, битгий урвай! гэж намайг зоригжуулав.

Цэцгээгийн ээжий ямар сайн хүн гэж бодно. Тэр байсхийгээд манайд орж ирээд цай хоол хийж өгөөд Цэцгээ бид хоёрын духан дээр үнсээд:

-Ээж нь удахгүй эдгээд ирнээ хүү минь! Харин ирэхэд нь л хэдүүлээ энэ сааль сүүг нь таслахгүй байвал сайнсан гэнэ. Гэтэл / манай ангийн Дугар, Балдан хоёр нэг өдөр ирлээ. Би Цэцгээтэй үхэр тэргээр ус авчрахаар гол дээр очоод эргэж ирж явсан чинь тэр хоёр давхин ирлээ. Уулзангуут мориноосоо үсрэн бууцгаагаад:

-Еэ, бид хоёр жаахан хоцорчихож... Тэргүйсэн бол та хоёрыг торхоо дүүргэхэд чинь туслах байсан гээд намайг тэвэрч аваад

-Цэвэлмаа багш, бид хоёрыг зориуд явуулсан юм чам уруу. Ер нь ч бид хоёр ирэх гэж зөндөө бодсон л доо гээд

-Чамайг сэтгэлээр унах вий. Тэгж болохгүй, ээж нь сайн, болж байгаа гэж хэлээрэй гэж байна билээ. Багш хот руу цахилгаан өгсөн хариуг нь авсан юм байх. Ээж чинь хагалгаа хийлгээд их сайн болж байгаа юм байхаа гэлээ. Би ийм сайн нөхөдтэйдээ баяртай байв. Багш минь нөхөрлөлийн тухай их ярьдаг юм л даа.

-Хүүхдүүд ээ! Нөхөрлөлөөс сайхан юм хаа ч байхгүй. Бие биедээ итгэж, тусалж нэгийнхээ төлөө санаа зовж, нөхөрлөцгөөе! гэж хэлдэг юм.

Миний сэтгэл сэргэж Дугар, Балдан хоёрын гарыг атгав. Бид хэд манайд ирж хашааны бууц цэвэрлэлээ. Тэгээд тэр хоёр ажил хийлцэж, хийлцэж орой болсон хойно явав.

Оройн цаг

Орой. Би гэртээ ганцаархнаа хэвтэж байна. Нойр үл хүрнэ. Гэрт тас харанхуй. Тооноор сарны бүдэг гэрэл хоймор тусна. Гадаа хотонд хоньд яраглан, ямар нэгэн ишиг эхээ дуудан зөөлхөн майлах сонсдоно. Хөөрхий ээжийдээ би ямар их хайртай вэ! Тэр хагалгаа гэдгийг хийхэд лав их өвддөг байх даа. Ээжий минь өдийд эмнэлэгт хэвтэж, түүний өмнө аав минь сахиад л сууж байгаа, ээжийг гайгүй бол аав жаахан ч гэсэн унтаж амраасай даа. Би ээжийгээ ямаршуу янзтай байгаа бол гэж дүрслэн бодож үзлээ. Ээжий цав цагаан дэр дэрлээд эмнэлгийн орон дээр тамирдуу царайтай хэвтэнэ. Ээж нүдээ г алгуурхнаар нээж аав уруу харна. Аав олон хоног нойргүй байснаас ядраад үүргэлнэ. Тэгэхэд ээж, аавыг сэрээж:

-Өвгөн минь, унтаж амар. Надад битгий зов. Би их сайн байна гэнэ дээ. Тэгэхлээр аав цочиж сэрчихээд нүдээ нухаж

-Зүгээр, зүгээр Лхам минь! Би зүгээр л тэгж бөхийсөн юм. Огт ядраагүй...гэнэ дээ.

-Муу хүү минь яаж байгаа бол? гэж ээжий сэтгэл нь зовсон янзтай ааваас асуухад аав:

-Зүгээр, тэр чинь айхтар хүү. Миний хүү эр хүн шүү, дажгүй гэж хэллээ. Нээрээ тэгсэн болов уу? Ээжий лав надад сэтгэл нь зовж баугаа л даа, үргэлж тэгдэг юм. Бас ажлынхаа төлөө зовж байгаа.

Ээжий эдгээд хүрээд ирнэ. Бодсон санасан нь бүтэж, саалиа таслаагүй байхлаар бөөн баяр болно. Цэцгээд лав их баярлана даа. Цэцгээ сайн охин шүү!

Миний энэ бодол үнэхээрийн л үнэн болчихсон шиг надад баярлах сэтгэл төрүүлэв.

Би орондоо дэмий л тийчилж нойр хүрэхгүй ядав. Гэлээ ч удсангүй тэр бүх баярлах сэтгэлийн минь дээрээс шөнийн харанхуй нөмрөөд би сарны гэрлийг харсаар байсан боловч нойрондоо дийлдэв. Нэг мэдэхэд өглөө болчихсон Цэцгээ миний хажууд инээмсэглэн зогсож байлаа.

7 дугаар сарын 18.

Хэдэн өдөр дараалан Цэцгээ бид хоёр саалин дээр уралдав. Цэцгээг ийм сүрхий саальчин болчихно вий гэж урьд нь бодоогүй юм. Хүн ер нь нэг сурья гэсэн юмаа сурахдаа амархан юм. Түүнд зориглосон зориг, идэвхтэй оролдлого ч байвал юуг ч хүн хийж чаддаг юм байна. Цэвэлмаа багш энэ тухай дандаа тэгж хэлдэгсэн. Эртээрээс хойш бид хоёр уралдаад гадаа самбар зоож хэн нь олон литр сүү саах нь вэ гэж үздэг байлаа.

Мэдээжийн би урьд нь хийдэг байсан юм болохоор түрүүлээд л байв. Цэцгээ энэ бүгдэд надад хожигдоод цөхөрсөнгүй. Миний / гарыг атган:

-Сайн байна, Болд оо! гэнэ, эсвэл:

-Харж байгаарай. Болд оо! Би чамаас түрүүлнэ дээ гэнэ. Айлын авгайчууд хүртэл, Буниа гуай

хүртэл, Цэцгээгийн ээж хүртэл бид хоёрын уралдааныг сонирхож хонины хашааны дэргэд тавьсан самбарыг хараад:

-Болд түрүүлж...

-Маргааш хэн нь вэ?

-Маргааш Цэцгээ түрүүлнэ биз гэдэг байв.

Бид хоёрын уралдаан эхэлснээс хойш Буян гуай орой бүр самбар үзээд сэтгэл нь хөдөлчихсөн:

-Чи нэг түрүүлээч. Алив харж байя, охин минь гэдэг байв. Тэгснээ нэг юм санасан мэт болоод айлынхныг цуглуулж яриа хийхдээ:

-Харж байгаа биз та минь! Хүүхэд, пионерүүд сайхан үлгэр үзүүлж байна шүү. Алив та нар хоорондоо бас уралдах юм биш үү? гэсэн гэнэ.

Гэвч авгайчууд эргэлзээд байгаа юм байх. Өнөө оройн сааман дээр ямар сэтгэл хөдлөм явдал болсон гэж бодно! Саалийн дараа сүүгээ хэмжээд үзсэн чинь Цэцгээ надаас хавьгүй илүү саасан байв.

-Анх удаа Цэцгээ түрүүллээ. Баяр хүргэе! гэж би сэтгэл хөдлөн гарыг нь атгав.

Цэцгээ бөөн баяр боллоо. Би самбар дээр Цэцгээгийн дүнг бичсэнд тэр ээждээ үзүүлнэ гээд гэр рүүгээ гүйн одлоо. Өнөөдөр би ямар их баяртай байна вэ! Бүх л юм надад сайхан санагдана. Цэцгээ өнөөдөр түрүүлсэн! Би хожигдсон ч гэсэн Цэцгээгээ түрүүлсэнд маш их баяртай байв.

Цэцгээгийн тэмдэглэл

7 дугаар сарыг 20

Ямар өрөвдмөөр уйлмаар явдал болсон гэж сананаа! Өчигдөр аав сумын төв ороод ирэхдээ нэг л хачин царай муутай ирлээ. Гэлдэрсээр морины уяаны тэнд буугаад гэртээ үг дуу ч үгүй орж ирлээ. Энэ үед Болд бид хоёр уралдааныхаа самбарын дэргэд зогсож байв. Бид бие бие рүүгээ хараад гэрт гүйлдэн орлоо. Аав ээжийд ямар нэгэн юм хэлсэн бололтой юм бодон зогсоно. Тэгээд бид хоёрыг орж очингуут Болдыг тэвэрч аваад духан дээр нь нь үнсэж санаа алдаад: -Хүү минь явж үз... Ээжий нь...

-Ээжий яагаав! гээд л Болд уйлж гарлаа. Би ч бас адил.

-Ээжий нь амьд мэнд... хагалгааны сүүлд жаахан муудсан л юм байх. Утас ирсэн гээд гаргав. Түүнд тавхан үг бичсэн нь «Эх нь муудлаа. Хүүг явуул. Шарав» гэжээ. Эдгээр үгсийг уншаад Болдын царай цайж, хэрхэн үг хэлж чадахгүй болтлоо сандарсныг тэмдэглэхэд хэцүү.

Түүний байдал шал ондоо болоод хий л сандран, уйлж байхад нь ээжий хүртэл өрөвдөн уйлсныг яах вэ.

Манай гэрийнхэн цөмөөрөө Болдыгоо үдлээ. Тэр шуудангийн машинд суугаад хөдлөхдөө гараа өргөж над уруу инээмсэглэх гэж оролдсон ч гэсэн инээдийг нь айх түгшүүр зайлуулчихаад сэтгэлээр унаж байгаа нь ил байлаа. Болдын суусан машин холдон холдтол бид зогсоод дор бүрдээ түүний хувь заяаны тухай бодож байв.

-Ээжий нь их л муудаж дээ. Тэгээгүйсэн бол цахилгаан ирэх учиргүйсэн гэж аавыг санаа алдан хэлэхэд:

-Амьд мэндэд нь уулзаасай билээ. Ээ дээ энэ өвчин гэдэг ч хэцүү юм аа даа гэж ээж толгой сэгсрэв.

Надад энэ бүх явдал даанч өрөвдөлтэй байлаа. Би ганцхан Болдыг л бодож, тэр сайн явж хүрээсэй. Ээж нь эрүүл энх байгаасай. Эдгээсэй гэж л хүсэж байв. Миний оронд ч гэсэн надтай адил Болдын найз байсан бол бас л ингэж бодох байсан биз. Болдыг яваад өгөхлөөр бас л мундахгүй яриа гарлаа. Өнөөх / олон хонийг чухам хэн сааж маллах, хэнд энэ ажлыг өгөх зэрэг нь тэр л ярианы гол байв. Нэг нь хэлэхдээ нэгдэлд өгөхөөс сайхан юм байхгүй гэнэ. Нөгөө нь хэлэхдээ айл айлд тасалж өгөөд хариуцуул гэнэ. Эдгээр яриаг би сонсож дотроо эргэлзэх, тэвдэх сэтгэл төрнө. Болдынхоо нэрийг бодож хонийг би саах ёстой шиг надад санагдавч өдий олон хонийг би яаж дийлэх вэ дээ. Би үнэхээр ядарвал яана. Тэгээд тийм их ядарсан мөртлөө ямар ч амжилтгүй бол яана. Ингэж би бодохлоор эргэлзэх, айх сэтгэл төрнө. Гэвч эцэст ядарсан дорой дуугаар би:

-Аав аа, Хэнд ч битгий өг. Би саая...гэв.

Бүгдээрээ миний зүг гайхсан шинжтэй харцгаав. Гэлээ ч гэсэн тэд надад итгэж байгаа, эсвэл

үгүй хоёрын алийг ч би мэдэх нөхцөлгүй байв. Уг нь бол итгэх л хэрэгтэй байсан даа. Пионер хүн гэдгийг бодоод үзсэн ч, урьд нь Болдтой уралдаад түрүүлснийг харсан ч, итгэх л хэрэгтэй байсан. Аав ээжий рүү бас урьдын адил асуух янзтай харав. Ээжий юу ч гэж хариулсангүй, өөдөөс нь ч харсангүй. Бүгдээрээ л шийдвэр хүлээнэ. Гэвч шийдвэр нь бас л гардаггүй. Хүмүүс энэ бүх л бандлыг харж өрөвдсөн ч юмуу, дотроо юм бодсон ч юмуу бүү мэд дүнсийн сууцгаана. Тэгснээ Гоогормаа эгч намуухнаар

-За яах вэ, тэр хэдэн хонио надад цөмийг нь өгчих...Би саая! гэв. Тэр өөрөө хот дүүрэн хонь саадаг болохоор хүмүүс энэ саналд гайхсан юм уу, түүний зүг харна.. Гоо эгч ч гэсэн өөртөө итгэсэн итгэл дүүрэн л зогсоно. Тэгтэл гэнэт ээжий:

-Үгүй... гэж дуу алдаад,

-Үгүй...өгөхгүй. Алив Буян минь охиндоо өгье. Би элбэе...гэв. Ямар нэгэн сэтгэл хөдлөм байдал эзэмдэв. Хүмүүс миний зүг итгэлтэй дулаахнаар харцгаана.

* * *

Болд, Цэцгээ хоёр түүнээс хойш тэмдэглэл хөтөлсөнгүй. Хэн хэнд нь зав чөлөө болсонгүй. Уг нь тэмдэглэл хөтлөх зав г байгаад хөтөлсөрсөн бол тэдний цаашдын амьдрал үйл явдал уншигч бид хоёрт улам сонин байх байсан биз.

Өнөөдөр 8 дугаар сарын 25

Хурц нар орой дээрээс шарж оройтож шаагисан царцаа энд тэндгүй ниснэ. Баянгол долгио хаялан урсаж эрэг дээр нь буусан хот айлуудын дүрсийг зурсан зураг адил өөртөө тусгана.

Одоохондоо хараахан гүүр тавьж амжаагүй Баянголын өндөр хөвөөн дээгүүр хоёр морьтой хүн гарч ирлээ. Тэд гоёлын хувцас хөх даавуу дээл өмсөж, шар дурдан бус бүслээд, нисэхийн цэргийн дарга нар шиг ташаандаа цүнх зүүцгээжээ. Ялгаатай нь энэ цүнх сургуулийн хүүхдийн номын сав байв. Хүзүүнд нь хоёр салаа улаан зангиа хийсэж байв.

Уншигч минь таньж байна уу? Болд Цэцгээ хоёр маань байна шүү дээ. Өнгөрсөн өдрүүдийг тэр хоёр ямаршуу сонин явдалтайгаар өнгөрөөсөн бол. Цэцгээ хонио сааж чадаа бол уу. Болдын ээж яалаа даа. Миний зохиолын баатруудтай зүрх сэтгэл нэгтэй байдаг уншигч бяцхан дүү нартаа энэ явдлыг тайлбарлалгүй орхиж хэрхэн болох билээ. Гэвч уншигч минь хүлээ. Биднээс нэн их дутахгүй сэтгэл нь зовсон Цэвэлмаа багш маань сумын дунд сургуулийн үүдэнд хүүхдүүдээ хүлээгээд зогсож байна.

Болд, Цэцгээ хоёрыг багш ямар баяр хөөртэй угтсан гэж санана. Багш сэтгэл нь тэгж их хөдөлсөн юм уу, яасан юм, тэр хоёртой уулзангуутаа тэврэн үнсээд:

-Ёстой сайн хүүхдүүд! гэж дуу алдсан юм.

Бид ч гэсэн тэр хоёрын төлөө зөндөө баярласан. Багш биднийг ширээнд суусан хойно өмнөө журналаа тавьснаа босож:

-Хүүхдүүд ээ!

Бүх л зуныхаа турш бидний сэтгэлийг зовоосон үйл явдлууд тайлагдсан гэхэд болно. Болдыг хот руу явсны дараа Цэцгээ түүний ажлыг үргэлжлүүлэх гэж хичнээн ядарсан гэж бодно. Мэдээжээр ганцаараа тэр олон хонины сүү саалийг дийлэхгүй / л дээ. Тэгэлгүй яах вэ. Ээж нь тусалсан. Тэгээд ч энэ ажил амжилттай дууссан.

Харин?!..гэхэд хүүхдүүд багшийн зүг нүдээ бүлтийлгэн харна.

-Болдын маань ээж өчигдөр эмнэлгээс гарч ирсэн гэхэд: -Урай, урай, урай! гэж хүүхдүүд хашгиралдав. "Та нар мэдэж байгаа. Болд ч аль эрт гэртээ ирсэн шүү дээ, Ээж нь түүнийг ажлаа хийг гэж явуулсан юм.

Хүүхдүүд ээ!

Би та нарт нэг чухал юм үзүүлэх хэрэгтэй байна гээд

-Нэгдлийн ерөнхий хороо манай Болд Цэцгээ хоёрт талархаж пионер хүний сайн сэтгэлий нь сайшаан, ангийн маань нэр дээр бэлэг ирүүлсэн юм гэж саалийн мөнгөн хөнөг гаргаж ирэв. Энэ хөнөг бол үнэхээр цоо шинэхэн бөгөөд жижигхэн, оосрын нь сэнж товруутай, хүрэн бор өнгөтэй хувин байсан юм. Багш түүнийг ширээн дээрээ тавьсан нь бидэнд тодхон харагдах бөгөөд тэр хувин бид бүхнийг саальчин болоорой, над шиг ийм мөнгөн хөнөг барьж сүү шиг ариун сэтгэлээр ямагт хөдөлмөрлөж яваарай! гэж байх шиг санагдуулж байсан юм.

-Болд Цэцгээ хоёртоо баяр хүргэе! гэж багш хэлэхэд бид алгаа халтал ташицгаав.

-Цэцгээ минь, сайн сурагч хүн гэдэг чинь бүх л талаараа сайн байх хэрэгтэй юм шүү! гэж анхааруулах мэт хэлээд:

-Би та нарыг зун энэ хоёроос дутахгүй их ажил хийсэн байх гэж ятгаж байна гэв.

Бүх хүүхдүүд баяртай сайхан байв. Цэцгээ ч гэсэн бөөн баяр!

Тэр дэвтрээ өмнөө тавьж, мэрийвэл юм болгоныг сурдаг юм байна. Тоогоо заавал бодож чаддаг болно доо. Сайнаас доош дүн авахгүй дээ. Мэрийнэ дээ гэж бодож суулаа.

1965 он



1.«Хулгайлагдсан» жаалууд

Хаврын шалгалт дуусах дөхөж байлаа. Урд голын зүлгэн дээр \ бөөн бөөнөөрөө хэвтэж хичээлээ давтдаг жаалууд ч цөөрөв. Охидууд харин хувцсаа угаан дэлгэж, хөдөөнөөс заримын нь морь ирчихээд хүүхдүүд морь унаж энд тэндгүй хэснэ. Ер нь удахгүй амралт эхлэх дөхсөн нь ил байв.

Тэгтэл ер бусын явдал гарав. Сумын төвөөс жаахан хүүхдүүд алга болдог болов. Нэг эмээгийн ач хүү ердөө л тун саяхан дэргэд нь зогсож байснаа газарт ууссан мэт алга болчихож...

Бас нэг айлын таван настай охин амбаарын цаад булан тойроод л алга болж...Өөр хоёр айлын хүүхэд тоглоомтойгоо үгүй болж, харсаар байтал худалдагчийн хүүхэд дэлгүүр дотор алга болов. Үгүй мөн гайхалтай яа! Ээж аав нар хөлсөө урсган гүйлдэж бие биеэс асуух боловч нэмэр алга. Хонгил, жалга, хавийн байшингийн дээвэр, хажуугийн айлын хашаа хороог нэгжээд ч эс олов.

Тэгсэн чинь өнөө хэдэн хүнийг дагаж явсан жаал хүү бүр харсаар байтал алга болчихов.

Юу болох нь энэ вэ? Ямар аюул гарав? Тэдний жаахан хүүхдүүдээр хэн юу хийлгэх гэсэн юм бол оо? Бодоод байхад хүүхдүүд ердөө л өнөөдөр, чухам л яг өнөөдөр алга болжээ. Зарим нь өглөө, зарим нь үд дээр, үлдсэн нь бүр үдээс хойш алга болжээ.

-Тэнд байна! Тэнд...гэж хэн нэг нь Сампил гуайн хуучин амбаар уруу заав.

Үнэхээр амбаараас хүүхдийн уйлахтай ч юмуу, нохойн гаслахтай ч юм уу адилхан дуу бүдэгхэн сонсогдож байв.

Бүгдээрээ л тэр зүг адуу шиг пижигнэтэл гүйлдлээ. Нэг нь амбаар доогуур орж нүдээ нээгээгүй нэг жаахан гөлгийг татан гаргаж ирэв. Хүүхэд байсангүй...

Хүмүүс бие бие рүүгээ харж, ахиад чимээ чагнав. Энэ удаад зүүн айлуудын цаана хүүхэд инээх дуулдлаа. Хамаг амьтан шороо тоос манартал тэр зүг гүйлдэв. Зарим нь таварцаглаж т унаад дээлээ гөвж байв. Харин тэгсэн чинь Дамбий гуайн хэдэн А тахиа юм түүгээд явж байв.

Аав, ээж нар дуу алдацгаав. Одоо яах вэ? Нэг хэсэг, ялаа ниссэн ч дуулдахаар тийм нам гүм боллоо. Яг тэр нам гүмийн дундуур урд айлд хүүхэд уйлах нь тодоос тод сонсогдлоо. Хүмүүс бас л гүйлдэв. Ойнодоо хүрч байгаа төдий жаахан хүү ээжийнхээ мөөмийг хөхсөөр, орж ирж байгаа хүмүүсийг гайхан харж байлаа.

-Одоо хаачих вэ?

- Хүүхдээ яаж олох вэ?

-Байх л газраар нь эрлээ дээ.

Хүмүүсийн ийнхүү шуугилдаж байтал гаднаас хэн нэг хүн

-Олсон... Бүгдээрээ байна! гэх дуу хангинах нь тэр. Аав, ээж нар бие биеэ түлхэн шахцалдан айлаас гарцгаав.

Хаана, хаана? гэлцэн тэд ер ухаан алга.

Тэгтэл алга болсон жаалууд нь тэртээ байшингийн булан тойроод ирж явав. Аав, ээж нар ч баярлан ухасхийлээ.

Хүүхдүүд нь амьд мэндээр барахгүй ер гадаа тоглодгоосоо тэс өөр маш цэвэр, хамар амаа хүртэл сайхан цэвэрлэсэн байв. Хүүхдүүд туйлын баяр хөгжөөнтэй байлаа.

-Юу болох нь энэ вэ? Хичнээн эрэв? Хаачив? Хаана байсан бэ? гээд л аав ээж нар хүүхдүүдийг шалгаав.

-Бид нар цэцэрлэгт орсон...

-Багш сайхан дуу заасан.

-Бас гоё хайлмаг өгсөн...гэж хүүхдүүд ярив.

-Юун цэцэрлэг! Сумын цэцэрлэг үү?

-Үгүй ээ өөр цэцэрлэг...хаана байдаг нь нууц гэсэн...

Эх эцгүүд бие бие өөдөө харан шуугилдав. Үгүй мөн ийм явдал байдаг аа!

Үнэндээ суманд ганц цэцэрлэгтэй болохоор хүүхдүүд багтдаггүй юм байж.... Өөр цэцэрлэг байгуулах тухай ярьж байсан боловч тийм амархан бүтчих юм гэж хаа байх вэ.

Тэгтэл хүүхдүүд цэцэрлэгт орсон байдаг... Хүүхдүүдээ А олсондоо тэд баярлаад харьцгаав. Тэгсэн чинь маргааш нь, / нөгөөдөр нь бас л алга болцгоов.

Хүүхдүүд зөвхөн алга болсон биш, айлуудаас хүүдийтэй ааруул, мөн өрөм, өчигдөрхөн авсан талх, эсвэл хусам алга болдог болов.

Тэр нь ч бас яая гэх вэ. Үхрээ тэжээхээр явсан жаал тэр чигтээ алга болж, ус авахаа мартаж, түлээ хөрөөдөхөө бүр байсан явдал гарлаа. Нэг айлын охин хогоо ч шүүрдэхгүй, тоосоо ч арчихгүй явснаас аав ээжийг орой ажлаас ирэхэд цай ч үгүй, царай ч үгүй, эзгүй хоосон гэр угтжээ.

Ямар нэг явдал болж, хүүхдүүд цөм түүнд оролцож байгаа нь тодорхой боллоо. Алга болсон хүүхдүүд илбийн юм шиг гэр орноос гэнэт үгүй болсон нь идэх уух юмтай холбоотой болохыг ч бас гадарлаж эхлэв.

Тэгтэл нэг явдал боллоо. Оройхон хэрд юмсанж. Харуй бүрий дөнгөж л болж, хүүхдүүд

тоглоомоо орхин гэр гэртээ орж байлаа. Сумын төвийн гэрэл хараахан асаагүй байтал урд зуслангийн айлууд дунд нэгэн том шувуу гэнэт гарч ирэв. Тэр шувуу тогоруутай их төстэй. Бас дуу нь ч гэсэн, гур-рр, гур-рр гэж сонсдох бөгөөд ялгаатай нь тогоруунаас асар том, бас бараан өнгөтэй байв.

Амьтан судлалын хичээл үзсэн хүүхэд бол тэр шувууг томоороо тэмээн хяруултай адилхан гэж хэлэхсэн байх. Харин ямар ч номд заагдаагүй тэр тогоруу айлын хажуугаар явж, гэрийн дэргэд зогсон үг чагнаж байх нь үнэхээр хачин гээч.

Гэр дотор бол хүмүүс ойрын хэдэн өдрийн явдлыг л ярьж байлаа. Хүүхдүүд үл мэдэгдэх, нууцгай цэцэрлэгт явдаг болсон нь нэг талаар бодвол аймшигтай гэлцэнэ. Яагаад вэ гэвэл, тэр цэцэрлэгт ямар багш, юу заадгийг хэн мэдэх вэ, нөгөө талаар хүүхэд гадуур тэнэхгүй, гутлаа урахгүй, хамар амаа сайхан цэвэрлэж, тун ч нямбай байдаг болсон нь сайн гэлцэнэ. Бас хүүхдүүдийн төлөө эх эцэг нь зовохгүй, сэтгэл амар ажлаа хийх бол аштай байх уу даа.

Сүүлийн үгийг сонсоод аймшигт тогоруу яг л хүүхдийн хоолойгоор баярлан инээд алдав. Тогоруунаас айх, шохоорхох зэрэгцэн холоос харж байсан хоёр жаал бүр гайхаж орхилоо.

Тэр инээх нь тэгээд өөр хэн ч биш, тэдний сургуулийн 4-ын б ангийн Тогоогийн дуутай даанч адилхан сонсогдсоныг яана! Өнөөх хоёр зориг орж, аймшигт тогорууг барьж авах юм болов. Тэгээд дайрч үзлээ. Харин тогоруу тэр хоёрыг түрүүхэн тун их айлгаснаа ч мартан хөлийн хурдаар жирийлээ. Хоёр жаал улам зориглон хойноос нь хөөв. Түрүүчийн хүүхэд аймшигт тогорууны биенд хүрэн:

-Хүрэн алдан байснаа сүүлэн дээрээс нь шүүрэн барилаа. Тогоруу унаж, уухилж, хүүхдийн дуугаар хангинатал инээд алдаад тэр дороо өд сөд, урт хошуугаа хөсөр орхин, нүцгэн хүүхэд болж, бие нь сугарч гараад харанхуй уруу одов. Үлгэрт гардаг нусгай бор хүү хангарьдыг барьсан адил мань хоёр ихэд баярлаж, аймшигт тогорууны өд сөдийг авч гэр рүүгээ буцав.

Тэгээд гэрэлд үзсэн чинь нөгөөх тогоруунаас нэг дээл, урт мод ханцуйг боосон оосроос өөр юу ч үлдсэнгүй. Харин дээлний дотроос хумхиж базсан нэг цаас гарч ирэв. Түүнд бичсэн нь «Аав ээж нар аа!

Битгий сандрагтун! Бид та нарын ажилд туслах гэж сумын төвийн цэцэрлэгт ороогүй бүх хүүхдийг харж асрах цэцэрлэг байгуулав. Энэ цэцэрлэгт 1 настайгаас 7 нас хүртэл бүх хүүхдийг оруулж болно. Тэдэнд бид дуу зааж, бүжиг сургана. Бас ном зааж өгнө. Гоё зурагтай ном үзүүлж үлгэр уншиж өгнө. Харин хүүхдүүдийг өдөрт алга байхад битгий зовоорой. Хүүхдүүд хаана очихоо мэдэх юм болохоор өөрсдөө ирэг.

«Дүү нарыг асрах бүлэг» гэсэн байв.

«Хулгайлагдсан» жаалуудын учир олдлоо. Тэр бүлгийг үнэхээр сайхан үйлс бүтээе гэсэн жаалууд л байгуулсан байж таарлаа. Хүүхэд болгон тэр бүлэгт нь оролцохсон гэж бодох болов. Мөн гайхалтайяа! /

Харин нөгөө хоёр жаал дээлээр хийсэн тогорууны хувцсаа хаяж орхисон өнөөх Тогоотой

уулзахын хүслэн болов.

Тэгээд Тогоог босоогүй байхад нь бүр өглөө эрт очлоо.

-Та нар юу гэж яваа вэ? гэж ээж нь асуув.

-Тогоотой уулзах гэсэн юм.

-Тогоо босоогүй байна, яах нь вэ?

-Уулзах гэсэн юм юу...гэж түгдрээд нэг нь тэгж их загатнасан мэт хүзүүгээ маажив.

-Тогоо, бос бос! Чамтай хүүхэд уулзах гэнэ гэж ээж нь түүний хучлаганаас татав. Тогоо харин түргэн сэрж өндийгөөд нүдээ нухан;

-Хэн бэ? гэлээ.

-Уулзъя гэж нэг нь хэлэв.

-Яах гэж?

-Яахав дээ, зүгээр...гаръя л даа.

Тогоо бушуухан хувцаслаж гарлаа. Харин нөгөө жаал ардаа нэг юм нуун:

-Чи бид хоёрыг «Дүү нараа асрах бүлэгт» оруулж өгөөч! гэв. -Ямар бүлэг гэнээ?!

-Дүү нараа асрах бүлэг. За гайгүй шүү дээ, оруулчих л даа. -Би тийм бүлэг ерөөсөө мэдэхгүй. Бүр үнэн! -Аа ямар шинжгүй юм бэ? Оруулчих л даа! Хэрэв оруулчих юм бол чамайг бид хэлэхгүй шүү. -Юу хэлэхгүй гэж!

-Яагаав дээ, өчигдөр орой хөглөснийг чинь... ,

-Юу яриад байгаа юм бэ? Яаж хөглөсөн гэж?

-Яагаав дээ, тогоруу болсныг чинь... За оруулчих л даа. Бид бас дүү нартаа тусалъя л даа.

Нэгэнт цэцэрлэг байгуулсан нь маш нууц юм болохоор Тогоо хэлэхгүйгээр шийдэв. Хоёр жаал Тогоогийн дээл, өлгүүр модыг гарган ирлээ. Тогоо бол тэгж тогоруу болохдоо хүнд танигдахгүй байж, хүмүүсийн яриаг сонсьё л гэж бодсон юмсанж. Тэгтэл өчигдөр орой түүнийг барьж авсан нь энэ хоёр жаал байжээ.

-Би мэдэхгүй, наад дээл чинь минийх биш...Өөр хүүхдээс асуу л даа. Би мэдэхгүй! гээд Тогоог орох гэтэл, харин ээж нь

-Юу мэдэхгүй гэж! Энэ чиний л дээл байна шүү дээ. Хаанаас олсон юм? Нааш нь өг! гэх нь тэр.

Тогоогийн царай ихэд улайв. Тэр дээлээ авч, гэрт оруулчихаад тавган дээрээс хоёр ааруул явуут шүүрч аваад л гүйн гарлаа. Хоёр хүүхэд хойноос нь хөөсөн боловч гүйцсэнгүй. Цаг найм болж байлаа.

2. Маамуу нааш ир

Хорвоо дэлхий дээр гайхалтай цэцэрлэг байх юм даа. Дээр үед сүү тосны завод байгаад орхиж хаягдсан хуучин байшингийн буланд хүүхдийн нэгэн мундаг «цэцэрлэг» ажиллаж байв. Хог шороог нь гялалзтал цэвэрлэчихсэн тэр байшингийн оронцогт ногоо дэвсэж, хүүхдүүд маш журамтай сууцгаажээ.



Ханан дээр «Маамуу нааш ир» гэсэн бичиг байгаа нь яах аргагүй хүүхдүүдийг урьсан урилга бололтой. Ширээний оронд цагаан хайрцаг тавиад яагаад ч юм, түүхийн багш Ёхамсүрэн гуайг дууриан нүдний шил зүүж Чимгээ хүүхдүүдэд дуу зааж А байлаа. Чимгээ цэцэрлэгийн багш юмсанж. /

Ер нь Чимгээ багш болох дуртай, бага ангийнхны хичээл давтуулах болбол хамгийн түрүүн «би» гэж гараа өргөнө

Тоглохдоо багш болно. Эмээгийн юм оёхдоо зүүдэг нүдний шилийг зүүж, дүү нараа гэрийн хойморт суулгаж байгаад:

-За хүүхдүүд ээ! Өнөөдөр бид эртний улс Вавилоны тухай үзэцгээе! гэж эхэлнэ.

Сүүлчийн шалгалт дуусаж байхад хэдэн жаал ангидаа үлдээд зуныхаа амралтаар ямар мундаг үйлс бүтээх тухай ярьж байв.

-Би ногоон дээр ажиллана. Яадаг юм, муусайн хорхой шавьжтай дайн зарлана. Тэгээд төмс, байцааг ёстой сүр ургуулна (сүртэй гэх гэсэн бололтой), намар болохоор хуу хурааж аваад шагнуулна гэж

Тогоо хэлэв.

-Тэгвэл би адуу маллана. Эмнэг даага сургана.

-Би тэгвэл барилгад ажилладаг юм бил үү. Арван хоёртой, жаахан байна гээд авахгүй болов уу?

-За яахав, ээж намайг хааш нь ч явуулахгүй дүүг харуулна гэсэн...Би гэртээ л...гэж Чимгээ урамгүй хэлэв.

-Зунжингаа юу? гэж Баяраа гайхав.

-Тиймээ, зунжингаа гэж Чимгээ санаа алдав. Тогоо:

-Тэгвэл ингэе... Чи ч адуунд явахгүй, би ч ногоон дээр очихгүй, Баяраа ч барилгадаа ажиллахгүй, цөмөөрөө хүүхдийн цэцэрлэг байгуулъя! гээд сайхан юм бодсондоо инээд алдлаа.

-Цэцэрлэг байгуулах аа?

-Тийм цэцэрлэг. Хар л даа, сумын төв ганц цэцэрлэгтэй болохоор хичнээн хүүхэд аав ээжийнхээ ажилд саад хийж байна? Тэдэнд тусалъя!

-Зөв! Яг тэгье... одоохон явж байр олъё. Тэгээд л хүүхдүүдийг аваачаад байя.

- Хүүхдүүд ээ! Энэ бол нууц...Бид дөрвөөс өөр хэн ч мэдэх ёсгүй. Тэгээд цэцэрлэгээ «Дүү нараа асрах бүлэг» гэж нэрлэе. Л Цэцэрлэг, гэдэг чинь олон хүүхэд цугларах юм болохоор бас идэх уух юм, орон байр гээд л олон юм хэрэгтэй болно шүү дээ. Түүнийг эхлээд олъё, байраа цэвэрлэе гэж Чимгээ санал гаргав. Ингээд л «дүү нараа асрах бүлэг» байгуулагдсан юм даа. Чимгээ ингэж багш болов. Байшингийн нөгөө өрөөнд цагаан малгай өмссөн нэг жаал бяслал зүсэж суув. Яг л тогооч шиг, түүний эргэн тойронд хайрцаг саван дээр хүүхдүүдийн гэрээсээ авчирсан өрөм, бяслал, ааруул, боорцог тавиастай байв.

Гайхалтай нь, Тогоогийн ам маш завгүй идэж байлаа. Энэ бол Тогоо тогооч!

Тогоо цэцэрлэг санаачилсан болохоороо эндхийн дарга болов. Дарга бөгөөд тогооч Тогоо гэхлээр хүүхдүүдийн инээд ихэд хүрдэг билээ.

Ер нь Тогоо мөрөөдөх дуртай, юм болгонд гайхаж явдаг хүүхэд байв. Хүнд ярьдаггүй болохоос биш сонсвоос элэг хөшмөөр сонин гэнэн явдал Тогоод маш олон тохиолдсон удаатай.

Жишээ нь л өчигдрийн тогорууны явдал байна. Түүнийг бол ердийн нэг саваагүй зангаасаа хийсэн юм биш. Дотуур байрны хүүхдүүдийн дээлийн нэг ханцуйг уяж, түүндээ мод шургуулаад тогоруу болон тоглохыг Тогоо харсан билээ. Тэгээд л хүн ер нь цэцэрлэгийг нь юу гэж ярьж байгааг огт танигдахгүй мэдэхийн далимаар тогоруу болж очвол яадаг бол гэж үзэх гэжээ.

Хүн бүр мориндоо зөв талаас нь морддог байхад Тогоо «Буруу талаас нь болохгүй юм бол уу» гэж бодох жишээтэй. Баяраа усчин болов. Гэрээсээ хоёр дугуйнд бэхэлсэн мөрөвчтэй тэргээ авчирлаа. Ер нь Баяраа ус зөөх дуртай, гол нь тэрэг дархлах дуртай. Тэр, тэргийг юугаар ч хийж чадна. Том машины хоёр араа л байвал болох нь тэр. Бас өвөл цана, чарга дархална. Баяраа ус авчирч түүгээр нь Чимгээ хүүхдүүдийн нүүрийг угаана. Харин Сүхээ манаач боллоо. Цэцэрлэг нь нууц газар байрласан болохоор хавийн амьтанд мэдэгдэхээс сэргийлж Сүхээ нурсан ханынхаа нэгтээ ёстой л А хилийн харуулч шиг нүд цавчихгүй манаж байв. Энэ ажил харин / Сүхээд ер таарсангүй. Сүхээ уг нь тамирчин болох дуртай юмсанж. Ямагт тэр

гүйх юм уу, харайж явах, хаданд ямаа шиг асах дуртайг яана. Толгой нь гол төлөв шороо болсон явна. Энэ бол зүлгэн дээр гимнастик буюу бие халаах дасгал хийснийх юм.

Сүхээд нээрээ л манаач тохирсонгүй. Цэцэрлэгийн хичээл эхлээд таван ч минут болоогүй байтал Сүхээ түгшүүр зарлав. Чимгээ хүүхдүүдийн дууг намдааж, усанд явсан Баяраа айхдаа газар унаж, цэцэрлэгийн дарга Тогоо нэг том хайрцаг уруу цээжээрээ шургалаа. Тэгтэл аймаар юм ер биш, ердөө л хоёр ямаа бэлчиж явахдаа хана шөргөөсөн юмсанж. Дараа нь тун удахгүй Сүхээ дахин түгшүүр зарлав. Тэгсэн чинь мань Сүхээ нэг хэдгэний далавчин дээрээс барьж дүнгэнүүлсээр орж ирэв.

-За болиоч дээ. Ямар тэнэг юм бэ? Хүн хичээл заалгахгүй гэж Чимгээ уурлав. Сүхээ ч инээсээр гарлаа. Дараа нь Сүхээ нурсан хананы нэгтээгээс дөрвөн хар хорхой барьж түүнийгээ лаазанд хийгээд хэрхэн тэдгээр амьтад гарах гэж ядаж байгааг харахаар тохитойхон суув.

Өнөөдөр хүүхдүүд гэнэт алга болцгоосон тул эх эцгүүд бас л эрэлд гарлаа. Тэгэхдээ бүгдээрээ явсангүй. Долоон настай Жаргал, зургаан настай Эрдэнэ хоёрын аав ээж нэг юм гадарласан тул явсангүй.

Аав ээж нар ахиад хашаа хороог нэгжиж, айлын амбаар савыг нижигнүүлэв. Ер тэдэнд хүүхдүүдийг ямар нэг сахилгагүй хүүхэд уруу татаж байгаа мэт бодогдсоор байлаа.

-Хэрэв тэр муусайн турсгуудыг барьж авдаг юм бол ганц сайн хашрааа байз! гэж зарим нь уурлан хэлж байв.

Дөрвөн хорхойныхоо дээрээс бас нэг чийгийн улаан нэмж хийгээд Сүхээ үнэхээр нэг сэтгэл нь сэргэсэн мэт харсаар суув. Яг энэ үед хоёр хүүхэд хэрмэнд ойртон ирснийг Сүхээ яаж мэдэх билээ. Тэр хоёр бол «Дүү нараа асрах бүлэгт» оръё гэж Тогоогоос гуйсан хоёр жаал байлаа.

Тэд ёстой л эсрэг тэмцэгчдийнхээ хуаран уруу орж байгаа тагнуулчид шиг маш болгоомжтой мяраасаар явж Сүхээг хараад Л цааш хана даган бөгтийсөөр явж хүүхдийн цэцэрлэг уруу өнгийн хичээл зааж байгаа Чимгээг харав.

Чимгээ огт ажиг сэжиг авсангүй, хичээлээ зааж, хүүхдүүд Тогоогийн хувааж өгсөн нэг нэг хэрчим бяслагийг идсээр сууж байв. Тэгтэл өнөөх хүүхдүүдийн дунд байсан дүү нь ахаа таньж хоёр жаалын өнгийсөн цонх уруу гүйсээр ирэв. Мань хоёр зугтаах хэцүү байх хэцүү юм болов.

Дүү нь дуудсаар байлаа.

Чимгээ гайхан мөнөөхөн жаалын хойноос ирээд цонхны дор бөхийж нуугдсан хоёр жаалыг үзээд дуу алдав. Цаад өрөөнөөс Тогоо ирж, өнөөх хоёр ч босож, харин Сүхээ бүх зүйл өнгөрсөн хойно унтсанаа сэрсэн мэт түгшүүр зарлан хагархай цангаа балбасаар орж ирлээ.

Ээ мөн тоогүйяа! Тэдний нууц задрах нь тэр. Уг нь тэд нууцаа маш нарийн хадгална гэж

ярьсан юм.

-Та хоёр хаачиж яваа юм бэ? гэж Чимгээ аяархан асуулаа.

-Бид хоёр уу?...Бид хоёрыг цэцэрлэгтээ ав л даа! гэж нэг нь гуйв.

-Орон тоо байхгүй биз дээ? гэж Чимгээ яг л цэцэрлэгийн багш шиг хариуллаа.

Авчихъя, авчихъя. Яагаад вэ гэвэл эд бидний нууцыг задална шүү дээ! гэж Сүхээ айсандаа Тогоод шивнэв.

-Тэгээд бид хоёрыг авахгүй л юм биз дээ?

-Авахгүй.

-За яахав, тийм болог! Явъя! гэж нэг нь хэлэв.

-Цэцэрлэг байгуулах ёстой сайхан. Дүү нарыг асраад л, хоол унд зөөгөөд л бас нүүр гарыг нь угааж тоглуулаад л, энэ чинь ээж аав нарт тусалж байгаа, хэрэг шүү дээ, үнэхээр сайхан үйлс мөн гэж Сүхээ хэлэв.

-За яахав, та хоёрыг авъя. Бидэнд чадах чинээгээрээ л тус болбол боллоо. Хүүхдүүдийг сэмээрхэн авчирна. Бас сэмээрхэн буцаана. Энэ байрыг хэнд ч хэлэхгүй. За юу? гэж Тогоо хэлэв.

-Тэгвэл бид хоёр энэ цэцэрлэгт чинь орохгүй, мэдэв үү! А Яагаад вэ гэвэл, энэ чинь хүүхэд хулгайлсан цэцэрлэг. Аав ээж: / нар уурлаж байгаа, мэдэв үү? гэж Жамц гэдэг жаал хэлэв.

Харин цаадах Балдан нь эргэлзэж байлаа.

-Үгүй, чи ор л доо. Хамт дүү нараа асаръя. Тоглоод л, ёстой сайхан шүү дээ гэж Баяраа үүдэн дээр усаа авчирч тавьчихаад хэлэв.

-Орохгүй!

-Ор л доо, гайгүй шүү дээ! гэж Тогоо хэлж,

-Хэрэв чамайг орох юм бол би чамд алтан загастай үзгээ өгнө гэв. Тэр алтан загастай үзэг гэдэг нь шингэн дотор загас хөвж яваа тийм тосон бал юмсанж. Сумын аль ч хүүхдэд байхгүй тэр үзгийг ах нь өгсөн болохоор Тогоо даанч их хайрладаг боловч нууцаа задлахаас айж аргагүй л Жамцад өгөхөөр амлав.

-Нээрээ юу?

-Нээрээ.

-За тэгвэл яахав, орьё. Харин би цэцэрлэгийн дарга болно шүү. Би ус зөөхгүй, хүүхэд

харахгүй, бас манаач болохгүй, надад дарга юмуу, тогооч болох нь их аятайхан санагдаж байна гэж Жамц ихэмсэг хэлэв.

-Ээ ямар ичдэггүй вэ? гэж Чимгээ дуу алдлаа.

3.Идэмхий

Жамц дарга бөгөөд тогоочийн албыг Тогоогоос булаан авав. Түүнд тогоочтой адилхан хүүхдүүдэд идэх юм хуваарилах нь бүхнээс илүү таалагдсан бололтой. Тэгээд тэр Тогоогийн малгайг булаан өмсөж, цагаан хайрцагны дээр эвтэйхэн зүсэж тавьсан бяслагийг хараад

-Өө! гэж дуу алдав.

Хүүхдүүд түүнийг харсаар л зогсож байлаа. Жамц зөвхөн дуу алдаад зогссонгүй, хэмжээнээс том харагдах гараа явуулж, хэдэн зүсмийг тэр чигээр нь давхарлан ам руугаа хийж орхив.

-Чи болиоч! гэсэн чинь:

-Яадаг юм бэ? Тогооч бөгөөд дарга хүн чинь хоолоо эхэлж амсдаг Л шүү дээ гэж байна. Дараа нь тэр, өрмийг амталж, тун ч цөөхөн чихрээс хоёрыг зэрэг цааснаас нь задлан ам руугаа хийчихэв.

Энэ бүр дэндсэн юм боллоо.

-Чи боль л доо. Жаалууд сүүлд нь уйлна шүү дээ! гэж хамт ирсэн хүүхэд нь гуйж үзэв.

Жамц зориуд тэгэхээс тэгэх гэсэн мэт ахиад хэсэг ааруул үмхэж, дээрээс нь шанага ус уусны дараа:

-Та нар юугаа харсан жаалууд вэ? Ажлаа хийцгээ! гэж зандарлаа. Тэгээд ногоо дэвссэн шалан дээр суун, ихэд нойр нь хүрсэн мэт эвшээв. Хэдийгээр энэ бүхэн маш муухай санагдсан боловч хүүхдүүд биеэ барьжээ. Ийм идэмхий амьтан гэж ер байх уу даа? Хэрэв Жамцын, идсэн бүхнийг жаалуудад хуваасан бол олон хүүхдэд хүрэлцэх байлаа л даа. Тэгсэн хамгийн гол нь энэ цэцэрлэг нууцаар байгуулагдсан юм болохоор хоол ундыг хүүхдүүд гэр гэрээсээ зөөснийг яана.

Чимгээ хүүхдийнхээ өмнө очиж, намдуухан дуугаар:

-Хүүхдүүд ээ, хичээлээ үргэлжлүүлье гэж эхлэв.

Жамц ногоон дээр хэсэг зуур хэвтээд уйдав бололтой. Тэр дэргэд нь суун Чимгээгийн ярихыг ихэд анхааран харж байсан нэг жаахан хүүгийн толгой уруу зөөлхөн нясалж үзэв. Хүү гайхан эргэж харахад нь Жамц нүдээ анин унтсан дүр үзүүлж байв. Хүү Чимгээ уруу харахад Жамц дахин өнөө жаалыг шоглов.

-Аа, аа!.. гээд л өнөөх хүү ориллоо.

-Боль л доо. Хүүхэд зүгээр байлгаач дээ гэж Чимгээ ихэд бухимдсан боловч биеэ барин зөөлхнөөр гуйв.

Жамц юу ч хэлсэнгүй. Тэгээд өөр газар очиж суулаа. Энэ удаад нэг жаалын хоёр хөлний

завсар байсан чихрийг авч зажлаад нэг охины цэнхэр туузыг сэм тайлав.

Хүүхдүүд мэдээгүй болохоор уйлж бахирсангүй. Чимгээ энэ бүхнийг мэдэж байвч биеэ барьсаар л байлаа. Ер нь Жамц өөдгүй хүүхэд байв. Сурлагаар муу, сургуулийн хүүхдүүд түүний зодооч, хачин зантайг гайхна. Тэр үдэш болгон айлаар хэсэж А бусдын хоол горьдож явдаг зантай, бүтэлгүй юм болгонд л тэр / оролцсон байна. Тэгээд зогсохгүй муу зантай хүүхэд юм.

Жамц баахан үймүүлснээс хүүхдүүд ч хичээлийг сонирхохоо болив. Жаалууд шуугилдаж, нэг нь:

-Миний чихэр! гээд л уйлж гарлаа.

-Миний туузыг! гэж нөгөө нь бүр ч чангаар дуу хадаав. Чимгээ сандарч, нэгд нь чихэр өгнө гэж амлаж, нөгөөд нь өөрийн хамгаас эрхэм цэнхэр туузаа тайлж өгөхөөс өөр аргагүй болов. Харин Жамц хүүхдүүдээс холдлоо. Тэр Тогоогийн суудал дээр буруу харж суугаад л идэж гарав.

Баяраа ус зөөхөөр явж, Сүхээ ч манааныхаа байр луу очлоо. Дэмий байх нь шившигтэй ч гэж бодсон юм уу, Дэмбээ гэдэг нөгөө Жамцын найз Баярааг дагалдав. Тэгсэн чинь, Баярааг дөнгөж усаа авчиртал, бүр ч хэтэрсэн явдал болов. Жамц үд дээр хүүхдүүдэд тараах гэж байсан бяслагийг бүгдийг нь идчихээд хахах шахсандаа сандран ус залгилж байв.

Баяраа үнэндээ тэссэнгүй, хэдийгээр Баяраа зодоонд дуртай биш боловч энэ удаад нударга зангидаад л дайрлаа. Тэндээс Тогоо бас ирж, Сүхээ хүртэл лаазанд хийсэн сохор хар хэмээх хорхойнуудаа чулуудчихаад дайрч ирэв.

-Ёо ёо ёо! гэж Жамц ориллоо.

-Болиоч дээ! гэж Чимгээ хоривч нэмэр алга.

-Хүүеэ! Хүмүүс ээ! Аав ээж нар аа! Хүүхдүүд чинь энд байна. Хүүхдийг чинь эд нар хулгай хийсэн. Эд нар!...хэмээн Жамц бүр ч чангаар орилов. Түүний дууг хүүхдээ эрсээр яваад хуучин хэрмэнд тун ч ойрхон ирсэн хоёр аав сонсчээ.

Эх эцгүүд тэр зүг гүйлдэн ирлээ.

Аймшигт орилоон бахираанаас болоод Чимгээгийн хичээл зааж байсан хүүхдүүд ч уйлж гарлаа.

Хамаг нууц задарлаа. Эх эцгүүд хүүхдүүдээ хараад учрыг ойлголоо. Тэдний зүг жаалууд нь гүйлдэн очлоо.

-Айхтар мондинууд!

-Хүүхэд авч явчихаад...

-Яана гэнээ? Тоглох юмаа олов оо бас!

-Үгүй ер энэ Жамц дуудаагүй бол бид ч бүр эрэлд хатах байлаа шүү. Сайн хүү юм гэхчилэн аав, ээж нар. Жамцыг магтана. Гэвч хүүхдүүд нь маш цэвэр, ер муу юмны ямар ч ул мөргүй, харин ч хөгжилтэй сэргэлэн байхад аав ээж тэр дороо л тайтгарцгаав.

-Үгүй ер, хүүхдийн ухаан гэж! Та нар тэгээд цэцэрлэг байгуулсан юм биз дээ?

-«Дүү нартаа туслах бүлэг» гэнээ! хи, хи хи!

-Уг нь ч томоотой хүүхдүүд л дээ,

-Аав, ээжид нь хэлэхгүй ингэж яаж болно! гэлцэв.

Бяцхан жаалууд аав ээжээ дагаад л явцгаалаа. Цэцэрлэг дотор хэн ч үлдсэнгүй. Жамцын юу ч үгүй хоосолчихсон хоолгүй цэцэрлэгт тэд юу ч хийх юм билээ дээ.

Хүүхдүүд аав ээж нар болоод жаалуудын хойноос гунигтай харж үлдэхэд Жамц ихэмсэгээр нуруугаа үүрэн, үнэхээр ялсан дийлсэн хүний дүртэйгээр явж одов. Харин Дэмбээ явсангүй.

-Чи яваач! гэж Чимгээ хэлэв.

-Үгүй! гээд Дэмбээ юу ч хэлсэнгүй.

-Одоо яах вэ? гэж Сүхээ болгоомжтой нь аргагүй асуув.

Хэн ч түүнд хариу өгсөнгүй. Үнэндээ энэ явдал өөрсдийн нь болмгүй явдлаас болсон юм болохоор эрт орой хэзээ боловч мэдэгдэх чимгүй л байсан шүү дээ.

Тийм болохоор, аав ээж нар хүүхдүүдээ тэднээс салгаж аваачих нь аргагүй л юм. Ер нь аав ээжтэй нь зөвлөхгүйгээр хүүхдүүдийг нь нууцаар харж болох уу даа.

Харин ч аав ээж нь уурлаагүй нь л яамай. Хүүхдүүд тэгээд тарцгаав. Энэ явдал хэн хэнд нь үнэхээр их юм бодогдууллаа.

4. Хүүхдүүд мороодож байна.

Их үйл хэрэг эхлэхийн өмнөхөн яльгүй бүтэл муутай явдал гардаг л даа. Үнэндээ хойшдоо энэ сумын жаалууд ямар мундаг юм бүтээхийг хэн мэдэх билээ. Хүүхдүүд хэтэрхий их сонин юм хийх гэж хичээсэн болохоор л хүүхдийн цэцэрлэг байгуулсан, тэр нь бүтэхгүй болов.

Хүүхдүүдийн урам жаахан хугараад хэд хоногтоо уулзахаа ч байв.

Гэлээ ч тус тусдаа мөрөөдөж л байлаа.

Сумын төв их сайхан газар юм. Эргэн тойрон яг л үлгэрийнх шиг давхраат уулсаар хүрээлэгджээ. Сумын төвийн өмнүүр нарийхан гол долгио татуулан урсана.

Тэр голд сумын төвийн хүүхдүүд шумбан сэлэх дуртай, охидууд зүлгэн дээгүүр нь эрвээхэй хөөцөлдөж, угааж дэлгэсэн даавуу шувууныхаа хажууд зарим нь ном дэлгэж зураг үзж хэвтэнэ.



Чимгээ одоо зүлгэн дээр сууж байна. Нүдээ онилгож, алс уруу ширтэж, ямар нэг сонин юм бодож олох гэж мэрийнэ.

Далавчин дээрээ ягаан толботой хөөрхөн цоохор эрвээхэй хажууд нь ирж буув. Эрвээхэй өөр уруу нь ихэд таатай харж байснаа цэцэг гэж андуурсан юм уу яасан юм, даашинзан дээр т нь суулаа. А

Энэ эрвээхэй ид шидтэй болоосой гэж Чимгээ бодлоо. Чимгээ тийм ид шидтэй эрвээхэйтэйсэн бол, яасан их гайхамшигт үйлс бүтээхсэн бол оо! Ямар ч гэсэн тэр эрвээхэйг Чимгээ хүслийн эрвээхэй гэж нэрлэхсэн байх. Яагаад вэ гэвэл, тэр нь жаахан охин Чимгээгийн хүссэн бүхнийг биелүүлэх юм,

-Эрвээхэй нисэн одлоо. Чимгээ хойноос нь харсаар л байв. Хүслийн эрвээхэй...Сонин оо! Хүслийн эрвээхэйтэй бол Чимгээ юу эсийг бүтээх вэ. Нисэн одож яваа эрвээхэй гэв гэнэт эргэж ирээд гар дээр нь суун хүний хэлээр:

-Чимгээ чамд юу хэрэгтэй вэ? гэвэл Чимгээ яах вэ?

Чимгээ эхлээд л амттайгаас амттай мөхөөлдөстэй болохсон гэж бодлоо. Зоо нуруу халаасан

Энэ наранд ам нь их цангаж байв.

-Үгүй, үгүй, тийм өчүүхэн зүйлийг яалаа гэж хүслийн эрвээхэйгээс гуйх вэ. Багш юу гэдэг билээ? Аа тийм «Хүсэл бол агуу их юмыг бүтээнэ» гэдэг шүү дээ. Бас үүн дээр ээжийн хэлдэг үг бий. «Амиа бодвол шившиг». Тийм эрвээхэйтэй бол давын өмнө, нэг чарга түлээ л эмээгийнхээ гадаа буулгаж өгнө. Яагаад вэ гэвэл, эмээ байсхийгээд л түлшгүй болчихдог шүү дээ. Жаахан эрвээхэй тийм их түлээ даахгүй бол яана? үгүй, дааж л таарна. Яагаад вэ гэвэл идтэй шидтэй юм чинь...

Чимгээ ийнхүү бодсоор бослоо. Угаасан юмаа ч эвхэж авлаа. Ээж аав нь ажлаас ирэх ч дөхсөн байв. Суман дээр олон албан газар байдаг. Чимгээгийн аав нь тэр хамгийн хойд талын байшингаас ирнэ. Тэр нь бол эмнэлэг. Ээж нь сумын контороос ирнэ.

Чимгээ аав, ээжийгээ ирэхэд халуун дай чанаад, бас оройн хоолонд хийх гурилаа элдчихсэн байлаа. Түүнд хүслийн эрвээхэй тусалсан юм уу, бүү мэд...

«Тэгвэл яах бол оо?» Энэ бол Тогоогийн үг шүү дээ.

Цэцэрлэг тарснаас хойш Тогоо ээж ааваасаа яльгүй зэмлэл авсан олохоор одоо ёстой л мундаг үйлс бодож олохоор шийджээ. Ээж нь гуанзанд тогооч болохоор эртээ гэгч яваад А өгнө. Аав нь даргын машиныг жолооддог тул мөн бас мөддөө / ирэхгүй.

-Чи голоос бургас түүхийг бодоорой, түлээгүй болох нь байна шүү! гэж ээж нь өглөө явахдаа хэлэв.

Тогоо шуудай авч Баяраагийн очлоо. Харин Баяраа ердөө л цэцэрлэгийн бяцхан жаал шиг дүү нартайгаа савангийн хөөсөөр тоглож байв.

-Баяр аа! гэж Тогоо дуудав. Нэмэр алга. Баяраа өвдгөн дээрээ суун бөхийж, хоёр жаалын хамт хөөсөөр бөмбөлөг хийх үзэж алдаж байлаа.

-Баяр аа!

Баяраа сая л нэг сонсож ухасхийн босов.

-Өө чи юм уу, яах гэж?

-Уулзъя.

Хоёр найз хашааны буланд уулзлаа.

-Чи юу хийж байна? Сонин юм бодож олов уу?

-Үгүй... Аа чи?

-Хоёулаа түлээнд явья. Гол уруу очъё, загас барья! гэж Тогоо -Тэгье

Баяраа шуудай авч хоёулаа гол уруу явав.

Нартай дулаахан өдөр байлаа. Сумын төв дайран өнгөрдөг их замаар машинууд давхилдана. Тэр машинууд Элст хоолойд барих нэгэн том уурхайн ачаа зөөж байв. Хүүхдүүдийг зам дөнгөж өнгөртөл нэгэн сонин гялгар юм нүдэнд гялсхийн харагдав.

-Юу вэ?

-Аль?

-Яагаав, тэр гялгар цагаан.

-Хоёр найзыг хүрч очиход ногоон дээр маш гоё гялгар өнгөтэй ноосны өөдөс хэвтэж байлаа.

Тогоо түүнийг алган дээрээ болгоомжтой нь аргагүй тавив. -Ямар гоё ноос вэ!

-Юуных юм болоо?

-Наранд солонгорч байна гээч! гэлцлээ. Л

Хорвоод ховор чухал нандин юм олсондоо хэн хэн нь баяртай болов.

-Энэ лав хонины ноос байх гэж Тогоо хэлэв. -Үгүй, хялгастай төстэй юм. -Ямааны хялгас юм уу?

-Бишээ, ямааны хялгас үүнээс чинь дор, мэдэв үү? Ийм солонгорсон өнгө гарахгүй. Энэ лав шөнө гэрэлтдэг байгаа даа. -Нээрээ шөнө гэрэлтдэг байвал мөн гоё оо! -Үгүй, энэ чинь галт шувууны өд байх гэж Тогоо хэлэв. -Ямар галт шувуу?

-Яагаав дээ, өнөөх бөхтэй морьхон гэдэг кинонд гардаг...

-Еэ! Тэгвэл чи галт шувуу манай оронд байдаг гэх нь үү?

-Юумыг яаж мэдэх вэ. Нээрээ хүн танихгүй мэдэхгүй галт шувуу гэв гэнэт гараад ирсэн бол яах юм? Түүнийг нээж олбол ёстой гавьяа!

-Тэгвэл хоёулаа галт шувууг олж нээх үү?

-Тэгье!

-Яаж?

-Яах юу байх вэ, яг л кинонд гардаг шиг, шөнө гадаа хүлээгээд л байна.

-Эсвэл өвөөгийн ярьдаг үлгэрийн хангарьд шувууных юм болов уу?

-Тэр чинь гэрэлтэй юм уу?

-Ид шидтэй болохоороо гэрэлтэй л байж таарна.

-За тэгвэл өнөө шөнө хоёулаа галт шувуу барья. Тэгэх үү?

-Тэгье.

Шөнийн харанхуй дундуур орчныг гэрэлтүүлэн буух галт шувууд тэр хоёрын сэтгэлд бууж ирлээ. Тийм шувууг барьж эс чадлаа гэхэд ядаж нэг өдийг нь зулгааж авсан ч нээлт шүү дээ. Тэр өд нь тэгээд яг л үлгэрт гардаг шиг гарт шөнө гэрэлтэж байвал мөн сайхнаа! Хэрэв тийм өдтэй болбол юуны түрүүн А Хуягаа багшдаа л тэд үзүүлнэ. Хуягаа багш толгойгий нь илж: /

-Зүйтэй, би бүр Тогоо, Баяраа хоёрыг байгалийнхаа буланд ийм сайхан юм олж өгнө гэж мэдээд байсан юмаа гэнэ.

Тэр гэрэлт өднүүд «байгалийн буланд» гэрэлтэж, хүүхдүүд мань хоёрыг ихэд атаархан харж байгаа шигээр тэд дүрслэн бодоцгоогоод их урам зоригтой болов.

Гол дээрээс хүүхдүүд маш түргэн эргэж ирэв. Хэдийгээр шугуй бургасаар явах ч сайхан, тэнд өдөржингөө барьсан ч загас элбэг байсан боловч тэр хоёр гэр рүүгээ л яарлаа. Шөнийг тэсэж ядан хүлээв. Харин шөнө хоёул мөнөөхөн гайхамшигт эрдэнэ болох, солонгорон харагдах ноос байсан газарт сэм очиж, галт шувууг барихаар отоцгоов. Тэр үнэт эрдэнээ тэд, гялгар уутанд хийж хадгалсан билээ. Гайхалтай нь тэр эрдэнээс ямар ч гэрэл туяа гарсангүй боловч мань хоёр ер гугарсангүй, учир нь зам дээр удаж бороонд нурууд ч юмуу, гэрэл нь үхсэн байж болох л доо.

Шүүдэр унаж эхэллээ. Машиныуд ч цөөрлөө. Айлын ноход хуцах нь цөөрч, сумын төвийн айлуудын гэрэл унтарч эхлэв. Гэвч галт шувуу үзэгдсэнгүй. Од бүрхсэн тэнгэр, эргэн тойрны харанхуй уул, ямар нэгэн юм хүлээсэн мэт аниргүй тайван боллоо.

Одоо л гараад ирэх байх гэж хоёр жаал хүлээв. Тэгтэл, ер хавь ойрыг гэрэлтүүлсэн галт шувуу ч үзэгдсэнгүй, дуу шуугиан ч гарсангүй, оронд нь ердийн нэг ялаа нисэхтэй адил дуу гарч нэг хачин амьтан хөх дөл гарган ниссээр ногоон дээр буух нь дуулдлаа.

Хоёр жаал ч ухасхийв. Хөх дөлт амьтан ногоон дээр зөөлхөн явж байв.

Баяраа авч алган дээрээ тавилаа. Тэр бол цог хорхой байв. Энэ шөнө галт шувууд ирсэнгүй, маргааш нь ч бас үзэгдсэнгүй. Ямар гайхалтай хэрэг вэ?!

-Энэ угаасаа галт шувууны өд биш байх. Тийм шувуу үлгэрт л гардгаас биш, манай Монгол оронд байхгүй ч юм билүү гэж Л эцэст Баяраагийн урам хугарав.

-Тэгвэл энэ юу вэ? Энэ чинь ямар нэгэн амьтны л үс байхаас зайлахгүй шүү дээ гэж Тогоо үл цөхөрнө.

-Хүүе, би бодож оллоо. Энэ лав ямааных байх. Тэгэхлээр байна шүү, нэг мундаг юм хийе. Хоёулаа Дамбий өвөөгийн ямааны ноолуурыг ялгаж туслая, тэр ноолуурт нь хялгас ихтэй байдаг болохоор өвөө өдөржингөө хялгасыг нь түүх гэж ядардаг шүү дээ. Ямар нэг ухаантай

хүүхэд биднээс түрүүн ямааны ноолуурыг усанд хийгээд ноолуурыг ялгах арга олсон байж таарлаа. Тэгээд хялгас нь ийм гоё өнгөтэй болсон байх гэж Баяраа ярив.

-Тэгвэл хоёулаа үзэх үү? гэж Тогоо шохорхов.

-Тэгье. Яг мөн дөө. Чи харж л байгаарай!...

Хоёр жаал сумын хойд энгэрт байдаг Дамбий гуайнх уруу гүйлдэн очив. Өвөө ч яахав дээ, гэрийнхээ сүүдэрт гудас дэвсчихээд л ямааны ноолуураас хялгасыг нь нэг нэгээр түүж байв.

-Өвөө, өвөө!

-За хүүхдүүд юу гэж яваа вэ? Тараг уух уу? Тэгвэл гэрт ор, эмээ нь байгаа гэж өвөө нүднийхээ шилэн дээгүүр харж хэлэв. -Үгүй, үгүй, Тараг уухгүй. Зүгээр л...гэснээ Баяраа -Чи хэл! гэж Тогоог тохойгоороо ёвров. -Үгүй чи...Тогоо ухарлаа. -Бид хоёр танд туслах гэсэн юм.

Ямааны ноолуураас хялгасыг нь ялгах маш мэргэн арга олсон юм байхгүй юу, та үүнийг хар л даа ямааны хялгас шүү дээ? гэж Баяраа өнөөх гялгар уутанд хийсэн гоё үсээ гаргаж ирлээ. Өвөө хялгасыг гар дээрээ тавьж үзсэнээ:

-Яг ийм болно гэнээ?

-Тийм ээ, яг ийм.

-Тэгээд яаж яг ийм болгох юм бэ дээ? А

-Усанд хийхгүй юу, хялгас нь хүнд болохоор дороо тунана, / ноолуур нь хөнгөн болохоор дээр нь хөвнө... -Ха ха ха! гэж өвөө инээв. Хоёр жаал бие бие рүүгээ гайхан харлаа. -Тэгээд та хоёр надад туслахсан гэж бодсон юм уу? -Яг тийм.

За тэгвэл яахав, май! Усанд хийгээд үзвэл үз! гээд өвөө нэг атга ноолуур өгөөд

-Тэр түмпэн байна, ганд ус бий гэв.

Хэдийгээр өвөө тэгж хэлэхдээ нэлээд ёжтой инээмсэглэж байсан боловч хоёр жаал ер ажигласангүй, шууд л түмпэн авч ус хийлээ. Тэгээд мөнөөх атга ноолуурыг усанд хутгав.

Өвөө инээмсэглэсээр дэргэд нь ирлээ. Юун хялгас усанд тунахтай мантай, бүгдээрээ л норсон хачин юм болоод авах хэцүү байх хэцүү юм болов.

-Ха ха ха! гэж өвөө инээсээр байв.

Бүр нулимсаа гаргаж нүднийхээ шилийг хүртэл аваад ханцуйгаар нүүрээ арчин -Ха ха ха! гэж инээв.

Баяраа бүр ч сандарчээ, тэр ноолуурыг хутгаж усан дотор задалж үзсэн боловч ноолуур хялгаснаас салсангүй. Тэгээд хамаг хөлс нь цутгаж гарлаа. Ха ха ха! гэж өвөө инээж инээж:

-Юу болоод байнаа? гэсээр эмгэнээ ирэхэд:

-Эд маань надад тус болж байгааг нь хараач! гэв.

-Энэ чинь одоо юу вэ, та минь! Ноолуураа усанд хийчихсэн юм уу даа, ээ мөн хөгийн улс аа. Зөнөг, тэнэг нийлсэн хэдэн хүн байх шив дээ зайлуул гэж эмгэн хэлэв.

-За боль, боль. Наадах чинь болохгүй. Та нарын авчирсан юм чинь шилэн хөвөн байхгүй юу. Энэ хөвөнгөөр Элстийн уурхайн барилгад дулаалга хийдэг юм билээ л дээ. Тэгээд л машинаас унахгүй юу даа гэж өвөө сая инээхээ болиод хэлэв.

-Нээрээ юу?

-Нээрээ байлгүй яах вэ. Би та нарт сүүлд уурхай орохдоо Л авчирч өгсөн ч болно... Өвөөдөө тусалъя гэсэн чинь сайн л даа. Ер нь мөрөөдөх сайхан шүү. Одоо гэрт орцгоо тараг ууцгаа! гэж өвөө тэдний толгойг иллээ.

5. Цирк

Холын энэ суманд цирк үзнэ гэдэг ямар их сайхан үйл явдал болдог бишээ. Цирк маргааш ирж тоглоно гэж хэн нэг нь хүүхдэдээ хэлсэн юм байж. Тэр сонссон хүүхэд нөгөөдөө хэлж, нөгөө нь гуравдахдаа хэлэх зэргээр тэр дороо л сумын төвийн бүх хүүхэд мэдлээ. Циркэд том баавгай, ууртай арслан, хөгжөөнтэй сармагчин бий гэнэ.

Хамгийн гол нь элэг хөшөөмөөр инээдтэй алиалагч байна гэнэ.

Хүүхдүүд түүнийг үзэхсэн гэхээс тэсэж ядаж байв. Харин тэгсэн чинь цирк ирж чадахгүй, учир нь гэвэл Элст хотгорын уурхай дээр машин нь эвдэрсэн гэж маргааш нь дуулдлаа.

Хүүхдүүд Төмөр ахынх уруу гүйлдлээ. Төмөр ах дөнгөж ирчихээд гаднаа гараа угааж байв.

-За юу болох нь энэ вэ? Ямар олон хүүхэд вэ? гэж Төмөр ах нуурээ арчингаа гайхав.

-Төмөр ах аа, цирк авчирч өгөөч!

-Цирк...Ямар цирк?

-Яагаав дээ. Элст хотгорын уурхайд тоглолт хийж байгаа...Тэдний машин эвдэрсэн гэнэ...

-Тэдэнд баавгай бас ууртай арслан, хөгжөөнтэй жаахан сармагчин бий, бас алиалдаг ах яваа...Яваад өг л дөө!

Төмөр ах инээмсэглэн хэлсэн нь:

-Явж болох л юм. Явахгүй ч байж бас болно. Яагаад вэ гэвэл, хүүхдүүд та нарын дунд машины дугуй дор хадаас гозойлгон шивж хорлодог муу хүүхэд байна. Түүнийг хүүхдүүд та нар олоод өг л дөө. Хэрэв тийм хатуу тоглоомтой хүүхдийг л олоход туслах юм бол явж болох юм.

Хүүхдүүд бие бие рүүгээ харав. Тэнд Чимгээ, Баяраа, Сүхээ, А Дэмбээ бас бус зөндөө хүүхэд байлаа. Үгүй, бие биесийг хараад / л тэдний дунд хорлогчин амьтан алга гэдгийг мэдэв. Харин бүгдээрээ тэд Төмөр ахын хэлсэн үл бүтэх амьтантай тэмцэхэд бэлэн, чухам тэмцэхийн тулд бүгдээрээ нэг санаатай болсон нь илт байв.

-Бид тэр хүүхдийг олно! гэж Баяраа хэлэв.

-Нээрээ шүү ах аа, бид олно. Яагаад вэ гэвэл бид ерөөсөө юм мэдэхгүй гэж Чимгээ дэмжлээ.

Төмөр ах хүүхдүүдийн шийдэмгий царайг хараад

-За яахав, тийм болог. Би явж цирк авчирья гэв.

-Ура! гэж хүүхдүүд баярлалдав.

-Та нар явцгаа, тарцгаа! Би цайгаа ууна. Дараа нь бензин тос авна. Тэгээд л хөдөлнө дөө гээд Төмөр ах гэртээ оров.

Хүүхдүүд тарах гэсэн боловч нэгэн зүйлд хоргодон явж чадахгүй байна. Магадгүй Төмөр ахыг хөдлөөд явахлаар ч сэтгэл нь амрах юм уу. Тэгтэл «Хүүхэд» гэсэн үг тэр олон жаахан хүнийг нэгтгэсэн нэг нэр билээ. Тэр хүүхэд гэсэн нэрийг хөөдсөн муу амьтан нэг байж, том хүмүүс тэгээд хүүхдүүдэд итгэхгүй байгаа шиг жаалуудад санагдсаар байлаа.

Удсангүй Төмөр ах гарч ирэв. Тэр асар том ЗИЛ—130 машиныхаа бүхээгт оров. Тэгээд асааж хөдөллөө. Тэгтэл юу болсон гэж сана. Гэв гэнэт хүчтэйгээр тэсрэх чимээ гарч нэг дугуй нь харсаар байтал шалчийв. Төмөр ах тоормос дараад зогсож ууртай гарч ирлээ.

Хүүхдүүд машин уруу гүйлдэн очив.

-За харж байгаа биз дээ? гэсэн шиг Төмөр ах дугуй руугаа харчихаад хүүхдүүдэд нүдээрээ заав. Хүүхдүүд ичсэн мэт доошоо тонгойлоо.

-Одоо яая гэх вэ, хагархай дугуйтай явж болох биш.

-Ах аа, би туслах уу? гэж Баяраа дөхөж очоод аяархан хэлэв.

-Би ч гэсэн хийлэлцэж өгье! гэж Сүхээ хэллээ. Энэ хүүхдүүдэд ямар ч буруугүйг Төмөр ах мэдэж байсан болохоор дуугүйхэн л түлхүүр авч, гар хүрэх төдийд эсгэмээр хурцалсан богино хадаас дугуйнд лав шигдэж орсныг бахиар сугалан гарган ирээд Л хэлсэн нь:

-Та нар энэ хэрэг хийсэн хүүхдийг заавал олж өгнө шүү. Хадаас зориуд хурцалсан байна шүү. Энэ явдал өчигдрөөс л эхэлсэн юм. Сүндэв гуайн тэрэг аймаг явах гэж байгаад хагарч, минийх энүүнтэй гурав дахь удаагаа болов. Энэ бол хатуу тоглоом шүү. Өнөөх цирк авчрах ч өнгөрлөө! гэв.

Хүүхдүүд тэгэхэд урам нь ямар их хугарсан гэж санана. Үнэндээ л энэ дугуй хагарсан нь хүүхдийн л хийсэн ажил гарцаагүй шүү дээ. Тэгвэл хүүхэд гэдэг нэр тэнд байгаа бүх жаалтай холбоотой болохоор хэн нэг муу хүний балаг тэр бүх сайн санаатай жаалуудын нэрийг баллаж чаддаг юм байх нь ээ.

Хүүхдүүдийн урам хугарсан байдлыг, хараад Төмөр ах:

-За яахав би илүү дугуйгаа тавиад явъя, цирк авчирна шүү гэлээ.

Хүүхдүүд тэгэхэд хичнээн их баярласан гээ.

Хүн сайн сайхан үйлсэд баярладаг байхад бас хүн жигшмээр муухай юм хийчихээд баярладаг хүүхэд байх юм даа. Хэрэв л би тэр хүүхдүүд дунд байсан бол тэр муухай амьтанг олохын тулд дор нь хөөцөлдөх байсан юм.

Далд газраас Төмөр ахын дугуйг писхийн хагарахыг дуулж ухаангүй тэнэгээр баярласан хүн бол Жамц байлаа. Түүнд хагарсан дугуйны дуу писс сс... гээд үнэхээр тааламжтай сонсогдох

ажээ. Жамцад чухам үзүүрлэсэн хадаасан дээгүүр нь явж, хагарсан дугуйны дуу л сонин байсан болохоос биш, тэр машин ямар ажилд явах, тэгээд хүмүүс яаж хохирох нь огтхон ч хамаагүй байжээ. Жамц өчүүхэн зүрхэндээ ихэд баяртай зугтан одов. Жамц хийх ажилгүй, үерхэх найзгүй ихэд гунигтай байв. Хүүхдүүд түүнээс зугтдаг болжээ. Эцэст тэр өөрийгөө зугаацуулах сонин юм бодож олсон нь тэр. Энэ чинь тэгээд хүсэл мөрөөдөл үү? Огтхон ч биш. Жамцын энэ сонин гэгдэх тоглоомыг Чимгээгийн хүслийн эрвээхэй. Баяраа, Тогоо хоёрын галт шувуутай зүйрлэх ч юм алга шүү дээ. Энэ бол А зөвхөн амиа бодсон хүүхдийн арчаагүй муухай тоглоом байлаа. /

Төмөр ах яваад өгөв. Түүний машины тоос доод хөндий уруу хуйлран орохыг харсаар хүүхдүүд үлдлээ.

Одоо цирк ирнэ. Сайхан тоглолтоо эхэлнэ. Хүүхдүүд урд өмнө үзээгүй, ёстой амьд баавгай, арслан, сармагчинг ойрхноос харах болно.

Бас туйлын хөгжилтэй алиалагчийг харж элгээ хөштөл хөхөрцгөөнө. Тэгтэл хэн нэгний нь санаанд, өнөөх хорлогчин циркийн машины дугуйг цоолж аюул таривал яах вэ гэсэн нэгэн бодол харван оров.

-Нээрээ тэгвэл яах юм бэ?

-Бас л бидний нэр гарна шүү дээ.

-Халиун сумын хүүхдүүд л....гэж ярина шүү дээ.

-Хүүхдүүд ээ тэр муухай амьтныг олъё! гэж Чимгээ хэлэв.

-Нээрээ тэгье.

Хүүхдүүдийн бодсоноор л олдчих амархан юм гэж хаана байх вэ. -Хүүхдүүд циркийн машиныг ээлжээр харж, ээлжээр цирк үзэхээр болов.

Төмөр ах ямар сайн хүн бэ?

Орой нь цирк ирлээ. Сумын клубын хашаан дотор Төмөр ахын машинаас тоглолтод хэрэглэх зүйлийг буулгаж, өөр нэг автобус, бас амьтан ачсан уртаас урт бүхээгтэй машин зогсож байв.

Хүүхдүүд хэзээний зангаараа юмыг нь зөөлцөн гүйлдэж, зарим нь «бид чадна» гэж гуйсаар байгаад зарлалыг нь наахаар явав. Эхлээд тэд дэлгүүрийн үүдэнд наалаа. Ойр хавь хүн байхгүй байсан боловч Сүхээ, Баяраа хоёр зарлалаа чанга дуугаар уншив.

«Зарлал. Өнөө орой сумын клубт улсын циркийн тоглолт болно, Дүүжин дээр харайгчид, ид шидийн үсрэлт үзэж, сургуультай баавгай, арслан сармагчинг сонирхоно. Та бүхэнд нэрт алиалагч Намхай инээдмээр хөгжөөнө».

Хүүхдийн цангинасан хоолойгоор зэрэг уншсан энэ зарлалыг хажуугаар нь явсан хэсэг морьтой хүн сонсоод «Юу гэнээ? Цирк Л ирж гэнээ?» гэсээр ойртов.

Дараа нь Сүхээ, Баяраа хоёр зарлалыг гуанзны үүдэнд наагаа мөн чанга дуугаар унших зэргээр бүгдийг энд тэнд наав.

Цирк оройтож ирсэн боловч тэр дороо тайзаа бэлдэж тоглоход бэлэн болжээ. Тэгсэн чинь үзэгчид байдаггүй.

-Хүмүүс яагаад алга байна? Зарлал наасан уу? гэж дарга нь гайхав.

-Наасан. Бид хоёр наасан гэж Сүхээ, Баяраа хоёр зохион байгуулагчийн өмнөөс зэрэг хариулав.

-Сайн байна. Тэгээд яагаад хүмүүс ирдэггүй билээ? Эсвэл танай эндхийхэн цирк үзэх дургүй юм уу?

-Дуртай,

-Тэгээд! Алив хөө, надтай яв, зарлалаа яаж наасныг харья гэж дарга хэлэв.

Хоёр жаал даргыг дагуулан дэлгүүрийн үүдэнд ирлээ. Тэгсэн чин зарлалын нь дээрээс баахан шавар шидэж муухай болгоод 18 цагаас гэснийг нь юу ч үгүй баллаж орхисон байв.

-Энэ юу болж байна?

Хоёр жаал юу ч хэлж чадсангүй.

-Өөр хаана наасан гэлээ?

-Гуанзны тэнд, бас эмийн сангийн үүдэнд...гэж өнөө хоёр зовсондоо дорой дуугаар хэлэв. - Очиж үзье.

Тэгтэл гуанзны өмнөх зарлал хэвээр атал, хэн нэгэн хүн «18» гэснийг баллаж «21» болгон зассан байв.

-Хм. Хачин юм даа! Та хоёр битгий зов. Танай энд дүрсгүй хүүхдүүд байдаг шиг байна, тусгүй дээ! гэж дарга хэлээд

-Одоохон та хоёр гүй! Айлуудаар явж цирк одоохон тоглоно гэж зарла! Тэгээд сүүлд нь надтай уулзаарай! гэв.

Хоёр жаал ч гүйлдэн одлоо. Замдаа тэд Чимгээг Дэмбээтэй авч дөрвүүл дөрвөн зүгт гүйлдэв.

Хүмүүс ч цирк үзэхээр цуглаж эхэллээ. А

Ийм үед ямар сэтгэл хөдлөм байдгийг хүүхдүүд андахгүй, / клуб дотроос хөгжим дуугаран, гэрэл чийдэн олон өнгөөр асаж гоёлын хувцастай хүмүүс яаран яаран орсоор л байна.

Хүүхдүүд бүр ч баяртай, тэд улаан хүрэн хөшиг нээгдэхийг тэсэж ядан хүлээнэ. Ийм сэтгэл

догдлом мөчид харин Баяраа гадаа байв. Түүнд машин харах ээлж ноогдсон нь нэгэн талаар бодоход тоогүй юм болжээ. Гэсэн ч Баяраа бол өөдгүй этгээдийг олохсон л гэж бодож байв. Баяраа машинуудын нэгтээ, хаалганаас далд газар зогсож, цирк үзэхээр орогчдыг атаархан харж зогсоно. Тэгтэл гайхалтай юм боллоо. Жамц хүрээд ирэв. Тэр билет шалгагчийн хажуугаар зүтгэлээ.

-Хүүе, жаал аа билет ээ! гэж шалгагч хэлэв.

-Би зарлал наасан шүү дээ гэж Жамц хээв нэг хэллээ.

-Ямар зарлал?

-Яагаав дээ, цирк тоглоно гэсэн зарлалыг...Бас айлуудаар зарласан...

-Тийм үү? гэж гайхаад билет шалгагч

-Чамаас арай л өөр хүүхэд байсан шиг санагдах юм. Мөн л юм биз дээ. За яахав гэв.

Баяраа нууц газраасаа эгээтэй л хашгирсангүй. Тийм зальтай амьтан байх уу даа. Нэг ч удаа зарлал наагаагүй, тэр ч байтугай айлуудад ч хэлээгүй мөртлөө...цирк үзэж явдаг.

Гэвч Баяраа, үл бүтэх этгээдийг олох ёстой байсан болохоор байрнаасаа хөдөлсөн ч үгүй.

Тоглолт эхэллээ. Хөгжим сүртэй сайхнаар нүргэлж гарлаа. Баяраад цирк үзэх хүсэл маш их байв. Тиймээс тэр тэсэж ядан зогссоор л байлаа. Өдийд гоё гялалзсан хувцастай жүжигчид тайзан дээр гарч ирээд элдэв гоё юм үзүүлж байгаа. Магадгүй мундаг илбэ үзүүлж байгаа юм бил үү.

Баяраа зөвхөн, юу гарч байгааг харъя гэж бодлоо. Тэгээд цонхонд ойртож сэм шагайв. Тайзан дээр хүмүүс явж, хоёр эгч жонглёр хэмээх тоглоом тоглож байв. Баяраад тоглолтод ормоор хичнээн их санагдана вэ. Тэр гав ганцаараа энд зогсож т байдаг ямар азгүй юм бэ. А

Баяраа гэв гэнэт уйлж орхив. Тэгээд, энэ азгүй явдал хэн нэг муу хүүхдээс л болсныг сайтар ойлгож авлаа. Хэрэв тэр хүүхэд машины дугуйнд хадаас ивээгүйсэн бол өдийд Баяраа юм үзээд л сууж байх шүү дээ. Маргааш оройны нь тоглолтон дээр Тогоо ээлжинд гарлаа Баяраа, Чимгээд суудал захичихаад Тогоотой хэсэг түр зогсов. Жамц ирлээ. Тэр билет шалгагчид зарлал наасан гэж худал хэлж орох гэхэд нь Баяраа очиж, таныг хуурч мөнгөгүй орсон гэлээ. Жамц тэгэхэд ямар их уурласан гээ. Царай нь улайчихаад тэр эгчийг

- Ямар ичдэггүй жаал вэ? гэж хэлэхээр яваад өгөв.

Баяраа ч орлоо. Энэ өдөр Баяраа цирк үзэж үнэхээр нэг баярлав. Харин Тогоо, бүх хүнийг явсан хойно циркийн машины түүгээр нэг сүүдэгнэсэн юм явахыг харав. Тэр нь өөр юу ч биш, Жамц байлаа. Жамц өнөөх үлдсэн гурван хадаасаа машины дугуй дор босгон тавьж явав. Циркэд оруулаагүй тэр эгчийг шийтгэж чадаж байна гэж Жамц боджээ. Сүхээ ч Жамцыг бариад авлаа. Жамц тэр хоёр дээр дороо орон ноцолдов. Тэдний уурлах дууг тоглолт үзэхээр сая ирсэн Төмөр ах сонсож:

-Юу болоод байна! гэсээр ирлээ.

-Ах аа, энэ Жамц циркийн машины дугуйн дор хадаас... гэтэл Жамц чихийг нь дүлийртэл цохив.

Төмөр ах дор нь л Жамцыг бариад авлаа.

6. «Галт онгоц» сүйрсэн нь

Цирк яваад удлаа. Одоо бол аливаа юманд авирах дуртай Сүхээ ямар нэг гайхамшигт сонин юм бүтээх хүслээ дийлэхээ болив. Уг нь тэр, уулчин больё гэж бодоод ганцаараа нэг өдөр эгц ханан хаданд авирч гарсан удаатай. Тэр хаданд ер явж болохгүй байсан тул хориод алд өгсөөд л буцав. Уулчин болох хүслээс нь юу үлдэв гэвэл гутлынх нь хойд зан ховхорч, өмдний нэг талын өвдөг хуруу хэртэй цоорчээ.

Дараа нь тэр, модонд авирах сургууль хийв. Модны мөчрийг А дамжин явсаар байтал оройд нь ихэд дөхсөн боловч газар руу / хараад толгой нь эргэж эгээтэй л унасангүй, тэгээд арайхийж буув. Ийнхүү бодсон хүссэн бүхэн биелсэнгүй байтал цирк ирэх нь тэр. Сүхээ циркийн тоглолт дотроос тэмээний нуруун дээр зогсох юм уу, гимнастик хийдэг гайхалтай сонин хүнийг ихэд шохоорхлоо. Тэр яг л хүссэн зүйлээ эндээс олох шиг болов. Сүхээ циркчин болно, тэмээг байдгаараа тэшиж хурдалж байхад Сүхээ нуруун дээр нь босоо зогсож явна. Ай мөн гайхалтай яа! Хүмүүс Сүхээгийн тэр гайхамшигт тоглолтыг дахин дахин үзэхсэн гэж гуйна. Жамц бол бүр ч их гуйх байх...

«Машины дугуйнд хадаас шивсэн нь миний буруу. Намайг уучил, өршөө! Гагцхүү гоё тоглолтоо л үзүүлж өгөөч!» гэж Жамц уйлан гуйж байх шиг санагдана. Гэвч сэтгэл дотор байгаа тэр тоглолтыг үнэхээр үнэн болгоход зай их бий. Сүхээ тэмээ хайж эхлэв. Сумын төв хангай газар байрласан болохоор тийм ч олон тэмээ байхгүй юм. Харин мал эмнэлэгт нэг тэмээ бий. Тэр тэмээнд тэрэг хөллөж мал угаалгын газар уруу тос зөөдөг байлаа. Тэргийг Ламжав гуай хөтөлнө. Унтах дуртай, намхан нуруутай хүн юм. Сүхээг хүрч очиход Ламжав гуай тэргэн дээрээ тос ачиж дуусаад дугуйны сүүдэрт түр зуур дугхийх гэж зүүрмэглэж байлаа. Тэмээ нь тэрэгний нөгөө дугуйнаас бурантгаараа уяатай, бохьажилж байгаа юм шиг хивж байв.

-Ламжав гуай, хүүе Ламжав гуай! гэж Сүхээ дуудлаа. Ламжав гуай сэрэх шинж алга.

Сүхээ дуудсаар байж арай гэж өрөөсөн нүдийг ив нээлгэв. Ламжав гуай түр боловч сайхан унтуулахгүй яагаад байна гэсэн шиг зовхио арайхийн өргөж өрөөсөн нүдээрээ түүнийг ажиг.

-Ламжав гуай, би танд тусалъя, тэгэх үү? Та тэмээгээ надад өгчих. Би тосыг чинь угаалгын газар хүргэе гэж Сүхээ гуйв.

-Яана гэнээ хө?

-Би тос зөөх гэсэн юм.

-Уухайс, тэгээд чи чадах юм уу хө?

-Чаднаа. Би өвөөгийн тэмээг унаж үзсэн. Өвөө урьд жинд Л явдаг байсан юм гэнэ билээ.

-За тэгвэл тэгэхээс биш дээ. Тэмээ номхон л доо гэвч юмыг яаж мэдэх вэ, үргэж мэднэ, сайн харж яв. Замаас гарч хэрэггүй. Аль вэ би чамд хөллөөд өгье.

Арван мөчийн дараа Сүхээ тэмээн тэрэг хөтлөөд угаалга уруу явж байв. Тэмээ нь юун жаахан хүү намайг хөтөлдөг билээ? гэсэн шиг Сүхээг үнэрлэж үзнэ. Эхлээд бүх явдал номоороо л боллоо. Үнэндээ ч Сүхээ тэмээнээс айсангүй. Өвөөгийн тэмээг унаж үзсэн гэдэг нь ч үнэн юм байх.

Тэгтэл сүүн тасгийн хажуугаар өнгөртөл гэнэт хэн нэг хүүхэд:

-Аа яа яа! Сүхээ ямар мундаг вэ? гэх дуулдлаа. Харсан чинь Баяраа, Тогоо хоёр зогсож байна,

-Мундаг байгаа биз? гэж Сүхээ онгирмоор санагдаж хэлэв.

-Ёстой мундаг, өнөөх идэр жинчин гэдэг л яг мөн! гэж Баяраа хэлэв.

-Хүүе жинчин гуай тэргэн дээр чинь сууж үзье, болох уу? гэв.

-Болно. Жаахан эвгүй үнэртэй юм. Гэвч тэмээ номхон, унавал, уна! гэж яг эзэн хүн шиг Сүхээ хэлэв.

Баяраа, Тогсо хоёр тэргэн дээр суув. Тэгтэл гуанзны тэнд Чимгээ нэмэгдлээ. Бас Дэмбээ сууж, Сүхээ өөрөө тэмээгээ унахаас өөр аргагүй болов. Сүхээ тэмээний нуруун дээр гарчихаад үнэхээр галт онгоцны ахмад болсон мэт өөрт нь санагдав. Үнэхээр ахмад нь л тэгж гэрэлт тавцан дээр зогсон «Баруун тийш! Зүүн тийш!» гэж командалдаг шиг Сүхээ тэмээний хоёр бөхний дундаас бурантгийг залан:

-Анхаар! Баруун тийш, зүүн тийш! Жолоогоо! гэж цангинатал хашгирав.

-Ямар мундаг вэ! Сүхээ лут байна! гэж Тогоо хашгирлаа.

-Нээрэн үү! гэнгүүтээ Сүхээ гэв гэнэт тэмээний хоёр бөхийн хооронд тэнцэж зогсов. Тэмээ зөөлхөн явж байсан болохоор эхэндээ ч яахав тэслээ л дээ.

-Ёстой мундаг, ямар гайхалтай вэ! гэж нэг нь дуу алдав. А

-Яг циркчин шиг байна шүү. Сүхээ лав тэмээний гүйдэл дунд / зогсож чадах байхаа гэж бас нэг нь хашгирлаа.

-Үзнэ үү, аа? үзвэл, үз л дээ! гээд Сүхээ тэмээгээ гуядав. Тэмээ ер нь тэгж гуядуулж үзээгүй байсан ч юм уу, эсвэл тэгж их өвдсөн үү гэнэт ухасхийв. Тэргэн дээр байсан жаалуудаас нэг нь унаж, Сүхээ тэмээнийхээ хажуу руу холбирон бөөрөн дээр нь дүүжлэгдэв. Тэмээ тэгэхэд миний хажуу бөөрөнд юу үсрээд наалдчихав гэсэн шиг хялайж харснаа гэв гэнэт тонгочин туйлав.

Хүүхдүүд үсрэн унаж, лут Сүхээ ногоон дээр чулуудуулаад «галт онгоц» үнэхээр их далайн давалгаанд автсан мэт дайвалзан хайвалзан эхлэв. Бөмбөгөн дугуйтай тэрэг дээр дээр үсэрч байснаа татлага хүлээсээ зад татан, угаалгын тосыг газраар нэг асгаж, наг мэдэхэд тэрэг газрын хэвгйд онхолдон уналаа.

Ийм ч явдал болох гэж! Ийм ч балаг тарих гэж! Хүмүүс гүйлдэн хүүхэд шуугин, ноход хуцалдаж, сумын төвийнхөн түймэр гарсан мэт л дуу хадаан тэрэгний зүг гүйлдлээ.

Харин ч тэмээ нь номхон тулдаа хол явсангүй тогтов. Тэрэг ч бага эвдэрч, гагцхүү хамаг тос л газраар нэг мэлийн урсаж байв. Тэр тос маш эхүүн үнэртэй байлаа.

Хамаг амьтан цуглаж, тэмээг барьж, тэргийг босгосны хойно Ламжав гуай ирлээ. Нэлээд унтаж, нүд нь улайсан тэр ах гуай, ихэд гүйснээс амьсгаадаж:

-Аа базарваань, юу болох нь энэ вэ. Өнөөх хүү мэнд үү? Ээ тэнгэр минь гээд л үглэж гарлаа.

Сүхээ ийнхүү мөрөөдлөө биелүүлж чадсангүй. Тэр ихэд ичиж, онгирч хөөрснөөсөө болоод тун ч ичмээр явдалд хүрснийгээ санахаас байх суух газраа олж эс чадан хүмүүсээс холдов. Харин Баяраа, Тогоо хоёр тэрэгнээс унасан ногоон дээрээсээ босож, Чимгээг олоод гурвуул хаашаа ч юм, алга болсон Сүхээг олохоор явав. Дараа нь тэр Дэмбээтэй тавуул гол дээр сууж байлаа. Хэн хэн нь мөрөөдлөө биелүүлж чадаагүй, тэр нь дандаа буруу хэрэг болж хувирсныг санаад тэд урамгүй болжээ. Л

-Бид ер нь хүмүүст гайхагдахаар сайхан үйлс бүтээж чадахгүй юм байна. Цэцэрлэг байгуулах гэсэн болоогүй, галт шувуу баригдсангүй, циркчин болох гэсэн нь бүтсэнгүй, одоо яах вэ? гэж Чимгээ хэлэв.

-Нээрээ тийм, өөдгүй юм. Бид нар ер нь муу хүүхдүүд байх. Тэгээд л хүслээ биелүүлж чадахгүй байна. Муу санаатай хүний үйлс бүтдэггүй юм гэж ээж хэлдэг хэмээн Сүхээ хэлэв.

-Тийм биш ээ. Бид эсвэл дэндүү их том юм бодчихоод тэр лут том үйлсээ гэв гэнэт бүтээх гэж бодсоноос л сүйрч байгаа байх. Хуягаа багш, аливаа их том үйл явдал багаас эхэлдэг гэдэг шүү дээ гэж Баяраа хэлэв.

-Үгүй, бид бөөнөөрөө нэг санаагаар нэг чухал юм хийсэнгүй, түүнээс л олж байна. Эвт шаазгай буга барьдаг гэдэг шүү дээ. Эмээ тэгж хэлдэг юм байхгүй юу гэж Тогоо хэлэв. Чухам ямар гоё үйлс бүтээхээ шийдэж чадсангүй тэд буцахаар явлаа.

7. Эвт шаазгай буга барина

Хүүхдүүд сумын төв дээр эргэж ирэв. Шинэхэн байшингийн гадаа нэг машин зогсоод ядарсан өвөө, эмээ хоёр юм буулгаж зөөх гэж зүдэрч байв.

-Хүүхдүүд ээ, энэ айлд тусалъя! гэж Баяраа хэлэв.

-Тэгье!

-Зөөлцөө!

-Өвөө, эмээ бид зөөе! -Ээ буян нь дэлгэр.

Таван хүүхэд цай чанахын зуурт л машин дээрх авдар сав, ор дэрийг буулган зөөж орхилоо.

-Гялайлаа хүүхэд минь, гялайлаа! Зуу насал! -Зүгээр ээ, эмээ!

-Баяртай, өвөө! А

Хүүхдүүд өөрсдөө ч гайхахаар тийм түргэн зөөсөн болохоор / нэг мэдэхэд машин хоосон байхад нь бүр гайхав.

- Ямар хөгийн юм бэ? гэж Баяраа дуу алдлаа.

-Харин тийм. Эвт шаазгай буга барина гэдэг чинь энэ шүү дээ!

-Хүүхдүүд ээ, бид юу ч хийж чадах юм байна. Гагцхүү бид тус тусдаа байгаа, бас хүчээ нэгтгэхгүй, ажилгүй суугаа болохоор л уйдаж байгаа юм байна шүү дээ гэж Тогоо хэлэв.

-За тэгвэл хүчээ нэгтгэе. Аль вэ өөр хийх юм, байна уу?

Тэгтэл шуугилдаж яваа жаалуудын мөр дээр нэг жаахан дүү машиныхаа өрөөсөн дугуйг унагачихаад хийх гэж оролдож ядаж байв.



-Миний дүү яаж байгаа юм бэ? -Машин...

-Машины нь дугуй салаад унаж орхиж. -Засаж өгье!

-Аль вэ, Баяраа, тоглоомыг нь ав, гэр чинь ойр шүү дээ. Сүхээ гүй, бахь эргүүлгүүр авчир!

Хүүхдүүд машиныг нь авч ногоон дээр сууцгаав. Баяраа яг л том машин засах гэж байгаа юм шиг машиныг хажуудуулж тавилаа. Сүхээ ч дорхноо ирлээ.

-Баяраа нөгөө дугуйг нь ав.

-Уухай. Л

-Наад бахиараа голыг нь сайн хавч!

-Бас ачааны нь бүхээгийг төмөр утсаар торгоосон юм байна шүү дээ.

-Одоо дугуйгаа хий! гэхчлэн хүн бүр хэлээд зогсохгүй гар оролцон жижигхэн машиныг засалцав.

-Одоо хүүхдүүд ээ, машиныг нь гялалзтал арчиж өгье. Сүүлд нь манайд бид бүхэн очно. Манайд ийм ногоон будаг зөндөө бий! гэж Чимгээ дугуйг хийсний хойно хэлээд нусныхаа алчуурыг гаргаж тоглоомын машиныг гялалзтал арчлаа. Өнөөх машины эзэн жаалд ихэд баярлав. Хүүхдүүд хөгжөөнтэй сэргэлэн боллоо.

-Ура! Машин зассан!

-Бүгдээрээ зассан шүү дээ! гэж тэд жаахан хүүг машинаа чирэн гэр рүүгээ очихыг харж хэлэв. Үнэхээр тэдний бүгдээрэнгийн нь сэтгэл тэр машиныг засахад тусалжээ. Хэдийгээр энэ ажил өчүүхэн жаахан боловч бүгдээрээ гар хүрсэн юм болохоор хүүхдүүдийн сэтгэлийг ихэд баярлуулав.

-Хүүхдүүд ээ, бүгдээрээ нийлж юм бүтээвэл болдог юм байна. Хүнээс ч нуухгүй өөрийн чадах чинээгээрээ л хүнд тус болбол аятайхан юм байна гэж Чимгээ хэллээ.

-Одоо яах вэ? гэж нэг нь асуув.

Үдэш орой болж, нар далд ороод, хүүхдүүд гадаа ид шуугилдан тоглож байлаа. Сургуулийн хашаа уруу тэд явсаар орцгоов. Зун болж тэнд бужигнаж байсан хүүхдүүд цөм тал тал тийш орцгоожээ. Харин багш нарын байрнаас нэг хүүхэд сонин шохоорхон уншсаар гарч ирлээ.

-Жаал аа сонингоо үзүүлээч! гэж Чимгээ гуйв.

-Үзвэл үз л дээ. Харин би бүр өгөхгүй шүү, яагаад вэ гэвэл энэ сонин дээр загас үржүүлэх зөвлөлгөө байгаа юм гэж тэр жаал хэлэв.

-Загас үржүүлэх ээ?! А

-Тиймээ загасны сав яаж барих, бас, зөгий яаж үржүүлэх /

зэргийг бичсэн байгаа юм...

Хүүхдүүд ихэд сонирхон авч уншив. Үнэхээр тэр сонин дээр

загас хэрхэн үржүүлэх, зөгийг яаж өсгөхийг товч тодорхой

бичсэн байв.

-Хүүхдүүд вэ! Сургуульдаа загастай больё, тэгэх үү? гэж Баяраа хэлэв.

-Зөгий үржүүлбэл дотуур байрны хүүхдүүд зөгийн бал идээд л ёстой гоё доо гэж Сүхээ хэллээ.

-Бал гэнэ ий?! Ямар бал? гэх нэг хүүхдийн дуу гарлаа. Тэр бол Жамц байв. Жамц тэднүүсийг түрүүнээс хойш дагасаар яваа билээ. Тэгэхдээ өөрсдөд нь хэлэхгүй «уугдаж сэм дагажээ. Ер нь эртний явдлаас хойш сумын төвийн бүх хүүхэд Жамцыг үзэж чадахаа байв. Жамц үнэхээр ганцаардаж, уйдаж, хүүхдүүдтэйгээ нийлэхсэн гэхээс бүр зовж гүйцэв. Хүүхдүүд түүнийг хаана ч эелдгээр угтсангүй. Жамц идэх дуртай билээ. Ялангуяа амттай юманд бол онцгой дуртай юм. Тийм ч учраас зөгийн балны тухай сонсоод тэсэж чадсангүй.

-Тийм ээ бал! Зөгийн бал! Хүүхдүүд зөгийн баланд цадах болно. Харин чамд өгөхгүй. Яагаад вэ гэвэл... гэж Сүхээ ууртай хэлэв.

-Байг даа, хөөрхийг! Жамц буруугаа хүлээж байгаа шүү дээ гэж Чимгээ өрөвдөв.

-Муу хүүхэд дутагдлаа бүрэн засаагүй цагт бидний дунд байх эрх байхгүй гэж Дэмбээ хэллээ.

-Тийм шүү. Жамц чи яв, яв!

-Дутагдлаа бүр засчихаад л эргэж ир.

-Би зөгий олж өгье л дээ гэж Жамц гуйв.

Чиний зөгий бидэнд хэрэггүй!

Хүүхдүүд Жамцад үнэхээр их гомджээ. Хэрэв тийм их гомдоогүйсэн бол яалаа гэж хатуу үг хэлэх вэ. Жамц ч тэгээд холдохоос өөр аргагүй боллоо

Хүүхдүүд орой болтол ярьцгаав. Загас үржүүлж, хэд хэдэн сав загас ангидаа тавина. Бас зөгий үржүүлнэ. Тэр зөгийнөөс Л амтат бал авч дотуур байрны жаалуудад өгнө гэх зэргээр хүүхдүүд хийх ажлаа сэтгэлдээ төсөөлцгөөв. Тэгсэн чинь чухамдаа загас гэдэг нь Халиуны голын жараахай биш зориуд өрөө тасалгаанд байлгадаг өөр загас, зөгий ч хээрийн зөгий биш, тэжээмэл тусгай үүлдрийн амьтан байдгийг хүүхдүүд яаж мэдэх билээ.

Жамц хүүхдүүдээс холдож явахдаа «Зөгий барина даа» гэж бодож явлаа. Тэр «хүүхдүүдийн нууцыг мэдсэн шүү дээ» гэж бодон «Намайг хөөгөөд байгаа бол би хорондоо тэр зөгийг нь тэднээс өмнө үржүүлж балыг нь авна даа!» гэж шийдлээ.

Маргааш өглөө нь яагаа ч, үгүй эрт Жамц зөгий олохоор явлаа. Тэр ойд очиж, ноднин намар

олон зөгий эргэлдэж байсан өмх хөгшин модонд хүрэв. Тэр модонд бөөрөнхий бөөрөнхий цагаан юм байлаа. Зөгийнүүд тэр цагаан юмнаас гарч орж байв. Энэ үүр нь байх. Хэрэв үүрийг нь аваад явбал зөгийнүүд аяндаа хойноос дагахгүй хаашаа зайлах вэ гэж Жамц бодлоо. Тэгээд зөгийнний үүрэнд дөнгөж хүрэв үү, үгүй юу бөөн аюул болов. Үй олон зөгий, дүнгэнэн нисч гар хуруу хүзүү хоолойны энд тэндгүй хатгав. Жамц айж зугтаагаад ч нэмэр болсонгүй. Жамц зөгийд идүүлж гүйцлээ. Тэр эцэст Халиуны гол уруу харайн орлоо. Маргааш нь Жамц нүүр ам нь боолттой гэртээ хэвтэж байлаа.

-Үгүй ер дөө, ингэх гэж. Юуны чинь зөгий! Юуны чинь бал! Ингэсээр хоронд нь хордож үхвэл яана! Ээ элээ минь, халаг минь! гэж ээж нь түүний хавдар дээр тараг түрхэн үглэж суулаа.

8. Монгон шүүдэр

Нэгэн өдөр хүүхдүүд маш сонин зүйлийг үзэв. ^

Сумын хүүхдийн цэцэрлэгийн өмнө хашаан дотор барилгачин хоёр ах ямар нэгэн сонирхолтой юм хийж байлаа.

-Ах аа, ах аа юу хийж байгаа юм бэ? гэж хүүхдүүд тэнд өрсөн дугуй хэлбэртэй зүйл, хажууд нь зуурч буй шаврыг харан гайхан асуув.

-Яах нь вэ?

-Хэл л дээ ах аа.

Хүүхдүүдийн ихэд сонирхсон царайг хараад хоёр ах бие бие рүүгээ инээмсэглэн харж:

-Энд маш сайхан юм хийнэ. Харин та нар тусалбал зүгээрсэн. Хэзээ ч билээ дээ. Энэ зун л юмдаг хэдэн хүүхэд «дүү нартаа туслах» бүлэг гэдгийг байгуулсан юм гэнэ билээ. Тэр бүлэг даанч эвгүй юм хийж хүүхдүүдийг гэрээс нь оргуулж байсан боловч угтаа бол сайхан үйлс бүтээх гэсэн юм билээ л дээ.

Бид бас хүүхдүүдэд тустай юм хийх үүрэг авсан улс л даа. Цэцэрлэгийн жаахан дүү нарыг цэнгүүлэхийн тулд манай барилгынхан эднийхийг тохижуулж өгнө гэсэн юм. Тэгтэл юуны түрүүн усан оргилуур барих гэж оролдож байгаа маань энэ. Хэрэв бидэнд тусалж, голоос ус зөөх юм бол та нар бас л ялгаагүй энэ ажлыг хийлцлээ гэсэн үг шүү дээ! гэж нэг ах хэлэв.

-Усан оргилуур гэнэ ий?

-Тийм ээ, усан оргилуур! Бас цэцэг тарина. Тоглоомын хөөрхөн талбай барина.

-Ямар гоё вэ! Бид цөмөөрөө тэр ажилд туслалцвал болох уу?

-Бололгүй яахав, за хүүхдүүд ээ голоос ус зөө!

Хүүхдүүдэд ийм ажил л хэрэгтэй байсан юм. Тийм ч учраас хүүхдүүд маш их хөгжөөн

шуугиантайгаар ус зөөхөөр гол уруу хувин авч гүйлдлээ.

Замдаа Баяраа хэлэх нь:

-Хүүхдүүд ээ! Тэр усан оргилуурын нь дотор загас явж байвал мөн гоёо! Л

-Нээрээ тийм шүү, загас барья. Тэгээд усан оргилуурын усан дотор загас явж байг! Хүүхдүүд хараад л...

-Ерөөсөө сонинд загас үржүүл гэсэн шүү дээ.

Тэд өдөржингөө ус зөөв. Зарим нь шавар зуурахад тусалж бас зарим нь чулуугаар дугуй хана өрөхөд гарч хүрч үзэж байв. Орой нь тавуулаа Халиуны гол уруу явлаа. Хэдийгээр ганцхан дэгээтэй байсан боловч тэд загас барихаар шийдсэн байв.

Баяраа тэр дэгээг гол уруу шидчихээд үнэхээр мундаг загасчин шиг ихэд анхааран харж зогслоо. Бусад нь тээр тэнд хүлээн зогсоно. Загас санаснаар амархан баригдсангүй. Сүхээ бүр сүүлдээ уйдаж гүйцээд:

-Хүүхдүүд ээ, ерөөсөө ингэж дэмий зогсоод яах юм бэ. Жараахай барья л даа гэж гуйв.

-Яаж?

-Яахав дээ нэг юмаар л шүүхгүй юу, тийм нэг даавуугаар... өмдөөрөө шүүсэн ч яадаг юм!

-Ха ха ха! гэж хүүхдүүд инээлдэв.

-Татаарай, татаарай! гэж тэндээс Баяраа хашгирлаа. Үнэхээр нэг мундаг загас дэгээнд нь орсон мэт тэр гэдэргээ цахлан хүчтэй угзарч байв. Дэгээнд нь нэг юм тээглэсэн бололтой.

-Дэгээ чинь модонд орооцолдсон юм биш биз дээ? гэж Тогоо асуув.

-Үгүй, үгүй, тун саяхан хөдөлсөн, намайг чангаасан гэж Баяраа сүртэй хэлэв.

Хүүхдүүд дэгээний оосроос хүчлэн чангаав. Тэгсэн чинь загасны оронд харин нэгэн том хар үндэс оосорт нь орооцолдсоор гарч ирэх нь тэр.

-Түй, яадаг муу хог вэ! гэж Баяраа дуу алдав. Хүүхдүүдийг эргэн харахад харин Сүхээ цамцаа тайлан жараахай шүүхээр бөхийж байв.

-Жараахай барья. Хүүхдүүд ээ, ерөөсөө том загасаар яах А юм бэ. Жараахай бол жижигхэн, бага усанд л таарна гэж нэг нь / хэлснээр бүгд Сүхээ рүү очлоо.

Тэд орой болтол жараахай шүүв. Энэ ажил үнэхээр хөгжөөнтэй байлаа. Жараахайг хоёр нь үргээнэ хоёр нь цамцыг дэлгэн барьж усан дотор зогсож хүлээнэ. Жараахай нөгөө хоёроос үргэж бөөнөөрөө гол уруудан, урсгал дагаж ирэх бөгөөд тийм бөөн жараахайг цамцан дээгүүр өнгөрмөгц л Сүхээ, Баяраа хоёр тороо дээш өргөнө. Тэгэхэд нэг юм уу, хоёр жараахай

заавал баригддаг билээ. Чимгээ бол зөвхөн тэдний барихыг харж л:

-Яанаа, ирлээ! Цамцаа өргөөч дээ! гэж дуу алдах л ажилтай байв. Барьсан жараахайгаа жимсний шүүсний том шилэнд хийлээ.

Үдэш орой боллоо. Гэвч хүүхдүүд явахыг хүссэнгүй. Голын эрэг дээр түүдэг асаан шөнө жараахай барих юм болов.

Хэрэв ойн цагдаа Чүлтэм гуай ирж гал түлэв гэж зэмлээгүйсэн бол тэд шөнө дөл болтол суух байв. Нөгөөтэйгүүр хэн нь ч билээ, нэг нь агаар дутаж, ус нь багадсанаас муужран алдаж буй шилтэй жараахайг хараад

-Хүүхдүүд ээ, эд нар чинь цөмөөрөө үхэж байна! гэж дуу алдсан юмсанж.

-Нээрээ тийм байна. Одоо яах вэ?

-Хараач! Нэгний нь цагаан өехий дээшээ харчихлаа гэж дуу алдацгаав.

-Усанд нь буцааж тавья. -Нээрээ тэгье

-Усан оргилуурыг барьсан хойно жараахайг шууд барьсан дороо л аваачиж хийе гэлцэв.

Усан оргилуур ч удахгүй бэлэн боллоо. Нэг сайхан өглөө тэр оргилуур ажиллаж хүүхдүүдийг харсаар байтал олон өнгөөр солонгорох усан дуслууд нь үзэсгэлэн төгс цацарч эхлэв. Тэр дуслууд яг л мөнгөн шүүдэр шиг цэвэр тунгалаг байлаа.

Хүүхдийн сэтгэл ч тэр мөнгөн шүүдэр шиг тунгалаг дэвэр юм. /

Хэрэв тиймгүй бол тэр оргилуурын доод биенээ усан дотор жараахай хөвж, тэр оргилуур тийм амархан бүтэх ч үгүй байсан биз. Одоохондоо энд жараахай л байна. Цаашдаа өнгийн чулуу, жинхэнэ суурин газрын олон өнгөт загас тэнд бүжиглэн тоглох ч юм уу хэн мэдэх вэ.

Тэд мөрөөдөлд дуртай юм. Мөрөөдөл нь талаар өнгөрөхгүй...

1976 он

<Tv>

\

ГАРЧИГ /

Өмнөх үг 3

Зоригтой хүү /1981/ 9

Зудын жил 37

Аав цэцэрлэгт орсон нь 69

Түн түн-пин пан буюу ойн дээрэмчид /1976/ 99

Болд Цэцгээ хоёрын тууж 138

Мөнгөн шүүдэр /1979 онд/ 179

Table of Contents

Оршлын оронд

Монгол оронтой нүүр учран танилцахад

1. Үүрээр

2. Миний хүү зоригтой хүү

3. Оодон хээр

4. Бүтэлгүй жаал

5. Чи жэлнэ үү, үгүй юу!

6. Жижигхэн тагнуул

7. Ажиад уулзав

8. Хэнийжэн бэ?

9. Сайн жүн

10. Баярын нулимс

Нэгдүгээр бүлэг

Хоёрдугаар бүлэг

Гуравдугаар бүлэг

Дөрөвдүгээр бүлэг

Тавдугаар бүлэг

Зургадугаар бүлэг

Долдугаар бүлэг

Наймдугаар бүлэг

Оршил

1. Цэцэрлэгт

2. Автобусанд

3. Тоглоом

4. Бээлийгээ идсэн нь

5. Зочин

6. Бэлэг

7. Осолтой тоглоом

8. Эцэг эжийн журал

9. Ялихгүй явдал

10. Өвдсөн нь

Төгсгөл

Оршлын оронд хүүхдийн жотын тухай

Нэгдүгээр бүлэг

Хоёрдугаар бүлэг

Гуравдугаар бүлэг

Дөрөвдүгээр бүлэг

Зургадугаар бүлэг

Долдугаар бүлэг

Наймдугаар бүлэг

Есдүгээр бүлэг

Аравдугаар бүлэг

Арван нэгдүгээр бүлэг

Арван хоёрдугаар бүлэг

Арван гуравдугаар бүлэг

Төгсгөл

Өмнөх өгүүлэл

Өчигдрийн тэмдэглэлийн үргэлжлэл

Болдын тэмдэглэл

Цэцгээгийн тэмдэглэлийн үргэлжлэл

Болдын тэмдэглэл

Оройн цаг

Цэцгээгийн тэмдэглэл

1.«Хулгайлагдсан» жаалууд

2. Маамуу нааш ир

3.Идэмхий

4. Хүүхдүүд мороодож байна.

5. Цирк

6. «Галт онгоц» сүйрсэн нь

7. Эвт шаазгай буга барина